

# АР ХАЛХЫН ШИЛИЙН САЙН ЭРЧҮҮД

ГУРАВДУГААР ДЭВТЭР



Ар халхын шилийн сайн эрчүүд-3  
Зохиолч: Б.Ойдов

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

[www.bookstore.mn](http://www.bookstore.mn)

## Гуравдугаар дэвтэр

### Өмнөтгөл

“Ар халхын шилийн сайн эрчүүд” номын нэг, хоёрдугаар дэвтэрт шилийн сайн эр гэж ямар хүн болохыг тод томруун тайлбарласан болохоор энд дахин тодотгох шаардлагагүй гэж үзлээ. Харин энэхүү 3-р дэвтэрийг туурвихад Увс, Завхан, Өвөрхангай, Архангай, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Хөвсгөл, Булган, Сүхбаатар, Хэнтий зэрэг аймгийн олон арван хүн дээхэн үед нутаг орондоо цуутай явсан шилийн эрчүүдийнхээ тухай хүүрнэсэнд гүнээ талархсанаа илэрхийлье. Тухайлбал Увсын сайн эр Шагжийн Шаравын тухай өгүүлсэн улсын начин М.Мижиддорж, Дундговийн сайн эр “Сээтэн” Жалбаагийн тухай өгүүлсэн ахмад зохиолч Д.Лувсандэлэг, “Сайн хулгай” Цэрэндондог, Манлайн Хув нарын тухай өгүүлсэн ахмад зохиолч Сономын Чулуун, Засагт ханы Дампил панз, “Дөрөөт” Тэгшбүрэн нарын тухай өгүүлсэн Жанцангийн Болд, Баянхонгор аймгийн шилийн эрсийн тухай хүүрнэсэн Г.Дашчирэв, Ч.Ядам, Э.Дашцэрэн, Дарьгангын шилийн эр “Төлгөн” Жамбалдоржийн тухай өгүүлсэн Г.Аюуш, Дорноговийн домогт эрс “Тэлмэн” Зундуй, “Хилэн хормойт” Ашуу нарын тухай хүүрнэсэн яруу найрагч Г.Цагаандэрэм, ахмад зохиолч А.Шартолгой, Увсын домогт эр Харигийн Цийрэнгийн тухай өгүүлсэн Маасайн Аюурзана, Хан Хэнтийн “Гайхал” Батчулууны тухай өгүүлсэн А.Азжаргал, Архангай, Увс аймгийн шилийн эрчүүдийн талаар хүүрнэсэн Сундуйн Чявгачамба, Дайчин вангийн “Хулгар” Нацагийн ач О.Дэлгэрэх, Баруун гурван аймагт домог болж явсан “Доль” Банзрагчийн охин Б.Дагьмидмаа нарын олон арван хүн энэхүү номыг бүтээхэд сэтгэл харамгүй тус болсон юм. Дайчин цогтой өвөг дээдсийнхээ домог түүхийг мөшгөн судалдаг, омог бардам амьдралыг нь шүтэн биширдэг, эх оронч сэтгэлгээтэй, нийгмийн идэвхи сайтай ийм хүмүүс олноороо бий болоосой гэж ерөөе! Ингээд эрхэм уншигч та бүхэн Ар халхын шилийн сайн эрсийн гайхамшигт ертөнцөд тавтай морилно уу.

## Дарьгангын сайн эр “Хангай” Базар

Зохиолч Д.Маамын “Газар шороо” романы гол баатар “Хангай” Базар нь Дарьганга нутагт төрж өссөн бодит хүн бөгөөд тэрбээр хошуу тамгын газрын тахруудад мэдүүлэг өгөхдөө “Алдар нэр Алтаншүхэрийн Базар, адуулж дассан нутаг алтан Дарь овоо” гэж өчдөг байжээ. Манж ноёдын дуулгавартай зарц болж, тэдэнд мал сүрэг, газар шороогоо найр тавин өгч байсан хошуу ноёдын эсрэг тэрсэлж боссон Дарьгангын шилийн сайн эрчүүдийн хамгийн том төлөөлөгч нь “Хангай” Базар билээ. Түүний эсэргүүцлийн хэлбэр нь Манжийн хааны Сүрэгчин хошууны адуу малаас эрх дураараа тасдан авч нутаг хошууныхаа ядууст тараах байсан бөгөөд үүгээрээ тэр Дарьганга нутагт “Дархлагдсан хулгайч” гэгдэж явжээ. Ямар сайндаа л тэрбээр Сүрэгчин хошуунаас Хятад руу гаргах гэж байсан адуун сүрэг дээр ганцаараа давхиж очоод “Миний хөөсөн адууг данснаасаа хасчихаарай” гээд манж, хятадуудын нүдэн дээр адуунаас нь тасдаж хөөгөөд явчихдаг байсан гэдэг. Энэ нь нутаг орондоо дархлагдсан хулгайчийн үйлдэл мөн биз. Хориод насандаа шилийн эр болсон тэрбээр таван жилийн турш тасралтгүй адуу хөөсний эцэст “Шилийн адууг шилбүүрдэж хөөхгүй, шилбүүр хоншоороо билүүдэж явахгүй” хэмээн өөрөө өөртөө тангараг өргөөд хошуу тамгын газраас мээрэн тушаал хүртэж, засгийн албанд зүтгэж эхэлсэн ч эргээд л мөнөөх шилийн эрийн зам руугаа хальтирчихсан гэдэг. Ингэж хальтирсан нь цаанаа бас нарийн учиртай байж. Энэ тухай Дарьганга нутгийн уугуул 75 настай Т.Сундуйжав гуай “Шилийн эрийн замаас татгалзаж эхэлсэн тэрхэн үедээ “Хангай” Базар Дарьганга нутгийн “Сайхан” Сумъяа хэмээх царайлаг бүсгүйтэй учир ургуулж, улмаар тоонотой гэрт толгой холбохоор болж “Шилийн амьдралаас холдож, ширдэгний амьдралд ойртоё. Дархан эрхтэй гэрийнхээ ханыг Дарьгангын шороон дээр хатгая” гэж шийдчихээд байж. Тэгээд өдөр судар товлож байгаад “Сайхан” Сумъяагаа авахаар очтол тэдний гэрт цуутай хулгайч “Хангай” Базарыг баривчлахаар хятад, монгол хоёр хүн отоож байсан гэдэг. Базар тэрхэн даруйдаа гэрийн голд дүрэлзэн асч байсан тулгыг отоож байсан хоёр этгээд рүү манартал өшиглөөд гарч зугтсан гэдэг юм. Тэгээд л шилийн эрийнхээ зам руу буцаад орчихсон байгаа юм. Энэ тухай “Газар шороо” романд ч цухас гардаг. “Сайхан” Сумъяа нь Базарыг үнэхээр барьж өгөх гэж гэртээ хүн орогнуулсан уу, эсвэл түүнийг засаг ноёд нь эрхшээлдээ авч “Базарыг бидэнд барьж өг” гэж дарамталсан уу гэдэг нь тодорхойгүй. Ямар ч байсан “Хангай” Базарыг “Сайхан” Сумъяа гэдэг Дарьгангын цуутай сайхан хүүхэнтэй цухасхан холбогдож байсныг манай нутгийн хөгшчүүд барим тавим ярьдаг байлаа” гэж өгүүлсэн юм. “Хангай” Базарын жинхэнэ гэргий нь “Газар шороо” романд Бадам гэдэг хүүхний дүрээр гардаг. Дээхэн үеийн Дарьгангын хөгшчүүл Бадам гэдэг нэрийг уран зохиолын нэр биш, “Хангай” Базарын заяаны хань болж явсан бүсгүйн жинхэнэ нэр нь гэж ярьдаг байж. Хэрвээ зохиолч Д.Маам агсан эдүгээ амь мэнд байсан бол Бадам хүүхний тухай багтай хариу өгөх байсан болов уу. Бадам хүүхний уран зохиолд мөнхөрсөн дүрээс “Хангай” Базар” гэдэг хүний дүр төрх аяндаа тодроод ирдэг. Жишээ нь “...Бадам хүүхэн өл залгах бадрын аянд эр нөхрийнхөө тухай бодолтой цуг гарчээ. Эрдэнэт хүний биед ухаан бодол хэмээх гайхамшигийн ид шид заяасан нь юутай сайхан гэж Бадам бодож явна. Базарынхаа намуухан хэрнээ тод хардаг бор нүд, хангай нэрэндээ зохисон чилгэр сайхан бие, ханхар цээж, духны нь хоёр талаар түрж орсон халзан, монгол хүнд арай өндөрдүү гэмээр сүрхий зохисон шулуун хамар. Унахад түшээд босгодог, унтчихад нь сэрээгээд босгодог, уйлаад суучихад нь аргадаад босгодог саруул сайхан ухаан, үнэн халуун халамж, гал цог шиг хайр сэтгэл энэ бүхнийг Бадам хүсч, үгүйлж явав. Ижил ханийн ирэх

сайхан, явах хэцүү байдаг билээ. Хөөр баяр, хайр сэтгэл, алиалан шогчлох үг яриа, амраглан тэврэх халуун гар, итгэн мишээх уяхан харц, инээн байж үнсэх уруул, ер нь юу Бадамд хэрэгтэй, тэр бүхнийг аваад ирнэ. Явахдаа тэр бүхнийг аваад явчихна. Үнэн ханиа ирэхэд Бадам үдийн нарыг тэвэрсэн юм шиг болно. Үнэн ханийгаа явчихаар үдшийн бүрийд төөрсөн юм шиг болно. Уруул нь яльгүй өмөлзсөнөө болор тунгалаг нулимс нүдийг нь бүрхэж хүүхэн зогсов. Амьдралын атганд базуулан уланд дэвсүүлж цагаан байснаа хар болтол хиртэж, цаас адил түм дахин нухчигдавч бөхийснөө бөхийлөө гэлгүй явж, зүдэрсэнээ зүдэрлээ гэлгүй хийж, амьдралд суутал нудруулбал суугаагаараа мацаж, амьдралд унатал түлхүүлбэл хэвтээгээрээ мөлхөж, эрхийн чинээ хоёр хүүгээ өлсгөвч өлбөрүүлэлгүй, цангаавч харангасаалгүй өдий болгосон ганц бие энэ хүүхэнд зовлонгоо нимгэлэн уйлах завтай цаг одоо бодох нь ээ олддоггүй байжээ...” хэмээн бичсэн нь буй.

Энд хоёр хүүхдийн тухай өгүүлсэн байх бөгөөд Дарьгангын түүхэнд тэмдэглэгдэж үлдсэнээр бол “Хангай” Базар нь Саарай, Санзай хэмээх хоёр хүүтэй, Гүнсмаа гэдэг охинтой байсан бөгөөд Санзай, Гүнсмаа хоёр нь саяхан болтол нутаг усандаа сайн сайхан амьдарч байгаад насан өөд болцгоожээ. Харин “Хавчиг” Саарай нь эцгийнхээ шийрийг хатаах маягаар шилийн эрийн замаар замнаж яваад эр дунд насандаа сураггүй болжээ. “Газар шороо” романд өгүүлсэнээр бол Бадам хүүхний хоёр хүүхдийн нэг нь өлбөрч үхдэг. Тэгээд үлдсэн хүүхэд нь Галдан гэдэг нэртэйгээр Ардын хувьсгалд оролцож жанжин Д.Сүхбаатартай хамт гамин, цагаантануудын эсрэг мөр зэрэгцэн тулалддаг. Мөн “Хангай” Базар ч Ардын хувьсгалыг үзээд зогсохгүй өөрөө цэрэг удирдан дайсны эсрэг тэмцдэг билээ. Энэ нь соц реализм үнэртүүлсэн цэвэр зохиомж бөгөөд хэрвээ зохиолч ийм үйл явдал оруулалгүйгээр “Хангай” Базар болон түүний хүү “Хавчиг” Саарайг шилийн хулгайч чигээр нь романаа төгсгөж гэмээнэ дал, наяд оны хэт үзэл сурталжсан коммунистууд “Газар шороо” романыг элдвээр гоочлоод хэвлэхгүй байх байсан биз. Соц нийгмийн үед ингэж “хүчиндүүлсэн” сайхан сайхан зохиолын баатар мянга мянгаараа төрөн гарч байлаа. Дарьганга нутагт олон арван дуу, шүлгэнд мөнхөрч үлдсэн шилийн эр гэвэл “Торой” Банди билээ. Үүн лүгээ “Хангай” Базарын тухай дуу, шүлэг Дарьганга нутагт бас үлджээ. Жишээ нь,

“Ганган хар мориороо

Гансраа нь үгүй яваарай

Ганга л сүргийн Базар чи

Гандал үгүй яваад ирээрэй

Манарч байгаа шилийг

Маргааш яаж туулна даа чи

Магадын амраг чамайгаа

Мартагнуулж яаж үднэ дээ би

Эр хүний жаргалыг

Эзгүй хээр гэх юм чи

Эзгүй хээр чамтай минь

Элдэв муу юм учрах вий” хэмээсэн эмэгтэй хүний захиас үг бүхий энэхүү дуу дээхэн үед Дарьганга нутагт дуулагддаг байжээ. Шилийн сайн эрийн хажуугаар Дарьгангын сайн бөх гэгдэж явсан “Хангай” Базар нутгийнхаа засаг ноёдыг яг л хүүхэд загнаж байгаа юм шиг зандардаг, хошуу тамгын газрын “Хар гэр” нэртэй шоронг юман чинээ тоодоггүй, цоож цуурга, хаалга туургыг нь эвдэж хэмхлээд, эсвэл хар гэрийг нь дотроос нь өргөж чулуудчихаад арилж өгдөг байсан гэдэг. Энэ тухай зохиолч Д.Маам агсан өгүүлэхдээ “Базарыг сэрэхэд толгой нь дүүрчихсэн хамаг бие нь чичрээд, хонгоны арьс нь таталдан хорсч байв. “Аа би чинь баригдаж, Авга да вангийн д хүргэгдсэн л дээ” гэж дотроо бодлоо. Бул чулуу зүүчихсэн юм шиг хүндэрсэн толгойгоо өргөвөл нүд нь бүрэлзээд юм харж чадсангүй. Хэдэн хормын дараа муу гэрээсээ арай томхон хар гэрт гартаа гавтай, хөлдөө гинжтэй хэвтэж байгаага ойлгов. “Хай эцэг чинь шорон юу байхав дээ, үлээхэд хийсмээр эмтэрхий модон аяга шиг эд юм. Манжийн хаан ер нь ямар харамч бирд вэ. Цөөхөн лан мөнгө зараад энэ хошуудад олигтойхон шорон байгуулчихгүй. Сайн шоронгоос сайн эр төрөх ёстой” гэж бодсоноо шоронг аягатай зүйрлэснээс болж учиргүй цангаж байгаагаа мэдэрчээ” гэх буюу нутгийнхаа хошуу ноёнд хандаж “Дарьгангын хулгайч нар хошуу хульжиж, аймаг алгасч чам шиг тарган баяд, тамга яам, хурал жасын хөрөнгөнөөс хураан авч өнчин өрөөсөн, өтгөс ядууст өгч байснаараа энэ хошууг чинь муу нэрэнд дуулгаагүй юм. Өвөрлөгч 49 хошуу, Хөх нуурын дээд монгол, Ар халх, баатар Өөлдийн хязгаарт энэ Дарьгангыг чинь шилийн сайн эрчүүд л алдаршуулсан юм шүү. Засагт ханы нутгаас сайн эр болох гэж манай Шилийн богдод эрчүүл хүрдэгийг чи мэдэх үү. Сономдовдон чамаас хэрэгтэй юм сурах гэж Засагт ханаас байтугай зам гудсаас хүн ирж байхыг би хараагүй. Бид хүний төлөө хулгай хийж баригдаад Манжийн хар ташуурт хонгоныхоо махыг хичнээн уруулавч ядууст улам хайртай болж явсан. Харин чи яаж байна. Манжийн хааны мөрөн дээгүүрээ шидэж өгсөн баастай тамгыг цустай болтол нь булаалдаж, Дарьгангын ноёд дийлсэн дийлсэнийгээ алж байна гэж хошуу хульжааж, аймаг алгасуулж, гүрэн гүйлгэж цуу тараалаа. Чи хувиа бодож хойшоо урагшаагаа хоёр гурван хоногийн газар байгаа энэ хошууны нэр нүүрээр ингэж тоглов” гэх зэргээр нүүрийг нь улалзтал зандардаг.

Тэрбээр хошуу тамгын газрын харгис тахаруудад хандаж “Монгол эрийн чөмөгний цус та нарын нус биш шүү” гэж сануулдаг байжээ. “Хангай” Базар Манжийн хааны Сүрэгчин хошуунаас адуу хулуулж Сансрайдоржийн хошуу руу оруулахаас гадна Өвөрлөгч хошууд болох Авга засгийн хошуу, Авхнар бээлийн хошуу, Авга да вангийн хошуу, Шилийн голын чуулган, баруун, зүүн Сөнөд зэргээс адуу хөөж Дарьгангын нутаг руу оруулж ирдэг байж. Өвөрлөгчийн бараг хошуу болгонд “Базарын уутач” гэж байсан бөгөөд энэ нь түүний Манжийн хааны сүргээс хулуулж ирсэн адууг нааш нь цааш нь болгодог хүмүүс юмсанж. “Хангай” Базар хамгийн сүүлд нэгэн урвагч “Уутач”-аас болж Авга да вангийн хошууны хар гэрт хоригдож, есөн эрүү тулгагдаж байсан гэдэг. “Годил шар толгойт”-ын уутач Батаа гэгч тэрхүү урвагч нь Авга да вангийн дотны түнш байж. Базарын хүү “Хавчиг” Саарай буюу Базарын Хавчиг мөн л өвөрлөгч хошуудыг нэвт шувт “нүхэлчихсэн” шилийн эр байсан бөгөөд ямар сайндаа л тэрбээр Ардын хувьсгалын журамт цэргүүдээс зугтсан цагаантаны дүрвэгчдийг Дарьганга нутгаар дайруулалгүйгээр цөлөөр газарчлаад урагш нь хил давуулж

байжээ. Харамсалтай нь тэр өөрөө өвөрлөгч нутгаас иргэж ирээгүй гэдэг. Удам дамжсан шилийн эр “Хавчиг” Саарай нь эцэг шигээ ихээхэн бяр чадалтай, хошуу, даншиг наадамд хааяа барилддаг бөх хүн байж. Тэрбээр Дарьганга нутгийн “Тохой хар” гэдэг газар голдуу өвөлждөг байжээ. Тогоо дүүрэн хонины махыг галын хайчаар доогуур нь тулаад ганц гараараа гаргадаг, бодын чөмгийг хуга мушгидаг, бүтэн хонины мах идчихдэг, тэр хэрээрээ их унтдаг хүн байсан гэдэг. “Хавчиг” Саарай хошууныхаа наадамд олон удаа түрүүлж байсан бөгөөд дүү нар нь түүнийг “Лам ах” гэж авгайлдаг байж. Тэрбээр ид шажигнаж явах үедээ өвөрлөгч хошууны нэгэн хот айлд очжээ. Энд нэг залуу нас гүйцсэн эр үхрийн ширээр сур хийхээр үсийг нь авч байсан бөгөөд тэр шир нь цоохор үхрийн шир байж. Тиймээс “Хавчиг” Саарай “Цоохор үхрийн шир хэврэг байдаг юм. Цоохроороо урагдчихдаг юм” гэхэд гэрийн эзэн “Та тэгвэл урчих л даа” гэсэн байна. “Хавчиг” Саарай тэрхүү нойтон ширийг хуруугаараа өлгөж аваад цоохортой хэсгээр нь түвэггүй ураад хаячихаж байсан гэдэг. Тэрбээр нэг үе лам болж энэ тэнүүгээр бадар барьдаг байсан бөгөөд нэг удаа дүн өвлийн цаснаар Өвөр Монголын Сөнөд хошууны эзгүй цөлөөр явж байгаад нэг айлд очсон байна. Тэр айл нь адууны оторчид байж Төдөлгүй Саарай газар заалгаж аваад явах гэхэд гэрийн эзэн “Манай энд айл амьтангүй. Эзгүй цөл газар. Ганцаараа яваа хүнийг чоно нохой дагадаг юм. Хоноод яв” хэмээжээ. Гэвч “Хавчиг” Саарай үгэнд нь оролгүй гараад алчихаж. Төдөлгүй харуй бүрий болж түүнийг долоон чоно дагаж, өмнө хойно нь хоргоож байсаар гэв гэнэт дайрцгаасан байна. Энэ үед “Хавчиг” Саарай тулж явсан саваа модоороо хоёр чоныг нь цохиж алаад бусадтай нь улаан гараараа ноцолдож, сүүлдээ хариугүй тамир нь тасраад ухаан алдан унажээ. Үүр цайх үед мөнөөх оторчин айлын хаалгыг нэг хүн хүчтэй угзарч түгжээг нь мултлан орж ирээд сөхөрч унасан нь “Хавчиг” Саарай байх нь тэр. Түүний хувцас хунар, гар хуруу нил цус болсон байхыг гэрийн эзэн хараад асарч тойлон хэвтүүлжээ. Адууны оторчид түүнээс юу болсон тухай асуухад “Ямар ч гэсэн саваа модоороо хоёр чоно цохиж алсан. Бусадтай нь тамираа тасартал ноцолдсон. Яасан ийснийг бүү мэд” хэмээжээ. Адуучид тэр даруйдаа түүний мөрөөр хөөж мөшгихөд хоёр чоно цохиж алаад саваа мод нь хугарсан, үлдсэн таван чоныг гараараа тасар татаад хаячихсан байсан гэдэг.

Д.Маамын “Газар шороо” романд шилийн сайн эр “Хангай” Базар Манжийн харгис есөн эрүүг даваад гарч байгаа тухай гардаг билээ. Өнөө цагийн уншигчдад зориулж одоогоос дөч гаруй жилийн тэртээ бичигдэж байсан тэрхүү “Есөн эрүү”-нээс товчлон сийрүүлэе.

“...Тугалын хороо гэлтэй намхан нарсан хашлаганаас “Хангай” Базарыг чирч гулдарсаар гаргаж ирэв. Тэрбээр нарны гэрэл, сэрүүн агаар хоёрт цохиулж ухаан алдан үгдэхийн унажээ. Хэдэн хормын дараа сэргэж ангас ангас хийж байгаа толгойгоо хоёр гараараа базалсаар нүдээ нээсэнд цээжин бие нь нил нойтон болчихсон байлаа. “Аа, намайг ус хийж сэргээж шүү. Тийм их хэрэг болоо юм байх даа. Бас нэг шинэ дөрөө сэдэх нь үү. Сансрайдоржийн хошууны явдлыг мэдчихээгүй л бол яамай” гэж дотроо арзагануулан боджээ. Зандалчин эр, хялар манаач хоёр Базарыг сугадаж босгоод, чирч гулдарсаар хэд алхсан нь морины уяа гэтэл арай ойрхон зоосон хоёр шон модны дэргэд хүрч ирэв.” За тэсч үзээрэй. Ес дэх эрүү чинь шүү!” гэж хялар эелдэгхэн шивнээд буцсанд зандалчин “Дарьгангын хулгайч түргэлз үзээ! Гэрт хэдэн хүүхэд хүлээж байгаа. Чамайг бушуухан дүүжилж орхиод явах минь” гэв. “Чи үртэй хүн юмуу” гэж Базарыг хэлсэнд цаадах нь цочсон буюу сэжиглэсэн харцаар харж “Би арван гурван хүүхдийн эцэг” гэв. “Чи харихдаа гараа сайн угааж харьж бай! Чамд хүүхдүүдээ тэжээх өөр арга олдохгүй байна уу?” гэсэнд “Дуугаа тат”

гээд баруун гарынхаа эрчээр хүзүүн дундуур нь буулгатал Базар том биеэрээ найгасхийснээ өнхрөөд явчихав. Гэвч ухаан алдсангүй. Нэг юм тэнцэж ядан босоод харсан чинь цаадах нь алцайн зогсоод уурандаа багтран амьсгаадаж “Би ямараар ч гэлээ үр хүүхдээ тэжээж байна. Харин чи бол зовоож байна. Чамайг долоон хошууны дунд аагаа багтаан явахад үр хүүхэд чинь үхэж дуусч байгаа даа. Бушуу явж дүүжинд ор” гэхэд Базар аль ч эрүүнд үрчийгээгүйгээ үрчийж билээ. Мах арьсыг нь зулгаадаг тэр зандалчны үг зүрхэнд нь тусах увидастай байв. Базарын бие нүсэр хүнд тул дүүжинд их зовжээ. Гурван хятад туйпуу давхарлан тавьж дээр нь зогсоогоод хоёр шонгийн хооронд тэрэгний гол шиг нарийн төмрөөс хоёр гарыг нь баглаж, дээд талын туйпууг сугалж хаяад зандалчинг явснаас хойш Базар Авга да вангийн Содномпил гэдэг багачуултай хоёр өдөр дүүжинд ганхав. Гангийн халуун нар шатааж алах шахна. Ялаа батгана шарх сорвийг нь иднэ. “Үхэж үү, нүдийг нь ухах минь” гэсэн элээ хөлхөх хүмүүсийн чөлөө олж дээгүүр нь эргэлдэнэ. Эмс авгайчуул гаслалдан өнгөрнө. Хүүхдүүд гайхан гөлөрнө. Шингэн нь савирч, ширэгдэггүй хөлс нь урсана. Тооловч эс барагдах түмэн гасланд тоотой тэр хоёрхон өдөр Базар бишгүйдээ нуруугаа бөхийлгөж байлаа. Харин Содномпилийг харж “Энэ мөн сайн хүү еэ дээ” хэмээн дотроо дэвтээж, хүний үрийг уруу татахгүйн тулд, бас аман хайландаа хүрч орь дуу тавихгүйсэн гэхдээ хөмхийгээ зуун амьсгаадаж хоёр өдрийг барахчаан болжээ. “Ер яана даа. Алдыг нь аваад дэлэм дээр, атгыг нь аваад чимэх дээр, одоо л үхэх юм байх даа. Ухаан балартаад байх чинь” хэмээн түүнийг бодтол өмнүүр нь нэг муу нохой газар шиншлэн гүйснээ юу юугүй явж ирээд салбарч урагдсан өмдний нь завсраар цухуйх цус нөж нь садран урсч, идээ бээр цуван буй өгзөгний нь махнаас өмлөж байна уу даа гэлтэй долоож эхэлжээ. Дуугарах гэсэн чинь дуу нь гарсангүй. Хөлөө хөдөлгөж үргээх гэвэл ер хөлгүй юм шиг болоод мод шиг дэрийсэн хоёр муу өвдөг нь хонгоороо эс нугарлаа. Содномпил хажуунаас нь “Хөөе яв. Явахгүй юу чи, холд” гэж зандарсанд нохой тоосон янзгүй, холдсон ч үгүй, Содномпилийн бие амьд төдий үхдэл болохыг мэдэж, урт хэлээрээ хамраа шилэмдэн ахин долоосноо шүдээ ярзайлган нэгэнтээ эвшээгээд, Базарын гуяны шархан дээрээс хавхийн зуужээ. “Ээ харла, амьдаар минь намайг нохой зулгааж байна” гэж Базар бодоод ухаан алдчихав. Тэр золбин нохой гэрээдээ түр одсон манаач хялар авгыг чингэж чөлөөдсөн хэрэг буй. Хялар ханцуйнаасаа лонхтой ус гаргаж хоёр завьжаа түмбийлгэн амаа дүүргээд Базарын харласан нүүр рүү хүчтэй нь аргагүй тургисанд цаадах нь нэг муу юм сэргэхчээ боллоо. “Базаар хө, чи чинь Дарьгангын “Хангай” хочит шилийн сайн эр шүү. Энэ хоёр модны хооронд танай чигээс хүн үхэж гэж дуулаагүй юм байна” гэж хэлээд хялар манаач Содномпилийг чиглэн алхав. Саяын тэр үг шидэт үг байсан юм. Базарын дотор онгойгоод явчихав. Үнэн худлаа хэлж, шилбүүр хоншоорондоо агдан, ноёд баяд нараас зарга авч сайн эрийн нэгэнд бүртгэгдэж асан Базар үхэхийн босгон дээр ийнхүү үгээр түшүүлэн өндийх юм гэдгээ огт зүүдэлсэнгүй явжээ. Базар шоронгоос дөрвөн хөл дээрээ хөөгдөн гараад мөлхөө суугаагийн хооронд явж Жадамбаа хэмээх нөгөө хялар эрийнд хүрчээ. Тэгээд баруунтайгуур нь хөм гудасхан хаяулаад үг маггүй унаад өгөв. Дарьганга хэмээх тэнгэрийн хаяан дахь холын хошууны хөвөө, хүүхэд шуухадгүй үүд онголзуулаад эхний хоёр өдөр баахан тойвтой байлаа. Гэвч жил хагасын хар тамнаас амьд салаад шархиран өвдөх долоон зовлогоо урагдаж шалбарсан хул чисчүү тэрлэгэндээ далдлаад шуухитнан хэвтээ Базар ус уух хувь тавиландаа баярласаар авай. Базарын бие Авхнар бээлийн шоронгоос “Доль хангай” гэгдэх хялар Жадамбаагийн гарч ирсэнээр ховор олддог хар ус нь мөн л ховорхон олддог хар цайгаар солигдсоноос өөр хоолны хувьд гавьтай өөрчлөлт гарсангүй. Ингэсээр бүтэн сарыг элээхэд шарх нь эгээ л нэг юм өтхөөргүй болж, шархиралт өвдөлт нь намдан халуун нь бууж, хөл дээрээ нэг муу юм бэмбэгнэн явах төдий болжээ...”



## “Ирэг зум”-аар гаршсан Хоноцын Самдан

17-р зууны үед Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошуунд Хоноцын Самдан хэмээх шилийн эр амьдарч байжээ. Хоноц гэдэг нь нэг талаар түүний хоч боловч нөгөө талаар түүний эцгийн нэр юмсанж. Самдан нэг ёсондоо хоноцын хүүхэд бөгөөд эмээ ээж нь түүнийг багад нь өхөөрдөөд “Хоноцын хүүхэд” гэж дууддаг байж. Тиймээс эцэггүй бутач өссөн Самдан нэгэн цагт гэрт нь ирж хоноод өөрийг нь “хийгээд” явсан хоноц эцгийнхээ нэрээр овоглох болжээ. Тэр нь бодвол хээрээр гэр, хэцээр дэр хийдэг шилийн эр явсан ч юмуу, Самдан мэдээ орсон цагаасаа эхлээд л хээр хөдөө тэнэх дуртай, энд тэндээс адуу мал хөөчих гээд байдаг нэг тийм төрөлхийн хулгайч араншинтай болох нь ойр тойрныхондоо анзаарагджээ. Тэгээд эрийн цээнд хүрмэгцээ л баруун, зүүн аймгаас адуу хөөж эхэлсэн байна. Харин нас нь тавь хэвийгээд ирмэгц хурц түргэн морьдын гишгэдэл даахаа байснаар тэмээгээр жин тээх болжээ. Гэхдээ тэр нь бас л хулгай. Мань эр Дарьгангын “Сүрэгчин” хошуунаас Манжийн хааны “Ирэг зум” гээчийг дээрэмдэн тэмээнд ачаалаад нутгийн зүг оддог байж. Энэ тухай өгүүлэхийн өмнө Манжийн хааны “Сүрэгчин” хошуу хийгээд “Ирэг зум” гээчийг тайлбарлах нь зүйтэй болов уу. 1700-гаад оны үед Ойрадын Цэрэнжав хэмээх ноён Зүүн гарын хаант улсыг захирч асан Галдан бошигттой санал зөрөн муудалцсанаар өөрийн харьяаны гурван зуу гаруй өрх айлаа аваад Сэлэнгийн сав газарт очиж нутаглажээ. Төдөлгүй Галдан бошигт Манжийн эсрэг тэмцэж эхэлсэнээр Цэрэнжав ноён түүнээс урьдын өс хонзонгоо авахын тулд Энх-Амгалан хаанд өөрийн элчийг илгээсэн байна. Тэрбээр илгээмжиндээ “Агуу их хаан таньд морь, нохой мэт үнэнч явахаа андгайлъя. Би хааны цэргийг толгойлон явж Галдан бошигтыг төгс ялмуй. Надад цэргийн итгэлт жанжин болох эрх олгоно уу” гэж хичээнгүйлэн гуйжээ. Гэвч Энх-Амгалан хаан Цэрэнжав ноёнд хариу өгсөнгүй. Харин өөрийн итгэлт жанжин Фунинга гэгчид түмэн цэрэг захируулан давшуулж Галдан бошигтыг дарж авчээ. Үүний дараа арван хоёр дахь жарны үхэр жил Манжийн хаан Дарьганга нутагт Сүрэгчин хошууг байгуулах үедээ Цэрэнжав ноёнд элч илгээж нэгэн зарлиг буулгажээ. Тэрхүү зарлигт “Чи нэгэн цагт их зориг гаргаж Галдантай харгалдан тулалдъя хэмээсэн билээ. Эдүгээ манай их цэрэг түүнийг нэгэнт эрүү өвдгөөр нь мөлхүүлэн аюул үгүй болгов. Чингэхлээр надад зүтгэе гэсэн чиний биеийг өөр зүйлд заръя хэмээн шийдэв. Чи Захын хар овооны нутагт ирж миний чулуулсан түмэн сүргийг адуулан буй ард олныг хичээнгүйлэн захирч, шинэ хошууны бүгдийн тэргүүний тушаалд суу! Надад хүлэг сайт адуун сүрэг, хүзүү сайт үхэр сүрэг, зоо сайт хонин сүрэг, зогсоол сайт тэмээн сүрэг өсгөн үржүүлж, одоохондоо жил болгон агт үрээ таван зуу, тайлган тэмээ таван зууг тус тус илгээж бай. Албат нараа аван Захын хар овооны шилийн бэлчээр нутаг руу яаравчлан нүүтүгэй!” гэж тушаажээ. Ингэж Ойрадын Цэрэнжав ноён Дарьгангын “Бүгдийн тэргүүн” хэмээх өндөр албан тушаалыг хамгийн анх засаглан авсан түүхтэй аж. Цэрэнжавыг тохоон суулгаснаас хойш даруй гучин дөрвөн жилийн дараа 1731 оны цагагчин гахай жил манж нар сүрэгчин хошуунд дахин хонин сүрэг нэмэн үүсгэжээ. Найралт төв хэмээх Манжийн Юн Жэн хааны зарлигт “Адуун сүргээс гадна хонь буулгаж, миний ордоны хэрэглэлд жил бүр 3500 ирэг хонь хөдөлгөн ирүүлж байхаар тогтоов. Хошууг эрхлэхийн тул бүгдийн тэргүүн түүний туслахаас гадна сүргүүдийн дарга 11, бошго 22, малчин 220-ийг байгуулсугай” хэмээжээ. Түүнээс хойш Манжийн хааны ивээлд байсан Дарьганга хошууны мал нэлээд өссөний дээр эзэн хаанд өргөсөн бэлэг нэрийдлээр Гурван голын Монгол нутгийн гүнээс, өвгөчүүлийн хэлдэгээр “Баатар Өөлдийн орон”-оос хүртэл харшаан хайлуулан тууж Дарьгангын нутагт авчирсан

олон мянган адуу мал нэмэгдсэнээр “Сүрэгчин” хошуу ерөөсөө л Манжийн хааны мал бэлтгэлийн орон болж хувирсан байна. 18-р зууны үед Дарьганга нь хоньчин, адуучин, үхэрчин гэх мэтийн таван гарын 198 сүрэг бүхий баян хошуу болжээ. Сүрэг гэдэг нь зуугаас дээш мал бүхий нэг малчныг хэлж буй хэрэг. 198 сүрэгтэй байсан гэж бодохоор Манжийн хааны зарлигт өгүүлсэн 220 малчин гэдэгт тун дөхөж очсон байх жишээтэй. Хоньчин гар, баруун зүүн адуучин гар гэж байсан бөгөөд гар болгоныг гарын ноён захирна. Гарын ноёныг Галайда гэдэг байсан бөгөөд энэ нь “Гарын дарга” гэсэн манж үг ажээ. Гарын ноёны туслахыг “Да” гэдэг байж. Адуучин гарын “Да”-г “Адуун зургаан эр” гэдэг байсан бөгөөд зургаан хүн нийлж нэг “Да” болох жишээтэй. Сүргийг ерөнхийд нь “Да” нар дааж, нутаг бэлчээр сонгох, Манжид илгээх агт үрээг ялгах, “Ирэг зум”-ын албыг хөтлөх, ноос үс, арьс ширийг хошуу тамгын газарт нутгийн мээрэн нараар тушаалгах зэрэг ажлыг хариуцдаг байж. Үүнээс гадна Манж Чин улс халхыг эрхэндээ оруулмагц ноёрхолоо улам бэхжүүлэх, мөн баруун Монголыг эзлэх зорилгоор цэрэгжүүлсэн буухиа өртөөг гол чиглэлүүдэд байгуулжээ. “Өдрийн сонин”-ы саяханы нэг дугаарт “Манжийн өртөөг залгуулахад жилд таван зуун мянган толгой мал хэрэглэдэг байжээ” гэсэн мэдээлэл нийтлэгдсэн байлаа. Энэ нь хөдөлбөргүй үнэн бөгөөд 18-р зууны үед 140 гаруй буухиа өртөөнд 1700 гаруй өрх үйлчилж байжээ. Мөн цагдаа, хавсарга 700 гаруй өрхийг нэмж, 2500 шахам өрх өртөөний алба хаших үүрэгтэй болжээ. Энэхүү олон замын өртөөний албыг залгуулах үүрэг ард түмэнд хүндээр тусч байсан түүхтэй. Монголын ард түмнээс Манж Чин улсад нийлүүлж байсан 27 төрлийн албаны дотроос хамгийн хүнд нь олон замын өртөө байж. Зөвхөн Сайр-Ус, Их хүрээ, Хиагт, Ховд, Улиастай зэргийг дайруулж байгуулсан 120 суурь буухиа өртөөний хэрэгцээнд жил бүр 47 мянган тэмээ, 250 мянган адуу, 55 мянган хонь, нийтдээ хагас сая толгой мал хэрэглэж байсан баримт үлджээ. Албан үүрэг нэмэгдэх үед зарим өрх алба залгуулж чадахгүйд хүрдэг байсан тул хавсрага хэмээх өртөөг нэмэх ба өртөөний суурь хүчийг сэлбэхэд ард олныг дайчилдаг байж. Өртөө харуулын албыг гүйцэтгэхээр хошуу нутгаасаа хэдэн мянган бээр газар алслан нүүж одсон зарим айл өрх нутаг буцаж чадалгүй тэндээ үлдэх тохиолдол цөөнгүй гардаг байжээ. Дээр өгүүлсэн Хоноцын Самдан яг ийм албанд зүтгэж яваад Дарьганга нутагт хаягдсан байх бөгөөд үүний ашиг нь гэвэл Дарьгангын шилийн эрчүүдийг дагаж Манжийн хааны сүргийг жаал жуул шоглосонд оршино. Харин тэр тавь хэвийсэн насандаа тэмээн жингийн даамал нэр зүүж, “Ирэг зум”-ын дээрэмчин болжээ. “Ирэг зум”-ын алба нь жил болгон намрын сэрүүн унах цагт нас бие гүйцсэн 3500 эр хонь нядалж, үсийг нь зумлан хөлдөөгөөд Манжийн хааны амины идшинд зориулж Бээжин хотын Шар ордон руу тээдэг байж. Үүнийг хурц түргэн морьдын гишгэдэл даахаа байсан Хоноцын Самдан тэргүүтэй хэдэн шилийн эр замд нь отож байгаад дээрэмдэж, дор хаяад 500 хонины махыг тэмээнд ачаалаад Сайн ноён хан аймгийн нутаг руу арилж өгдөг байжээ. “Торой” Банди мэтийн танагтай шилийн эрчүүд бол Манжийн хааны хэрэгцээнд урагшаа гардаг байсан түм буман адуунаас хөөх жишээтэй. Үнэндээ манж нар Монголын мал сүргээр ёстой тоглох шиг болдог байж. Зөвхөн өртөөний ажилд гэхэд л жилд таван зуун мянган мал хэрэглэж байсан гэж бодохоор Монгол улс, тэр дундаа Дарьгангын “Сүрэгчин” хошуу Манжийн хааны мал бэлтгэлийн бааз болж хувирсан нь илт байгаа юм. Ийм нөхцөлд эх оронч сэтгэлгээний хэлтэрхий болон гялалзаж асан шилийн эрчүүдийн цөс нь хөөрч, аазгай нь хөдлөхгүй ч яахав дээ. Гэхдээ тэд “Ирэг зум”-ыг нэг их тоодоггүй байсан бөгөөд тухайн үед шилийн эрчүүдийн дунд “Шандаст хурдан хүлгийг бол нутаг дамнуулан хөөхсөн, шалзалсан ирэг зумханыг мориндоо дүүрээд зугталтай нь биш” гэдэг хэлц үг хүртэл гарч байсан гэдэг. Харин нас нь тавь хэвийгээд хурц түргэн морьдын явдал даахаа байсан Хоноцын Самдан мэтэд бол “Ирэг

зум” гээч нь их л аятайхан бөгөөд зөөлхөн хоол болж байжээ. Дашрамд хэлэхэд Манжийн хааны “Сүрэгчин” хошууны адуучин гарын “Да” болох “Адуун зургаан эр” гэгчид хол ойроос мал тоншчих гээд байдаг шилийн хулгайч маягийн эрчүүдийг зориуд сонгон авч цалин пүнлүү өгөөд адуу маллуулдаг байсан гэдэг. Гэхдээ үүнийг төрөлхийн шилийн хулгайч, ноёд баядын мөнхийн дайсан болж явсан “Торой” Банди мэт нь тоож авч хэлэлцдэггүй байсан нь тодорхой.

## Бээжингийн шулаачдыг бэмбэгнүүлж явсан Орлойн хөх Доодой

Энд өгүүлэх Орлойн хөх Доодой нь Дарьгангын сайн эр “Хангай” Базартай нэгэн цаг үед амьдарч асан шилийн эр билээ. Зохиолч Д.Маамын “Газар шороо” романд Орлойн хөх Доодой нь цухасхан дурдагдаад өнгөрдөг. Энэ хүн “Хангай” Базарыг нас барах үед эхнэр Бадамтай нь цуг түүний ясыг барьж, улмаар Алтан овоонд нутаглуулдаг. Ийм нэг бэсрэг дүр байдаг ч бодит амьдрал дээр Орлойн хөх Доодой нь жинхэнэ шуугиулж явсан эр ажээ. Энэ тухай Дарьганга нутгийн уугуул 75 настай Т.Сундуйжав гуай хуучлахдаа “Манжийн үед Дарьгангын “Сүрэгчин” хошуунд “Хошуу үрээний алба” гэж байсан юм билээ. Түүх сударт үүнийг “Агт үрээ” гэж тэмдэглэсэн байдаг. “Хошуу үрээний алба” нь Манжийн хааны зарлигаар Бээжин рүү жил болгон мянга мянган азарган үрээ аваачдаг байж. Тэр үед Дарьганга нутагт “Агтан хүрээ” гэж байсан бөгөөд урагш нь аваачих азарган үрээдийг энэ хүрээнээс манж, хятад нийлсэн хорь гучаад эр тууж явдаг байсныг бодоход их л хатуу харуул хамгаалалттай байсан бололтой. Яагаад гэвэл Дарьгангын сайн эрчүүд азарган үрээдийг урагш нь гаргаж байгаа сургаар замаас нь дээрэмддэг байж. Энэ дээрмийн гол толгойлогч нь Орлойн хөх Доодой гэдэг шилийн эр байсан тухай манай нутгийн хөгшчүүд ярьдаг байлаа. 1950-иад оны үед намайг хорь гаруй настай байх үед манай нутгийн Гүрдамба гэдэг өвгөн Орлойн хөх Доодойтой цуг Бээжин рүү гаргадаг азарган үрээдээс тасдаж хөөдөг байсан тухайгаа ярьдаг байсан юм. Гэхдээ Гүрдамба гуай Орлойн хөх Доодойтой эн зэрэгцэхээр шилийн эр байгаагүй юм билээ. Ердөө л адуу хөөх үед нь хамжигчаар оролцдог жижигхэн банди байж. Дарьгангын сайн эрчүүдээс Орлойн хөх Доодой нь Манжийн эсрэг тэмцэгч чанараараа нэлээд дээгүүр бичигдэх сайн эр мөнөөсөө мөн” гэсэн юм. Энэхүү ярианаас арга зальтай манж нар халхын азарган үрээдийг яагаад урагш нь гаргадаг байв гэсэн асуулт гарч ирнэ. Эзэн Чингисийн үеэс эрчит дөрвөн туурайгаараа дэлхийн талыг тамгалж явсан давжаа биетэй, давхилт сайтай монгол морьдын чадал чансааг манж нар мэдэж авсанаар тамир тэнхээ, үр төл муутай хятад гүүнүүдээ хээлтүүлэх гэж Ар халхын азарган үрээдийг Бээжинд хүргэдэг байсан нь ойлгомжтой. Арга зальтай манж, хятадуудын дотор санааг ямар барж идэх биш. Тэдний энэхүү санааг аймхай хулчгар халх ноёд мэдсэн ч мэдээгүй царайлаад эрх мэдэл муутай ядмагхан хувь заяатайгаа эвлэрдэг байсан биз. Харин Орлойн хөх Доодой мэтийн шилийн эрчүүд Бээжин рүү цөлөгдөж буй мянга мянган азарган үрээдээс хэд гурвыг тасдаад авч үлддэг байсан нь яамай даа. Гэхдээ тэр азарган үрээдийг халхын нутагт явахад нь тасдаж хөөдөггүй, Хятадын нутаг руу лавхан орж Бээжинд дөхөөд ирмэгц өмнөөс нь тосч очоод тасдаж хөөдөг, нэг ёсондоо “Угтуул дээрэмчин” гэдэг нь байж. Энэ нь Ар халхын шилийн сайн эрчүүдийг манж ноёд хардаж сэрдэхгүйн нэгэн баталгаа болдог байсан бөгөөд азарган үрээдийг туусан манж, хятадууд халхын нутгаас алслан холдмогцоо “Муу хулгай нарын савраас мултарчихлаа” гэж бардам бодоод тайвширч явтал өмнөөс нь хятад дүр төрх бүхий дээрэмчид гэв гэнэт гарч ирээд л адуунаас нь тасдаад хөөчих жишээтэй. Орлойн хөх Доодой нь ийнхүү Бээжингийн шулаачдыг Бээжин хавьцаа нь дээрэмддэг аргагүй л ухаан сүйхээтэй сайн эр байжээ. Тэрбээр зүгээр нэг адуу хөөдөг цөлх эр байсангүй. Засаг ноёдтойгоо заргалдан тэмцдэг, үгийг нь авч хэлэлцэхгүй бол Да хүрээний сайд нарт заргын бичиг илгээдэг, ухаандаа Цэцэг нуурын дугуйлангийн “Ард” Аюуш маягийн хүн байж. Жишээ нь Жанчхүүгийн Хусай амбан Дарьгангын “Хоньчин гар”-ыг өөртөө тасдаж авахаар улайрах үед Орлойн хөх Доодой тэргүүтэй хүмүүс эсэргүүцэн тэмцэж байсан гэдэг. Сүүлдээ Хусай амбан улам улайрч “Хоньчин гарыг нь тасалж болдоггүй юм бол хотол хошуугаар нь ховх татна” гэж

аархаад өөртөө халх ноёдыг урвуулах, Дарьгангын хоньчин гар, баруун зүүн адуучин гар, “Бүгдийн тэргүүн” гэх мэтийн албан тушаалд дотуур тамиртай хятад ноёдыг суулгах, Орлойн хөх Доодой мэтийн тэмцэгч эрсийг “Муу хулгайч”, “Төрийн бөөс” гэж дайрч давшлан тамгын газрын тахруудаар залхаан цээрлүүлэх гэх мэтийн увайгүй үйлдэл хийж эхэлжээ. Үүний эсрэг Орлойн хөх Доодой эцсээ хүртэл тэмцэж, Да хүрээний сайд нарт заргын бичиг илгээж, улмаар Жанчхүүгийн Хусай амбанаас заргаа авч байсан гэдэг.

## Шилийн богдод тангараг өргөсөн 32 дахь сайн эр “Исгэрдэг” Дамба

Манжийн дарангуйллын үе болон Богд хаант Монгол улсын үед Дарьгангын Шилийн богд ууланд нийтдээ 32 шилийн сайн эр тангараг өргөсөн байх бөгөөд эдгээрийг Дарьгангачууд ард түмэнд албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн шилийн сайн эрчүүд гэж үздэг юм байна. Ардын хувьсгал ялан мандсанаас хойш буюу соц нийгмийн үед Шилийн богд ууланд очиж тангараг өргөсөн шилийн эр мэр сэр байдаг ч тэд дээрхи 32 сайн эрийн зиндаанд үнэлэгдэж явсангүй. Энэ нь социалист төрийн үед шилийн эрчүүд “Малын хулгайч” гэж адлагдаж явсантай нь холбоотой биз ээ. Албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн дээрхи сайн эрчүүдийн хамгийн сүүлчийнх буюу 32 дахь тангараг өргөсөн хүн нь Дарьгангын шилийн сайн эр “Исгэрдэг” Дамба ажээ. Лхаагийн Дамба нь 1890-ээд оны дунд үед Сүхбаатар аймгийн Онгон сумын “Шар бүрд” хэмээх газар төржээ. Тэрбээр эрийн цээнд хүрмэгцээ л ар, өвөр хошуудаас аль л баян тарган гэсэн ноёд, феодалын адуу малыг хулгайлж ядуу буурай хүмүүст тарааж өгдөг болсоноор нутаг хошуундаа хүндлэгдэх болжээ. Түүнийг ямар ч харанхуй шөнө морины толгой алдалгүй уургалдаг, газар сайн таньж мэддэг, сайхан исгэрдэг хүн байсан хэмээн нутгийн нь хөгшид өнөө болтол дурсдаг аж. Тэрбээр Маажаяа, Саарал, Бор, Борхүүхэн, Онгойбор, Адъяа, Оюун нарын долоон хүүхэдтэй байж. Онгойбор, Оюун нар нь дээхэн үед Сүхбаатар аймагт жолооч хийж явжээ. “Исгэрдэг” Дамбын долоон хүүхдээс Адъяа нь эдүгээ амьд сэрүүн байгаа бөгөөд тэрбээр Сүхбаатар аймагт амьдардаг аж. Саяхан Онгойборын хүү Чулуунбаатар (Цагдаагийн ерөнхий газарт жолооч хийдэг) бидэнд өвөг эцгийнхээ зураг хөргийг авчирч өгөхдөө бяцхан дурсамж хүүрнэсэн юм. Дамбын төрсөн эгч Цэрэнлхам гэдэг хүн байж. Хожим Цэрэнлхам дүү Дамбынхаа тухай “Би дүүгээ олон хоногоор явахад нь их л санаа зовж, өдөр шөнөгүй хүлээдэг байлаа. Тэгээд исгэрэх чимээнээр нь дүүгээ ирж байгааг мэддэг байсан. Оройн дуу их сонор байдаг. Намайг голдуу үнээ сааж байх үед дүүгийн маань исгэрэх чимээ сонсогддог байлаа. Энэ чимээнээр нь тулгандаа цай тавьж буцалгаад сууж байхад дүү маань орж ирдэг байсан. Бүр хагас өртөө газраас исгэрэх чимээ нь сонсогддог байсаныг бодоход дүү маань гайхамшигтай сайхан исгэрдэг хүн байж дээ” гэж дурсдаг байж. “Исгэрдэг” Дамба ихэвчлэн Өвөр Монголын Сөнөд, Барга, Үзэмчин хошуудаар явж адуу хөөж ирдэг байжээ. Өвөр Монголын сайн эрчүүдийн заримтай нь дотно нөхөрлөж, заримтай нь зодолдож ташуурын амт үзүүлж явсан гэдэг. Нэг удаа Дамба нутгийнхаа шилийн эр болохын дон шүглэсэн “Хутгуур” Жанаа гэгчтэй Өвөр Монголоос адуу хөөхөөр болжээ. Гэвч Жанаа цаанаа муу санаа агуулсан байсныг Дамба мэдсэнгүй. Учир нь тухайн үед “Исгэрдэг” Дамба, “Хөх” Ханд нарын шилийн эрчүүд Дарьгангын ард түмний дунд ихэд нэрд гарч байсан бөгөөд үүнд атаархсан Жанаа өрсөлдөгчөө хороож өөрөө нэрд гарахыг хүсчээ. Тэгээд тэр Өвөр Монголоос адуу хөөж ирье хэмээн Дамбыг өдөр шөнөгүй гуйж байсаар нэг өдөр хүслээ гүйцэлдүүлж Дамбын хамт Өвөр Монголын Сөнөд хошуу руу явсан байна. Гэвч тэр цаагуураа Сөнөдийн хулгайч нартай хуйвалдчихсан байж. Мань хоёр Сөнөдөөс баахан адуу хөөгөөд Дарьганга нутгийн зах сэжүүрийг хараад амсхийж суутал хойноос нь хэдэн хүн гээг даран хөөсөөр гүйцэж ирсэн байна. Угийн бие томтой, зодоон цохионд гаргууд “Исгэрдэг” Дамба тэдэнтэй шууд л барилцаад авчээ. Харин хар амиа бодсон Жанаа тэдэнтэй барилцаж авахын оронд Дамбын эмээлтэй морийг хөтлөөд, хөөж явсан адуунаасаа тэн хагасыг нь тасдаж хөөгөөд нутгийн зүг оджээ. Хээр хөдөө явган нүцгэн, бас тэгээд дөрөв таван хүнтэй ганцаараа ноцолдоод үлдсэн Дамбыг Жанаа амьд гарахгүй гэж итгэсэн байна. Тэгээд ч түүнтэй хуйвалдсан Сөнөдийнхөн Дамбыг алах даалгавартай байж. Жанаа шууд явсаар

Дамбынд ирж эхнэрт нь эмээлтэй морийг нь өгөхдөө “Нөхөр чинь амь үрэгдсэн. Би эрийн сайнд амиа авч гарлаа. Харийн хошуунаас адуу хөөсөн бидний хохь болохоор нааш цааш нь юм ярьсаны хэрэггүй шүү” гэж захиад явжээ. Харин энэ үед Дамба дөрөв таван хүнтэй хүч тамираа бартал ноцолдож арай гэж амьд гараад ойролцоох адуун дундаас нэг морь дэлдэж унаад нутгийн зүг хөдөлсөн байна. Түүнийг хагас өртөө газраас исгэрэхэд эхнэр нь энэ чимээг сонсоод цай чанадаг байсан бөгөөд “Хутгуур” Жанаагаас нөхрөө үхсэн гэж сонсоод уй гашуу болж суусан тэрбээр гэнэт исгэрэх чимээ сонсоод мэл гайхаж, цэл хөхөрчээ. Дамбыг гэртээ орж иртэл эхнэр нь авдран дээрээ зул өргөчихсөн, аяганд нь цайныхаа дээжийг хийгээд тавьчихсан уйлаад сууж байсан гэдэг. “Исгэрдэг” Дамба гэртээ хоёр хоног биеэ тэнхрүүлээд “Хутгуур” Жанаа дээр явж очтол мань эрийн царай цонхийгоод эгээтэй л цус харвачихсангүй. Дамба түүнд хандаж “Чи ч эр хүний сүг юм даа. Харь нутгийн дээрэмчдийн дунд нэгийгээ орхиод амь зулбан зугтана гэдгийг чинь мэдсэнгүй. Цаашид хоёулаа бие биенээсээ хол явцгаая” гэж хэлээд түүнтэй тангараг тасарч байжээ. Жанаа урдаас хөөж ирсэн адуугаа ядуу ардуудад тараалгүй өөртөө авчихсан байсныг Дамба бүгдийг нь тууж аваачаад ядуу айлуудад тарааж байсан гэдэг. Үүний дараа арга ядарсан Жанаа хөдөө хээр хонь хариулж явсан жаахан хүүхдийн амийг бүрэлгээд хэдэн хонь туугаад явчихаж. “Исгэрдэг” Дамба энэ тухай дуулж сонсоод арчаагаа алдсан хулгайч Жанааг морин дээрээсээ хурга шиг шүүрч дүүрэн ууланд аваачаад “Чи яах гэж нялх амьтаныг алж байгаа юм бэ” гэж зандарчээ. Хариуд нь Жанаа “Хүүхэд ч гэсэн амьд гэрч шүү дээ” гэсэн байна. Энэ үгийг сонсоод Дамба аймшигтайгаар хилэгнэж “Гэрчийг алдаг юм бол чи ч гэсэн адууны хулгайн гэрч шүү” гээд түүнийг хөлөөр нь модноос дүүжлээд орхиж оджээ. Гэвч муу хүн үхдэггүй гэгчээр “Хутгуур” Жанааг модонд дүүжлээстэй үхлүүт байхад нь нутгийн нь нэг хүн тааралдаж амийг нь аварч байсан гэдэг. “Исгэрдэг” Дамба нэг удаа До яамныханд баригдаад Хэнтийн шоронд саатуулагджээ. Тэгээд хуягуудын арга эвийг олж гадуур ажиллаж байхдаа нэгэн хянагчийн хоёр сайхан морийг хулгайлж унаад эхнэр, хүүхэдтэйгээ уулзахаар нутгийн зүг одсон байна. Ингээд гэртээ гурав хоноод Хэнтийн шоронд буцан ирж мөнөөх хянагчид хоёр морийг нь өгөхдөө “Эр хүнийг хүссэн газарт нь хүргэж өгдөг сайн морьд байна” гээд морьдыг нь үнсчихээд мөрдөнд буцаад орж байсан гэдэг. Үүнээс үүдэн До яамныхан түүнийг итгэлтэй сайн хулгайч байна гэж үнэлээд тагнуулын хэрэгт ашиглахаар хот руу авч явжээ. Ер нь тухайн үед шилийн сайн эрчүүдийг өвөрлөгч нутаг руу явуулж тагнуул хийлгэх зорилго агуулж байсан бөгөөд ингэх болгондоо До яамныхан өмнө нь адуу мал хөөж туусан, дээрэм тонуул хийсэн гэх хэргийг нь өлгөж аваад шорон гянданд хорьж, нэг ёсондоо барьцаалдаг байж. Тэгээд дараа нь “Чамайг хэрвээ эх орныхоо төлөө үнэнчээр зүтгэх юм бол ялаас чинь чөлөөлнө” гэх жишээтэй. Хээрээр гэр, хэцээр дэр хийгээд сурчихсан шилийн эрчүүд энэхүү саналыг нь шууд л зөвшөөрдөг байж. “Эх орныхоо төлөө” гэдэг нь харийн нутаг руу орж тагнуул хийхийг хэлж байгаа хэрэг. Тухайн үед До яамны чекистүүд шилийн эрийн дүрд хувирч тагнуул хийдэг байжээ. Гэвч чекистүүд шилийн хулгайчийн дүрд хувираад тагнуул хийх нэг хэрэг, шилийн эрчүүд жинхэнэ дүр төрхөөрөө эх орноосоо даалгавар аваад тагнуул хийх бүр ч өөр хэрэг. Өөр хэрэг гэдгийн учир нь өвөрлөгч нутагт аль хэдийн танил болсон “Исгэрдэг” Дамба мэтийн шилийн эрчүүдийг хятадууд хэзээ ч тагнуул туршуул гэж хардаж сэрдэхгүй, харин олз ашиг хайхаар явна гэж сэрэмжлээд адуу малаа хямгадаж таарна. Гэтэл цаагуур нь мань хүмүүс хэний ч санаанд оромгүй үйлдэл хийх жишээтэй. Шилийн хулгайч нараар тагнуул туршуул хийлгэх нь ийм л ашигтай байж. До яамныханд баригдаад Хэнтийн шорон руу ачигдсан “Исгэрдэг” Дамба хэдэн сарын дараа хоёр нүдний сунадаг дуран, цахиур буугаар шагнуулаад нутагтаа ирж байсан гэдэг. Энэ нь хэрэг дээрээ төр засгийн даалгавараар

тагнуулын үүрэг гүйцэтгээд ирсэний нотолгоо байлаа. Шилийн богд ууланд тангараг өргөсөн Дарьгангын 32 сайн эрийн нэг болох “Исгэрдэг” Дамбыг Сүхбаатар аймгийн Онгон сумын харъяат, яруу найрагч Г.Мэнд-Ооёо сайн мэддэг, амьд ахуйд нь барааг нь харж үг солилцож явсан гэдэг. Сайн эр Дамба 1972 онд 80 орчим насандаа таалал төгсчээ. Өвгөн болсон хойноо ч түүний хүч тэнхээ тэгтэлээ харьж байсангүй. Нэг удаа түүний хүү Онгойбор гэртээ согтуу ирээд ойр хавийнхаа хүмүүст агсам тавих аядсан байна. Тэгтэл дал гаруй настай “Исгэрдэг” Дамба босч ирэн өөрөөсөө том хүүгээ барьж аваад орон дээр чулуудтал түүний өрөөсөн гутал холоо суга үсэрч байсан гэдэг.



## Тахь зайран буюу “Сунагар” Цэсрэн

Гучаад оны үед Хөвсгөл аймагт Тахь зайран хэмээх цуутай эр байсан бөгөөд тэрбээр зарим үед Тахь зайран нэртэйгээр бөөлж бусдад хараал жатга хийгээд сүйдэлчих шахдаг, заримдаа “Сунагар” Цэсрэн нэртэйгээр Хөвсгөлийн тайгад шилийн эр маягаар амьдарч энд тэндээс адуу мал хөөгөөд явж байдаг, нэг ёсондоо хоёр нэртэй, хоёр янзын дүрд хувирдаг элдэвтэй хүн байсан бололтой. Түүний тухай зарим нэг яриа нь хүн үнэмшмээргүй, эгээ л домгийн шинжтэй байхыг яана. Хөвсгөл аймгийн харъяат Ж.Буянхишиг, Д.Баясгалан нарын хүмүүс түүний тухай хуучилсаныг нэгтгэн сийрүүлэв.

Тахь зайран буюу “Сунагар” Цэсрэн гэгч нь хар нялхаасаа маш хүнд хэцүү амьдрал туулжээ. Учир нь тэр үед Орост дайн самуун дэгдэж, үүнээс дүрвэж зугтсан эсэн бусын явуулын тэнэмэлүүд Монголын хилийн дээсийг алхаж Хөвсгөл нутгийн цаатангуудыг хүчирхийлэн, дээрэмдэж, улмаар амьдрах эх сурвалж болсон цаа буга, урц оромжноос нь салгаж хаях нь их байж. Тиймээс Тахь зайрангийн сэтгэл зүйд явуулын дээрэмчдийг үзэн ядах үзэл хар нялхаас нь сууж эхэлжээ. Тэгээд тэднээс өш хонзон авахын тулд бөө болж хараал жатгын хар судрыг өдөр шөнөгүй бясалгах болсон байна. Нэг удаа тэрбээр Хөвсгөл нутагт бүгсэн тавь гаруй явуулын тонуулчныг хөнөөхийн тулд Хөвсгөлийн тайгад зориуд урц барин сууж арав хоногийн турш хараал хийжээ. Нээрээ ч төдөлгүй Ренчинлхүмбэ хайрханы арын их тайга руу хүн толгойтой цөөвөр чононууд гүйлдэх болсон байна. Эдгээр хачин амьтад биесээ цуу татан, цусан далай савируулан хооллоцгоож байхыг тус нутгийн цаатангууд холоос хараад мэл гайхацгаасан байна. Сүүлдээ мөнөөх цөөвөр чононууд хайрханы ангал руу биесээ хороосоор үхэж үрэгдэж дуусчээ. Гэтэл үүний дараахан Ренчинлхүмбэ хайрханы гүн хавцалд тавь гаруй хүний араг яс овоорчихсон байсан гэдэг. Орой үдшийн цагаар уг хавцалаас хөх гал дүрэлзэн асдаг, ойр хавьд нь явсан хүн амьтан цахилгаанд цохиулсан мэт тэр дороо үхдэг болсон гэх бөгөөд хэрвээ дээрхи явдал амьдрал дээр жинхэнээсээ тохиолдсон бол аюултай л юм байна. Бас гайхамшиг ч гэж хэлж болохоор юм. Явуулын тонуулчдад өширхөж хорссон нутгийн ардууд сэтгэлээ тайтгаруулахын тулд дээрхи яриаг зориуд зохиомжилсон байж ч мэдэх юм. Дээрхи итгэмээргүй явдлын тухай хожим Тахь зайран “Үйлийн үр гэдэг нь аливаа хүнд заавал ч үгүй ирдэг ёстой юм. Тэр цөөвөр чононууд маш их нүгэл үйлдсэн болохоор дааж давшгүй хөнөөл сүйрэлд өртсөн юм шүү дээ” гэж ярьдаг байсан гэдэг. Гэхдээ Тахь зайран байнга хараал жатга хийгээд байдаггүй, чухамхүү аргагүй шаардлагатай үед л гоц мэдрэхүйгээ ашигладаг байж. 1937 оны их хэлмэгдүүлэлтийн үеэр До яамны ногоон малгайтанууд Хөвсгөлийн лам хуварга, ноён баяд, ард иргэдийг олноор нь хядсан байдаг. Чухам тэр үед Хөвсгөлийн тайгад нэг зэрлэг хүн бусдыг олноор нь алж устгаад байгаа мэдээ До яамныханд иржээ. Тэрхүү зэрлэг этгээдийг устгахаар До яамнаас дөрвөн мэргэн буудагчийг илгээсэн гэх бөгөөд тэд бүрий болсон хойно Ренчинлхүмбэ хайрханд хүрчээ. Гэтэл тайгын хавцалаас хөх гал маналзаад явчихаж. Мэргэн буудагчид тэр зүг рүү гал нээтэл мөнөөх гал улалзахаа больжээ. Тэнд ямар ч гэсэн хүн байгаа нь ойлгомжтой болсон тул мэргэн буудагчид нэгийгээ үлдээгээд, гурав нь тэр зүг рүү явцгаажээ. Гэвч тэднийг хавцалын ирмэгт дөнгөж очтол гэнэт хөх гал маналзаж байсаар тэнгэрээс цахилгаан цахиад бүгдийг нь аянга ниргэж орхисон гэдэг. Энэ нь мөн л Тахь зайрангийн хийсэн үйлдэл байсан бололтой. Энэ явдлаас хойш хэдэн сарын дараа До яамны зэвсэглэсэн хэдэн ногоон малгайт “Буутай цэргүүдийг маань аянга буулгаад хөнөөчихдөг тийм ид шид гэж юу байсан юм бэ. Энэ бол

шашны мунхруулга” гэж онолдоод Тахь зайранг барьж устгахаар Хөвсгөл аймгийг зорьсон байна. Тэд Ренчинлхүмбэ суманд очуугаа л Тахь зайранг сураглаж, улмаар нутгийн цаатан ардуудыг баривчлаад “Зайрантан хаана байгааг хэлж өг” гээд эрүү шүүлт тулгаж эхэлжээ. Харин энэ үед Тахь зайран өөрөөс нь болж гэмгүй иргэд До яамныханы гарт тарчилж байгааг мэдчихээд нэг үдэш ногоон малгайтануудыг тайгын хавцалд бусдыг яргалж байхад нь шууд яваад очсон байна. Гэхдээ тэр зүгээр нэг очсонгүй. Нэгэн том биетэй цаа уначихсан, тэгсэн хэрнээ толгой байхгүй, нэг гартаа савар, нөгөө гартаа толгойгоо барьчихсан цаатануудын урцанд тулж очжээ. Үүнийг хараад ногоон малгайтануудын зүрх амаараа гарах шахсан гэдэг. Тэд айсанаасаа болоод зэрэг зэрэг гал нээж, мөнөөх цаа унасан толгойгүй хүн ойн чөлөө рүү ухасхийжээ. Ногоон малгайтанууд хойноос нь өчнөөн буу тавьсан ч оногдсонгүй. Төдөлгүй тэнгэрээс цахилгаан цахилаад явчихаж. Энэ нь аянга буух дохио байсан бөгөөд өмнө нь гурван мэргэн буудагч аянганд цохиулаад үхчихсэн болохоор ногоон малгайтанууд “Бидэнд аянгын дохио өгөөд байх шиг байна. Эндээс бушуухан холдъё” гээд машинаа асаагаад давхиж одсон гэдэг. Хожим Тахь зайран “Тэр үед би шууд аянга буулгаж болохоор байлаа. Даанч тэр цэргийн хүмүүстэй цуг энгийн номхон цаатангууд амь үрэгдчих гээд байсан юм. Тэгээд л би дохио өгч сануулсан юм даа” гэж хуучилж байсан гэдэг. Хөвсгөл нутгийн шилийн сайн эр “Сунагар” Цэсрэн гэдэг хүний нэр өмнө нь бас сонсогдож байлаа. Хөвсгөлийн зарим иргэд “Сунагар” Цэсрэн, Тахь зайран хоёрыг нэг хүн хэмээн барим тавим нотолдог ажээ. Нээрээ ч энэ хоёр хүний амьдарч асан нутаг орон, цаг хугацаа яг тохирдог бөгөөд Тахь зайранд зарим үед нэрээ өөрчлөөд өөр хүний дүрд хувирах шаардлага тулгардаг байсан бололтой. Ингэснээр ч зарим ажлыг сүрхий бүтээдэг байж. Дан ганц бөө зайрангаар яваад байх нь түүнд бас хангалттай санагдсангүй. Дээхэн үеийн Дарьгангын шилийн эрчүүдийг төр засаг малын хулгайчийн дүрд хувиргаад тагнуулын хэрэгт ашигладаг байсан гэдэгтэй л утга нэг юм. 1930-аад оны үед Хөвсгөл аймгийн Дотоодыг хамгаалах хэлтэст Будын Цэнд-Аюуш гэж айхтар харгис этгээд байжээ. Тэрбээр хэлмэгдэгсэдийг байцаахдаа “Миний гарт сайн эр гурав хоног нухлуулдаг юм. Дунд зэргийн эр хоёр хоног, жирийн эр ганц хоног нухлуулдаг. Тэгэхээр чамайг ямар эр болохыг чинь үзнэ ээ” гээд яргалж эхэлдэг байж. Тэгээд ганц хоногийн дотор буулгаж авахаар янз бүрээр тамлах бөгөөд үүнд Манжийн үеийн есөн эрүүнээс ч хэрэглэдэг байжээ. Тухайлбал тус нутгийн “Саарал” Гомбо гэгч залуухан ламыг яргалахдаа эрхий хуруунаас нь дүүжлэн тоосго сугалсан байгаа юм. Гэвч Гомбо ганцхан тоосго сугалуулаад л хилс хэрэг хүлээж байсан гэдэг. “Мөн “Хувилгаан” Дүүвээ гэгч настай ламын хумс руу хулс шааж хилс хэрэг хүлээлгэсэн бөгөөд Дүүвээ лам түүний яргалалыг даалгүй гурав хоногийн дараа нас барсан гэдэг. Тухайн үед зөвхөн хэлмэгдэгсэд бус гэмт хэрэгтэнүүд ч Будын Цэнд-Аюушийн гараар орж хамаг хэргээ хүлээдэг байж. Нэг өдөр дээр өгүүлсэн Тахь зайран буюу “Сунагар” Цэсрэн Тувагаас адуу хөөсөн хэргээр цагдаа нарт баригдаад Хөвсгөл аймгийн цагдаагийн газарт хүргэгджээ. Гэхдээ тэр Будын Цэнд-Аюуштай зориуд уулзахын тулд албаар баригдсан байгаа юм. Учир нь тэр Будын Цэнд-Аюушийг эрийн цээнд хүрэх гэж ядаж явахад нь төрсөн ахтай нь цуг энд тэндээс адуу хөөдөг, нэг ёсондоо түүний эртний танил, дотны хүн нь байж л дээ. Тэрбээр баривчилж авчирсан хүмүүстээ “Би танай тэр том дарга Будын Цэнд-Аюуштай уулзмаар байна. Түүнтэй уулзаагүй цагт би та нарт юу ч ярихгүй” гэж адарчээ. Тиймээс тэд түүнийг арга буюу Цэнд-Аюушийн өрөөнд дагуулж орсон байна. Цэнд-Аюуш түүнийг хармагцаа “За Сунагар ах ямар хэргээр наашаа ирэв дээ” гэхэд Цэсрэн “Ийм л хэргээр ирлээ дээ” гээд ширээн дээр тавьсан нарийхан хулсыг шүүрч аваад өөрийнхөө хумс руу шааж орхижээ. Тэгээд тэр “Энэ чинь Манжийн үеийн эрүү шүүлтийн эхний даваа биз дээ. Дүү хүү нэг иймэрхүү л юм хийж суудаг болоо юу. Их юм сурч гийгүүлж дээ. Хүний

хумс руу хулс шаах тэгээд ямар байна. Сайхан байгаа биз дээ” гэхэд Цэнд-Аюуш “Сайхан муухайг нь ёстой мэдэхгүй юм. Танд ямар байна даа, өвдөж байна уу?” гэж асуужээ. Тэгтэл Цэсрэн “Арван тавны цагдаа нар миний хумс руу энэ хулсыг мөн ч олон удаа шаасан даа. Одоо бүр дасал болчихож. За дүү хүү ахынхаа эрхий хуруунаас дүүжлээдэх. Цагийн сайханд би долоон тоосго сугалуулдаг байсан юм. Гэвч чиний өрөөнд ердөө гуравхан тоосго байх чинь. Дүү хүү дахиад дөрвөн тоосго олоод ир” гэж шавдуулсан байна. Тэгтэл Цэнд-Аюуш эвгүй байдалд орж “Сунагар ах аа. Та одоо юу яриад байна аа. Би таныг яалаа гэж байцаах юм бэ. Таныг наад цагдаа нар чинь л байцаана биз. Би зөвхөн хувьсгалын эсрэг тэрсэлсэн хүмүүсийг л байцаадаг хүн. Хулгайч нартай зууралдаж чадахгүй. Та одоо яв” гэсэн байна. “Сунагар” Цэсрэн бүр ч омогшиж “Чи чинь хулгайч нарын хулхийг буулгадаг юм биш үү. Дүү хүү өөрт хамаагүй ажилд битгий оролцож бай. Тэгээд ч чи энэ нутагт төрж өссөн хүн. Нутгийнхаа номхон хүлцэнгүй хүмүүст хатуугаар ханддаг чамайг би хувьдаа өршөөхгүй. Яасан задарсан тархи вэ чи. Эцэг, эх хоёр чинь амьд байсан бол чамайг яах байсан бол. Энэ байдлаараа чи үхээд тамд очих биз. Одоо чи наад тоосгоо гаргаж хая. Би танай хувьсгалт засагт гомдол мэдүүлнэ. Танай засаг яагаад Манжийн үеийн эрүү шүүлт хэрэглэдэг билээ. Танай засаг чинь ардын засаг, энэрэнгүй засаг биз дээ” гэхэд Цэнд-Аюуш түүний өмнө сөгдөж “Сунагар ах аа. Та намайг өршөө. Та надад битгий л хараал хийж үзээрэй дээ. Энэ бол хувьсгалт засгийн шийдвэр биш, миний шийдвэр. Би дахиж ингэхгүй. Одоо энэ тоосгонуудыг гаргаж хаялаа. Ахын минь найз байсаны хувьд дүү хүүгээ өршөө. Би таныг хэргээс мулталж чадна шүү” гэх зэргээр гуйж царайчилсан байна. “Сунагар” Цэсрэн түүний үгийг үл тоож “Чи намайг хэргээс мултлах гэж үү. Чамтай чамгүй би хэргээ өөрөө аргалчихна. Тэгээд ч хүн чанараа барсан чиний нэг муу нохой тус надад өчүүхэн ч хэрэггүй. Намайг оролдсон хүмүүс өөрсдөө удахгүй баларч сүйрнэ” гэсэн гэдэг. Энэхүү сүрдүүлэг Будын Цэнд-Аюушд сүрхий цохилт болж төдөлгүй тэр өөрийн сайн дураар ажлаасаа халагдсан байна. Гэвч тэр До яамны хар дансанд хэдийнэ орсон тул 1939 онд баахан ногоон малгайтнуудын хамт Зөвлөлт рүү ачигдаж тэндээ цаазаар авахуулсан гэдэг. Харин “Сунагар” Цэсрэн цаашид хэрхсэн эсэх нь тодорхойгүй. Зарим хүн түүнийг адуу хөөсөн хэргээр арван жилийн ял авсан гэдэг бол зарим нь “Тахь зайран буюу “Сунагар” Цэсрэн 1960-аад оны үед Ю.Цэдэнбалын цаатангуудад барьж өгсөн цагаан байшинд суугаагаараа өөд болсон гэж ярьдаг аж. 1960-аад оны үед Цэдэнбал дарга Хөвсгөл аймгаар зорчихдоо тус аймгийн Ренчинлхүмбэ сумаар орж л дээ. Тэгээд цаатангууд гэж бүхэл бүтэн сумын хэмжээний зэрлэг хүмүүс ой модонд урц овоохойд амьдарч явдагийг мэдээд буцжээ. Төдөлгүй тэр Ренчинлхүмбэ суманд жижигхэн амины орон сууцны дан байшингууд бариулсан бөгөөд сумын удирдлагууд хөвч тайгаас цаатангуудыг урьж залах шахуу юм болцгоож байж энэхүү байруудад оруулсанаар тэдний зарим нь тохилог сайхан орон сууцанд тав тухтай амьдрах болсон байна. Энэ үед Тахь зайран буюу “Сунагар” Цэсрэн аль хэдийн томоожчихсон, бусдад хараал жатга хийхээ байгаад, мөн бусдын адуу малыг хөөхөө байгаад, ёстой л коммунист дэглэмийн засуулсан “хуц” болж хувирсан байж. Ер нь ч коммунист дэглэмийн суртал ухуулга ямар ч аавын хүүг ингэж л номхруулдаг байлаа шүү дээ. Эцэст нь өгүүлэхэд Тахь зайран, “Сунагар” Цэсрэн гэдэг нь нэг хүн үү, хоёр хүн үү гэдгийг хэн ч үл мэднэ. Эсвэл нутгийн нь зарим хүн хэн хэнийг нь нэрд гаргах гээд хоёр хүнийг нэг болгож “хүч” оруулсан ч байж мэдэх юм.

## Тувагийн баячуудын шүдний өвчин болж явсан “Чотонгийн Арьяа

Чорос овогт Чотонгийн Арьяа нь аргын тооллын 1912 он буюу 17-р жарны “Усан хулгана” хэмээх жилийн хаврын тэргүүн сарын эхэнд Дөрвөд далай хааны Раа гүний хошууны “Харганат хэрэм” хэмээх газар ядуу тайж Чотонгийн нэгдүгээр хүү болон мэндэлжээ. Тэрбээр 2010 онд хэвлэгдсэн “Ар халхын шилийн сайн эрчүүд” номонд бичигдэж байлаа. Түүний тухай дээрхи номонд бичигдэлгүй орхигдсон зарим нэг домог түүхийг Увс аймгийн харьяат Цэвээний Доржсүрэн хэмээх эр хүүрнэсэн юм.

Чотонгийн Арьяа хэмээх Увс нутгийн нэгэн сайн эр 1980-аад оныг хүртэл нутгийн олондоо “Гайхал” гэж хүндлэгдэн сайн сайхан амьдарч байгаад таалал төгсч билээ. Түүний үр сад өнөөдөр Говь-Алтай, Увс аймгуудад энх тунх амьдарч байна. Баруун аймгийн зон олон туйлын ядуу зүдүү амьдарч байсан гучаад оны үед эрийн цээнд хүрсэн Арьяа гэр бүлээ бүү хэл хажуу хавийн айл амьтанаа тэжээдэг байсан тухай олны ярихыг хэд хэдэн удаа сонссон. Тэрбээр морь гайхалтай сайн бугуйлддаг, моринд эрэмгий нэгэн байж. “Би ч залуудаа бугуйл хоосон газар бараг тавиагүй дээ. Сартай шөнө морьдыг бугуйлдан барих нь мөн ч сайхан даа” гэж ярьдаг байж. Тэрбээр өвлийн нэгэн хацар хайрам жавартай хүйтэн шөнө Тэс сумын харьяат “Хамар” Дондог гэгчийн хамт Тувагийн баян Жалбуу гэгчийн адуунаас аль тарганыг нь шилж барьж аваад нутгийн зүг хөөж явахдаа “Ээ баларсан юм боллоо. Эдгээр морьдыг хоёулаа Тэсийн хэдэн ядуу айлд тарааж өгчихөөд мөрөө хөөе” гэж байсан гэдэг. “Гайхал” Арьяа нь дандаа Тувагийн хилийг нэвтэрч тэдний баячуудын адуунаас нь шилж сонгон бөөн адуу хөөж Увсын нутагт оруулан ядуу зүдүү айлуудаар тараан явсаар “Гайхал” гэдэг хочтой болсон гэдэг. Ер нь тэрбээр нэг үе Тувагийн баячуудын шүдний өвчин болж явсан байдаг. Дээхэн үед намайг бага байхад нутгийн маань хөгшчүүл “Хорь, гучаад оны үед Увс аймгийн Наранбулаг сумын гурван хүний нэг нь лам, харин Тэс сумын гурван хүний нэг нь зард гарсан шилийн хулгайч байсан” гэж ярьдаг байлаа. Энэ нь ч бараг үнэн юм билээ. Чотонгийн Арьяа нь тэр шилийн хулгайч нарынх нь нэг. Тэр үнэхээр дуунд хүртэл дуулагдаж, буунд хүртэл онилогдож явсан цуутай эр байж. Гэгээнтэнд мөргөж, гэрт хонохгүй явсан үед нь “Арав хориод адуу үзэв үү, артелийн гуталтай Арьяа харагдав уу?” гэж малаа алдсан хүн сураг гаргадаг байсан гэдэг. Арьяа нэг удаа Данзан хэмээх баян ламын гурван азарга адууг хөөж оджээ. Адууг нь хулгай авсныг дуулаад Данзан ламтан “Хулгайч хол байна. Тэсийн голын хажууд ойртоод ирэхээр нь очиж уулзана даа” гэж адуучиндаа хэлжээ. Адуучин эр “Өндөр настай ламтан зуу гаруй км-ийн цаана байгаа Тэсийн голыг яаж хүрэх юм бол доо. Сайн хулгайч зарлаж байгаад хулгай хийдэг гэдэг. Шилийн сайн эр Арьяа “Наранбулагийн лам нарт ноостой нохой ч үлдээхгүй” гэж ярьж явсан гэдэг. Тэрийгээ л гүйцэтгэж явна даа” гэж ойр тойрныхондоо хүүрнэжээ. Хэд хоногийн дараа Данзан лам адуучинаа дуудаж жил нас, мэргэ төөргийг нь үзээд “Чи сум атгах болох нь дээ” хэмээжээ. Тухайн нутгийн лам нарын хулгайчийг барих нэгэн уншлага ёс нь “Сум гүйлгэх” хэмээх зан үйл байж. Сум атгадаг хүн нь өөрийн бодол санаагүйгээр номын тааллыг хүлээж түүний хүчийг дагадаг юмсанж. Жирийн хүмүүсийн яриагаар бол нэг бодлын гажигтай хүмүүс л сум атгадаг ажээ. Адуучин эр ч энэ мэтийг өмнө нь мэдэх болохоор Данзан ламтанд мөргөж “Эхнэр маань хариугүй амаржих болчихоод байна. Би сум атгамааргүй байна” гээд л уйлан дуулсан байна. Данзан лам түүнийг нэг том хараад “Би чамайг юу гэж элий балай амьтан болгох юм бэ. Чи битгий ай” гэж зоригжуулжээ. Үнэндээ шилийн сайн эр “Гайхал” Арьяагийн гэрт мань адуучинаас

өөр сум атган очих зориг зүрхтэй хүн Данзан ламын ойр хавьд байсангүй. Ингээд шөнө болмогц Данзан лам адуучин эрийг хажуудаа суулган гарт нь сум буюу хонхны очир атгуулаад өөрөө ном гүрэм уншаад суучихаж. Ламтаны дуу улам чангарч ирэхэд сум атгасан эр дагжтал чичирч, амнаас нь цагаан хөөс сахраад иржээ. Данзан лам сүүлийн шад номоо хүнгэнүүлэн дуусгатал мөнөөх сум атгасан эр үсрэн босч зуухан дээгүүр харайж гараад уян дээр байсан мориндоо мордон баруун хойд зүгийг чиглээд давхиж одсон байна. Энэ үед Данзан лам магнайнхаа хөлсийг арчингаа “Үүр цайхын алдад миний адууны сураг гарна” гэж амандаа гүвтнэж байжээ. Тэс, Наранбулаг сумын хооронд хоёр зуу гаруй км зайтай бөгөөд адуучин эр тэр замыг мориор гурав дөрөвхөн цаг туулсан байгаа юм. Бартаа ихтэй, хөтөлгөө мориор гарсан хүн хоёр хонох газар гэдэг. Тэр шөнө шилийн эр Арьяа Тувагийн нутгаас адуу хөөгөөд дөнгөж гэртээ ирээд байж. Тэгээд үүр цүүрээр жаахан зүүрмэглэх аядаад байж байтал том улаан нүдтэй хүн тотгоор нь шагайгаад “Адууг минь өг. Эсвэл хүүг чинь авна” гэж шивэгнэжээ. Гэвч угийн шашин шүтдэггүй, айх гээчийг мэддэггүй Арьяа тачигнатал хөхрөөд “Танай хэдэн адуу тамд байгаа. Өөрөө очоод авахгүй юу” гэж хэлээд унтаад өгчээ. Гэвч өглөө нь түүнийг сэрэхэд эхнэр нь зургаан сартай хүүхдийнхээ хөрсөн биеийг тэврээд уйлаад сууж байсан гэдэг. Ингэж Арьяа нэг удаа айхтар чадуулсан гэдэг юм. Гэсэн ч үлэмжийн бөх зүрхтэй тэрбээр хэнд ч бууж өгдөггүй шазруун нэгэн байсан бөгөөд айхавтар хараал хийсэн Данзан ламд хүртэл бууж өгсөнгүй. Дээрхи явдлаас хойш Арьяагийн гэрийн тотгоор мөнөөх том улаан нүд үүр шөнийн заагаар байнга шагайдаг болж. Тэгэвч Арьяа “Чаддаг юм бол намайг үхүүлэхгүй юу” гэж хэлээд унтаад өгдөг байж. Түүнээс хойш Арьяагийн эхнэр нь дахин хүүхэд гаргаагүй гэдэг. Ийнхүү баядын нэгэн цуутай хулгайчийн удам гурван азарга адуунаас болж тасарсан гэдэг билээ. Уг нь хонхны очир атгасан хүн хулгайчийг олоход хулгайч этгээд тэсэлгүй үнэнээ улайгаад уйлж дуулдаг юмсанж. Гэтэл мань Арьяа огт тоохгүй унтаад өгдөг байжээ. Тэрбээр тавин нас гараад ирмэгцээ тууврын мал дагадаг болсон байна. Хөвсгөлийн Ханх тосгонд малаа хүргэж тушаагаад буцахдаа,

“Шийр лам дагаж

Ширэг долоож явсаар

Шилбэ хүртэл бөөстөв” гээд замаасаа адуу хөөж өртөөлөх мэт давхисаар бусад тууварчдаасаа түрүүлээд нутагтаа оччихдог байж. Нэг удаа түүнийг тууврынхаа малыг тушаачихаад нутаг буцаж явтал нэг айлын уян дээр баахан морьд багшран харагджээ. Байдлыг ажиглавал гэрт бөө бөөлж байгаа маягтай байж. Бөө, удганд угийн дургүй, тэр дундаа ганц хүүгээ хараал жатгаас болж алдсан Арьяагийн уур гэнэт хүрч уян дээрхи бүх морьдын уяаг тайлж суллаад гэрт явж орсон байна. Өвдөж ядарсан нэгнийг ац модон дээр суулгаад бөө бөөлж эхлэхтэй тэр яг таарчээ. Бөө хамаг л шившлэгээ дуусгаад өмнөө тавьсан түмпэнтэй юмны бүтээлгийг авахад элдвийн өт хорхой язганалдаж байсан бөгөөд Арьяа үүнээс сэжиглээд бушуухан гарч мордон өмнө нь сул тавьсан морьдио хуу хаман хөөж оджээ. Хойноос нь хөөх морьтой хүн байсангүй. Гэвч Арьяаг нэгэн хөтөл даваад эргэж хартал наран доогуур ширтэх мэт онийсон нүдтэй, цав цагаан толгойтой их л сонин эмэгтэй хойноос нь хөөж явах нь тэр. Арьяаг ташуураа далайгаад эргэтэл тэр эмэгтэй “Толботой цагаан морийг үлдээчих. Бусдыг нь та аваарай” гэж хашгирчээ. Арьяа бас зовлон үзсэн хүний хувиар тэрхүү этгээд эмэгтэйн үгэнд орж уг морийг үлдээгээд бусдыг нь хөөж одсон гэдэг. Тэрбээр хол ойроос өч төчнөөн азарга адуу хөөж ирээд нутгийнхаа ядуу зүдүү хүмүүст тараагаад өгчихдөг, өөртөө ердөө хоёр

гуравхан сайн морь л авч үлддэг байж. Тиймээс нутгийнхан нь “Уг нь манай нутгийн хамгийн баян хүн бол шилийн сайн эр Арьяа шүү дээ. Даанч тэр өөртөө унагатай ганц гүү ч байхгүй. Тэгсэн хэрнээ түүний нэрний адуу манай нутагт азарга азаргаараа байдаг. Түүний өмч бол азарга адуу мэтхэн биш. Нутгийн ардууд тэр чигээрээ түүний өмч” гэж ярьдаг байсан гэдэг. Чотонгийн Арьяа дөч, тавиад оны үед Увсын хойд талын хилийн заставынханд мундашгүй тус хүргэдэг байсан тухай тэр үеийн хөгшчүүл өнөө ч дурсдаг юм. Нэг удаа хилийн заставын дарга Донров гэгч Арьяаг дуудан уулзаж “За чамд төрийн өмнөөс нэг даалгавар өгье. Энэ даалгаварыг биелүүлж чадвал чамайг бид зүгээр орхино. Тувагийн хилийн дээрэмчдийг хоёр хоногийн дотор барьж ир. Барьж чадахгүй бол чамайг барьж тушаана” гэж хэлжээ. Арьяа юу ч хэлэлгүй мордоод явчихаж. Тэгтэл нэг харанхуй шөнө Тувагийн дээрэмчид “Үүлийн толгой” гэдэг газрын бутан дунд амарцгаан хэвтэж байтал Арьяа сэмхэн тэдэнд ойртсоор дэргэд нь ирээд гэнэт довтлон гурван тува дээрэмчинийг яах ийхийн зуургүй барьж сайтар хүлээд тэнд нь орхиж оджээ. Нөгөө дээрэмчид хүлгэндээ тийчилж муухай орилсоор л үлдсэн гэдэг. Тэр шөнөдөө Арьяа давхисаар хилийн застав дээр ирж “Барихыг нь би барилаа. Янзлахыг нь та нар мэд. Үүлийн толгойн бутан дунд хэдэн бээвийсэн юм хэвтэж байгаа” гэж хэлээд морджээ. Хилийн цэргийнхэн түүний тусламжтайгаар ийнхүү Тувагийн хэдэн зартай дээрэмчнийг барьж авч байсан гэдэг. 1930-аад оны үед түүний Тувагаас хөөж ирсэн зээрд азаргатай, жороо хүрэн морьтой 400 шахам тооны адууны үр төлөөр Увс нутгийн Зүүнговь, Тэс сумдын адууны цус сайжирч олон арван хурдан хүлэг шинээр мэндэлсэн түүхтэй юм. Тиймээс өнөөгийн баруун аймгийн уяач нар шилийн сайн эр Чотонгийн Арьяагаар бахархаж явах ёстой. Харамсалтай нь тэд энэ хүний намтар түүхийг мэддэггүй. Намтар түүх байтугай овог, нэрийг нь ч мэддэггүй. “Гайхал” Арьяа өөрөө сайн уяач морь шинжээч байсан гэдэг. Увс нутагт дээхэн үед “Арьяа хурдан халтар” гэдэг гайхалтай хурдан хүлэг байсныг баруун аймгийн настайчууд өнөө ч дурсан ярьцгаадаг юм. 1961 онд Увс аймаг байгуулагдсаны 30 жилийн ойгоор нижгэр том наадам болсон бөгөөд уг наадмын их насны морьдын уралдаанд 250 морь 30 км-т уралдсан нь аймгийнхаа түүхэнд хамгийн томд тооцогдож үлдсэн. Энэ наадамд хурдан халтарыгаа уралдуулахаар авчирсан Арьяа гуай “Тэс сумын хурдан хүлгүүдийг шинжиж үзлээ. Түрүүлэх нь бүү хэл айрагдах морьд алга. Миний хурдан халтарын урд гишгэх ганцхан бөгтрөгтэй зээрд морь байна” гэсэн нь ёсоор болж Ховдын Сорогдогын зээрд түрүүлж, Арьяагийн халтар удаалж байсан түүхтэй билээ.

## Жараад оны “Хэлхээн” Чойжилсүрэн

Жараад оны үед “Хэлхээн” Чойжилсүрэн гэгч том биетэй, эртэй бяргай шилийн хулгайч Сэлэнгэ аймгийн нутагт нэг хэсэг нэрд гарчээ. Уг нь зайлуул эрт цагийн шилийн эрсийг дуурайгаад Тува, Буриадаас хазаар гүйлгэхээр андгай тангараг өргөсөн юм байх. Тэгээд залуу зандан насандаа нэг хэсэг Тува, Буриадын нутгаар хэрэн хэсчээ. Харин нас нь дөч хэвийгээд ирэх үед алс хол газар явахаасаа залхуураад хаяагаа хадарж эхэлсэн байгаа юм. Тэрбээр зөвхөн Сэлэнгэ аймгийн нутгаас гэхэд л 40 гаруй адуу хулгайлжээ. Түүнийг 1970 оноос хойш цагдан сэргийлэхийн эрлийн хэсгийнхэн бүтэн таван жил эрж хайсан байгаа юм. “Хэлхээн” Чойжилсүрэн цагдаа нараас зугтаж зайлахдаа мэргэжсэн нэгэн тул Сэлэнгэ, Төв аймгийн цагдаагийн хэлтэс дээрээс олон удаа зугтаж чадсан байна. Нэг удаа тэрбээр өөрийг нь байцааж байсан залуухан мөрдөн байцаагчийн мөрөн дээр алгадаад “Ах нь жорлонд бие засчихаад ирье. Гартаа гавтай, явган нүцгэн би хаа холдох билээ дээ” гэж хэлж гараад л захиргааны үүдэнд уяатай байсан бусдын мориноос шилж унаад оргочихож байсан гэдэг. Мөн нэг удаа тэрбээр хээр хөдөө машинтай цагдаа нарт яалт ч үгүй баригдчихжээ. Тэгээд шөнө нэг газар хоноглох болж. Хээр хөдөө явган нүцгэн түүнийг зугтаалаа гэхэд хойноос нь машинаар хөөгөөд л бариад авах байлаа. Тиймдээ ч цагдаа нар түүнийг нэг их сүрхий цагдаж манасангүй. Тэгтэл “Хэлхээн” Чойжилсүрэн шөнө дундын үед сэмхэн босоод машиных нь гал хамгаалагч буюу севченүүдийг суга татаж хармаалаад өмнө зүгийг чиглээд дуу аялаад алхчихсан гэдэг. Өглөө нь цагдаа нарыг сэртэл Чойжилсүрэн байдаггүй. “Аа тэр муу хулгайч хаа холдов гэж. Явган нүцгэн түүнийг одоохон бариад авна аа” гэж цагдаа нар аархаад машинаа асаагаад хөдлөх гэтэл машин нь ассангүй. Мань эр энэ мэтээр цагдаа нарын гараас хэд хэдэн удаа мултарч байжээ. Сүүлдээ шилийн хулгайч “Хэлхээн” Чойжилсүрэнг баривчлахын тулд тухайн үеийн Улсын мөрдөн байцаах газраас эрлийн хэсэг томилжээ. Нэг ёсондоо аймгийн эрлийн хэсгийнхэн түүнийг дийлэхээ байгаад Улсын мөрдөн байцаах газарт хандсан хэрэг. Эрлийн хэсгийнхэн түүнийг хаагуур явдаг, хэн хэнтэй нөхөрлөдөг талаар сар гаруй тандалт хийсэний үр дүнд овоо мэдээлэл цуглуулжээ. “Хэлхээн” Чойжилсүрэн ихэвчлэн хээрээр гэр хийх бөгөөд сард ганц хоёр удаа хот айлуудаар бууж тамхи тариатай залгадаг болохыг ч тогтоосон байна. Тэгээд л эрлийн хэсгийнхэн түүнийг уулнаас бууж ирэхийг дөхүүлж байгаад отолт хийж байсаар 1975 оны 3-р сарын 18 буюу эрчүүдийн баярын өдөр баривчилжээ. Гэхдээ тэр тийм амархан баригдчихсангүй. Уулнаас нэлээд зутарсан шинжтэй шөнөөр бууж ирээд нэг айлд хоноглосон ч цагдаа нар отоож байгааг мэдчихээд уян дээр байсан морио ч эмээлэлгүйгээр зайдан чигээр нь унаад модтой уул руу зугтсан байна. Харанхуй ой руу орсон түүнийг цагдаа нар барихад бэрх болжээ. Тиймээс эрлийн хэсгийн бүрэлдэхүүнд багтсан эрэлч нохой “Альма”-гаар мөрдүүлсэн байна. Харанхуй ой руу орсон “Альма” нохой төд удалгүй боргон хуцаж эрлийн хэсгийнхэнд дохио өгчээ. Тэднийг очвол “Альма” нохой “Хэлхээн” Чойжилсүрэнг модонд хэлхийтэл шахчихсан хуцаж байх нь тэр. Ингэж тэр цагдаагийнханы гарт сүүлчийн удаа баривчлагдсанаар үлдсэн насаа шоронд өнгөрөөх болсон бөгөөд хөвчийн хүрэн баавгай, араатан чоноос ч айлгүйгээр хээрээр гэр, хэцээр дэр хийж явсан шилийн эр мөртлөө эрхийн чинээ биетэй, эр хонгор дуутай нохой төдийхөнд ээрэгдсэн нь хачирхалтай. Үүнийг нутгийнхан нь “Цаст уулын цагаан барс цагаа болохоор шоргоолжинд бариулна” гэдэг үгтэй уялдуулан тайлбарласаар өнөө цагтай золгожээ.

## “Тайгын чоно” хочит Дүгэр бол шилийн сайн эр биш алуурчин

Дээхэн үед Хөвсгөл аймгаас “Ногоон” Жоондоон, Ролмаа баатар, “Дэлдэн” Мэнд, Баглааны Арилдий, “Данхар” Зундуй, “Өндөр” Цэрэнрааш нарын шилийн сайн эрчүүд тодрон гарсан байдаг. Харин 1960-аад оны үед Хөвсгөл нутагт “Аргай” Дэндэв хэмээх шилийн эр тодрон гарч хойд зүгийн тува, буриадуудыг нэг хэсэг бужигнуулсан гэдэг. Мөн 1980-аад оны үед “Тайгын чоно” хочит Дүгэр, “Хавх” Дорж, “Нударга” Гонгор нарын эрчүүд гарч иржээ. Энэ тухай наяд оны үед Хөвсгөл аймгийн цагдаагийн газарт ажиллаж байсан бэлтгэл хошууч Б.Цогтжаргал доорхи зүйлийг хүүрнэсэн юм.

...Өнөө цагийн хөвсгөлчүүд далаад оны шилийн эр “Уулын” Төмөр агсаныг их биширдэг. Харин жар, далаад оны үед тува, буриадуудын шүдний өвчин болж явсан “Аргай” Дэндэвийн тухай тэр бүр мэддэггүй. Арга ч үгүй юм. “Аргай” Дэндэв нь нэр, хочоо байнга сольж явдаг байж л дээ. Ер нь дээхэн үед нэр, хочоо байн байн сольж явдаг шилийн эр мэр сэр байсан байдаг. Энэ нь зарим тохиолдолд цагдаа энэ тэрээс нуугдаж бултахад хэрэг болдог байсан бололтой юм билээ. Олны дунд нэрд гарсан нэг л тогтсон нэрээрээ яваад байвал баригдаж хоригдох нь амархан, адаглаад л хаа нэгтээ адуу мал хөөсөн хэрэг гарлаа гэхэд юуны түрүүнд хардагдаж сэрдэгдээд эхэлнэ шүү дээ. Тиймээс “Аргай” Дэндэв нь төрсөн нутгаасаа өөр газарт нэрээ дандаа худлаа хэлж явдаг байсан байгаа юм. Тийм учраас хөвсгөлчүүдийн дунд нэг их нэрд гараагүй. Тува, Буриадаас сэмхэн хазаар гүйлгэчихээд л тэрүүхэн тэндээ нам жимхэн байдаг байж. Харин наяд оны үед Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ренчинлхүмбэ сумдад нэрд гарсан “Тайгын чоно” хочит Дүгэр гэгчийг манай нутгийн зарим хүн шилийн сайн эр байсан гэж дүгнээд байдаг. Энэ Дүгэр бол шилийн сайн эр биш алуурчин этгээд, шоронгоос оргосон оргодол байсан юм. “Тайгын чоно” хочит Дүгэр нь 1970 онд хамтарч хэрэг үйлдсэн нөхрийнхөө амь насыг зэрлэгээр хороож Хөвсгөл аймгийн шүүхээс 15 жилийн хорих ялаар шийтгэгдсэн байдаг. Тэгээд шоронд ердөө ганцхан жил болоод л оргож босоод Хөвсгөлийн тайгад гарчихгүй юу. Манайхан нэг зүйлийг буруу ойлгоод байдаг. Шоронгоос оргоод тайгад бүгсэн болгоныг л шилийн сайн эр гэж дүгнээд байдаг. “Уулын” Төмөрийн хувьд бол түүнийг шилийн эр гэж дүгнэж болно. Харин “Тайгын чоно” Дүгэрийн хувьд бол байдаг л нэг алуурчин, дээрэмчин. Би бас энэ тухай Ренчинлхүмбийн нэг нөхөртэй маргалдаж л байлаа. “Манай Ренчинлхүмбээс “Тайгын чоно” Дүгэр гэдэг агуу шилийн эр тодорсон” гэж ирээд л сүржигнэхээр нь би “Үхсэн хойно оо. Наад хулгайч чинь “Уулын” Төмөрийн хажууд хэн юм бэ. Тайгад бүгэж байхдаа хаанаас, хэний адууг хөөсөн юм бэ. Танай нутгийнханыг л баахан дарамталсан байх даа. Шилийн сайн эр гэдэг чинь ийм байдаггүй юм. Чиний магтаад байгаа Дүгэр чинь хүн алж хүрээ талсан нэг муу дээрэмчин шүү дээ” гэж хэлээд амыг нь таглаж билээ. Үнэн юм чинь. Яахав Дүгэрийн хувьд тайгад есөн жил бүгэхдээ цагдаа нарын олон удаагийн отолтонд орж байсан ч ганц ч удаа баригдалгүй эрийн сайнаар мултарч байсан хэд хэдэн аятайхан түүх байдаг л юм. Амь өрсөн арав шахам удаагийн бүслэлтээс гарч байсан гэдэг. Өндөр хясаан дээрээс морьтойгоо ус руу үсэрчихдэг, битүү хөвч тайгаар яг л чоно шиг дүүлдэг гэх мэтийн домог шиг юм яригддаг юм. Тэгээд л “Тайгын чоно” гэж дуудуулдаг болж. Цаатан айлуудаар ороод гарахдаа “Социалист төрийн цагдаа нар намайг барьж чадахгүй. Эд нарт нохойн гүйдэл байдаг бол надад чонын гүйдэл бий. Нохой хэзээ ч чоныг гүйцэж байсан түүх байхгүй” гэж аархдаг байсан гэдэг. Бас “Хавх” Дорж, “Нударга” Гонгор гэсэн хоёр дагуултай. Тэд нар нь мөн л шоронгоос оргосон хулгайч нар.



“Хавх” Дорж нь хүргэн ахынхаа толгойг сүхээр цавчсан хэрэгтэй. Энэ нөхөр чинь яагаав нөгөө наяд оны үед Мааньтын шоронгоос бүлэглэн оргосон Чойрогийн Дүгэрээ тэргүүтэй есөн оргодолын нэг шүү дээ. Энэ есөн оргодолын нэг нь эрлийнхэнд буудуулж үхсэн, нэг нь тайгад гарчихсан, бусад нь баригдсан байдаг. Тайгад гарчихсан хулгайч нь “Хавх” Дорж. Бусдыгаа бодвол их зальтай сэргэлэн нөхөр байсан байгаа юм. Алдарт Чойрогийн Дүгэрээ хүртэл түүний арга залиг барж иддэггүй байсан тухай ярицлага өгсөн байдаг. Тиймдээ ч тэр есөн оргодолоос ганцаараа баригдалгүй үлдсэн болов уу. Бас өөрийн гэсэн онцлог чанартай. Модон дотор биеэ далдлах дуртай, яах ийхийн завдалгүй газар ухаад өөрийгөө далдалчихдаг, тэр ч байтугай хүй нэгдлийн үеийнхэн шиг түүхий мах идчихдэг байсан байгаа юм. Бас хутга шидэхдээ гарамгай. Тиймээс Хөвсгөлийн цагдаа нар түүн рүү ойртож чаддаггүй байсан гэдэг юм. “Намайг баривчлах гэсэн хэнийг ч би шууд алж орхино” гэж аархдаг байсан ч энгийн номхон цаатан иргэдэд бол ямар ч аюул учруулахгүй. Тиймээс зарим цаатан түүнийг шилийн эр гэж хүндэлдэг байсан байгаа юм. “Нударга” Гонгор нь бас л үл бүтэх хулгайч. 1970-1980 оны хооронд Хөвсгөл аймгийн шүүхээр гурван удаа шийтгүүлсэн байдаг. Тэгээд 1980 онд Зүүнхараагийн чанга дэглэмтэй шоронгоос бүрэн зэвсэгтэй оргож босоод “Тайгын чоно” Дүгэр, “Хавх” Дорж хоёртой нийлчихгүй юу. Цагдаа нарын тодорхойлсоноор бол “Нударга” Гонгор нь мөрөө баллахдаа мэргэшсэн, тайгад тов хийсэн урц овоохойтой, чоно болж улихдаа гарамгай, архинд дуртай, эмэгтэй хүнийг их хүсдэг, хүнтэй нийлэх дургүй, маш аюултай этгээд байсан. Ийм гурван аюултай хулгайч Хөвсгөл аймгийн цаатан иргэдийн уугуул нутаг Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Ренчинлхүмбэ сумдын нутгаар орогнож нэг хэсэг бужигнуулсан юм. Сүүлдээ бүрэн зэвсэглэсэн эд нарыг Хөвсгөлийн ар талын сумдын цагдаа нар хүчрэхээ байснаар аймагтаа нэр хүндтэй төлөөлөгч Барням номхотгож байсан түүхтэй. Барням бол авхаалжтай, зоригтой жинхэнэ төлөөлөгч байсан. Манайхан түүгээр бахархсаар ирсэн. Миний хувьд гэвэл Барням төлөөлөгчийн хажууд орой гарч, дорой төрсөн цагдаа. “Тайгын чоно” Дүгэр нэг өдөр жар, далаад оны үед Хөвсгөл нутагт нэр хүндтэй явсан шилийн эр “Аргай” Дэндэвтэй уулзах сонирхолтой байгаагаа хүнээр хэлүүлсэн гэдэг. Амьхандаа нутаг орондоо хүндлэгдсэн шилийн эртэй нөхөрлөж нэр сүрийг нь ашиглах гэж л дээ. Яг тэр үед Хөвсгөл даяар нэрд гарсан “Уулын” Төмөр шоронд хоригдож байсан үе. Тиймээс тэд “Аргай” Дэндэвийг сонгож авсан хэрэг. Дэндэв энэ гурван аюултай хулгайчтай зориуд очиж уулзсан байгаа юм. Тэгээд намтар түүх, адал явдал, өдүүлсэн хэрэг зэргийг нь сонссоны дараа “Та нарын шоронгоос оргож босох бол яахав ээ. Эр хүний л хийдэг ажил. Уул тайгад бүгэж байгаа чинь бас л эр хүний хийдэг ажил. Үүнийг сайн эрийн явдал ч гэж хэлж болно. Харин та нарын хүний аминд хүрсэн явдал чинь надад ер таалагдахгүй байна. Шилийн сайн эр бол барагтай бол хүн алдаггүй юм. Тэр дундаа найз нөхөд, ах дүүсээ алж хяддаггүй юм. Нас ахиж яваа би алуурчин хүмүүст хэл ул болж чадахгүй. Гэхдээ та нарт саад хийхгүй. Надтай надгүй та нар буянаараа бол” гэж хэлсэн гэдэг. Цаадуул нь ч ёстой л буянаараа болсон байдаг. Гэхдээ тэр буян нь хар бараан өнгөтэй. Тэдний гэмт үйлдэлд саад хийж чадсан чекист Барнямыг наяд оны хөвсгөлчүүд сайн мэдэх учиртай. Жаахан хүүхдүүд хүртэл байлдаж тоглохдоо “Би Барням болно, чи дээрэмчин бол” гэдэг байсныг бодоход “Тайгын чоно” хочит Дүгэрийн хэрэг явдал Хөвсгөлд ихээхэн дуулиан болсон нь илт байгаа юм. Ерээд оны үед зарим цаатан отгийнхоны дунд “Хөвсгөлийн тайгад Барням чекистийн хөшөөг босгоно” гэсэн яриа гарч байсан ч “Тайгын чоно” Дүгэр, “Хавх” Дорж, “Нударга” Гонгор нарыг шилийн эр гээд итгэчихсэн хүмүүс үүнийг нам дарж байлаа. Тэгээд ч хүмүүс цагдаад ихэвчлэн дургүй байдаг шүү дээ. Харин орон нутгаасаа төрсөн шилийн эрчүүдэд бол их сайн байдаг. Энэ нь ерөөсөө монгол хүний төрөлхийн инстикт. Ямар

сайндаа л ерээд оны үед манай нутгийн хэсэг залуус “Бидний өвөг дээдэс цаг ямагт зовхи өөдөө явж ирсэн. Харин зах зээлийн энэ хүнд үед бидний амьдрал хэцүүдлээ. Юуны өмнө манай нутагт шилийн сайн эр, хурдан морь хоёр хэрэгтэй байна. Их Тогосынхоо голд Загдын хурдан алаг морь, “Уулын” Төмөр хоёрын толгойг авчирч онголон тахья” гэсэн уриалга гаргаж байлаа. Тэр үеийн залуучууд шилийн сайн эр гээчийг бас ч гэж хүндэлдэг байж. Одооны залуучууд бол хэрэг алга. Хэний хүчинд хэн болсоноо ч мэдэхгүй. Нутаг нугаасаа төрсөн шилийн эрчүүдийг хүндэлж бишрэхээ байг гэхэд эцэг эхийгээ хүндлэх хэрэгтэй ш дээ. Чекист Барням, “Тайгын чоно” Дүгэр нарын адал явдлын тухай манай нутгийн нэг зохиолч кино хийх юм яриад л байсан. Гэвч арваад жил боллоо, сураг алга. Гэхдээ яахав ээ, хөвсгөлчүүд бид бусад аймгийнханыг бодвол “Уулын Төмөр” гэдэг кинотой шүү. “Тайгын чоно” хочит Дүгэр ч гэсэн кино болчихоор адал явдалтай хүн. Чекист Барням түүнийг хоёр хамсаатных нь хамт баривчлахын тулд маш нарийн төлөвлөгөө боловсруулж байлаа. Тэгэхдээ цагдаа хувцас өмсөөд, ташаандаа буу зүүж сүржигнээгүй. Ердөө л жирийн нэг адуучны дүрд хувирсан. Тэгээд цаатан отгуудаар бууж мордож явахдаа Дүгэр нарын орогнодог газар, тэдэнтэй ямар хүмүүс холбоотой байдгийг тандаж судалсан байгаа юм. Тэр ч байтугай Ренчинлхүмбэ сумын “Дүүрэн нуур”, “Цахир боом” зэрэг газарт нутаглаж байсан айлуудаар бууж мордож явахдаа “Тайгын чоно” Дүгэрийн барааг олж харсан байдаг. Тэр үед Дүгэр цагдаа нараар өөрийгөө уучлуулах талын арга сэдэж, ухаандаа хил давж алдагдсан малын хулгайг илрүүлэхэд цагдаа нартай хамтарч ажиллах, Тувагийн зарим нэг зартай хулгайчийг тэдэнд барьж өгөх зэргээр тус дэм болох хүсэлт тавьж байсан гэдэг юм. Амьхандаа хөөрхий хаяагаа хадардаггүй гэх шилийн эрийн зарчмаар явах гэж л дээ. Чекист Барням яг үүн дээр нь дөрөөлсөн байдаг. Сүүлдээ тэр Дүгэрийн цагдаа нартай хамтарч ажиллах хүсэлт болон уучлал хүссэн өргөдөлийг дээш нь уламжилж өгөх “улаач”-ийн үүргийг гүйцэтгэх болж. Гэвч сүүлдээ долоо буудуулсан догширсон чоно Дүгэр Барнямыг цагдаагийн ажилтан болохыг мэдмэгцээ Улаан-Уул сумын Хөгийн голын эхэнд орогнож байсан газраасаа дүрвэж Тува руу гарахаар бэлтгэсэн байгаа юм. Тиймээс Барням түүнийг Тува руу алдахаасаа өмнө бушуухан барьж авахаар яаравчилж, энэ ажилдаа нутгийн зарим иргэдийн туслалцааг авч байлаа. Энэ тухай Дүгэр бас л мэдчихээд “Нударга” Гонгортоо хэлэхэд цаадах нь “Тэр муу шалдан цагдаа яадаг юм бэ. Бид бүрэн зэвсэгтэй. Гранат хүртэл байна шүү дээ. Ойртоод ирвэл гранат шидээд юу ч үгүй болтол нь дэлбэлээд хаячихна. Чамайг чинь овоо эр гэж бодсон чинь нэг муу шалдан цагдаагаас айдаг хариугүй амьтан байжээ” гэж дургүйг нь хүргэснээр мань хоёр барилцаж аваад баахан ноцолдсон байгаа юм. Ингээд хоорондоо эв түгжингүй болсоноор Дүгэр түүнээс салж Хөгийн голын айлуудыг бараадсан байдаг. Энэ үед төлөөлөгч Барням “Хуулийн энэрэнгүй чанар гэж байдаг юм. Чамд өршөөл үзүүлэх талаар Намын төв хороо хүртэл яригдаад байна. Тэгээд ч малын хулгайтай тэмцэхэд чиний туслалцаа улс эх оронд маш их хэрэгтэй байна. Чи тайгаас буугаад ир. Хоёулаа уулзаж сайн зөвлөлдөө” гэх мэтийн захидал бичээд Хөгийн голын нэг нөлөөтэй нөхрөөр Дүгэрт өгүүлсэн гэдэг. “Тайгын чоно” энэ захидлыг хүлээж авсан ч мөн л хаширлаад тайгадаа бүгэхээр шийдсэн байдаг. Тиймээс Барням төлөөлөгч “Нударга” Гонгорыг баривчлахаар яаравчилсан. Хэрвээ оргодолтой гэнэт тааралдаж гэмээнэ шууд буудах тушаалтай. Гэхдээ эхнийхээ сумаар шархдуулах, тэгээд бүр болохгүй бол устгах. Онц аюултай рецедивистүүдтэй ингэж харьцах дүрэмтэй байдаг юм. Төлөөлөгч Барням Хөвсгөлийн цагдаа нарын хамгийн шилдэг нь болох Дашцэрэнг дагуулаад намрын нэг өдөр тайга руу явж байлаа. Тэгэхдээ мань хоёр олон хоног бороо цасанд зутарч унаа малаа сүлдуулаад нутаг буцсан гэдэг ойлгоцыг нутгийн ардуудын дунд төрүүлсэн байдаг. Энэ нь тактикийн асуудал байсан. Ингэснээр тус тусдаа бүгэж байсан Дүгэр, Дорж,

Гонгор нарыг тайвшралд оруулах ёстой байлаа. Цаадуул нь ч үүнд итгээд хэд хоног тайгадаа амар жимэр бүгсэн байдаг юм. Хоёр төлөөлөгчийг унаа мал нь зутраад нутаг буцсан гэдэг яриаг сумын албан тушаалтанууд айлуудаар тарааж байлаа. Энэ цуу яриа оргодолуудыг тайгаас бууж ирэхэд их нэмэр болсон. Гонгор, Дүгэр, Дорж нар намрын хяруу унаад ирмэгц өвлийн бэлтгэл хийхээр заавал тайгаас бууж ирдэг байсан гэдэг. Ингээд хамгийн түрүүнд “Хавх” Дорж тайгаас буугаад ирж. Хэд хоногийн турш орсон хүйтэн бороо татарсаны дараа түүнийг Хөгийн голын айлуудаар орохоор өндөр цагаан морь унаад тайгаас бууж ирж байхыг Барням, Дашцэрэн хоёр алсаас харсан байдаг. Тэгээд шөнө болмогц юуны өмнө “Хавх” Доржийг явгалахаар шийдэж морийг нь нуучихаж. Хоноглож байгаа айлыг нь нэгэнт мэдсэн болохоор хоёр төлөөлөгч сэмхэн гэтэж явсаар дотроосоо түгжээтэй гэрийн хаалганы замган түгжээг мэргэжлийнхээ дагуу ядах юмгүй мултлаад дотогшоо ороход “Хавх” Дорж аль хэдийн хар авчихсан бололтой буугаа авч, хутгаа бүсэндээ хавчуулаад хөхүүртэй айрагны ард ороод нуугдчихсан байгаа юм. Хоёр төлөөлөгч үүнийг мэдсэнгүй. Харанхуйд мөлхөж очоод гэрийн хойморт унтаж байсан хүнийг дараад авч. Энэ хооронд зальтай сэргэлэн “Хавх” Дорж гараад зугтчихсан байгаа юм. Мааньтын шоронгийн есөн оргодолоос ганцаараа баригдалгүй үлдсэн, бас яах ийхийн завдалгүй газар ухаад өөрийгөө далдалчихдаг авьяастай сэргэлэн нөхөрт энэ зэргийн заль байлгүй яахав дээ. Түүнийг гарч зугтах чимээнээр Барням хойноос нь даган гарч “Зогс” гэж хашгираад хий буудсан ч Дорж зогсолгүй явсаар морин дээрээ хүрэх гэсэн ч явгарсанаа ойлгоод “Түй чөрт. Заяа нь орхисон шаар” гэж аймаар чанга хашгирсан гэдэг. Тэгээд ойролцоо идээшилж байсан морины чөдрийг яах ийхийн завдалгүй тайлаад мордтол Барням хажуухан талд нь ирчихсэн “Зогс” гээд дахиад хий буудахад догширсон хулгайч сая л нэг юм баригдсанаа ухаараад хоёр гараа гавлуулсан байгаа юм. Маргааш нь хоёр төлөөлөгч түүнийг төв рүү хүргэх замдаа элдэв арга хэрэглэж байгаад “Нударга” Гонгорын тухай мэдээлэл авч, улмаар түүний бас нэг хамсаатан цэргийн оргодол Догсом гэгчийг баривчилсан байдаг. Тэгээд Догсомоос Гонгорын байгаа газрыг мэдэж авмагцаа “Хавх” Доржийг бүдүүн мод тэврүүлэн гавлаж, амыг нь боож орхиод эрэлд мордсон ч Гонгор урцандаа байсангүй. Гэтэл мань хүн Бэлтэсийн голд нутагладаг нэг айлын 17 настай охины толгойг эргүүлж тайгад аваачаад жаргалаа эдэлж байсан байгаа юм. Битүү тайгаас түүнийг олох боломж үнэндээ байсангүй. Ингээд нэг хэсэг эрэл мухардаж, “Тайгын чоно”-ын ч сураг алдарсан байдаг. Цаатангууд түүнийг Тува руу гарчихсан гэж төлөөлөгч нарт итгүүлэх гэж оролдож байв. Гэтэл жилийн дараа Барням төлөөлөгчид Дүгэрээс нэг захидал ирдэг юм. Бас л нөгөө сэм уулзалдах, цагдаагийн ажилд туслах, Тувагийн зартай хулгайч нарыг барьж өгөх зэрэг үлгэр домог шиг юмаа бичсэн байдаг. Төлөөлөгч Барням энэ удаад манай цагдаа нараас Лхагваа гэдэг дажгүй цагдааг дагуулж явахаар болсон. Тэгээд “Тайгын чоно”-той болзсон ёсоороо “Дүүрэн нуур” гэдэг газарт очтол нөгөөдөх нь ирсэнгүй. Нэлээд хүлээж байгаад буцах гэтэл мань хоёрыг далдаас ажиглаж байсан Дүгэр тэнгэр өөд хий буудаж сорьж үзсэн байгаа юм. Барням ч зэвсэгтэй яваа гэдгээ мэдэгдэхийн тулд хариу буудаж дохио өгсөн гэдэг. Ингээд мань хоёр бие биенээ мэдэлцсэнээр яг л Америкийн ковбой нарын тухай кинонд гардаг шиг хоёр талаасаа ойртсоор гурав алхамын зайд тулж ирсэн байгаа юм. “Тайгын чоно” их л болгоомжилсон маягтай бууныхаа гохон дээр гараа аваачингаа “Ингэхэд та үнэн яриад байдаг хүн үү, худлаа яриад байдаг хүн үү. Миний ялыг хөнгөлж өгч чадах юмуу. Би хулгайч нарыг зааж өгнө. Гэхдээ тува мува гэж томрохгүй. Та нар л мэдэхгүй байгаа болохоос биш хойш нь адуу мал гаргадаг долоо найман цаатан байна. Ийм тийм нарийн ширийн юмаа мэдэхгүй байж мань мэтийн мөрөөрөө бүгэж байгаа юмнуудыг мөрдөж мөшгөөд хамаг цаг заваа барахыг яана. Ёстой дүүрчихсан амьтад. Би тайгад есөн жил бүгэж байна. Өөрийгөө

хангалттай шийтгэлээ. Одоо харин би та нарын ажилд тусалмаар байна. Та нар шиг ийм заяа нь орхисон цагдаатай байгаа болохоор Монголын хамаг мал хойшоо гараад дуусч байна. Олигтойхон ажиллахад яадаг байна аа” гэх зэргээр яг л цагдан сэргийлэх газрын том дарга шиг үүрэгдсэн гэдэг. Хариуд нь Барням “Яг одоо шийд хэлэх арга алга. Хоёр хоногийн дараа уулзаад нэг мөр хариу өгье” гэхэд Дүгэр дүрсхийтэл уурлаж ирсэнээ төдөлгүй тайвшраад “За яахав болж байна. Харин элдэв заль хэрэглэж намайг баривчлах гэвэл би шууд л тархинд чинь сум зооно шүү” гэж сүрдүүлээд яах ийхийн завдалгүй тайга руу ороод алга болчихсон гэдэг. Есөн жил тайгад амьдарсан болохоор хурд, хүч, хөдөлгөөн, сонор сэрэмж зэрэг нь дээд зэргээр хөгжчихсэн, хэрвээ буудалцлаа гэхэд алдаж буудахгүй, энэ ч утгаараа өөртөө хэт бардамнаад зэвсэг агссан төрийн төлөөлөгчөөс хүртэл айж эмээлгүйгээр уулзсан нь энэ. Хэрвээ түүнийг хүний амь насанд халдаагүй бол шилийн эр гэж бүрэн дүгнэж болохоор. Хойноос ч бас адуу мал хөөгөөд ирж байсан гэдэг л юм. “Та нар л мэдэхгүй болохоос биш хойш нь адуу мал гаргадаг долоо найман цаатан байна” гэж “Тайгын чоно”-ын сануулж хэлсэн нь аргагүй үнэн үг байсан. Нээрээ ч наяд оны үед халхын шоронд долоон цаатан морилж байсан түүхтэй. Хөвсгөл аймагт “Цаатангуудын хэрэг” хэмээх ланжгар том хэрэг дэгдэж халхын шоронгийн хоймрыг цаатан иргэд анх удаа эзэгнэж байлаа. Үүнээс өмнө нунж дорой цаатан иргэд шорон гянданд тэр бүр орж байсангүй. Хөвсгөл аймгийн дархад, цаатан иргэдийн уугуул нутаг болох Улаан-Уул, Баянзүрх сумаас 200 гаруй адуу хулгайлж улсын хил давуулсан хэрэг үйлдэгдээд хэргийн эзэн холбогдогч нь тогтоогдохгүй хоёр гурван жил болсон юм. Сүүлдээ энэ асуудал цагдаагийн байгууллагаас халиад НАХЯ-ны хэмжээнд яригдсан. Тэгээд мөн л нутаг орондоо туршлагажсан Барням төлөөлөгчийг энэ ажилд томилж, манай цагдаагийн хэсэг ч бас хамтраад оролцож байлаа. Төдөлгүй тэр Тува улсын хилийн ойролцоо нутагладаг уйгар, цаатан иргэдийн дотор гол ажлаа явуулахаар болж, Улаан-Уул сумын цаатан иргэн Дашзэвэг, Дашаа нарын зуслан, намаржааны газар, тэдгээрийн урцын буурь зэрэг газруудаас Орос улсад үйлдвэрлэсэн шинэ, хуучин янз бүрийн чихрийн цаас, тамхины хайрцаг, архины шил зэргийг илрүүлсэнээр энэ нь адууны хулгайч нарыг цаашид мөрдөхөд чухал хэрэглэгдэхүүн болсон юм. Сэжиг бүхий айлууд яг ийм зүйлүүдээр дайлж цайлж байсан төдийгүй орос винтов буу, оёдлын машин зэрэг эд зүйлс гэрт нь байлаа. Эдгээр айлууд улсын хил орчмоор тайгын гүнд нутагладаг сонирхолтой болох нь ч ажиглагдаж, төдөлгүй эдгээр айлуудаас улсын хил хууль бусаар давж зөрчдөг байж болох сэжигтэй байдлууд тогтоогдсон. Нөгөө талаар дээрхи иргэдийн садан төрлийн холбоотой хүмүүс Тувад амьдардаг, тэд нар нь байнга ирж очдог болох нь батлагдаж байлаа. Төдөлгүй сэжигтэн Дашзэвэг Тувагийн харьяат “Мухар” Дорж, Амдар, Жашвий, Совд гэх мэтийн хүмүүс хилээр хууль бусаар давж ирж удаа дараа адуу мал хулгайлдаг байсныг нь илчилсэн. Эдгээр гэмт этгээдүүд цаатан иргэдийнхээр бууж мордохдоо “Хэрвээ адууны хулгайн хэргийн талаар цагдаагийнханд ам ангайсан байвал ална шүү. Харин дуугүй суух юм бол та нарыг чихэр жимс, архи, тамхиар таслахгүй” гээд гоё ганган цаастай чихэр, сонин янзын ярликтай архи тамхи өгөөд явдаг байв. Дашзэвэг баривчлагдаад долоо хоносны дараа хил давуулсан адуугаа Тувагийн иргэн Дорж, Жашвий, Амбар нарт дамжуулдаг байсан тухай, мөн цаатан Гомбохүү, Мандах, Гоостой, Наянбат нарынхаар тува хүмүүс ирдэг байсан талаар мэдүүлсэн. Ингээд манайхан Гомбохүү, Мандах, Гоостой, Наянбат нарыг баривчилж Мөрөнгийн төвд авчирч мөрдөн байцаалтын ажиллагааг хоёр цэгт зэрэг хослуулан гүйцэтгэж байлаа. Үүний үр дүнд Дашзэвэг, Гомбохүү, Гоостой, Наянбат, Мандах, Дэлгэр, Баяраа нарын цаатан иргэд 100 гаруй адуу хулгайлж улсын хилээр давуулан тува иргэдэд дамжуулсан болох нь тогтоогдсон. Эд нараас гадна Тува улсын Кызыл районы Кунгуртук хамтралын нэр бүхий

найман иргэн Монгол улсын хилийг зөрчин орж ирж 100 гаруй адуу хулгайлсан болох нь тогтоогдсон. Үүнийг илрүүлэхэд Тува улсын дээд зөвлөлийн нарийн бичгийн дарга Сергей Хечекович, Кызыл районы цагдан сэргийлэхийн орлогч Саян, мөрдөн байцаах тасгийн дарга Михайлович нар ихээхэн дус тэм болсон байдаг. Ийм том хамтын хүчээр Тувагийн малын хулгайч “Мухар” Дорж, Жашвий, Амбар, Хөвсгөлийн цаатан Дашзэвэг, Гомбохүү, Гоостой, Наянбат, Мандах, Дэлгэр, Баяраа нарын томоохон бүлэг хулгайн хэрэг илэрч, Оросын шоронд гурван тува, Монголын шоронд долоон цаатан морилж байсан түүхтэй юм. Энэ хэргийг илрүүлэхэд “Тайгын чоно” Дүгэрээс илүүтэйгээр “Хавх” Доржийн мэдүүлэг их тус болсон гэдэг юм. За энэ ч яахав. Ярианаасаа баахан хадуурчихлаа. Төлөөлөгч Барням хоёр хоногийн дараа болзсон газраа очиход “Тайгын чоно” алсаас ажиглалт хийж байгаад уулзалгүй яваад өгсөн гэдэг. Тиймээс Барням “Тохиролцоё гэж итгэж байгаа бол тохиролцсон шиг тохиролцоно биз дээ. Төрийн өмнөөс явж байгаа бид олон удаа тоглоом шоглоом болж чадахгүй. Чиний хүрч очих газар бид хүрч очиж чадна шүү. Хариу” гэсэн бичиг үлдээгээд явсан гэдэг. Энэ явдлаас хойш хэд хоногийн дараа “Тайгын чоно” нутгийн хүмүүсээр дамжуулж нэг захиа илгээсэн байдаг. Тэр захиандаа “Уул тайгад арван жил бүгсэн хүний хэргийг цагаатгадаг гэдэг үнэн үү. Би ийм яриа хүнээс олж сонслоо. Хэрвээ үнэн бол би ганцхан жил бүгчихэд цагаадах юм байна. Тиймээс төлөөлөгч та надад энэ талын бичиж хэвлэсэн албан ёсны хууль байдаг бол авчирч үзүүл” гэсэн байж. Арван жил уул хаданд бүгсэн хүний хэргийг цайруулдаг гэсэн аман яриа байдаг ч ийм хууль байдаггүй. “Уулын” Төмөр яг үүнээс болж гэнэдэж баригдсан хүн шүү дээ. Энэ хүн бүтэн арван жил тайгад амьдраад намрын нэг өдөр тайгаасаа бууж “За, одоо л нэг эрх чөлөөтэй боллоо доо. Би хийсэн хэргээ ухаарч ойлгоод хэнд ч баригдалгүй арван жил оргох ганцхан зорилготой байсан. Энэ зорилгоо биелүүллээ. Одоо намайг төр засаг маань өршөөх байлгүй” гэж нутгийнхаа ардуудад хэлж байсан гэдэг. Гэтэл ийм хууль байдаггүй. Мань хүн гэнэдчихсэн. Дахиад шоронгийн хаалга татсан. Хэрвээ дээрхи аман ярианд итгээгүй бол мань хүн баригдахгүй байсаар байгаад л битүү тайгадаа насан эцэслэх байсан болов уу. “Тайгын чоно” бас ийм ярианд итгэж л байсан байгаа юм. Гэхдээ “Уулын” Төмөрийг бодвол аймаар хашир. Бичиж хэвлэсэн хууль байдаг эсэхийг нүдээрээ харахыг хүссэн. Даанч ийм хууль байхгүй болохоор Барням хад мөргөсөн байдаг. Гэсэн ч тэр Дүгэрийн орогнож байгаа газрыг олж тогтоогоод гэнэдүүлэн баривчлахаар шийдсэн. Энэ хооронд “Нударга” Гонгорын сураг гардаг юм. Мань эр нөгөө 17 настай охинтойгоо хамт Баянзүрх сумын “Азаргын нуруу” гэдэг газар нутаглаж байсан Жамба гэдэг айлд орогнож байгаа нь тогтоогдсон. Тэгээд Барням хэдэн цагдаагийн хамт нэг шөнө Жамбын гэрийг бүсэлж аваад түгжээтэй хаалгыг нь онгойлгох гэтэл өөдөөс нь юу юугүй буу тасхийгээд явчихсан байгаа юм. Төдөлгүй гэрийн хана шажигнаад явчихаж. Тэгсэн “Нударга” Гонгор гэрийн ханыг яах ийхийн завдалгүй өргөж гараад ойн чөлөө рүү зугтчихсан байгаа юм даа. Өмнө нь хоёр гурван ч удаа шоронгоос оргож босч байсан айхтар сүйхээтэй эр болохоор энэ зэргийн юмыг дор нь сэтгэсэн байгаа юм. Хожим харин төлөөлөгч Барням “Бид цагдаагийн сургууль төгсөөд л байдаг, мэргэшээд л байдаг. Гэвч “Тайгын чоно”, “Хавх”, “Нударга” нарын ухааныг барж идэхгүй л байгаа юм даа. Ухаандаа “Нударга” Гонгорыг гэрийн хана өргөөд зугтчих нь гэж зүүдлээ ч үгүй. “Хавх” Доржийг хөхүүртэй айрагны ард нуугдаж байгаад гарч зугтана гэдгийг төсөөлөөгүй. “Тайгын чоно” Дүгэрийг хуулийн заалт нэхэж шаардана гэдгийг бас л төсөөлөөгүй” гэж хуучилдаг байлаа. Гэсэн ч “Нударга”, “Тайгын чоно”, “Хавх” гурвыг гурвууланг нь ялан дийлж чадсан л хүн дээ. Гонгорыг гэрийн хана өргөөд ойн чөлөө рүү зугтахад нэг хүн хамт гараад хойноос нь гүйсэн байгаа юм. Гэтэл тэр нь нөгөө баригдашгүй өшөө авагч “Тайгын чоно” нь байж

байдаг байгаа. Тэгээд энэ нөхөр төлөөлөгч Барнямын суманд оногдон газар дээрээ нас барж, харин “Нударга” Гонгор тэр чигтээ зугтаагаад харанхуй ой руу уусан алга болсон байдаг. Энэ ёстой айхтар хулгайч. Ор мөргүй зугтсанаасаа хойш хоёр жилийн дараа баригдсан. Увс аймагт мөн л өөрийн ижил нэг оргодол босуултай нийлээд Тува руу гарах гэж байхад нь төлөөлөгч Барням хэдэн хүний хамт баривчилж байлаа. Тэр үед бид “Одоо цаад “Нударга” Гонгор чинь халхын шоронд очоод ямар дуулиан дэгдээх бол доо. Муусайн хянагч нарын үйлийг үзэх байх даа. Халхын шоронд ч ёстой нэр алдараа дуурсгана даа” гэж ярьдаг байлаа. Гэвч цуутай хүүхэн хуримгүй гэгчээр “Нударга” Гонгорын тухай хожим юу ч сонсогдоогүй. Үхсэн амьд нь ч мэдэгдэлгүй таг чиг болсон доо.

## Жа лам Дамбийжаагийн ивээлд багтсан “Тэмээний хулгайч” Архадын Дархай

Одоогоос зуугаад жилийн тэртээ Засагт хан аймгийн Баядын хошуу буюу өнөөгийн Увс аймгийн Хяргас сумын нутагт Архадын Дархай хэмээх шилийн сайн эр ид мандан бадарч байсан байна. Түүний тухай Увс нутгийн уугуул Ш.Нямсүрэн, Г.Бүрэнтөгс нарын ярьсаныг сийрүүлэе.

Архадын Дархай нь 1910-аад оны үед хол ойроос адуу хөөсөн хэргээр Ховд дахь Манжийн амбаны Заргачийн яаманд байсхийгээд л байцаагддаг, заримдаа Улиастайн шоронд хоригддог байж. Нэг удаа бүр Манжийн харгис есөн эрүүг ажралгүй даваад гарч байсан гэдэг. Мөн тэрбээр 20-р зууны эхэн үед Монголын баруун хязгаарт “Хоёр тэмээтэй бадарчин” хэмээн Монголын түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн Жа лам Дамбийжаатай ихэд дотно харилцаатай байсан бөгөөд тухайн үед Дамбийжаа өөрийгөө Манжийн эсрэг цогтой тэмцэгч Амарсанаагийн ач хүү гэж баруун монголчуудад итгүүлээд “Ойрадын хаант улс байгуулна” гэж нэг хэсэг бужигнуулсан байдаг. Дамбийжаа Монголд орж ирэхээсээ өмнө Өвөр Монгол, Түвд, Оросын нутгаар олон жил хэрэн хэсэхдээ бараг л шилийн эр аятай амь өрсөн тэмцэлдэж явсан болохоор өөрийнхөө үеийн Засагт ханы шилийн эрчүүдийг ихэд хүндэлж дээдлэн өөрийнхөө ивээлд багтаадаг байж. Түүний хүндлэлийг хүртэж, ивээлд нь багтаж явсан хүний нэг нь Архадын Дархай ажээ. Дамбийжаагийн тушаалаар нутаг орноос дуудагдаж ирдэг байсан жирийн иргэд бол түүний цэргүүд, харин цөөн тооны шилийн эрчүүд бол ховор чухаг “баатрууд” болоод явчих жишээтэй. Дамбийжаа хамгийн эдрээтэй чухал үйл хэргийг шилийн эрчүүдэд даалгадаг байсан бөгөөд Архадын Дархай ч түүний онц чухал даалгаварыг нэр төртэй биелүүлж байсан удаатай аж. Мөн Засагт ханы “Даалий” Намжил хэмээх шилийн эр Дамбийжаатай нэлээд дотно харьцаатай байсан гэдэг. Нэг удаа Даалий Намжил тамгын газрын тахаруудад баригдаж, Баатар вангийн хошууны нутагт орших “Нуур могойн шорон”-д хоригдоход түүний хүргэн ах Даншигийн шонхор “Мундаг” Довчин түүнийг эргэж очжээ. Тэгтэл Даалий Намжил “Ах та ажил төрлөө цалгардуулаад юунд наашаа ирэв. Надад санаа зовох хэрэггүй. Одоохон энэ айлуудаас айраг цэгээ олж уугаад эртхэн буц. Дүүд нь энэ Нуур могойн шорон юухан байхав. Дор нь цөм цохиод гараад явчихна” гэж хэлээд хэнгэнэтэл исгэрээд шорондоо буцаад орсон байна. Нээрээ ч хоёр хоногийн дараа Хасагт Хайрханы ар өвөр даяар “Даалий Намжил Нуур могойн шоронгийн хаалгыг цөм цохиод гараад явчихаж гэнэ ээ” гэх зэргээр шуугилдсан гэдэг. Нэг удаа баруун хязгаараас Жа лам Дамбийжанцан өөрийн бие төлөөлөгчөөр дамжуулан түүнийг дуудаж уулзаад “Хасгийн цоохор” гэж алдаршсан зартай хурдан хүлгийг надад хулгайлан авчирч өгнө үү гэж хүссэн байна. “Даалий” Намжил энэхүү үүргийг биелүүлэхийн тулд аргагүй л шилийн эрийнхээ зангарагийг харуулж буутай хасагуудад гурав дөрөв хоног хөөгдөн байж “Хасгийн цоохор” хэмээх алдартай хүлгийг Дамбийжаагийн гарт атгуулж байсан гэдэг. Тэрхүү “Хасгийн цоохор”-ыг Дамбийжаа Ховдын байлдаанд унаж, Хатанбаатар, Манлайбаатар нарын хамт Ховд хотыг манжуудаас чөлөөлж байсан түүхтэй аж. Үүн лүгээ Архадын Дархай ч бас Түвд, Шинжаан Уйгар луу хоёр гурван ч удаа явж Дамбийжаагийн онц чухал даалгаварыг биелүүлж байсан гэдэг. Харин 1921 онд Ардын хувьсгал ялан мандаж, улмаар Монголын баруун хязгаарт өөрийнхөө ноёрхолыг хэдийнэ тогтоогоод байсан Дамбийжааг Ардын намынхан устгаж үгүй хийснээр түүнтэй дотно харилцаатай байсан шилийн эрчүүд тус тусынхаа зам мөрийг хөөсөн байна. Архадын Дархайн нэг онцлог чанар гэвэл

Дамбийжааг эцэс болсоны дараа хол ойроос адуу хөөхөө больж, харин Дамбийжааг дуурайж байна уу гэлтэй байнга хоёр тэмээтэй бадарчилж явдаг болжээ. Гэвч үнэн хэрэгтээ бадарчлах биш, ерөөсөө л нөгөө шилийн эрийнхээ араншинг тавилгүй Өвөр Монгол болон говийн нутгаас тэмээ хулгайлдаг байсан байгаа юм. Тэмээ хулгайлахад хурц түргэн морьд хэрэггүй, ердөө л Дамбийжаа шиг хоёр тэмээ хөлөглөөд явж байхад л өнөөгийн хэллэгээр бол бүх юм “О кей” болчихдог байж л дээ. Тэгээд ч тухайн үед тэмээний хулгайг илрүүлнэ гэдэг тийм ч амар ажил биш байж. Хонь юмуу, үхэр, адууны хулгайн хэргийг илрүүлэхэд ажиллагаа багатай байдаг бол тэмээний хулгайн хэргийг илрүүлэх нь ихээхэн ярвигтай байдаг аж. Учир нь тэмээний хулгай ихэвчлэн дүн өвлийн тачигнасан хүйтнээр үйлдэгддэг болохоор хойноос нь эрэл сурал болоод явахад хэцүү, мөн хавар болж цас ханзраад ирмэгц тэмээний үс ноос хагдран унаж, өнгө зүс нь хувирдаг, үс нь биенээсээ хөндийрөөд эхлэхээр тэмээ богино хугацаанд маш амархан турдаг байна. Тэмээ ингэж турсан үед бөх нь янз бүрээр унаж, урьд байснаасаа танигдахын аргагүй өөрчлөгддөг аж. Тэмээний хулгайг илрүүлэхэд бас нэгэн бэрхшээлтэй зүйл гардаг нь худалдсан тэмээнүүдийг борлуулж зарсан юмуу сольсон хүн нь тэмээнийхээ өнгө зүсийг нэг өөрөөр хэлэхэд, худалдаж авсан этгээд нь бас нэг өөрөөр мэдүүлдэг байж. Ухаандаа зүүн аймгийнхан ердийн тэмээний зүсийг “Хүрэн аг” гэж байхад баруун аймгийнхан “Хар аг” гэх жишээтэй. Шилийн эр Архадын Дархай энэхүү онцлогийг маш сайн мэддэг байсан болохоор ихэвчлэн өвлийн цагаар тэмээ хулгайлдаг байж. Үүндээ жигтэйхэн дуртай, бараг л үндсэн ажил нь болчихсон байсан бөгөөд говийн нутгаас хорин тэмээ хөөж ирээд нутгийнхаа ардуудын идшинд өгчихөөд л өөрөө “Хоёр тэмээтэй бадарчин” гэж хэлүүлэх жишээтэй. Иймэрхүү байдлаар Архадын Дархай 1920-1950 он хүртэл гучин жилийн турш хэнд ч хал балгүйгээр “Тэмээ хөөсөн” байгаа юм. Уг нь шилийн эрчүүд адуу хөөдөг билээ. Харин мань хүн тэмээ хөөдөг байснаараа онцлогтой. 1950-иад оны үед тэрбээр наая орчим настай байсан бөгөөд ийм өндөр настай хирнээ дү өвлөөр хаа холын говь нутгаас тэмээ хөөгөөд байгааг гадарласан нутгийнхан нь “Манай Дархай ч аргагүй сайн эр юмаа. Хорь, гучин настангууд нь хойшоо урагшаа явахаасаа залхуураад, дөч, тавин настангууд нь дөмөгхөн эрийн шийр заахаасаа өнгөрөөд, жар, далан настангууд нь жалга довноосоо өндийж чадахгүй өмхийрөөд байхад харин наая настай Архадын Дархай л ясны сайн эр гэдгээ харуулах юм даа. Ийм бие сайтай, бэлчээр томтой хүн манай нутагт дахиж хэзээ ч төрөхгүй байх аа” гэж хуучилдаг байжээ. Нутгийн нь хүмүүс Архадын Дархайгаас “Та өвлийн тэсгим хүйтэнд хаа хол газар тэмээ унаад л хонуут өнжүүтээр шогшоод байх юм. Даарч хөрдөггүй юмуу” гэж асуухад “Ах нь Жа лам Дамбийжаагийн буянаар даардаггүй юмаа. Хориод оны хоёр тэмээтэй бадарчингийн арга барил тун нарийн шүү” гэдэг байж. Ижил мөрний хөвөөнд эхийн хэвлийгээс унасан Дамбийжаа эрийн цээнд хүрмэгцээ Орос, Монгол, Хятадын нутгийг хөндлөн гулд хэрэн хэсч бадарчлан явахдаа байнга хоёр тэмээ хөтөлж явдаг байсан нь цаанаа бас учиртай байжээ. Тэрбээр өвлийн тэсгим хүйтэнд болон салхи шуургатай зэврүүн шөнө хоёр тэмээгээ зөрүүлж хэвтүүлээд нэгнийх нь зогдорт хөлөө хийж, нөгөөгийнх нь зогдорт толгойгоо шургуулаад хачин сайхан дулаан хонодог байж л дээ. Дамбийжаатай дотно харилцаатай байсан Архадын Дархай чухам энэхүү нууцыг нь мэдээд авчихаж. Тэгээд л Ардын хувьсгал ялан мандсаны дараа өөрийгөө бусдад шилийн хулгайч гэдгийг мэдэгдүүлэхгүйн тулд хурц түргэн морьдоос татгалзаж “Хоёр тэмээтэй бадарчин”-гийн дүрд хувираад хол ойроос хорь гучин жил тэмээ хөөсөн байгаа юм.

Алтайн хязгаарын “Их гүзээт” Ширэндэв



Хөх сэрхийн нурууны нэгэн салбар уулсын эгц цавчим хадан хясаан дунд бүрмөсөн түгжигдэж хаагдсан нэгэн агуй байдаг тухай тавь, жараад оны Алтай нутгийн хөгшчүүд ярьдаг байж. Энэхүү агуй нь их сонин түүхтэй бөгөөд эрт цагт Саж бандид Намхайжамцын шавь Гунгаабалсанжамц хэмээх өвгөн даяанч лам сууж байсан, хожим харин Алтай нутгийн “Их гүзээт” Ширэндэв, “Ноцдог дэгээ”, “Тайшир тарлан бух” нарын шилийн эрчүүд үе дамжин орогнож байсан гэдэг. “Тунгалаг тамир” кинон дээр Итгэлт баян “Засагт ханы хөх харчууд хэцүү, хэцүү. “Ноцдог дэгээ”, “Тайшир тарлан бух” нарын айхтар эрчүүд байдаг л юм” гэж өгүүлдэг. Кинонд нэр нь дурдагддаг энэ хоёр сайн эр хориод оны үед Алтай нутагт нэг хэсэг нэрд гарчээ. Харин “Их гүзээт” Ширэндэв нь дөчөөд оны үед дээрхи агуйд толгой хоргодож байгаад тэндээ нас барсан юмсанж. Одоогоос жараад жилийн тэртээ нэрт зохиолч Ж.Лодойдамба агсан “Алтайд” романаа бичиж байхдаа энэхүү агуйн тухай нутгийн хөгшидөөс сонсоод алдарт шилийн сайр эр “Танган” Төгсийн нуугдан бүгэж байсан хадан гэрүүдийн нэг биш биз хэмээн очиж үзэхээр товлож байсан ч амжаагүй гэдэг юм. Хэрвээ бичгийн их хүмүүн Ч.Лодойдамба домог болсон тэрхүү агуйд амжиж очоод үзчихсэн бол эртний гэгээн хутагт лам нар байгалийн донжийг олж нээсэн ариун дагшин нэгэн газрын талаар яруухан хуудас Монголын утга зохиолын түүхэнд шаширлан үлдэх байсан биз ээ. Тэрхүү агуйг 1950-иад оны үед Алтайн ууланд геологи экспидецийн ажлаар явж байсан Оросын мэргэжилтэнүүд анх нээн олж удалгүй Говь-Алтай аймгийн Дотоод яамны үзэл суртал хариуцсан төлөөлөгчид хэд хэдэн удаа шалгаж үзээд сүүлдээ хүн ардын сэтгэл санаанд буруу бусармаг үзэл суулгаж мэдэх муу нөлөөтэй газар байна гээд уурхайн тэслэгчээр дэлбэлэн хэдэн арван тонн жинтэй том том бул чулуугаар дарж үүдийг нь нэгмөсөн түгжсэн байна. Буруу бусармаг үзэл гэдгийн учир нь эрт цагт даяанч лам нар сууж байсан, мөн уг агуйд Алтай нутагт нэг үе мандан бадарч явсан шилийн эр “Их гүзээт” Ширэндэвийн араг яс үлдэж хоцорсон зэрэг үг яриа их байсантай холбоотой болов уу. Энэхүү “Их гүзээт” гэгч нь бас хөөрхөн домог түүхтэй юмсанж. Тэрбээр 1910-аад оны үед Монголын баруун хязгаарт амьдарч байхдаа бүтэн хонины махыг нэг суурин дээр идчихдэгээрээ нутаг орондоо алдаршиж “Их гүзээт” гэдэг хочтой болжээ. Тэгтэл нэг өдөр Улиастай дахь Даашинхүүгийн салбар пүүсийн нэг зальтай луухаан “Их гүзээт”-ийг дуудаж уулзаад “За чи бүтэн хонины махыг нэг суурин дээр идчихдэг юм биз дээ. Хоёулаа мөрий тавина аа. Сарын дараа чи ходоод гэдсээ сайн сойж байгаад манайд хүрээд ир. Би чамд мундаг том эр хонь гаргаж өгье. Хэрвээ тэр хонины махыг идчихвэл би чамд бүх хөрөнгөө өгнө. Яагаад гэвэл надад хөрөнгөө өвлүүлэх үр хүүхэд гэж байх биш. Чиний л гүзээний чадал мэдэх хэрэг. Харин чи бүтэн хонины мах идэж чадахгүй бол бүх хөрөнгөө надад өг. Тохиролцох уу” хэмээжээ. “Их гүзээт” түүний саналыг уухайн тас зөвшөөрөөд “Луухаан чи мундаг том эр хонь гэв үү. Надад хонь л бол хонь. Том, жижиг нь хамаа байхгүй. Бяруу шиг том хонь байсан ч би идэж орхино. Сарын дараа би танайд өөрийнхөө хориод адуу, хоёр тугалтай үнээ, гучаад хонио туугаад ирье. Аз чинь таарвал луухаан чи эднийг аваад үлдэнэ биз. Харин миний аз таарвал би танайд малтай юутай хээтэйгээ эзэн сууна. Тэгээд эхнэр авна. Сарын дараа ерөөсөө би хамаг мал хуйгаа туугаад, гэрээ нүүлгээд ирье дээ” гэсэн байна. Тэр үед “Их гүзээт” хорь гаруйхан настай, эхнэр аваагүй, эцгийнхээ үлдээсэн хэдэн малыг адгуулж амьдардаг байж л дээ. Нээрээ ч сарын дараа “Их гүзээт” хамаг мал хуйгаа туугаад, гэрээ ачаалаад иржээ. Хажуудаа бас гэрч болох хүмүүсээ ч дагуулсан байж. Луухаан ч мөн гэрч болох хэдэн хятадыг гэртээ цуглуулсан байж. Луухааны хамаг хөрөнгөнд эзэн суухын тулд гурав хоногийн турш хэлэн дээрээ юу ч тавиагүй “Их гүзээт” дөнгөж ирүүтээ л “За алив хурдал. Тэр хонио бушуухан төхөөрөөдөх. Өлсч үхлээ” гээд л шавдуулж гарчээ.

Луухаан ч түүний нүдэн дээр мундаг том эр хонь төхөөрүүлээд чанаж гарсан байна. Төдөлгүй “Их гүзээт” модон тэвшин дээр битүү өрсөн хонины махнаас гүзээлж гарчээ. Гэвч тэр ердөө хонины нэг гуя, нэг хааг богтос чөмөгтэй нь идээд л нам зогсчихож. Идэх гэж хичнээн ам руугаа чихсэн ч хоолой руу нь орж өгсөнгүй. Өмнө нь нас бие гүйцсэн эр хонины махыг осолтгүй л ясыг нь үлдээгээд цөлмөж орхидог байсан “Их гүзээт” энэ удаад ёстой шалдаа буух нь тэр. Түүнийг дагалдаж ирсэн хүмүүс “Алив хөөе, чи чинь бүтэн хонины махыг торолгүйгээр залгиж орхидог биз дээ. Одоо тэгээд идэхгүй юугаа хүлээгээд байна аа” гэж шавдуулаад ч нэмэр болсонгүй. Ингээд тэр тууж ирсэн хамаг малаа мөрий тавьсан мөнөөх луухаанд үлдээгээд “Би өөрийгөө бүтэн хонины мах иддэг сайн эр гэж боддог байлаа. Гэвч би жинхэнэ сайн эр биш байж. Энэ цагаас хойш би энгийн хүний амьдралаар явахаа болилоо. Шилийн эр болж хадан агуйд амьдарна аа” гээд л мориндоо ташуур өгөөд алга болсон гэдэг. Ингэж тэр шилийн эрийн замд шуударсан бөгөөд чухам энэ үедээ л “Ноцдог дэгээ”, “Тайшир тарлан бух” нарын ахмад шилийн эрчүүдтэй дөрөө нийлсэн бололтой. Түүнийг яагаад чухам бүтэн хонины мах идэж чадаагүй талаар хамт явсан хүмүүс нь олон хоног толгойгоо гашилгасан гэдэг. Эхэндээ тэд мөнөөх луухааныг хараал жатга хийсэн болов уу гэж харддаг байж. Гэвч сүүлдээ бүх юмны учир тайлагджээ. Луухаан “Их Гүзээт”-эд идүүлэхээр бэлтгэсэн хониндоо бүтэн сарын турш элсэн чихэртэй ус уулгасан байгаа юм. Нэг ёсондоо элсэн чихрийн найрлага хонины маханд шингэчихэж. Гэхдээ амт нь чихэрлэг биш. Тийм болохоор “Их гүзээт” үүнийг нь мэдсэнгүй. Хэрвээ хонины махнаас чихэр амтагдаж байсан бол “Их гүзээт” уурлан босч ирээд “Луухаан чи намайг зальдахын тулд булхай хэрэглэсэн байна. Энэ чинь хаашаа янзын хонь вэ” гээд л өөрийнхөө тууж ирсэн хониноос нэгийг хагалж идэх байсан биз. Бүтэн сарын турш сахартай ус уусан хонины махыг хүн идэж чаддаггүй гэдгийг зальт луухаан эртнээс мэддэг байснаар Алтай нутгийн нэгэн сайн эрийн хамаг мал хуйг өөрийн болгосон түүхтэй аж. Харин хамаг малаа алдсан “Их гүзээт” Ширэндэвт шилийн эрийн замаар явахаас өөр арга байсангүй. Тэрбээр 1940-өөд он хүртэл хол ойроос адуу хөөх маягаар Хөх сэрхийн нууцлаг агуйд бүгэж байгаад тэндээ нас барсан гэдэг. Түүхэн сурвалжаас авч үзвэл Хөх сэрхийн нуруун дахь тэрхүү булагдаж дарагдсан агуй нь Цоросын Баатар хунтайж буюу Галдан Бошигтын эцэг Дөрвөн ойрадыг захиран Халхтай “44 түмний эвийн цааз бичиг” хэмээх эвлэрэлийн гэрээ байгуулж байх үед баруун Монголд амьдарч байсан Гунгаабалсанжамц хэмээх өвгөн даяанч ламын гэгээрэлд хүрсэн агуйнуудын нэг байж болох магадлалтай юмсанж. “Огторгуйн Далай” хэмээн Түвд, Хөх нуур, Халх, Ойрадад алдаршсан Саж бандид Намхайжамцын шавь хэмээн яригддаг Гунгаа ламын тухай олон янзын домог яриа байдаг юм. Тэрбээр Халхад Өндөр гэгээнийг тодрохоос өмнө Түвдэд таван номын эрдэм дүүргэн гавж хэмээх эрхэм цолыг хүртсэн ч Амдо дацанд шавилан суухаас татгалзаж, Алтайн уулсын өвөр дэх өөрийн төрсөн нутгийг зорин зүтгэсэн гэдэг. Гунгаа ламтан Монголын баруун хязгаарт ирэх үед Халх, Ойрадын хооронд зуугаад жил үргэлжилж ахан дүүс нэгнийхээ яс цусыг урсгаж хэмлэлцсэн өс хонзон авах дайн арайхийн завсарлаж, Цоросын Баатар хунтайж Халхын хаад ноёдтой хэлэлцэн эвлэрэл үүсгэж энх амгалан цагийг тогтоогоод байсан ажээ. Тиймээс Гунгаа ламтан эхлээд Саж бандида багшийнхаа зохиосон тод үсгээр бурханы сургаалийн мөн чанарыг яруу тод өгүүлсэн ном судар зохиохоор сэтгэл шулуудахын сацуу Алтайн өвөрт одоогоор Говь-Алтай аймгийн Дарви сумын нутагт “Их зуу” хэмээх номын ариун дагшин өргөө босгохоор хичээж байсан гэдэг. Гэвч тухайн цаг үед Буддын шашин төдий л хүчтэй дэлгэрээгүй, мөн хаад ноёдын зүгээс олигтой дэмжлэг авч чадаагүй байсан учир бурханы номын эрдэмийг биеэр үлгэрлэн үзүүлж олны санаа сэтгэлийг эрвээхэй сорох зулын гэрэл мэт татахаар шийдэж Алтайн ууланд

даяаны таван агуй бүтээж, 108 нас хүртлээ бясалгал зангидаад эцэст нь бодисадвагийн зиндаанд хүрч ертөнцийг огоорон орхисон гэх домог байдаг билээ.

## **“Цагаан шүдэн” Баатар, “Атгадаг” Тамжид нар Үзэмчин, Барга хошууд руу довтолсон нь**

Увс аймгийн Хяргас сумын уугуул Сэмжидийн Дамдинпүрэв хэмээх жар гаруй насны өвгөн “Ар халхын шилийн сайн эрчүүд” ном гарсанд талархал дэвшүүлэхийн зэрэгцээ дээхэн үед нутаг орондоо алдартай явсан шилийн сайн эр Дөрвөдийн “Цагаан шүдэн” Баатар гэгчийн тухай хүүрнэснийг толилуулъя.

Ардын хувьсгалын үед Дөрвөд далай ханы Зоригт ханы хошуунд “Цагаан шүдэн” Баатар хэмээх сайн эр амьдарч байсан юм. Энэ эр ядууст буян үйлдэж, баяд ноёдод өш хонзон зангидаж явсан байдаг. Баатар хар нялхаасаа ядуу зүдүүгийн зовлон амссан болохоор энгийн ардуудын зовлон зүдүүрийг алган дээрээ тавьсан юм шиг мэдэрдэг байсан гэдэг. Тэрбээр Тувагийн талаас ихэвчлэн адуу мал хөөнө. Алс холын аймгаар алгасан давхиж баяд ноёдын адууг хөөж, нутгийн ядууст тарааж өгнө. Шинийн 15-ны тэргэл сартай шөнө буюу 25-ны сар битүүрэх үеэр нутгийн олон нь сүү хөөрүүлж, тогоонд загсаагаад гэрийн бүслүүрт урт хулсан соруул хавчуулдаг байж. Баатар шөнө адуу мал авчирч өгье гэсэн айлынхаа шонд хэд хэдэн сайн морь уяж орхиод гэрийн бүслүүрээс бэлдэж орхисон урт хулсан соруулыг авч тогоотой сүүг дуустал нь уугаад явдаг байсан гэдэг. Түүнийг харанхуй шөнөөр таньж ядах юмгүй. Яг л адууных шиг том цагаан шүднүүд нь харанхуй шөнө одод анивчих шиг гэрэлтэж байдаг болохоор түүнийг нутгийн ардууд нь “Цагаан шүдэн” гэж нэрийдэх болжээ. “Цагаан шүдэн” Баатар хаа газрын сайн эрстэй уулзаж нөхөрлөж, “Хол нутгийн сайн эрсийн ид бярыг таньж мэдэрнэ” хэмээн хэдэн сараар үзэгдэхгүй алга болчихдог байж. Энэ үед нь нутгийн ардууд үнэхээр өнчирч баяд ноёдын дарангуйллыг жигшин зэвүүцэж, “Цагаан шүдэн” Баатарыгаа санаж мөрөөдөн дуу хүртэл зохиож байсан түүхтэй. Жишээ нь:

### **“Таван давхар тагийг даваад гардаг нь хонхолзуур зээрдээ**

Талын таван овоондоо мөргөөд морддог нь Цагаан шүдэн Баатар аа” гэсэн бэсрэг уртын дуу зохиосон байдаг. Энэ дууг Увс нутгийн зарим хөгшин өнөөдөр ч гэлээ аялж л суудаг юм. Баатар нэг удаагийн “шилрэлт”-ээрээ Ховдоор дамжин Шинжаан руу гарчээ. Мань эр Шинжааны торгууд нарын дунд “Цагаан” Буянжаа хэмээх сайн эр байдаг юм гэнэ лээ гэж битүүхэн сураг сонссон байгаа юм. Сайн эр хүний авхаалжтай хэрэг явдал салгуу ноёдод бол ид шидийн гэмээр байдаг. “Цагаан шүдэн” Баатар төдөлгүй Шинжаанд очиж царай зүс сайхантай, хээрээр гэр хэцээр дэр хийдэг зэрлэгдүү амьдралтай Торгуудын “Цагаан” Буянжаа хэмээх сайн эртэй уулзжээ. Тэгээд түүнтэй эр хүний нөхөрлөлийн андгай тавьсан боловч нэг л зүйлд эргэлзээд байж. Тэрбээр эр хүнийхээ зөнгөөр Буянжааг эмэгтэй хүн биш байгаа даа гэж сэжиглэсэн байна. Төдөлгүй Баатар түүнтэй цуг Шинжааны баячуудын адуунаас хөөхөөр болжээ. Тэгээд тэр ийнхүү боджээ. “Хэрвээ энэ нөхөр үнэхээр эр хүн бол хамт адуу хөөж болж байна. Харин эм хүн бол түүнтэй цуг адуу хөөж хэрхэвч болохгүй. Шилийн эрийн хийморь лундаа унахаас гадна адууны тэнгэр харина. Тиймээс адуу хөөхөөсөө өмнө түүнийг шалгаж үзсэн нь дээр байх” гэж шийдээд Буянжааг шууд барьж аваад хувцасыг нь хүчээр тайлж хаятал цаадах нь эмэгтэй хүн байх нь тэр. Нэгэнт эзгүй хээрийн хоймор эр, эмээ мэдэлцсэн хоёр халуун биеийн жаргал эдэлж, улмаар хагацаж салшгүй амраг болцгоосон гэдэг. Тэгэхдээ хамтдаа адуу хөөж тууж байсангүй. “Цагаан” Буянжаагийн эцэг нь “Торгууд”

Насан хэмээх чөмөгтэй эрчүүдийн нэг байсан бөгөөд Буянжаа хар багаасаа эцэгтэйгээ цуг энд тэндээс адуу хөөж явсаар яалт ч үгүй шилийн замаар орчихож. Эцэг нь ч түүнийг хар багаас нь эрэгтэй хүүхдийн хувцасаар хувцаслаж, сайн эрсийн хэрэг явдал, хууч домог ярьж өгөн морин дэлэн дээр ассан хүн болгож хүмүүжүүлжээ. Тэгээд л Буянжаа Шинжаан торгуудын нутагт нэр сүрээ цуурайтуулсан сайн эр гэгдэх болсон байна. Хээрээр гэр, хэцээр дэр хийсэн нэгэн зорилго зам мөртэй Баатар, Буянжаа хоёр жирийн хүний амьдралаар амьдрах гэж сайн эрийнхээ тангараг ёсноос хэдэнтээ хазайж үзсэн байдаг юм. Тэр бүү хэл Шинжааны өөртөө засах эрхийг булаацалдсан Хасаг, Торгууд, Хятад, Чантуугийн өвөр хоорондын дайнд хүртэл оролцож, тухайн үедээ л сүрхий нийгэмшиж байсан байна. 1921 оны Ардын хувьсгалын дараа Зөвлөлтийн хатгаасаар Шинжаанд бослого гаргасан Хасагийн тэмцэгчид Гоминданы цэргүүдэд шахагдаж Монголын хил рүү хөөгдөв. Зөвлөлтийн талыг баримтлагч Оспаныг Х.Чойбалсан Сталины шахалтаар тусгайлан хүлээж аваад Монгол орны баруун хязгаарыг хасаг босогчдын түшиц газар болгожээ. Тиймээс Гоминданыхан дайсныг нь газар нутагтаа орогнох боломж олгосон гадаад Монголын эсрэг тэмцэхээр шуударсан ч Мао Зе Дуны хувьсгалт армид салбарталаа нүдүүлсэн болохоор сэхэл авч чадахгүй байсаар америк ноёдын дэмжлэгтэйгээр Тайваны арал руу зугтаж одсон түүхтэй. Чухам тэр үед “Цагаан шүдэн” Баатар, “Цагаан” Буянжаа хоёр Монгол улсын эрх ашгийн үүднээс тагнуул хийж, Гоминданы чухал баримт бичгийг До яаманд өгч байсан байдаг. Энэхүү гавьяаных нь төлөө “Цагаан шүдэн” Баатарыг Монголын төр олон удаагийн хулгайн хэргээс нь цагаатгаж байсан гэдэг. Мөн тэрбээр гучаад оны үед мөнөөх л “Хол нутгийн сайн эрсийн ид бярыг таньж мэдэрнэ” хэмээх үзэл бодолдоо хөтлөгдөөд хаа холын Эрдэнэбишрэлт ван Пунцагравдангийн хошуу буюу одоогийн Дорнод аймгийн нутагт очиж тэндхийн шилийн сайн эр “Атгадаг” Тамжид гэгчтэй нийлж Өвөрмонголын Үзэмчин, Барга хошуудаас адуу хөөж байсан гэдэг. Дээхэн үед Сэцэнхан аймаг дорно талаараа Эрдэнэ-Уулаар зааглаж Хар мөрөн мужийн Хөлөнбуйртай зах нийлдэг байсан тул Эрдэнэбишрэлт ван Пунцагравдангийн хошууныхан Өвөрмонголын Шилийн голын Үзэмчин хошууныхантай худалдаа наймаа ихээр хийдэг байжээ. Тэр үед хил хязгаар энэ тэр гэж байгаагүй болохоор иргэд дуртай үедээ л ирж очдог байсан байна. Ерөөсөө Эрдэнэбишрэлт вангийн хошууны гадаад харилцаа нь Үзэмчин, Барга хошуудаас ирэх наймаачид л байсан байна. Харин Үзэмчин хошууныхан цаашаа Манжуур, Хятадтай холбогддог байсан тул нэлээд чинээлэг орон нутагт тооцогддог байжээ. Тэгтэл цаг үе өөрчлөгдөж Нийслэл хүрээнд ардын засаг мандахад Эрдэнэбишрэлт вангийн хошууг 1924 онд Хуралбаян уулын хошуу гэж нэрийдэж засаг захиргааг нь тогтоож эхэлсэн байна. Хэдий ардын засаг мандаад нэлээд хэдэн жил болсон ч монголчууд Шилийн гол аймагтай харьцсаар байлаа. Гэтэл уг хошууны дарга нь ард иргэдээ гэнэт Үзэмчин хошуунд зорчихыг хориглож, улмаар хил хязгаараа хамгаалах талаар асуудал дэвшүүлсэнээр цаг төрийн байдал илт чангараад ирсэн байна. Харин энэхүү шийдвэрийг ард иргэд нь таагүй хүлээж авсан нь хоёр үндсэн шалтгаантай байлаа. 1-рт уг хошууны иргэд Богд хаант улс дахин сэргэхэд Өвөрмонголоос дагаар орсон үзэмчин, баргууд байв. 2-рт тэдний хамаатан садан нь Шилийн гол аймагт үлдсэн байжээ. 3-рт Хуралбаян уулын хошуу нь үзэмчин хошуудтай эдийн засгийн нягт холбоотойгоос гадна тэдэнгүйгээр оршин тогтноход хэцүү байлаа. Үүнийг шинээр байгуулагдсан хошуу дарга огт тооцолгүйгээр гадны хүмүүсийг нааш цааш нь зорчуулахгүйн тулд харуул хамгаалалтаа юу юугүй л чангалаад эхэлжээ. Энэ нь үзэмчин, баргуудад таалагдаагүй учир Өвөрмонгол руугаа нүүх нь ихэссэн байна. Харин ардын засгаас энэхүү асуудалд анхаарал тавьж олон тооны ухуулагчдаа ард иргэдийн дунд оруулж ажиллуулсанаар урагшаа хөврөх их нүүдлийг түр зогсоож чадсан байна. Мөн энэ үед Өвөрмонголын Шилийн

гол аймаг хил хязгаараа чангалж эхэлжээ. Учир нь Ар Монголын шилийн эрчүүд тус нутгаас адуу мал хөөж туух нь эрс ихэссэн бөгөөд үүнд “Цагаан шүдэн” Баатар, “Атгадаг” Тамжид нар гол үүрэг гүйцэтгэж байсан байна. Ямар сайндаа л тэр үед монголчуудын дунд “Баян баргуудын адууг хөөлөө дөө” гэсэн дуу хүртэл зохиогдож байжээ. 1930-аад онд Барга, Үзэмчин хошууны иргэд малаа дотогш нь хумих үед мянга гаруй адуу, үхрийг нь “Цагаан шүдэн” Баатар тэргүүтэй тав зургаан шилийн эр гэгээн цагаан өдөр туугаад явчихсан гэдэг. Тэгмэгц баргууд тэдний араас зэвсэглэн хөөсөөр хил дээр ирэхэд хилийн цэргүүд өөдөөс нь буудсан байна. Энэхүү асуудлаас болж Барга, Үзэмчин хошууны ноёд Хуралбаян уул хошууны даргад гомдол мэдүүлэхээр элч илгээсэн аж. Гэвч энэ элчийг Монголын хил хамгаалагч нар огт тоолгүйгээр зодоод хөөж явуулсан байгаа юм. Харин тэрхүү адуу, үхэр нийлсэн мянга гаруй малыг тус нутгийн иргэд хувааж авсан бөгөөд хошууны дарга ч бас хувиа хүртсэн гэдэг. Төдөлгүй Үзэмчин хошууны хэдэн хулгайч нийлж Ар Монголоос олон тооны адуу нутаг руугаа хөөжээ. Хил хамгаалж байсан цэргүүд дөрвөн хулгайч адуу хөөж байгааг дэмий л хараад хоцорсон гэдэг. Энэ асуудлаас болж олон арван малчин хошуу ноёндоо гомдол мэдүүлжээ. Аргагүй байдалд орсон мань дарга урьд нь Өвөрмонголоос адуу хулуулж ирсэн “Цагаан шүдэн” Баатар тэргүүтэй шилийн эрсийн толгойг эргэтэл загнаад малчдын адууг олж ирэхийг тушаажээ. Ингээд Баатар, Тамжид тэргүүтэй таван шилийн эр маргааш өглөө нь Үзэмчин хошуу руу орсон байна. Тэд хоёр хоногийн дараа гэхэд барга ноён Дансран гэгчийн адуунаас мөнөөх хайж байсан адуугаа олж харжээ. Баатар, Тамжид хоёр тэдний адуучид дээр давхиж очвол хоёр барга эр цай чанаад сууж байж. Тэднийг буугүй байгааг мэдүүтээ Баатар, Тамжид хоёр мориороо дайрч ташуурдаж унагахад бусад нь довтолж бүх адууг нь хамаад нутаг руугаа хөдөлсөн байна. Хагас мянгаад адууныхаа хойноос Дансран ноён өөрөө хэдэн хамжлагынхаа хамт нэхэн хөөжээ. Баатар, Тамжид нар араасаа нэхэгч хүмүүст гүйцэгдээд ирүүт өөдөөс нь цахиур буугаар буудаж, улмаар Тамжид тэднийг тогтоохоор ганцаараа үлджээ. Дансран ноён Тамжид руу буудтал тэр үхэтхийн унасан байна. Сум түүний цээжийг нэвт цохиод гарсан тул амнаас нь цустай хөөс бургилж, Дансран ноён ч хүн алчихсандаа бантаад адууныхаа араас нэхэлгүй нутаг буцсан байна. Үүнээс хойш олон арван үзэмчин айл амьдрахын эрхэнд Өвөрмонгол руу нүүсээр байсан бөгөөд 1935 онд энэхүү их нүүдлийг Монголын төр цэргийн хүчээр арай гэж зогсоож байсан түүхтэй. “Цагаан шүдэн” Баатарын хувьд дотны анд “Атгадаг” Тамжидаа буудуулж үхсэний дараа “Шилийн сайн эр буу шийдэмтэй холбогдож ёстой болохгүй юм байна. Бугуйл цалам, чөдөр ногт ганзагалаад явж байхад л хэнд ч хал балгүй хоолоо олоод идчих байтал би юунд ингэж цахиур бууны тасхийх чимээнд тарчилж явах болов оо. Ерөөсөө л нутгаа бараадъя” хэмээгээд Дөрвөд далай ханы Зоригт ханы хошуу руугаа хөдөлсөн гэдэг. Үүнээс хойш түүний сураг тасарчээ.

## Тогос шиг гоёж явсан “Тогос” Чүлтэм

Эрт цагийн шилийн сайн эрчүүдээс “Торой” Банди, “Тогос” Чүлтэм хоёрын нэр толгой холбогдон дуурсагдсаар өнөө үетэй золгосон билээ. “Торой” Банди бол элдэв адал явдал, намтар түүхээр арвин. Түүний тухай Дарьгангын “Торой” Банди хэмээх ном хүртэл бичигдсэн. Харин “Тогос” Чүлтэмийн хувьд бол олигтой түүх намтар байдаггүй. Ерөөсөө “Тогос” Чүлтэм гэдэг нэр л яваад байдаг. Аль аймгийн ямар хошуунд, хэдэн онд амьдарч байсан нь тодорхой бус. Энэ хүний намтар түүхийг тодруулахын тулд дээхэн үеийн ахмад зохиолч, сэтгүүлчид болон домог түүх сонирхон судалдаг хөгшчүүдээс асуухад “Ямар ч гэсэн Засагт ханы хөх харчуудын л нэг байх” гэхээс өөр үг хэлсэнгүй. Харин худам монгол бичиг сайн мэддэг, тэр дундаа Өвөр Монголын номын санд очиж дээхэн үеийн домог түүх судалж сурвалжилдаг ганц нэг хүн “Тогос” Чүлтэмийн тухай зарим нэг баримт сэлтийг олж мэдсэн байх аж. “Тогос” Чүлтэм их ганган хувцаслаж явдаг, ухаандаа тогос шиг гоёж явдаг байсан учраас “Тогос” гэдэг хочтой болсон юм байх Бас тэр ихээхэн арга зальтай, хүний эвийг олохдоо гаргууд, авхаалжтэй сэргэлэн нөхөр байж. 2000-гаад оны үед Өсөхбаяр аварга Сүхбат аваргыг наадмын талбай дээр тийрч унагаад нэг хэсэг муудалцав даа. Дараа нь Өсөхбаяр аварга Сүхбат аваргатай эвлэрэх үедээ “Чи ер нь “Тогос” Чүлтэм шиг нөхөр шүү” гээд далан дээр нь алгадаад инээж байсан гэдэг. Тэгэхээр Өсөхбаяр аварга “Тогос” Чүлтэмийн тогос шиг гоёдог, арга зальтай, авхаалж самбаатай болохыг хэн нэгнээс сонсч байсан бололтой. Энэ хүний талаар ямар нэгэн мэдээлэлтэй байсан болоод л нэрийг нь онцолсон байж таарна. Тавь, жараад оны цагдаагийн генерал, хурандаа нар “Тогос” Чүлтэм гэгч хэн болохыг ерөнхийдөө гадарладаг байжээ. Ялангуяа Думбарай генерал “Тогос” Чүлтэмийн өдүүлсэн нэгэн том хэргийн тухай сайн мэддэг байж. Гэвч тэрхүү хэргийг социалист төр засаг ард түмэнд мэдэгдүүлэхгүйгээр хав дарахаар шийджээ. Учир нь “Тогос” Чүлтэм хориод оны үед хэдэн нөхдийн хамт Монгол улсын ганц банкныг тоночихсон юм байх. Энэ нь шинэ залуу Монгол улсын нэр сүрэнд сэв суулгаж мэдэхээр байсан тул “Тогос” Чүлтэмийн намтар түүх, элдэв адал явдлыг хэнд ч мэдэгдэлгүйгээр хав дарж, нэг ёсондоо газрын хөрснөөс арчихад хүрсэн гэдэг. Тэглээ ч Өвөр Монголын түүх сударт түүний тухай бичигдэж үлдсэн байгаа юм. Уйгаржин бичиг сайн мэддэг, урагшаа явж эртний домог түүх судалж сурвалжилдаг Г.Ням-Очир хэмээх залуу “Тогос” Чүлтэмийн зарим нэг хэрэг явдлыг олж мэджээ. Одоогийн Шилийн гол аймгийн Шилийн хотод Бэйсийн сүм гэж бий. Хориод оны үед Ванчин Богдыг Түвдээс хөөгдөөд Ар халхад ирэхэд Наймдугаар Богд бурхан болчихсон байж. Тэр үед Наймдугаар Богдын нэр хүнд их өндөр байж л дээ. Тиймээс Ванчин Богд тэр даруйдаа Өвөр Монгол руу явж тэндхийн Бэйсийн сүмд очоод Дүйнхорын ван тавих болж. Тэгтэл Ар Монголоос дөчин мянган хүн очсон байгаа юм. Тиймээс дөнгөж л хөл дээрээ босч байсан манай ардын засгийнхан энэ тухай дуулж мэдээд “Энэ Ванчин Богд гэдэг чинь хэлхээ холбоо сайтай, ард түмнийг яаж ч урвуулж мэдэхээр аюултай хүн байна” гээд ихэд айж болгоомжлоход хүрсэн гэдэг. Энэ тухай “Тунгалаг тамир” кинонд дээр хальт гараад өнгөрдөг шүү дээ. Ар Монголоос дөчин мянган хүн зориод ирсэнд Ванчин Богд ихэд эрэмшиж “Монголыг ер нь байлдан дагуулж болох юм байна” гэж мунхаглаад тухайн үед Нийслэл хүрээнд хулгай зэлгий хийдэг байсан сайн эрчүүдийг дуудсан байгаа юм. Тэдний дунд “Тогос” Чүлтэм ороод явчихаж. Ванчин Богд Ар Монголоос очсон тэдгээр хүмүүст шар хадаг зүүж, бууны ам долоолгоод “Одоо та нарыг бууны сум дийлэхгүй. Ардын засаг гэж юу байлаа даа. Тэд мөнгө санхүүгүй бол хөдөлж чадахгүй. Юуны өмнө та нар мөнгөний авдарыг нь

тоноод ир” гэж тушаасан байна. Ингээд л “Тогос” Чүлтэм тэргүүтэй тавь жараад хулгайч Их хүрээнд давхиж ирээд Монгол улсын ганц банкныг шөнөөр тонож, том том мөнгөн эмбүүг богцнууддаа дүүргэж аваад урагшаа хөдөлсөн гэдэг. Гэтэл нэг шилийн эр үлдэж хоцроод До яамныханд мэдээлчихэж. Мань эр “Би дээрэмчдийн буудаллах газрыг сайн мэднэ. Та нар намайг дагуулаад хойноос нь хөдөл” гэснээр До яамныхан “Тогос” Чүлтэмийн хойноос бөөнөөрөө хөдөлсөн байгаа юм. Тухайн үед сайн эрчүүд хоорондоо чөдөр зангидаж харьцдаг байж. Буудалласан газартаа чөдрийг янз бүрээр бөөрөнхийлөн зангидаж үлдээдэг, тэр зангилааг нь зөвхөн шилийн эрчүүд л тайлж уншдаг байж. До яамныхантай хамт явсан шилийн эр зангидаж орхисон чөдрийг тайлж уншсаар яваад Дорноговь аймгийн “Авгийн хонгил” гэдэг газарт хүрч иртэл “Тогос” Чүлтэм тэргүүтэй эрчүүд халхын хавтгайгаас гарахаасаа өмнө сайхан найрлая гээд хонхор газар гал түлж, үхэр алж идээд, архи дарс уугаад бөөн найр наадам болж байсан байна. Тиймээс До яамныхан тэднийг согтож унахыг нь хүлээхээр шийдэж. Бүрий болмогц бүгд нөгөө хонхортоо нам нам согтоод унасан байна. Харин “Тогос” Чүлтэм ерөөсөө нам дор газар унтдаггүй, өвөл ч байсан, зун ч байсан заавал уулын орой дээр гарч унтдаг хүн байж. Үүнийг нь До яамныхан анзаарсангүй. Тэд хонхорт унтаж байсан тавь гаруй хулгайчийг бүгдийг нь нам нам буудаж алаад тоногдож дээрэмдүүлсэн бүхий л мөнгөн эмбүүгээ аваад хот руу хөдөлсөн байгаа юм. Энэ нь нэгдүгээрт айхтар том аллага байсан, хоёрдугаарт байдаг л нэг хулгайч нарт банкаа тонуулсан болохоор До яамныхан энэхүү ноцтой хэрэг явдлыг ард түмэнд мэдэгдэлгүйгээр хав дарахаар шийдэж л дээ. Харин “Тогос” Чүлтэм уулын орой дээр унтаж байсан болохоор ганцаараа амьд гарсан гэдэг. Тухайн үеийн ардууд түүнийг Өвөр Монгол руу дүрвэсэн гэж ярьцгаадаг байжээ.



## Хуурамч зоостой хутгалдсан “Хөмсөг” Тавхай

*Одоогоос зуугаад жилийн тэртээ өрнөсөн энэхүү хэрэг явдлыг*

*Чингэлтэй дүүргийн 12-р хороонд оршин суух 91 настай Готовын Чойсүрэн гуай хуучилсан юм.*

18-р зууны үед Их Хүрээ одоогийн Төв аймгийн нутагт нааш цааш хоёронтоо нүүсэн байдаг юм. Их хүрээг нүүлгэх болсон учир гэвэл 5-р Жавзандамба хутагт нас барсаны дараа түүний хойд дүрээр тодорсон 6-р Жавзандамба Түвдээс халхад ирээд ганц ч сар бололгүй нас барсаныг газар нутаг зохиогүйтэй холбон тайлбарласан байдаг. Ингэж хүрээ нүүх нь ард иргэдэд ихээхэн чирэгдэл учруулж байсан нь ойлгомжтой. Тухайн үед Ар Монголд доншуучилж ирээд панз наймааны амтанд орчихоод байсан хятад худалдаачдад энэ нь бүр ч хүндрэлтэй тусчээ. Хүн амьтан олонтой хүрээ хийд бараадаж мундашгүй ашиг олдог байсан тэд Ар Монголд хот суурин газар бүрэлдэн тогтохыг ихэд дэмждэг байсан ч Их хүрээг ийш тийшээ нүүх болгонд хятадууд олон сар ноцолдон байж босгосон шавар байшин, мухлаг, дэлгүүрүүдээ хаяад нүүдэг байж. Харин сохорсон биш завшив гэгчээр тэдний орхиж нүүсэн шавар тагз, хашаа хороог малчид өвөлжөө болгон ашиглах нь олонтаа. 18-р зууны сүүлчээр Их хүрээ Богдхан уулын ард буюу Хатан Туулын хөвөөнд суурьших болсоноор хятад худалдаачид мөн л дагаж нүүгээд шавар тагзнуудаа энд тэнд эрийлгэж эхэлсэн байна. Харин тэр үед “Хоноц хоноцдоо дургүй” гэгчээр хүрээ хийдээр амьдралынхаа эх сурвалжийг хийсэн лам нар хятадуудыг үзэн ядаж, улмаар Их хүрээний сайд нарт хятад худалдаачдын талаар гомдол мэдүүлэх нь их болжээ. Үүний улмаас хятад худалдаачид аргагүйн эрхэнд Их хүрээнээс арав гаруй км-ийн зайд орших “Элбэг-Амгалант” гацаа буюу Маймаа хотыг одоогийн Амгалан хавьцаа байгуулж суурьшсан байна. Гэвч тэд өөрсөддөө л бараагаа шахахгүй бол Амгалан хавьцаа монголчууд гэхээр юм байсангүй. Тиймээс хятадууд бараа таваараа дамнаж үүрээд хүрээнд ирж наймаа хийх болсон бөгөөд энэ үүднээс Их хүрээнд “Баруун дамнуурчин”, “Зүүн дамнуурчин” гэх мэтийн газар нутаг, нэр томъёо үүссэн гэдэг билээ. Чухам энэ үеэс эхлээд дотор хүмүүсийн төрөлхийн муу чанар танигдаж Их хүрээг хар тамхи, садар самуун, үймээн самууны үүр болгох эх үндэс тавигдсанаар үндсэрхэг үзэлтэй зарим нэг хүний цөсийг хөөргөөд хаячихаж. Тэдний нэг нь Их шавийн Шанзудба Дандаржав гэгч байлаа. Тухайн үед Манжийн ноёрхол эцэс болох цаг ойртсон байсныг ч хэлэх үү, халх монголчуудын дунд манж, хятадуудыг үзэн ядах үзэл газар авч эхлээд байсан цаг. Тийм ч учраас Шанзудба Дандаржав хятадуудын худалдааг зогсоох, тэднийг Монголоос хөөх саналыг хүрээний сайд нарт тавьж эхэлсэн байна. Дандаржав нь ихэс дээдсүүдэд ихэд нэр нөлөөтэйгээс гадна Хятадыг үзэн ядах өвчнөөр өвчилсөн хүн байж. Учир нь түүний эцгийг хятадууд Бээжинд хорлосон юмсанж. Дандаржав энэхүү өшөөгөө санаж явсаар “Хүрээний шороо муудсан учир элдэв өвчин гарах нь ихэслээ. Иймээс Их хүрээг нүүлгэе” гэсэн саналыг сайд нарт тавих болжээ. Ухаандаа Их хүрээг дахин өөр тийш нь нүүлгэж хятадуудыг хохироох гэсэн санаа байлаа. Гэвч түүний санасанаар болсонгүй. Тиймээс тэр хүрээний аль л зориг зүрхтэй эрчүүдийг өөртөө нэгтгэж өдөр ирэх тусам шоргоолж шиг үржсээр байсан хятадуудтай ил далд аргаар бяцхан тэмцэл хийхээр шийдсэн байна. Одоогийнхоор бол “Даяар Монгол”, “Хөх Монгол” бүлгэм юмуу даа. Харамсалтай нь түүний санаанд нийцэх зориг зүрхтэй эрчүүд тийм ч амар олдсонгүй. Харин өмнө нь хятадуудыг хэд хэдэн удаа дээрэмдэж,

басхүү хол ойроос адуу хөөсөн хэргээр арван тавны цагдаа нараас зугтаад Богдхан ууланд бүгэж байсан “Хөмсөг” Тавхай хэмээх шилийн эр түүний таалалд ихэд нийцсэн байна. Тиймээс Дандаржав өөрийн биеэр Богдхан ууланд явж очоод “Хөмсөг” Тавхайтай биечлэн уулзаж “Чи одоо уулнаасаа буу. Арван тавны цагдаа зэргийг би аргална. Цаана чинь арван тавны цагдаа нараас илүү аюултай байдал нүүрлээд байна. Өдрөөс өдөрт ялаа шиг өсч үржсээр байгаа хятад худалдаачид Их хүрээг сүйрүүлж мэдэхээр болчихлоо. Тиймээс эх нутгаа гэсэн зориг зүрхтэй чам шиг эрчүүд бидэнд хэрэгтэй байна” гэх зэргээр хөөргөж байгаад түүнийг өөрийнхөө ивээлд авахаар болжээ. Ингээд “Хөмсөг” Тавхай хэмээх шилийн эр уулнаасаа бууж суурин газар бараадах нь тэр. Ухаандаа мань эр билэг танхай хөдөөний эр байхаа болиод бэл бэнчинтэй хотын хүн болж, шилийн эрийнхээ хуучин замыг орхиод шинэ цагийн атаманы замыг сонгосон хэрэг. Эр бор харцага шиг дэрвэлзэж явсан жигүүрээ хумиад эрүүгийн ертөнцөд хөл тавьсан гэж хэлж ч болно. Нэгэнт зохих ёсны эрх мэдэлтэй, нөлөөтэй хүний ивээлд багтсан тэрбээр хятад худалдаачдыг их багаар шоглохын зэрэгцээ бяцхан дээрэм тонуул хийх зэргээр атаманы ажлаа их л зоригтой бөгөөд эрчимтэй хийж эхэлсэн байна. Дандаржавын гол зорилго бол хятад худалдаачдыг Их хүрээнээс алгуур зайлуулах байсан бөгөөд байнгын дарамтанд байлгаад байвал хятадууд аяндаа өөрсдөө зайлаад өгнө гэж тэр сэтгэжээ. Гэвч дотор ухаантай хятадууд Дандаржаваас нэг шат дээгүүр сэтгэсэн байгаа юм. Хөх хотоос доншуучилж ирсэн баян худалдаачин Хөү Хуа буюу Хөвхүү хэмээх хятад эр Дандаржавын нууц ажиллагааг мэдмэгцээ Амгаланбаатар хотод том, жижиг пүүс ажиллуулдаг гуч гаруй хятад эрийг сэм цуглуулаад “Бидэнд илт дайсагнах болсон Шанзудба Дандаржавын үйл ажиллагааг зогсоох хэрэгтэй байна. Үүнд түүнийг хахуульдах, ямар нэгэн аргаар хуурамч хятад зоос атгуулж хэрэгт хийх, эсвэл устгаж үгүй хийх гурван зам байна. Гэвч дөргүй бух шиг тэр муйхар эр бидний хахуулийг авч хэлэлцэхгүй. Амь насыг нь хөнөөж гэмээнэ бусад ардуудын уур ундууцлыг барж илүү олон дайсантай болно” гэх мэтээр ярилцаж байгаад хамгийн хохирол багатайгаар нь хоёр дахь замыг сонгон авчээ. Энэхүү цугларалтын дараа Хөвхүү Улиастай дахь Настын пүүсийн эзэн Жян Ли гэгчид дээрхи хэргийг даалгасан байна. Жян Ли хэд хоногийн дараа өөрийн итгэлт түнш, хүрээний цуутай зодоонч “Далиу” Цэгмид гэгчийг хүрээн дэх гэртээ урьж цайлах зуураа “Хай, чамд их баян болох боломж бий ваа” гэхэд цаадах нь “Мөнгө л олдож байвал хүн алахаас бусдыг хийнэ” гэсэн байна. Хариуд нь Жян Ли “Хай, тэгвэл чи Дандаржав ноёнтоноос одоо хэрэглэж байгаа сүйх тэргийг нь үнэ цохиж авбаа. Тавхай гэдэг дээрэмчин чиний найз. Түүгээр дамжуулаад Дандаржавтай харьц. Сүйх тэрэг авах мөнгийг би бэлдсэн баа” гэж ирээд л намилзжээ. Хариуд нь Цэгмид “Чамд сүйх тэрэгний хэрэг юу байна аа. Илжигэндээ хөллөх гээ юу” гэхэд хятад худалдаачин “Үүний цаана ихээ том наймаа явж байгаа шүү. Чи бид хоёр мөнгө л олж байвал цаадах учрыг нь мэдэх гэж толгойгоо өвтгөх гээд юугаа хийнэ” гэснээ тулам ууттай зоос гаргаад өмнө нь тавьсан байна. Цэгмид яг л нөгөө “Ацаг шүдний зөрүү” кинонд гардаг Намжил шиг зоосон мөнгөнөөс нэгийг авч үлээгээд чихэндээ барьж чагаснаа “Энэ чинь дотроо гуультай хуурамч юм байна. Чи намайг хорлох гээ юу” гэж уурлахад хятад эр “Хай. Түнш түншээ хуурах ёсон байхгүй баа. Чамд тусгай мөнгө бэлдсэн баа” гээд элгэн ууттай мөнгө гаргахад дотор нь орос алтан зоос, хятад янчаан харагджээ. Ингээд Цэгмид өөрийн хийх ажлаа хятад эртэй тэр оройжингоо ярилцаад маргааш өглөө нь Дандаржавын өргөөнд очиж хуучны танил “Хөмсөг” Тавхайтайгаа уулзсан байна. Эрүүгийн хоёр нөхөр эздийнхээ өмнөөс хэрэг шийдэх гэж буй нь энэ. “Хөмсөг” Тавхай эзэн Дандаржавтаа ихээхэн итгэл олж аваад байсан тул Цэгмидийн авчирсан их хэмжээний хятад зоосыг хараад сүйх тэрэгний наймааг тэр дор нь толгой мэдээд шийдчихэж. Энэ явдлаас хойш хэд хоногийн дараа

Дандаржавын жасын нярав зах зээлийн газар хуурамч мөнгөөр худалдаа хийсэн хэргээр Манжийн амбан сайдын торгон цэрэгт баригдах нь тэр. Энэ хооронд Жян Ли манж амбанд бараалхаж “Шанзудба Дандаржав гэдэг хүн удаа дараа хуурамч мөнгөөр худалдаа хийж биднийг хохироов. Түүний хиа нь “Манай эзэн хувьдаа зоосны үйлдвэртэй” гэж гайхуулж байхыг би сонссон. Дандаржавын хуурамч зоосыг өмнө нь адуу малын хэргээр ялаас зугтсан Тавхай гэдэг дээрэмчин гүйлгээнд оруулдаг юм байна. Одоо Дандаржавын өвлийн байшинг шалгаж үзэх хэрэгтэй. Тэнд их хэмжээний хуурамч зоос байгаа тухай манай хүмүүс хэлсэн” гэх зэргээр гомдлын бичиг өргөн барьсанаар манж амбан тэр даруйдаа цэрэг илгээж Дандаржавын өвлийн байшинг шалгуултал өч төчнөөн хуурамч зоос гараад зогсохгүй цутгуур, цэнлүүр хүртэл гарсан байна. Энэ бүхнийг Дандаржавт өширхөгч хятадууд хийсэн байж. Дандаржав бүхнийг нударгаар шийдэх гээд байдаг, харин өрсөлдөгч хятадууд нь түүнээс нэг шат дээгүүр сэтгэж мань эрийг ялтан болгох эх үндсийг аль хэдийн тавьсан нь энэ. Ер нь ганц Дандаржав ч биш, олон арван монгол эр хятадуудын энэ мэтийн башир арганд хууртаж байсан бөгөөд энэ тухай ном зохиолд ч тусгалаа олсон байдаг. Дандаржав хуурамч зоостой холбогдсоноо мэдмэгцээ “Мал тэжээвэл ам тосдоно, хүн тэжээвэл толгой цусдана гэгчээр “Хөмсөг” Тавхай гэдэг шилийн хулгайч хятадуудтай хамсаж байгаад намайг дөнгөчихлөө” гэсэн ташаа ойлголт авч “Одоо хаашдаа өнгөрсөн. Би хэрэгт холбогдох нь тодорхой боллоо. Тавхай миний бүх муу явдлыг мэдэж байгаа. Хятадуудад худалдагдсан түүнтэй уулзах ч хэрэг алга” гээд мориндоо мордоод хаа нэгтээ зугтах гэсэн боловч манж амбаны цэргүүдэд баривчлагдсан байна. Харин хуурамч зоосны хэрэг явдал босоод ирсэнийг дуулж сонссон “Хөмсөг” Тавхай “Би ямар хээрээр гэр, хэцээр дэр хийж сураагүй биш дээ. Баригдаж туугдахаасаа өмнө баян хангайгаа бараадна аа” гээд ирсэн замаараа сурсан дуугаа аялаад галигуулж одсон гэдэг. Гэв гэнэт аянга цахилгаанд цохиулах мэт бүх амьдрал нь орвонгоороо эргэсэн Дандаржав хамаг бурууг “Хөмсөг” Тавхайд хамаатуулан гяндангийн хахир өрөөнд толгойгоо салаавчлан хэвтэж байгаад хор уугаад амиа хорлосон гэдэг. Гэхдээ чухам өөрөө өөрийгөө егүүтгэсэн үү, хятадуудад хорлогдсон уу гэдэг нь оньсого хэвээр үлдсэн байна.

## Гамин цэргийн эрлэг болж явсан “Сайн хулгай” Цэрэндондог

Дорноговь аймгийн уугуул, ахмад зохиолч Сономын Чулуун шилийн эр “Сайн хулгай” Цэрэндондог, Манлайн Хув нарын тухай өгүүлсэнийг тоймлон хүргэе.

...Хорго баянгийн хэцэд Цэрэндондог гэдэг сайн хулгайч эр өөрт оногдсон үйлээ бүр өвгөн болтолоо таталгүй явсаар өөд болсон тухай нэг бус удаа сонсч байлаа. “Сайн хулгай” Цэрэндондог хаягаа хадардаггүй, харц олонд ээлтэй сайн эр явсан шиг байгаа юм. Манай нутагт өмнө газрыг зорьдог их шар замын ором өдгөө ч өвс шарилж ургасан өргөн хотгор болон зурайж умар зүгийг барин одсон нь тов тодхон бий. Энэ замыг олон хятад данжаадыг шоглон хулуулж насыг элээсэн гэцгээдэг юм. Сөөг хэмээх элбэг сайхан ус булагтай баян бүрднээ нутаглах Дэмбэрэлийнхэн эсгий хийх гэж байсан цаг юмсанж. Цэрэндондог нэг өдөр тэднийхээр буухдаа “Та нарын эсгий хийх өдрийг би зааж өгье. Хүлээж байгаарай” гэсэнд цаадуул нь үгүй гэсэнгүй. Цэрэндондог хаашаа ч юм явж одоод хэд хоноод давхиж ирэхдээ “За өнөөдөр эсгийгээ хийгээрэй” гэж хэлээд өөрөө зар тараахаар явжээ. Төдөлгүй нутгийнхан цуглаж хүн мал багшран тэвхийсэн эсгий дэлгэн тавьсан жин үдийн цагаар Хавиргын баруун энгэрээр олон адууны тоос босоод иржээ. Энэ нь Хятад газарт хүрэх их агтын бараа байлаа. Сөөгийн ус булгийн анираар адуун сүрэг цувран давхилдаж саахалтын газар хэдэн бөөвийсөн хятад адууны сүүлчийг хумин наашлах зуур худгийн онгоцонд орж ирсэн аль л сайхан морьдыг Цэрэндондог чөдөрлөөд байж. Түрүүчийн адуу ус ууж ханаад гарч байхад тууварчин хятадууд хүрч ирсэн ч мөнөөх чөдөртэй морьдыг үл анзааран орхих мөртөө “Хай, энэ морьд бидний адууг дагаад явах нь ээ. Морьдоо аваарай” гэж хэлээд адуугаа тууж одсон гэдэг. Эсгий хийж байсан хүмүүс Цэрэндондогийн чөдөрлөж үлдсэн хорь гаруй сайхан морийг хараад хорхой нь хүрч “Олзыг олуулаа” гэхэд Цэрэндорж “Та нарыг чөдөрлөхийг хэн байг гэсэн юм бэ” гэж эрсхэн хэлээд мөнөөх морьдоо суллан ядуу буурай нутгийнхандаа тарааж өгөхөөр тууж одсон гэдэг. Арга зальтай цэвэрхэн хулгайч гэж бас байдаг аж. Шилийн эр Цэрэндондог тэртээ хориод оны үед Хятадын гамин цэрэг Монголд орж ирээд харгислал үйлдэх үед иргэнийхээ үүргийг нэр төртэй гүйцэтгэсэн байдаг. Ер нь гамин цувсан жилүүдийн униар тоосон дунд монгол хүний эр зориг, авхаалж самбааны улбаа үлдсэн нь зөндөө. Их шар зам бараадан нутгийн ардууд өглөөдөө өндөр ууланд гарч дуран барин сууж алсын бараа хардаг байж. Олондоо муу юмсын сураг дамжуулж, аюул сүйрлээс хамгаалж явсан “Өндөр” Мо гэдэг сайн эр Шороот, Бичигтээр нутаглаж байжээ. Тэрбээр ан гөрөө харах нэрээр нэгэн зунжин уул хаданд сууж олон, цөөн гамингийн ирж яваа сураг гарган амьтан хүн, мал ахуйгаа өмөөрч үлдээснийг нутгийн хөгшчүүл ярьдагсан. Өндөр янхигар биетэй, эрүү түүш өргөн тэрбээр ганц нэг гаминтай тааралдахад айж сүрдэх эр биш байжээ. Нэгэнтээ “Гурван тэмээтэй гамин цэргүүд гарч ирлээ” гэдэг хэлийг бэлийн айлд хүргүүлсэнд мөнөөх айлынхан уулга алдан дутааж өгч гэнэ. Холоо очиж амьсгаа даран байтал гэртээ уяатай хүүхдээ мартсан байжээ. Сандран гүйж ирэхэд мантгар цагаан хүү ер юу ч болоогүй юм шиг унтаж хэвтсэн тухай шог хоржоонтой яриа ч байдаг. Гамин замдаа тааралдсан айлын адуу малыг дээрэмдэн тууж явах нь их байж. Унаа ч болдог, хоол ч болдог байсан биз. Тэр цагт сайн эр Цэрэндондог Хоргын хэцийн нэг аманд гамингуудыг отож байгаад тууж яваа малыг нь дээрэмдээд эздэд нь тарааж өгдөг байсан гэдэг. Цэрэндондог морины сайн, эрийн овсгоо хоёроор гамингууд руу гэнэт дайрч самгардуулдаг байсан агаад түүнийг гамин цувсан үймээнт жилүүдэд “Бүргэд хар”-ын нэг жалганд аргаль, гөрөөсний

мах шарж идсэн шиг, адсага хөдсөн дээр унтаж хэвтсэн шиг хээрээр гэр, хэцээр дэр хийж явсан тухай аав маань нэг бус удаа хүүрнэж билээ. Өмнөд хөршөөс манай нутгийг дайрч умрыг зорьсон хоёр их зам байсан шиг байгаа юм. Одоо тэр замууд нэгэнт элэрчээ. Нэг нь Долнуураас Улиастайг чиглэн сунасан их өртөөний Баян-Овоо, Сүж, Толь, Төгрөг, Гашуун гэсэн цайны газар байсан тухай түүх цадигт бичдэг. Харин нөгөө нь Шар онь юм. Заримдаа Бээжин зам ч гэдэг. Энэхүү замыг дагаж цус, нулимс, өнгө мөнгө, эр зориг, дээрэм тонуулын гэх дандаа хар домог үлдэж хоцорсон байдаг. Он цагийн билүүнд мөлийж орхисон ярианаас хэдийг боловч хойч үдээ дамжуулмаар санагддаг юм. Алдарт Эргэлийн зооны баруун сугал Цагаан гогцоо гэдэг нэгэн хонхорт үй олон хүний үжирсэн яс саяхан болтол тарж байсан гэх. Гамин цувсан жилүүдэд “Хазгар” Мааньзав тэргүүтэй нутгийн сайн эрчүүд гамин цэргүүдийг тосон очиж алж хядаад хүүрийг нь энд овоолсон гэдэг яриа бий. Үнэн худлыг хэн ч нотолсонгүй. “Хазгар” Мааньзав нь зүгээр нэг шилийн эр биш Богт хаант улсын үеийн баатар эр байсан нь түүхэн үнэн. 1921-1922 онд Хиагт, Хүрээ, Ерөө, Хараа орчмоос амь зулбан зугтсан гамин цэрэг хэсэг хэсгээрээ нутгаа тэмцэн зугтахдаа замдаа дээрэм тонуул, аллага хядлага үйлдэж явсаар нутаг нутгийн сайн эрчүүдийн занаанд орсон байдаг. Тиймээс гамингууд сүүлдээ муу санаа агуулж ганц нэгээрээ шөнийн харанхуйд уулын жалга бараадан зугтдаг болсон гэдэг. “Сайн дэл”-д нэг айл хаваржиж байжээ. Өглөө эртээ гадаа нь тэмээ орилоход айж үргэсэн гэрийн эзэн тотгон дээгүүрээ шагайн хартал хариугүй муу шалдан тэмээ зайдалж, буу үүрсэн гамин цэрэг бууж харагдсан байна. Зуурын зайд сандарсан эцэг эх хоёр таван настай охиноо айргийн суулганы ард тэрлэгээр хучиж орхиод “Хөдөлж болохгүй” гэсэн хоёрхон үг хэлээд бүлтэлзэж байтал нөгөө гамин орж ирээд хоёронтоо буу тасхийлгэж гэрийн эздийг хөнөөгөөд цай хоолны шавхруу гударч аваад гарч одсон гэдэг. Охин тэсч үлдээд саахалтын айл руу орилон гүйж очсон байна. Тэр охиныг “Амьд явах учиртай байжээ” гэж хөгшид ярьдагсан. Амьд үлдсэн тэр охин болох Дэнсмаа гуай далан он хүртэл Сулинхээрт амьдарч байлаа. Урт замд яваа хүмүүс юу эсийг ярих билээ. Сонссон дуулсан, үзсэн харсанаа илэн далангүй ярьдаг хүнд би дуртай. Нэгэнтээ найман өртөө холыг гэтлэх аяны дөрөөнд тавь эргэм насны хүдэр эр хамт гишгэв. Тэрбээр өөрийгөө Өмнөговийн Манлай сумын харъяат Энхбаяр гэж танилцуулав. Элдэв хараал ерөөлийн талаар хөөрөлдөж явсанаа мань хүн Манлайн хув гэгч сайн эрийн тухай хүүрнэж билээ. Манлай сумынх болохоор нь хүмүүс Манлайн Хув гээд нэрлэчихэж. Энэ эр өмнө зүг хил даван одож Өвөр Монголоос адуу мал хөөж авчран нутаг усандаа тараадаг байж. Нэг удаа Муу мянганы хошуунаас хэдэн тэмээ хулгайлсан юм байх. Дандаа сайн ачлаганы ат байж. Наашаа элдэн хөөсөөр хариугүй хилийн дээс алхдагийн даваан дээр Хятадын хилийн харуул хойноос нь хөөж, Хув эгээтэй л гүйцэгдэлгүй нутагтаа орж ирсэн гэдэг. Мань эр Монголын хилийн цэргийнхэнтэй их сайн найзалдаг, үүнийхээ ачаар Хятадын нутгаас адуу мал хөөдөг байж л дээ. Хожуухан өвөрмонголчууд манай хилийнхэнээс “Хэдэн тэмээ хулуулсан тэр эрийг хэн гэдэг юм бэ?” гэж шалгаах дуртай байсан ч манайхан элдвээр дүйвүүлж амаа жимийн өнгөрдөг байж. Гэтэл нэг саваагүй нөхөр “Манлайн Хув гэдэг байх аа” гээд ам алдчихсан гэдэг. Үүнээс үүдэн хятадууд Манлайн хувьд хараал хийсэн байгаа юм. Тэд манай хилийнхэнд “Манлайн Хувын үр удмыг тасална” гэж заналхийлсэн үгээ дайн хэлүүлсэн гэдэг юм. Сайн эр Хув дөрвөн сайхан хүүтэй байж. Харамсалтай нь Хувын хөвгүүдийн хэн нь ч үр хүүхэдтэй болоогүй юм билээ. Чаддаг хүний онодог хараал гэж байдаг бололтой.

## Завхан аймгийн Сонгино сумын сайн эрчүүд

Завхан аймгийн Сонгино суманд олон жил ажиллаж амьдарсан Ч.Рагчаа соц нийгмийн үеийн Сонгино сумын амьд архив ажээ. Өнгөрсөн жил түүнтэй Завхан аймгийн орон нутгийн сэтгүүлч Т.Батбаатар хөөрөлдөж Сонгино сумын нэгэн цаг үеийн үүх түүхийг нэгд нэггүй яриулсан байх бөгөөд тэр бүгдээс дээхэн үеийн Засагт ханы шилийн эрчүүдийн талаар хүүрнэснийг нь толилуулья.

Батбаатар чи Сонгино сумын 80 жилээр сонин гаргахдаа сумынхаа шилийн сайн эрүүдийн тухай бичихгүй яасан юм бэ? Сонирхолтой шүү дээ. Дээр үеийн шилийн сайн эрчүүд гэдэг чинь ёстой шагай шиг нэл шөрмөс болсон хүмүүс байсан гэж байгаа юм. Сайн эрсийн авгай нар хүртэл тусгай хүмүүс байсан юм билээ. Манай нутгийн хамгийн сүүлийн сайн эр Даш-Ашаагаар л дуусах шив дээ. Сонгины энэ нутгаар шилийн сайн эрийн түүх их бий. Чамд ганцхан түүхийг ярьж өгье. Данжаахай гэдэг их түүхтэй хүн байсан юм билээ. Шилийн эр Данжаахай Увсад баригдчихаад шоронд сууж байж л дээ. Гэтэл Нөмрөгийн нэг нөхөр Увсын шоронгоос суллагдаад нутаг буцахдаа Данжаахайтай уулзаж гэр орон луугаа хэлүүлэх зүйл байна уу гэж асуусан байна. Хариуд нь Данжаахай “Сонгино сумын нутгийн хойд талаар Олонбулаг гэдэг газрын ойролцоо Данжаахай гэдэг нэг айл байгаа. За чи түүгээр очоод сураглаж байгаад тэр айлд ороод хоол цай хийлгэж дайлуулж цайлуулаарай. Тэгээд ингэж хэлүүлж байна гэж хэлээрэй. “Би Увсын шоронд сууж байна. Энэ өвөл ер нь их хатуу өвөл болох төлөвтэй. Нэг муу өнчин цагаан ишиг байгаа түүнийг л сайн маллаж онд оруулахыг бодоорой, би эндээс хаашдаа гарахад хэцүү боллоо” гэсэн үг дамжуулаатах гэж захисан байна. Нөгөө нөхөр нь “Үгүй ердөө, нэг муу өнчин ишгэнд ингэтлээ санаа зовоод байхдаа яахав дээ. Өөр захих зүйл байгаагүй л юм байх даа” гэж дотроо бодоод замд гарч. Тэгээд сурагласаар байгаад нөгөө айлд очсон юм гэнэ лээ. Гэрт нь орсон чинь нэг муу намхан хар авгай байж байх юм гэнэ. Тэгээд “За би Увсын шоронгоос суллагдаад явж байгаа хүн байна аа. Данжаахай гэдэг хүн намайг гэрээрээ нэг ороод гараарай гэсэн юм” гэхэд өнөө авгай “Өө та дээшээ суу” гээд л цай хоол болоод явчихаж. Тэгээд нөгөө хүн ойр зуурын хууч хөөрч байгаад Данжаахайн хэлсэн нөгөө үгийг хэлсэн байгаа юм. Гэтэл авгай “Энэ өвөл хатуу өвөл болох нь мэдэгдэж байна лээ, мэдэгдэж байна лээ. Би багцаалсан юм” гэж хэлээд тэр хүнийг явсаны дараа нөхрийнхөө гаансны төө илүү урт цагаан соруулыг шар эсгийнд боогоод тарваганы нүхэнд хийсэн гэж байгаа юм. Тэгээд нэг их удаагүй байж байтал Увсаас тэднийд нэгжлэг хийхээр хүмүүс ирээд юу ч олоогүй гэдэг. Тэр цагаан гаансыг нуусан нь эд хөрөнгө гэдэг талаасаа биш юм. Харин тэр нь Данжаахайг хулгайд гэрчлэх зүйл байж л дээ. Яасан гэхээр хулгайд малаа алдсан тэр нутгийнхан “Их сайхан урт цагаан гаанстай хүн манай үүгээр явсан. Тэр хүн л морьдыг минь хөөгөөд явчих шиг боллоо” гэж мэдүүлсэн байж. Хашир Данжаахай болохоор “Надад тийм гаанс байхгүй ээ” гэж мэдүүлсэн байгаа юм. Ингээд гэрт нь нэгжлэг хийхэд тийм гаанс гарч ирээгүй учир нотлох баримтгүй гээд Данжаахайг Увсын шоронгоос суллаж байсан гэдэг. Тэгэхээр тэр авгай мөн ч ухаантай байгаа биз. Сайн эрсийн авгайчуул хүртэл өөр байдаг гэдгийн нэг баримт энэ. Ер нь бол манай Сонгино суманд дээхэн үед олон сайн эр байсан юм билээ. Хамгийн сүүлчийнх нь Даш-Ашаа. Түүний өмнөх нь Данжаахай. Данжаахайг есөн эрүү давсан гэж ярьдаг юм билээ. Түүнээс өмнөх нь болохоор “Шар” Жамбал. Одоо Их Хонгилийн дээр түүний уяа нь байдаг. За тэгээд Баярмагнай, Баавай, Махбал, Лхасүрэн нарын шилийн эрчүүд байсан. Одоо энэ

Уртын дээд талд Лхасүрэнгийн уяа гэж байгаа шүү дээ. Би шилийн сайн эрсийг сонирхохоос гадна өөрийнхөө үеийн жаахан тиймэрхүү этгээд хүмүүстэй их нөхөрлөдөг байлаа. Яагаав нөгөө муу Авиа надтай их цуг явна. За тэгээд Пүрэвдорж, “Лугзад” Лутаа нар надтай мөн ч их цуг явсан даа. Яс юман дээрээ Авиа чинь их аймхай хүн байсан юм шүү дээ. Түүнийг Улиастайн гүүрэн дээр Дэмидтэй цуг явж байхад нь Улиастайн хэдэн хулигаан банди хоргоогоод “Ийшээ гараад уулзчих уу” энэ тэр гэж л дээ. Тэгсэн Авиа “За одооны хүүхдүүд аргагүй ээ. Та нар намайг дуулаагүй байх. Баатар зээлийн дошин дээр намайг хоргоодог хүүхдүүд бол овоо байж таарна. Зайгаа авчих уу” гээд ухарсан чинь нөгөөдүүл нь пир хийтэл зугтаж алга болсон гэдэг. Тэгмэгц Авиа “Баатар зээлийн бөөрөнхий чулуу, бандааш нь томдсон банди хоёрыг би мэднэ шүү дээ” гэж Дэмиддээ томорсон гэж байгаа юм. Том үг, том бие хоёроороо тэгж сүрдүүлэхгүй юу. Ээ, мөн холионы хүн шүү.

## **Халх дөрөв, шавь таван аймагт алдаршсан “Дөрөөт” Тэгшбүрэн**

Халх дөрөв, шавь таван аймагт “Гайхал ах”, “Сарвагар” Адьяа, “Хэрээ” Лхагва, “Чавганц” Дампил, Өвөрлөгч нутаг буюу дөрвөн Ойрадад “Тусч” Бүрэн нэрээр алдаршиж таван өөр хүн мэт яригддаг байсан нэгэн домогт эрийн тухай баруун аймгийнхан өнөө хэр дурсдаг аж. Энэ хүний тухай Говь-Алтай аймгийн харъяат, Их мянган овогт Жанцангийн “Жаахан” Болд хүүрэнэсэн бөгөөд тэрбээр аймаг, сумынхаа алдар цуутай хүмүүсийн тухай ном туурвиж байсан авьяаслаг нэгэн билээ. Тэрбээр хөрөг нийтлэлийнхөө өмнөтгөлд “Засагт хан аймгийн Тарган баатар вангийн хошууны “Анигар уургач” Амбаагийн хүү “Дөрөөт” Тэгшбүрэн хэмээх энэхүү сайн эрийн тухай өгүүлэхийн тулд түүний үр ач болох Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын багш Гомбын Доржсүрэн, “Хүч” бөөний төвийн худалдааны төвийн захирал, Баян-Уул сумын нутгийн зөвлөлийн дарга Гомбын Доржпалам нарын дурсамж яриа, тус нутгийн зохиолч Б.Шүрхүүгийн дурдатгал болон учир мэдэх хөгшчүүлийн яриаг үндэслэн бичлээ. “Гайхал ах” хэмээх энэхүү домогт эр өвдсөн хүнд оточ, нярайлсан хүнд ээж, өвгөд хөгшдөд тусч, өнчин өрөөсөн нялхаст өглөгийн эзэн гэж хүндлэгдсэн нэгэн байж. Харин тэрбээр мууг басамжлагч, доордыг зиндаархан дээрэлхэгч харгис түшмэд, баян ноёдтой хайр найргүй тэмцдэг, тэдний адуу малыг хэдэн өртөөний цаана байсан ч хамаагүй авах гэснээ авдаг, унах гэснээ унадаг, тэгсэн хэрнээ үзэгдэх мөргүй, харагдах бараагүй, сураглах нэргүй алга болдог жаатай эр байжээ” гэж өгүүлсэн байв.

### **“Гайхал ах” гайхашралыг тайлсан нь**

Дээхэн үед Баатар ван, Түшээ гүний нутгаар доншуур наймаачин Ни Зо Лин гэгч хятад эр тэмээтэй ачаа хөтлөн худалдаа хийж явдаг байж. Тэр наймаачин “Би Бээжин орж шинэ бараа авч ирнэ. Юу захих вэ” гээд тус нутгийн ардуудаас элдэв шалдав захиалга аваад ердөө тав зургаахан хоногийн дараа “Бээжин ороод ирлээ” гээд шинэ бараа аваад ирдэг байжээ. Шилийн сайн эр “Гайхал ах”-ыг айлуудаар бууж мордох үед түүнээс хол ойрын сонин хачин дуулж сонсохоор нутгийн ардууд шавааралддаг байсан бөгөөд нэг өдөр нутгийнхан нь түүнд хандаж “Доншуур наймаачин Ни Зо Лин зургаахан хоногийн дотор Бээжин ороод ирлээ гэх юм. Бээжин ийм ойрхон байдаг юмуу” гэж асуужээ. “Гайхал ах” хариуд нь “Цаад доншуур чинь Бээжинд зургаа хоноод ирдэг юм бол би өглөө гараад орой хүрээд ирье л дээ. Та нар юу захих вэ” хэмээжээ. Тэгээд тэднээс баахан захиас аваад маргааш өглөө нь Бээжин явахаар хөдөлсөн байна. Тэгтэл нээрээ орой нь баахан эд бараа ганзагаласаар хүрч ирсэн бөгөөд энэхүү үйлдэлээрээ тэр нутгийнхаа ардуудыг ёстой л гайхашруулах шиг болжээ. Эцэст нь тэрбээр “Ямар юмных нь Бээжин ороод ирэх байх билээ дээ. Ни Зо Лин бид хоёрын Бээжин энүүхэн Сүжигт гүний хошуунд, манай Хүйсийн говь, Шаргын говь хоёрын заагт Даашинхүүгийн пүүсийн суурин хэсэгт байдаг байхгүй юу. Ни Зо Лин тэр хашаанд та нараас авсан арьс үсээ буулгаад оронд нь та нарын захиасыг авч доншуучилсаар тав зургаа хоноод ирдэг юм шүү дээ. Та нар гайхаад, цаадах чинь гайхуулаад байх юм юу ч байхгүй” хэмээн үнэн учрыг тайлж өгч байсан гэдэг.

### **“Сарвагар” Адьяа ШАРГын голынхныг гайхашруулсан нь**

“Дөрөөт” Тэгшбүрэн буюу “Сарвагар” Адьяа нэг удаа Сайн ноён хан аймгийн нутагт олон хоногийн зүсэр бороонд саатжээ. Тэгээд тус нутгийн Шаргын голын хавьцаа байх шавар ус



болсон хот айлд ирж хамгийн захын айлд буугаад мэнд усаа мэдэлцээд сууж байтал гадаа нь “Хүүхэд усанд урсчихлаа, тус болооч” гэх дуу чимээ хадаж хот айлынхан сандралдаад явчихаж. Тэгмэгц “Сарвагар” Адьяа хөтөлж явсан морьдоосоо нэгэн шарга морийг зайдалж унаад улаан хоормогоор үерлэсэн гол руу давхиад орчихжээ. Тэгээд гар нь гозолзон живж буй хүүг уснаас шүүрэн авч морин дээрээ дүүрч ирээд голын эрэг дээр түрүүлэг нь харуулан хэвтүүлээд залгисан усыг нь гаргасан ч хүүхэд ухаан орсонгүй. Тиймээс Адьяа тэнд байсан хүмүүст хандаж “Та нар гэр гэрийнхээ тулганаас бүлээхэн үнс аваад ир” гэж тушаажээ. Хүн болгон л гэрээсээ үнс авчирсан байна. Төдөлгүй Адьяа мөнөөх хүүгийн биеийг үнсээр битүү хучиж, улмаар норж нэвтэрсэн хэсгийг нь бүлээхэн үнсээр сольж хучсаар байж. Ингэж байсаар хоёр цагийн дараа гэхэд мөнөөх хүү ухаан орсон бөгөөд “Сарвагар” Адьяагийн энэхүү эрдэм чадлыг хараад Шаргын голынхон гайхан биширцгээжээ. Хүүгийн эцэг түүний өмнө сөгдөн мөргөж “Ямар гээчийн сайн үйлст эр вэ. Миний муу өнчин хүүгийн амийг аварлаа. Ядуу дорой ах нь ачтай буянтай таньд юугаа өгдөг билээ дээ” гэж сандрахад Адьяа “Таниас би юу авах билээ дээ. Харин энэ хүүгийн нэрийг өөрчилж Усны-Эх гэж нэрлээрэй” гээд хүүгийн амийг аварсан шарга морио мөнөөх ядуу эрд бэлэг болгон өгөхдөө “Сайн ноён ханы “Сарвагар” Адьяаг дурсч яваарай. Алсын замд эзнээ орхиж үзээгүй ажнай сайн хүлгийг минь хайр гамтай эдлээрэй” гэж захиж хэлээд нутгийн зүг одсон гэдэг.

## **“Чавганц” Дампил тамгын газрын тахарын гайхлыг төрүүлсэн нь**

“Дөрөөт” Тэгшбүрэн Түшээт ханы нутагт “Чавганц” Дампил нэрээр нэг хэсэг бужигнуулжээ. Нэг удаа Түшээт ханы жасын агуулахаас нанжин гахай гөлөм тавин ширхэг, хонин тогоо хорин ширхэг, торхтой тос арван ширхэг алдагдахын зэрэгцээ түлээ зөөдөг арван сайхан шар нь бас үгүй болжээ. Энэхүү хэрэгт тамгын газрын тахарууд “Дөрөөт” Тэгшбүрэн буюу “Чавганц” Дампилыг сэжиглэн байцаасан байна. Тэгтэл мань эр “Би тэр шилийн хулгайч Дампил чинь биш ээ. Та нар шилийн сайн эр, нэг муу явган нүцгэн мөргөлчин хоёрыг ялгаж салгадаггүй яасан хачин улс вэ. Би Амарбаясгалант хийд орж төрсөн дүү Эрдэнэхамба хутагттай уулзахаар явж байгаад муу санаат хүний үгэнд орж төөрөөд явж байтал ийм юм боллоо. Над шиг ийм явган нүцгэн хулгайчийг та нар халхын хавтгайгаас олохгүй байлгүй. Миний хутагт дүүгийн таних тэмдэг болох энэ хөөргийг халх дөрөв, шавь таван аймагт андахгүй” гээд гарын атганд багтахгүй том чүнчигноров хөөргөөр тамхилжээ. Тэгээд тэр “Чавганц” Дампил гэдэг чинь над шиг ийм жол эр биш, шилийн нарс шиг сайхан эр байхгүй юу гэхэд тамгын газрын тахар “Тийм байлгүй дээ. Тэрэгтэй арван шар, олон торхтой тос, 20 ширхэг тогоо, 50 гөлөм шингээж байхыг бодоход явган нүцгэн хүн яавч биш. Ганцаараа ч биш олуулаа байж таарна. Би саяхан таны дүү Эрдэнэхамба хутагтад мөргөөд ирсэн. Лагшин нь тунгалаг байна лээ. “Чавганц” Дампил гэгчээс гадна “Сарвагар” Адьяа гэж нэг сайн эр дуулдаад байх боллоо. Энэ Адьяаг таньтай их адилхан гэж хүмүүс ярих юм” гэхэд мань хүн “Чавганц, Сарвагар хоёрыг манай Түшээт ханыхан андахгүй ээ. Тэд нар чинь над шиг богино хөлийн улс биш. Гурван сараар давхиж, арван таван өртөөнөөс цаашихыг цэгцэлдэг эрчүүд байхгүй юу” гэх зэргээр маанагтуулж байгаад өөрийгөө суллуулаад явж одсон гэдэг. Үнэн хэрэгтээ жасын агуулахаас алдагдсан нанжин гахай гөлөм, хонин тогоо, арван тооны амбан шар тэргүүтнүүд бүгд түүний гараар орсон байгаа юм.

## “Хэрээ” Лхагва хот айлыг гайхашруулсан нь

“Дөрөөт” Тэгшбүрэн Сан бээсийн хошуу хавиар “Хэрээ” Лхагва нэрээр алдаршжээ. Нэг удаа “Хэрээ” Лхагва хэмээх төв сайхан хувцастай цэмцгэр эр хошуу ноёны дүүгийн хот айлын уян дээр бууж хамгийн зүүн талын жижиг гэрт оржээ. Хижээл насны эмэгтэй түүнд цай хийж өгөнгөө хэт нутаг, хэрэг зоригийг нь асуугаад “Хошуу ноёны дүү манай эзэн байгаа юм. Эдний хүүгийн бие их муу байгаа. Хол ойроос ирсэн хүн болгон л биеийг нь эдгээх гэж оролдох юм. Гэсэн ч засрал олсон юм алга. Танд аврал байна уу” хэмээн горьдсон харцаар ширтэхэд “Хэрээ” Лхагва “Хөөрхий нялх амьтаныг зовлонгоос нь салгаад өгчих юмсан. Аав ээж нь дээдсийн удам юм бол харц надаар юу гэж л үзүүлэв гэж дээ. Тэр хүүг нүдээрээ үзэж, гараараа барьж байж л арга чарга байгаа үгүйг хэлнэ дээ” гэхэд гэрийн эзэгтэй “Одоохон” гээд гарч оджээ. Удалгүй орж ирээд “Таныг морилон ирнэ үү” гэж дээдэс залж байна” хэмээжээ. “Хэрээ” Лхагвыг хошуу ноёны дүүгийн ороход хүнд өвчин туссан гэх хүүгийн хөл ташаагаа тултал түлэгдсэн, тэр нь эвгүй үнэр орчихсон байж. Ингээд “Хэрээ” Лхагва түүнийг эмчлэхээр болжээ. Тэрбээр эхийн нь шээсээр хүүгийн хөлийг угааж цэвэрлээд өврөөсөө нандин боодолтой юм гаргаж бүлээн хар цайнд дүрж тэнийлгэн түлэнхий дээр нь тавьж боогоод хүүд нэг тан уулгажээ. Тэгээд аав ээж хоёрт нь хандаж “Энэ хүүхэд нам унтаад өглөөг үзвэл хурдан эдгэнэ. Харин наана нь сэрж зовиурлавал үүнийг өгөөрэй” гээд нэг тан өгөөд явахаар босчээ. Тэгтэл хүүгийн эцэг “Та түр саатаж хайрла. Бид хүүгээ халуун сүүнд түлчихээд сайн гэснийг нь түрхэж, наашаа харсаныг нь ачтан гэсээр байгаад улам хүндрүүлчихээд байгаа улс. Та хүүгийн биеийн байдлыг харж саатаж өгөөч. Би шан харамжийг сэтгэлээсээ өгнө” гэж гуйсан байна. Хариуд нь Лхагва “Би Сан бээсийн хошууны “Хэрээ” Лхагва гэдэг хүн байна. Баруун зүгт бас нэг зовж зүдэрсэн улсыг илааршуулах ажлаар явж байна. Одоо ингээд хөдөлөе дөө” гэснээ унтаж буй хүүгийн хөлс бурзайсан духыг харсанаа “За миний сэтгэл амрах шиг боллоо. Энэ хүүгийн өвдөлт илааршиж тайван сайхан унтаж байгааг харж байна уу” гээд духан дээр нь үнсчээ. Тэгээд аав ээж хоёрт нь хандаж “Та нар энэ сайхан хүүг эрүүл энх өсгөчихөөд эргүй мулгүй арчаагүй явдлаар татанхай түлэнхий үйлт амьтан болгож нүгэл эдэлж суух ямар байх билээ. Чимээг нь чагнаж бай, хонхон дуугаар аргамж. Дээлний ухаадсыг нь хүртэл цагаан сэтгэл, тэнгэрийн аврал, газрын лус аргадаж явуугаар даруулан хаддаг байтал самарч байсан сүүндээ түлнэ гэдэг юу гэсэн үг вэ” гэж хэсэг зэмлээд явах гэснээ “Миний яардаг зөв үү, буруу юу. “Ганган” Төгс амжуулсан бол сайн хэрэг, амжуулаагүй бол би хардагдаж аюул болно” гэж дотроо бодоод хүүгийн илааршихийг хүлээхээр шийджээ. Тэгээд хошуу ноёны дүүгийн гурав хоногийн турш дайлуулж цайлуулсан байна. Энэ хооронд хүүгийн түлэнхий өвчин намдаж, шаналж ёолох дуу нь инээдээр солигдоод иржээ. Ингээд “Хэрээ” Лхагвыг нутаг руугаа мордох үед гэрийн эзэн талархалын үгтэй богц дүүрэн бэлэг өгөөд түүнийг гүвээ давтал гаргаж өгөхөөр болсон байна. Тэгээд явах замдаа “Манай ах ноёны гурван азарга адууны саарал азаргатай адууг хулгайч аваад хоёр хонож байна. Мөр нь урагшаа гараад зүүн тийшээ зүглээд алдарсан гэлцэх юм. Таны зам зуур сэжигтэй хүн тааралдвал хэл хүргүүлж тус болоорой” гэхэд “Хэрээ” Лхагва “Ах нь саарал зүсмийн адуунд үнэн голоосоо дургүй. Ер нь би шанам малгайтад талгүй, сайрхуу эртэй нийлэмжгүй, яарсанд дэм өгч, ядарсанд тус хүргэж, задарсанд зараа болж, замбараагүйд цэгц болж явдаг хүн болохоос биш хулгайчийг мөшигж, худалчийг залруулж явдаг хүн биш” гэж хэлээд мориндоо ташуур өгчээ. Тэгээд хот айлаас холдмогцоо хулан хар мориныхоо чихэнд “Цаана чинь “Ганган” Төгс галаа асаагаад, олзоо бөхлөөд, чулуу таслаад сууж байгаа. Одоо

хоёулаа түүн дээр дөгийгөөд буучихна аа” гэж шивнэхэд хулан хар нь хандгай шиг хатирч, шувуун гөрөөс шиг цахилжээ. “Хэрээ” Лхагва

“Баруун суганд нь өссөн Баян богдын бараа

Барга, Цахарын нутгаас харагдаад байна уу

Барагтай ирэхийг захисан ээжийн минь үг

Баруун чихэнд минь шивнэн ховшоод байна уу

Замын шүншиг нь өлзийтэй Өлийн даваа

Захчин, Торгуудын нутгаас үзэгдээд байна уу

Жудагтай явахыг захисан аавын минь үг

Зүүн чихэнд минь шивнэн ховшоод байна уу

Даахиа угаасан Ганга-Хавхаасын ус нь

Дархад, Буриадын нутгаас амтагдаад байна уу

Давхар ухаантай Со засгийн минь үг

Далан өртөөний цаанаас шивнэн ховшоод байна уу” гэж дуулсаар хоёр өдөр, нэг шөнийн зам туулж Засагт ханы “Ганган” Төгсийн хүлээж байсан газар дөрөө мулталсан гэдэг. Засагт ханы Тарган баатар вангийн хошуунд “Гайхал ах” гэж алдаршсан “Дөрөөт” Тэгшбүрэн хэмээх сайн эр өвгөн болсон хойноо нутгийнхаа ардуудад хандаж “Би нэгэн цагийн цуутай шилийн эр “Ганган” Төгсөөр заалгасан хорин нэгэн чулуу таслахыг төөрч хэлэлгүй өтөллөө. Цахиур мэргэнээр заалгасан усгүй говь, замгүй тал, чонотой уул, баавгайтай хөвчид төөрч мунгинаж үзэлгүй өвгөрлөө. Засагт ханы цуутай бариач Шаазгай ахайгаар заалгасан хүн малын бэртсэн ясыг илааршуулах буян номын ид шидийг алдаа эндэгдэлгүйгээр хэрэгжүүллээ. Торгуудын “Тас” Номидын заасан уулзсан хүний хэлэх үг, хийх ажлыг нүдээр мэдэж, үгээр баталсаар өнөөдрийг хүрлээ. Аавынхаа заасан уургат бугуйлын ажлыг цасан шуурга, усан бороо, өдөр шөнө, өглөө үдэш, уул хад, шавар хайрга гэлгүйгээр алхан толгойд алдаж харамсалгүй өдий хүрлээ. Ээжийнхээ заасан учиг шингээх, уух цайгаа чанах, хангай дэлхийг аргадах, хан тэнгэрийг дээдлэх хүмүүн ёсыг дагаж лусад хорлогдолгүй, савдагт эрсдэлгүй насыг барж байна даа” гэж хуучилдаг байжээ.

## Мөнгөн тайгын “Улаан” Буядаа

Шилийн эрийн замаар замнаж яваад аргагүйн эрхэнд их замын дээрэмчин болчихсон хүн мэр сэр байдаг. Тэдний нэг нь далаад оны үед баруун аймгуудад нэр цууд гарч явсан “Улаан” Буядаа гэгч ажээ. Энэ эрийн тухай Увс, Баян-Өлгий, Ховд аймгийнхан янз бүрийн л дурсамж яриа хүүрнэж байдаг. Тиймдээ ч “Улаан” Буядааг дал, наяд оны баруун аймгийнхан “Мөнгөн тайгын их замын дээрэмчин” гэж нэрших болсон байна. Алс тэртээх баруун хязгаарт “Асгат” хэмээх эрдэнэсийн орд байдаг. Гадаадынхан, ялангуяа оросууд “Асгатын мөнгөний орд” гэхээр нүд нь сэргээд ирдэг. Асгатын орд бүхий Асгат хайрхантай хүй залгаа нутаг бол ОХУ-ын “Мөнгөн тайга”-ын район бөгөөд битүү ой мод, бэрх хэцүү зам харгуйтай энэ нутаг эрт цагаас эхлээд хол ойроос хазаар гүйлгэгсэдийн цөсийг шалгасаар ирсэн түүхтэй аж. Асгаттай хил залгаа Горно-Алтайн хязгаар ч энэ нутагт багтах бөгөөд ухаандаа Алтайн хязгаарын шилийн сайн эрчүүд Орос, Тувагийн нутгаас адуу мал хөөж туухдаа энэ л нутгаар дамждаг байж. Соц нийгмийн үед тэдний ёс заншил, арга барилыг “Улаан” Буядаа гэгч залгамжлан гарч ирсэн ч харамсалтай нь шилийн эрчүүдийг шилдэгээр тодруулдаг бус ширвэж хаядаг нийгэм байсан болохоор мань Буядаа нутгийнхаа ардуудаас сайн нэр дуулж байсангүй. Түүнийг “Шилийн сайн эр” гэж хүндлэхийн оронд “Малын хулгайч” гэж нүд үзүүрлэх жишээтэй. Ийм нэгэн золгүй тавилантай эр нэг үе “Мөнгөн тайга”-ын ой хөвчөөр бүгж, орос, монгол иргэдийн мал хөрөнгийг хооронд нь хольж солин ёстой л нэг дураараа дургиж байсан юмсанж. Мань эр зөвхөн Горно-Алтай, “Мөнгөн тайга” хавиар бүгээд байсангүй. Увс нуур, Тэсийн гол, Асгатын орд газрын ойролцоох Ногооннуур сум, алдар түүхтэй Толбо нуур, Дэлүүн сумын нутгийг дамнаж Хар тарвагатай, Булаг-Өндөр, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Сагсай, Улаанхус сумын нутгаар хөндлөн гулд давхиж явсан байх бөгөөд монгол эрчүүдийн алсын замд морь малаар зорчих яс чанар илэрхий муудаж машин тэргэнд хамаг найдлагаа тушааж явсан соц нийгмийн үед морин дэлэн дээр ингэж дэрвэж явсаныг нь бодохоор өөрийн эрхгүй биширмээр. Гэхдээ түүний явдал суудлыг Манжийн үеийн шилийн сайн эрчүүдийн явдал суудалтай зэрэгцүүлээд үзвэл инээдтэй л дээ. Манжийн үед манай шилийн сайн эрчүүд ямар байсан гээч. 19-р зуун бол Монгол орон шилийн сайн эрчүүдээр дүүрэн буцалж байсан үе билээ. Тухайн үед Хянганы нуруунаас Ил Тарвагатай, Тэнгэр уул, Алтайн уулс хүртэл, Сияаны тайга, Байгаль нуураас урагшаа Хөх нуур хүртэлх өргөн удам нутагт амьдарч байсан монголчуудад Манж Дайчин Чин гүрний төрийн хууль цааз үйлчилж байсан цаг. Гэвч отго жинстэй ноёд толгой бөхийн сөхөрдөг байсан энэхүү Манжийн хууль цаазыг огт тоосон шинжгүй “бөгсөө арчиж” явсан хэнэггүй хүмүүс бол тэр цагийн шилийн сайн эрчүүд байлаа. Манж дайчин гүрний Тэнгэрийн тэтгэсэн хааны 1762 оны мутрын үсэгтэй “Халх журам” хуулинд “Суурин худалдаачдыг тонон дээрэмдэж үл болно. Айлган сүрдүүлж тонон дээрэмдсэн тохиолдолд гэмтэнийг огтчин алах цаазын ялаар гэсгээн цээрлүүлмой. Нүүдэлчин иргэдийн өмч болох мал сүргээс хулгайлан завшсан этгээдийг хугацаагүй цэргийн албанд цөлөх, гар хөлийг нь цавчин мухарлах, хулгайн хэргээ дахин давтан үйлдвэл эзгүй цөлд ширлэж алах ялаар шийтгэмой” гэж заасан байдгаас үзэхэд Манжийн хууль нэлээдгүй хатуу чанга байсан нь ойлгогдоно. Гэвч хээрээр гэр, хэцээр дэр хийж явсан шилийн эрчүүд Азийн зүүн талыг тэр аяар нь улан доороо гишгэж явсан Манжийн хааны харгис хатуу хууль цааз айлын нохой хуцсан дайны санагддаггүй байж. Шилийн эрчүүд Хөх нуураас Тагна Урианхайн хязгаар хүртэл, Хянганы нуруунаас Тэнгэр уул, Ил тарвагатай хүртэлх өргөн удам нутгийг агтны туурайгаар тамгалж, хүлгийн сайныг шилж унан дур зоргоороо

жигүүрлэн нисч явсан байдаг. Тэр үед Монголын зүүн хязгаарт “Торой” Банди тэргүүтэй шилийн эрчүүд Дарьганга нутгийг агтны туурайгаар тамгалаад зогсохгүй урагшаа өвөрлөгч 49 хошууг нэлэнхүйд нь гүйцээдэг байсныг бодохоор үнэхээр бахархмаар. Гэвч энэ нь Чингисийн байлдан дагууллын хажууд бас л юу ч биш. Тэр үед Дэлүүн болдогоос Самарканд орох нь жирэмсэн эмийн шээх газар байсан гээд л бодчих. Ингээд бодохоор дэлхийн талыг агтны туурайгаар тамгалж явсан эртний монголчуудыг бишрэхгүй байхын аргагүй. Тэглээ ч Увс, Баян-Өлгий аймгийн нутгаар хөндлөн гулд давхиж явсан “Улаан” Буядааг нэг их “доош нь хийх” шаардлагагүй л дээ. Яагаад гэвэл мань эр орчин үеийн монгол эрсийн яс чанарыг баруун аймгийнханд хангалттай мэдрүүлсэн байдаг. Даанч сүүлдээ их замын дээрэмчин болж хувирсан нь нэг тиймэрхүү. Гэхдээ оросууд болон тувачууд өөрсдөө түүний дургүйг хүргэж байгаад дийлдэшгүй дайсантай болоод авсан байдаг. Нэг удаа “Улаан” Буядаа Горно-Алтайгаас хэдэн адуу хөөж яваад орос, тува нийлсэн дөрвөн нөхөрт баригдчихсан юм байх. Тэд түүнийг нэвширтэл зодож нүдсэний эцэст амьдаар нь нохой шувууны хоол болгохоор хүн амьтангүй битүү хөвчид модноос хүлж орхиод явчихсан байгаа юм. Энэ нь дэндүү хүн чанаргүй үйлдэл байлаа. Тэглээ ч “Улаан” Буядаагийн амьд явах хоногийн тоо нь арай дуусах болоогүй байсан ч юмуу, түүнд гэнэтийн аз таарсан гэдэг. Адуу малаа хайж явсан нэг өвгөн тааралдаагүй бол мань эр орос, тува нарын сэтгэсэнээр нохой шувууны хоол болох байж. Энэ цагаас эхлээд Буядаа “Цусан өшөө” зангидана гэдэг шиг л орос, тувачуудыг үзэж чадахаа байсан байна. Гэхдээ тэр цусан өшөө авах маягаар хүний амь хөнөөж явсангүй. Зам зуурт тааралдсан орос, тува нарыг дээрэмдэх, тэдний эд зүйлсийг хулгайлах маягаар “занималдаж” байгаад л “Мөнгөн тайгын их замын дээрэмчин” хэмээх нэр хоч зүүх болжээ. Буядаа багадаа жирийн л малчны гэрт өсч торнисон, харин мэдээ орсон цагаасаа эхлээд сургуулиас бултаж, багшаас баашилж холдсон сурлага номдоо маруухан хүүхэд байж. Түүнийг бага байхад хөдөө сумдын арван жилийн сургуулийн хүүхдүүд анги танхимаа орхиод хөдөө гэр лүүгээ оргодог үзэгдэл элбэг байж. Буядааг дөрөвдүгээр ангид сурч байх үед гэр нь Байрамын даваа, Долоон толгой хэмээх газар нутагладаг байсан бөгөөд сумын төвөөс явган нүцгэн гарсан бага насны хүүхдэд 100 гаруй км явж гэр орондоо эсэн мэнд очно гэдэг бардаг ажил, давдаг даваа биш байжээ. Тэглээ ч “Улаан” Буядаа яаж ийгээд л харьчихдаг байж. Бусдын чөдрийн морийг хулгайлаад чөдөр, аргамжаар нь оосорлоод л хөл залгачихдаг байсан нь түүнийг хар багаасаа хээрээр гэр, хэцээр дэр хийж явах одонд төрсөн болохыг илтгэнэ. Буядаа ийнхүү оргож зугтах маягаар үлгэн салган явсаар долдугаар ангиасаа сургуулиасаа бүрэн завсарлагдаж эрх чөлөөтэй болсон байна. Түүнчлэн малчин аав ээждээ тусалж, том эр хүн болсоноо хэд хэдэн удаагийн малын эрэлд амжилттай явснаараа баталж чадсан байна. Үнэндээ малд нүдтэй, эрлийн одтой түүнийг хээр гадуур юу хийж явааг аав ээж, ах дүүс нь төдий л анзаарсангүй. Энэ байдлаараа тэр бие даасан шийдвэр гаргаж, өөрийн малыг байтугай өрөөлийн малыг олоод “идчихдэг” болжээ. Тэрбээр 18 нас дөнгөж хүрмэгцээ шилийн сайн эр болохоор зориглон шулуудаж Мөнгөн тайгаар хил давсан байгаа юм. Тухайн үед Орос, Монголын хил дээр харуул хамгаалалт гэж нэр төдий байсан болохоор амных нь салиа арилаагүй бяцхан эрд ийм том боломж олгосон байдаг. “Улаан” Буядаа тэр үед хүүхэд гэхээргүйгээр томоор сэтгэсэн байгаа юм. Тэрбээр Оросын талаас сементаль үүлдрийн хэдэн үнээ оруулж ирэх овоо том төлөвлөгөө боловсруулжээ. Тухайн үед сүү сааль ихтэй, мундаг том дэлэн хөхтэй сементаль үүлдрийн үнээ Монголын зарим нутагт ид шүтээн болж байсан цаг. Манай зарим аймгийн дарга нар тэр үед “Казахын цагаан толгойт олж ирж сүү саалийнхаа төлөвлөгөөг давуулан биелүүлнэ” гээд л хойд хөршийг зорьдог байлаа шүү дээ. Арван найман настай Буядаа амьхандаа аймгийн даргын хийдэг ажлыг бүтээх гэж хэтэрхий том сэтгэсэн хэрэг.

Гэвч энэхүү том санаа нь бүтэлгүйтэх тийшээ хандсан байна. Яасан бэ гэхээр ямар ч туршлагагүй залуу хулгайч Буядаа орос иргэдийн үнэтэй цайтай сементаль үүлдрийн үнээг зүгээр л сул задгай бэлчиж явдаг гэж бодож л дээ. Холоос дурандаж үзэхэд үхэр малын ойролцоо ямар ч хүн байсангүй. Тиймээс тэр дэнхийсэн өндөр биетэй, цагаан толгойтой сүрэг үхрэн дээр тавиад буучихаж. Өөрийн юм шиг туугаад хилийн дээс алхчихвал сүрэг үхэр түүнийх болох байлаа. Ердөө дөрөв тавхан км газар туухад л хүсэл нь биелэх байв. Гэвч оросууд үхэр малынхаа хөлийг төмөр гинжээр чөдөрлөөд цоожилж орхидог байсныг шинэ залуу шилийн эр “Улаан” Буядаа мэдсэнгүй. Тэднийг малаа гавлаж хадгалдаг гэсэн ойлголтгүй явсан Буядаагийн уур ундууцал дээд цэгтээ тулж ямар сайндаа л идээшилж байсан нэг үхрийн толгой руу маш чанга өшиглөж орхисон гэдэг. Гэсэн ч тэр шантарсангүй. Үхэр малаа хүртэл гавлаж гяндалдаг орос тосгоныхонд ихэд дургүй нь хүрсэн тэрбээр “Энэ муу хэдэн адсагыг чинь авахдаа л нэг авна даа” хэмээн шүд зуун занаж байсаар нэгэн арга сүвэгчилжээ. Тэгээд мөнөөх дургүйг нь хүргэсэн орос тосгоныхныг үнээгүй болгохоор хэдэн өдрийн турш холоос дурандсан байна. Тэгтэл нэг орой хамтралынхан сементаль үүлдрийн үхэрнүүдийнхээ гав гинжийг тайлж хашаанд нь оруулаад найрлаж гарах нь тэр. Тосгон руу хэтэрхий ойртож очсон Буядаад баян хуур хөгжмийн дуу, тип тап хийтэл бүжиглэх чимээ сүрхий чангаар сонсогдож байлаа. Хэрвээ бүтэлгүйтээд буцаж зугтлаа гэж бодоход нуугдах бартаатай газар морио уяж орхисон нь дээр гэж Буядаа агшин зуур сэтгээд авсан байгаа юм. Тэгээд тэр тун болгоомжтой явсаар ухаан жолоогүй найрлаж байсан хүмүүсийн хажуухан талд ирээд нэгэн дүнзэн байшингийн араас бүхнийг тольдонгоо “Социализмыг ингэж л байгуулдаг юм байх даа” гэж шивнэж байсан гэдэг. Эр эм нийлсэн арав гаруй хүн уусан архиндаа мансуураад ид бужигнаж байх бөгөөд сүүлдээ зарим нь зогсоо зайгүй бүжиг танц хийснээс болоод хоёр хөл нь дайвалзаад суудал дээрээ лагхийтэл ойчоод өгөх нь харагджээ. Төдөлгүй бүрэнхий болсоноор найрлаж буй хүмүүс дотор эрүүл ухаантай хүн үлдсэнгүй. Чухам энэ үед “Улаан” Буядаа үхрийн хашаанд явж ороод хорь гаруй сементаль үхрийг хашаанаас зугуухан хөөж гарган өмнө зүгийг чиглүүлж орхиод эзэнгүй байсан нэг байшинд орж гал тогооны өрөөнөөс нь идэж уух юм авч өвөртлөөд, үүдний өрөөний нь хананд байсан хоёр амтай шувууны бууг авч үүрсэн байна. Хэрвээ хойноос нь хүмүүс хөөвөл өөдөөс нь буу тавих гэж тэр. Тэгээд мань эр урагш нь зүглүүлж орхисон хэдэн үхрээ туугаад хөдөлжээ. Гэвч шөнийн цагаар бэлчээрт явж сураагүй үхрүүд эргэж хашаа саравч руугаа гүйлдээд байж. Тэглээ ч шилийн хулгайч болох гэж нөр их хичээл зүтгэл гаргаж, үүний төлөө цуцалтгүй тэмцсэн “Улаан” Буядаа тэдгээр үхрийг яаж ийгээд л Мөнгөн тайга руу оруулж дөнгөсөн байгаа юм. Нэгэнт ийш нь оруулаад авсан болохоор түүнд айх аюул байсангүй. Яагаад гэвэл мансуурталаа согтож унасан хамтралынхан өглөөнөөс нааш сэрэхгүй. Харин өглөө сэрээд үхэрнүүдээ алга болсоныг мэдмэгцээ Мөнгөн тайга руу мөлхөх нь холгүй мацах нь ойлгомжтой. Тиймээс “Улаан” Буядаа үүр цайхаас өмнө Мөнгөн тайгыг туулж бараад нутгийнхаа зах сэжүүрээс атгаад авсан байхад л оросуудын гараас мултарчихлаа гэсэн үг. Үнэндээ ч тэр анхныхаа том олзыг шөнөжин тууж явсаар үүр хаярах үед нутгийнхаа барааг олж харжээ. Хүн гэдэг амьтан үр хүүхдээ хэзээ ч муу үйл хийхгүй байгаасай гэж боддог ч өөрт нь хэрэгтэй зүйлийг олоод ирсэн байхад ашигтай талаа бодолцоод арга буюу хувь тавилантайгаа эвлэрдэг тохиолдол бас бий. Яг л энэ жишгээр Буядаагийн аав түүнийг загнаж зандрахын оронд хаа холоос хулгайлаад ирсэн үхрүүдийг нь ихэд нууцалж байсаар өөр сумдын сүүн фермийн айлуудад хямд үнээр зарж амин хувьдаа овоо хөөрхөн цулайгаад ирсэн байгаа юм. Эцэг нь түүнийг анх ингэж өөгшүүлсэнээр “Улаан” Буядаагийн шилийн хулгайч болох зам мөр их л сайхнаар гэрэлтээд ирсэн гэдэг. Сүүлдээ мань эр Горно-Алтайгаас өндөр

зэгзгэр биетэй тоомсог адууг хэд хэдэн ч удаа хөөж авчраад нутгийн гүн рүү оруулаад “шахсан” байдаг. Гав гинжтэй сементаль үүлдрийн үхэр хөөгөөд ирсэн сүрхий эр ганц хоёроороо яваа тоомсог адууг бол ядах юмгүй тонших нь ойлгомжтой шүү дээ. Чухам ингэж манаргаж явахдаа орос, тува нийлсэн хэдэн хүнд баригдаад нохой шувууны хоол болох дөхсөн нь тэр. Энэ цагаас хойш мань эр “Мөнгөн тайгын их замын дээрэмчин” болж хувирсан бөгөөд нэг удаа тэрбээр өлсч цангахын эрхэнд давааны зам дээр отоонд гарчээ. Дотроо мэдээж орос, тува нарыг занасаар байж. Тэр үед Оросын хүнд даацын машинууд Мөнгөн тайгаас Хандгайт руу банз болон модон материал тасралтгүй зөөдөг байж. “Совет-Транс” гэсэн бичигтэй улаан, цэнхэр, шар өнгийн “Камаз” машинууд цувна. Морио нууцалж уяад зам отсон Буядаа давааны орой дээр булагнаж үлдсэн хоёр машин руу дайрахаар шийдсэн байна. Түүнийг том балиусаа бэлэн зэхээний байдалтай түрийлээд очиход дундаа том шилтэй бараашик тавьчихаад найрлаж суусан орос, тува хоёр жолооч нэлээд халамцсан нүдээр хяламхийж харсанаа “Өө, пастух...Самогон есть” гэх мэтээр архинд улайрсан хээгүй архичны араншингаар угтжээ. Буядаа хилийн ойролцоо нутагладаг монгол иргэдийн нэгэн адил ойр зуурын тува хэлтэй тул яаж ийгээд өөрийнхөө гэрийг давааны доохонтой байдаг гэж ойлгуулаад “Байшин барих гэсэн чинь банз хэрэг болчихлоо. Банз өгвөл шимийн архи өгч болно” хэмээжээ. Хариугүй архиа дуусах гэж байсан хоёр уухайн тас машинаа асаасан байна. Буядаа тува жолоочийн машинд суусан бөгөөд аз болоход орос жолооч нь түрүүлээд хөдөлсөн байна. Тэгмэгц Буядаа мундаг том балиусаа гаргаж иржээд тува жолоочийн эрүүнд тулгажээ. Эхэндээ тэр жолооч гайхаж, хүүхдээрээ шахам Буядааг арай ч ингэхгүй байх гэж бодсон байдалтай байснаа түүнийг яахаас ч буцахгүй болохыг ажиглаж мэдмэгцээ машинаасаа буугаад давааны уруу унан тусан зугтсан байна. Буядаа түүнийг тэр чигт нь орхиод машины кабинд байсан гахайн утсан мах, талх, өтгөрүүлсэн сүү зэрэг тухайн үедээ л тансаг хоол хүнсийг ууталж аваад, мөн тува жолоочийн зам зуураа малчидтай наймаалцах гэж авч явсан жижиг сажиг бараа таваарыг хуу хаман оджээ. Энэ нь түүний орос, тува нарт өширхөж хийсэн анхны дээрэм байлаа. Яваандаа тэр өөрийн хань хамсаатантай болж, орос, тува нарыг Мөнгөн тайгын даваан дээр нэг хэсэг сандаргаж байснаа сүүлдээ илчлэгдээд ирмэгц Хандгайтын зам дээр оросуудыг отоож байгаад бензин шатахууны цистерн дээрэмдэх болжээ. Социализмын үед юманд тооцоо байгаагүй тулдаа түүнд дээрэмдүүлсэн жолооч нар яланд унаж, ясанд хахалгүй салдаг байсан байх. “Улаан” Буядаа эрийн цээнд хүрч 28 нас хүртэлээ цэргийн албанд явсангүй. Эрлэгийн данснаас хасагдсан гэдэг шиг төрийн данснаас хасагдсан тэрбээр сүүлдээ Мөнгөн тайга, Горно-Алтай хавиар дураараа дургих боломжгүй болсон тул Увс нуур, Тэсийн гол, Толбо нуур, Хар тарвагатай, Булаг-Өндөр, Баян-Өлгий аймгийн Цэнгэл, Сагсай, Улаанхус сумын нутгаар хөндлөн гулд давхих болсон гэдэг билээ. Хамгийн сүүлд тэрбээр нэгэн тува эрийн тархийг хага цохьсон хэргээр шоронд ороод л сураг алдарсан гэдэг. Гол нь тува эрдээ биш байсан бөгөөд цагдаа нарын гарт баригдсан нь л энэ байлаа. Тэрнээс биш “Улаан” Буядаа 18 настайгаасаа эхлээд л шоронд орж, шонд өлгүүлэхүйц эсэн бусын хэрэг зөндөөнийг үйлдэж байсан хүн аж. Энгийн амьдрал энэ тэр гэж бодож санах юмгүй, чухам юуны төлөө хулгай хийж, яах гэж зам гудааст дээрэм тонуул үүсгэж явсаныг нь бодохоор гайхмаар. Зарим хүнд хээрээр гэр, хэцээр дэр хийж явах төрөлхийн дур сонирхол гэж байдаг бололтой. Хэрвээ “Улаан” Буядаа өнөө цагт дээрхи шигээ манаргаж явсан бол Увс, Завханы хойд чиглэлийн сумдын малчдыг атгандаа авч айлган сүрдүүлээд мал сүргийг нь улаан цагаан дээрэмдээд байгаа новшийн тува нартай нэлээд үзэлцэх байсан болов уу. Ийм нэгэн тэсгэлгүй хулгайч, тэрслүү эр хасаг, тува, оросгүй айлгаж ичээж явсан хачин түүх бас байх юм. Ямар сайндаа л түүнд дээрэмдүүлж тонуулсан орос, тува нар “Буядаа гэдэг тэр сайн



эрийг ялах ганцхан юм бий. Тэр бол цаг хугацаа. Насны эцэст энэ хүн амьдралын шаргал тоосон дээр далаараа цэвэр тавиулна” гэж ёжилдог байж. Ёстой л аргаа барсан хүмүүсийн үг дээ.

## **Ногоон малгайтануудаас булгаж хээрээр гэр, хэцээр дэр хийсэн эрчүүд**

Гучаад оны их хэлмэгдүүлэлтийн жилүүдэд хар, шар феодал хэмээн адлагдаж явсан хүмүүсийн зарим нь ногоон малгайтануудаас булгаж зугтаад уул хаданд бүгэх нь их байж. Зөвхөн хар шар феодал гэлтгүй сэхээтэнүүд, цэргийн дарга нар, төр нийгмийн зүтгэлтэнүүд хүртэл их хэлмэгдүүлэлтээс зугтаж уул хаданд бүгэж байсан баримт байдаг. Ингэж дүрвэсэн хүмүүсийн зарим нь амьдралын шаардлагаар яалт ч үгүй хол ойроос хазаар гүйлгэж шилийн эрийн замаар хүссэн ч, хүсээгүй ч “давхиад” орчихсон байдаг билээ. Тэгээд арав хорин жил ийм замаар замнаж яваад хэлмэгдүүлэлтийн уур амьсгал зөөлрөөд ирсэн тавь, жараад оны үед уулнаасаа буугаад энгийн амьдралд хөл тавьсан байх жишээтэй. Ингээд ногоон малгайтануудаас булгаж асга хад, агуй хонгил, хөндий тал, хөдөө цайдамд морин дэлэн дээр дэрвэж явсан зарим хүний тухай өгүүлье.

### **Нэг: Цаазын тавцангаас мултарсан Соёрохын Мягмар**

1945 он. Хороо, хороогоор хөврөх морин цэргийн тоос манарч аагим бөгчим хохсон талаар цуваа аажим урагшилна. Хянган хэмээх сүрт уулын цаад дор заавал устгах заналт дайсны үүр байгааг дарга, цэрэг бүхэн мэдэх тул цөм халуунд харласан нүүрэндээ хөлс дуслуулан алхацгаана. Суман захирагч ахмад Соёрохын Мягмар аяншиж ядарсан ч хоолойн товчоо тайлалгүй цэргийн даргын ёсоор цовоо сэргэлэн явахыг хичээнэ. Сумангийн дарга хүн бусаддаа үлгэрлэх учиртай. Суман үдшийн сэрүү унаж бүрий хүүшлэхэд Асгат сэргэнгийн нөмөрт амрахаар бууцгаажээ. Аяны хоолоо идэв үү, үгүй юу цэргүүд бүхлээрээ энд тэндгүй хад, асган дэрлэх нь дэрлэж, эмээлээ түших нь түшиж нойр, ядаргаа хоёртоо дийлдэж унасан байна. Төдөлгүй ахмад Мягмарын гүн нойрон дунд харуулын буу гэнэт тасхийн онгоц шунгинах нь бүүр түүрхэн сонсогджээ. Тэрбээр Японы хахирган дуутай бөмбөгдөгч хоёр онгоц агаарт эргэлдэж байгааг хармагцаа “Суман тараад, тараад” гэж чадлаараа хашгирч автоматаар агаар луу галлаж гарчээ. Энд тэндгүй бөмбөг дэлбэрч утаа хярвас манан татахад ахмад Мягмар дөчин сайхан цэрэг эрээ Японы бөмбөгдөлтөнд алдсан байна. Дайн бол дайн, дайсан бол дайсан хойно ийм гэнэтийн гамшигийг тэвчин туулахаас өөр аргагүй. Гэсэн ч ахмад Мягмарын дайчин эрс Хянганы сүрлэг нурууг давж Өвөрмонголын Жэ-Хэ хотыг Японы түрэмгийлэгчдээс чөлөөлж баатарлаг гавьяа байгуулж чаджээ. Дарга, цэргүүдийн өнгө жавхаа гялалзаж, энгэрт нь байлдааны гавьяаны одон медалиуд гялалзана. Тэгтэл ахмад Мягмарыг Дотоод явдлын яамны ногоон малгайтанууд гэнэт баривчлах нь тэр. Ингээд л тэрбээр учир битүүлэг хилс яланд унажээ. Төдөлгүй Дотоод явдлын яамны төв шорон гэгдэх тамын оромжны харанхуй хонгилд Мягмарыг тарчлаан тамлаж хилс хэрэг тулгаж эхэлсэн бөгөөд До яамны туршуул, мэдээлэгч Тавдайн тодорхойлолт гэх худал гэрчилсэн зүйлийг байцаагч гаргаж ирээд “Нөхөр ахмад Мягмар та цэргүүдийг зориуд амрааж Японы онгоцны бай болгосон. Энэ хэрэгт дөчин цэрэг амь насаа алдсан” хэмээн чанга дуугаар уншаад “Хэргээ хүлээ” хэмээн суран бүсний арлаар ороолгож гарсан байна. Ер нь ганцхан ахмад Мягмар ч биш Ардын армийн олон сайхан офицер хувьсгалын эсэргүү, Японы хамсаатан гэдгээр хилс хэрэгт тулгагдан яр шархандаа баригдталаа тамлуулсан байдаг. 1946 оны Октябрийн баяр гэх сүр дуулиант баярын урд шөнө ахмад Мягмар нарын олон сайхан баатарлаг залуусын зовлон дуусчээ. Тэднийг үүр шөнөөр машинд ачаад Сонгинохайрхан уулыг зүглэж явсаар нэгэн гүнзгий жалганы амсар дээр авчирсан байна. Энэхүү жалга нь

гучаад метр урт, гурван метр гүнзгий ажээ. Төдөлгүй “БНМАУ-ын нэрийн өмнөөс... Эх орноосоо урвасан... Японы харгисуудын гар хөл...” гэх зэрэг үл ойлгогдох цаазын тушаалыг нэгэн хүн бүрэнхийд сүүтэгнэх гар чийдэнгийн гэрэлд уншиж эхний буун дуу тачигнаад явчихаж. Тэгээд хоёр, гурав, дөрөв дэх буун дуу тачигнах үед Мягмар өрсөөд жалга руу сөхрөх аятай гулсан унаж, үхсэн мэт хэвтээд өгчээ. Дээрээс нь буудуулсан цогцоснууд унаж байсан ч тэсвэртэй нь аргагүй хэдэн хором хэвтээд ногоон малгайтануудыг машинаа асаагаад хөдөлсөний дараа Мягмар үхдэлүүдээр дүүрсэн гүнзгий жалганаас арай ядан мөлхөн гарчээ. Ахмад Мягмар цаазын тавцангаас ийнхүү амьд мэнд мултраад төрсөн нутаг Баянхонгор аймгийн Бууцагаан сумынхаа “Бага Богд” ууланд очиж арав гаруй жил хээрээр гэр, хэцээр дэр хийсэн гэдэг. Тэрбээр нэгэн цагт авхаалжтэй, сэргэлэн цэргийн дарга явсаны хувьд, басхүү Хянганы сүрлэг нурууг давж Өвөрмонголын Жэ-Хэ хотыг Японы түрэмгийлэгчдээс чөлөөлж явсаны хувьд ядах юмгүй урагшаа хил давж өвөрлөгч нутгаас адуу хөөгөөд орж ирдэг байжээ. Ингэж яваад 1957 онд цагдаа нарын хараанд өртөж, улмаар До яамны мэдээлэгч нарын хов живэээр ногоон малгайтануудад дахиад баривчлагдсан байх бөгөөд харин аз болж энэ үед улс төрийн уур амьсгал эрхбиш зөөлөрсөн байснаар өмнө нь хилсээр шийтгүүлж явсан Соёрохын Мягмар шүүхийн цагаатгалаар суллагдсан байна. Мөн 1945 онд түүнтэй хамт Сонгинохайрхан уулын өвөрт хүргэгдэж очоод хилсээр цаазлуулсан Дамбийшарав, Дагдан, Даржаа, Самдан гэх арваад нөхөд нь ч түүнтэй цуг цагаатгагдсан гэдэг. 1945 оны чөлөөлөх дайны баатар, ахмад дайчин Соёрохын Мягмар Хан-Уул дүүргийн 6-р хороонд амьдарч байгаад 1984 онд таалал төгсчээ.

## Хоёр: Хүүхэн хутагтын шавь “Ойлон” Санжаа

Дээхэн үед Хэнтий аймгийн Наран бригадын нутагт Хүүхэн хутагтын хүрээ гэж байсан бөгөөд эдүгээ ердөө дуган сүмийн суурь довжоо л үлджээ. Хүүхэн хутагтын хүрээ нь 15-р жарны харагчин тахиа жил буюу 1873 онд Балжирсамбуу гэдэг хүнийг “Хүүхэн хутагт” хэмээн өргөмжилж ширээт ламаар суулгаснаар анх үүссэн түүхтэй аж. Энэ цагаас хойш Хүүхэн хутагтын дүрүүдэд Цэвээнлуvsанданзан, Лувсанжамбалдагва, Лувсанжигмид, Жамъяндамбийбалсан нарын зургаан хутагтыг тодруулан залж байсны хамгийн сүүлчийн Хүүхэн хутагт Жамъяндамбийбалсан нь 19-р зууны үед Хэнтий аймгийн малчин Цэнднямынд төржээ. Хүүхэн хутагт гэж нэрлэсэн өөр нэг онцлог нь гэвэл хутагтын дүрд тодорсон зургаан хүн зургуулаа босоо бужгар үстэй байж. Чухам энэ шинжээр нь тодруулдаг байж л дээ. Монгол улсын тамгатай хутагтын нэг Хүүхэн хутагт Жамъяндамбийбалсан нь хүрээний хамгийн тэргүүн том лам төдийгүй хавь ойрдоо ихэд нэр хүндтэй нэгэн байж. Мөн тэрбээр хол ойроос хазаар гүйлгэх төрөлхийн дур сонирхолтой, энэ ч утгаараа нэг үе шилийн сайн эр явсан болохыг “Ар халхын шилийн сайн эрчүүд” номонд тодорхой өгүүлсэн байдаг. Түүнийг дуурайгаад “Ойлон” Санжаа хэмээх шавь нь бас шилийн сайн эрийн замаар хэсэг манаргаад авсан байх аж. 1930-аад оны үед хутагт лам Жамъяндамбийбалсан Хэнтий аймгийн Дотоод яамны ногоон малгайтануудад баригдаад шоронд орсон байна. Энэ үед түүний шавь “Ойлон” Санжаагийн сэтгэл санаа ихэд хямарч “Багш маань бие нь тун чилээрхэж байхдаа баригдаж явсан юмсан. Шоронд яаж илаарших билээ. Бурхан шидээрээ л нартын өдөр хоногийг өнгөрөөж байж таарна. Тэгэхээр би шавь нь юм бол, шилийн эр ухаантай юм бол багшийгаа аврах л ёстой. Намайг харах юм, хамгаалах сахиус байж таарна. Багшийгаа нутагт нь авчирч төрөл арилжуулах нь шавь ёсны учир тавилан, аз заяаны минь дэнс. Гэвч багшийгаа оргуулаад иржээ гэхэд надад ял нүүрлэнэ. Үнсэнд хаягдсан шалз шиг л болно биз. Гэсэн ч багшийгаа заавал олж авчирна аа. Багш маань надад буянаа хайрлах байлгүй” гэж эргэцүүлэн бодож байсаар өвөлжин чөдөрлөж хөл нь улдаж, гэдэс нь цүдийсэн шанхан дэлтэй бор морио эмээллээд Мөрөнгийн голыг уруудаж Хэнтийн төвийг зорин шогшжээ. Тухайн үед хувилгаан хүн битгий хэл хуварга лам нар, энгийн ардууд хүртэл баригдсан л бол эргэж ирдэггүй байж. “Ойлон” Санжаа багшийгаа оргуулж авчрахаар явах замдаа “Би гэдэг амьтан Хутагт лам дээр очоод яаж уулзаж чадах вэ дээ. Тэгээд бас лам хүнийг шоронгийн мухраас гаргаж авна гэхэд ёстой л нөгөө “Жанцан тангадын улаан морийг авна” гэдэг үлгэртэй зүйрлэх хэцүү зүйл. Гэхдээ хэрэг явдал хэцүү тусмаа хүн түүнийг хийчихдэг л юм. Усны буйлаар орчихсон хүний хойноос эрэг дээрхи олон хүн яах учраа олохгүй барьц алдаж байхад нэг сайн эр эрэг дээрээс шувт үсрэн усанд цүлхийтэл ороод төдхөн тэр хүнийг үүрээд гараад ирэхийг би харсан. Тэгэхэд хөлгүй уснаас хүн аварна гэдэг сэтгэлд багтамгүй санагдаж байсан. Хэний ч санаанд оромгүй зүйлийг хийж бүтээдэгийн нууц нь хүний ухаан, овсгоо хоёрт л байдаг байх” гэх зэргээр бодож явжээ. Багшийгаа гэсэн энэрэнгүй сэтгэл гарган хойно нь ирэх муу хатуу далайлтын өмнө аймшиггүйгээр биеэ барьж өгөх гэж буй мятаршгүй эр “Ойлон” Санжаа нь шилийн эрээс гадна угаасаа заргач хэцүү нэгэн байжээ. Зах залгаа Жаргалтхаан сумынхан нь түүний нутгийнханыг “Оорцог бүрдээ далай гэдэг, Ойлон Санжаагаа хуульч гэдэг” хэмээн шүлэглэж байсан гэдэг. Төдөлгүй “Ойлон” Санжаагийн зорьсон хэрэг бүтсэн бөгөөд тэрбээр тас харанхуй шөнөөр багшийгаа гяндангаас оргуулан авч гараад мориндоо дүүрэн өдөр нь бүгэж, шөнөд нь сажлуулсаар Хутагтын хүрээн дээр авчирчээ. Хутагт ламыг авч явсан тэр шөнө Чандаган тал руу ороод

ирүүт цас хялмаалж нутаг ус нь хүртэл Жамъяндамбийбалсан ламыгаа өрөвдөн хайрлахдаа уйлан хайлан угтах нь энэ үү дээ гэмээр шавьд нь санагдаж нулимс алдруулж явжээ. “Ойлон” Санжааг багшийгаа аваад ирэхэд харамсалтай нь Хутагтын хүрээн дээр хэн ч байсангүй. Харин Хүүхэн хутагт цаг үеийг сайн мэдэрч байсан болохоор хүрээ хийддээ ирсэндээ сэтгэл нь амарсан бололтой тайван нойрсоод маргааш нь таалал төгссөн гэдэг. Амьсгаа хураахынхаа өмнөхөн шавьдаа баярласнаа илэрхийлж хүзүүн дэх эрдэнийн эрхиэ авч өгөөд “Дүнчүүр маани уншаарай” гэж захисан байна. Шавь “Ойлон” Санжаа нь удсан ч үгүй баригдаж ёстой л хувь заяа нь хутганы ирэн дээр болж байцаагдахдаа “Би аагаа багтааж ядсан амьд хүнийг авчраагүй ээ. Амьдын голтой төдий байхад нь багшийгаа авчирч нутаглуулсан нь миний сүсэг бишрэлийн онгод биз. Багшийгаа би ганцаархнаа Наранчандманы энгэрт оршуулсан. Одоо надад санаа зовох юм байхгүй. Та нар надад ямар ял тулгана өөрсдөө л мэд” гэсэн гэдэг. Түүний мөрөөр Дотоод яамны Хэнтий дэх хэлтэсээс хүмүүс очиж Хүүхэн хутагтыг оршуулсан гэх газрыг малтаж үзээд “Ойлон” Санжаагийн ярьсан зүйл үнэн болохыг мэдэж авчээ. Тиймээс тэд Санжааг “Үнэн үгтэй лам байна” гээд буудан алах ялаас хэлтрүүлж, тухайн үеийн “Улаан арав” гэдэг ялаар шийтгэж байсан гэдэг. “Ойлон” Санжааг нутгийн нь зарим хүн шоронгоос оргоод Батширээтийн битүү модтой ууланд бүгэж, Оросын нутгаас тоомсог морь оруулж ирдэг болсон гэж ярьдаг бол зарим нь арван жилийнхээ ялыг бүрэн эдлээд 1950-иад оны үед суллагдаад хойноос тоомсог адуу оруулж ирдэг болсон гэж ярьдаг юм байна. Хэнтий нутгийн харьяат Жамбаагийн Ганбатын ярьсанаар бол “Ойлон” Санжаа нь шоронгоос оргомогцоо “За надад амьдрах хоёр зам байна. Нэг нь ламын амьдрал. Нөгөө нь шилийн эрийн амьдрал. Даанч өнөө цагт ламын амьдралаар явж болохгүй болжээ. Тэгээд ч би оргодол хүн. Ийм хүн шилийн эрийн замаар явахгүй бол өөр хэн явах билээ дээ” гээд л шилийн эрийн замыг сонгож авсан юмсанж.

## Гурав: Тагнуулын ҮҮрэг гҮйцэтгэж Явсан “Домогт” Балдан

Гуч, дөчөөд оны үед Монголын төр шилийн сайн эрчүүдийг тагнуулын хэрэгт ашигласан явдал нэлээд байдаг. Бяр чадалтай, моринд эрэмгий, домогт тагнуулч Балдан хилийн цаадах Манжуураас “Халуун худаг” хүртэлх газрын ширхэг чулууг нь хүртэл анддаггүй байж. Нэгэн цагт шилийн сайн эр явсан тэрбээр үүнийхээ хүч аагаар олон арван онцгой даалгавар биелүүлжээ. Нэг удаа хилийн цаадах хот Амгалангийн цэргийн том баазын бензиний агуулахыг шатаах үүргийг дайчин нөхрийнхөө хамт гүйцэтгэжээ. Тэдний хийх ажил гэвэл шөнө дундын үед харуул хамгаалалтыг аюулгүй давж гараад том савтай бензинд нэг ширхэг шүдэнз зураад хаяхад л болох байв. Гэвч энэ нь туйлын аюултай. Өөрсдөө хамт үхэх нь гарцаагүй. Иймэрхүү үйлдэлийг амиа золиослон бөмбөг тэсэлдэг Лалын дайчид л хийж гүйцэтгэдэг билээ. Мөн гучаад онд харакири хийж амиа золиосолдог байсан япон дайчид иймэрхүү үйлдлийг төвөггүй гүйцэтгэдэг байж. Харин монгол дайчин бол өөр хэрэг. Гэхдээ тэдний дайны талбарт амь биеэ үл хайрлан цусаа урсган тэмцэлдэж явсаныг түүх мартахагүй. Домогт эр Балдан дээрээс өгөгдсөн энэхүү хэцүү үүргийг биелүүлэхээр харанхуйд бэдэрч явтал хөлийн доор нь тостой даавуу хэвтэж байжээ. Тиймээс Балдан тэрхүү даавууг бензинд сайтар дүрээд нэг үзүүрийг нь агуулахын савны ам руу шургуулаад цааш цуулаад л яваад байж. Овоо ч холджээ. Төдөлгүй даавууныхаа барьж байсан үзүүрт шүдэнз зураад орхиход галан зэл буун сум шиг сунайж төдөлгүй савны амсарт очиж бөөн дэлбэрэлт болсон байна. Энэхүү чимээнээр дайсны цэргүүд учраа олохгүй сандарч эхэлсэн бөгөөд энэ хооронд мань эр аль хэдийн мориндоо мордож амжжээ. Иймэрхүү үйлдлийг Дарьгангын сүүлчийн сайн эр гэгдэж явсан “Богино” Жалхаа гэдэг хүн гүйцэтгэж явсан байдаг. Нэг удаа тагнуулч Балдан Хандгайт хэмээх газарт байсан дайсны цэргийн томоохон баазыг илрүүлэх даалгавар авчээ. Гэвч тийшээ очих арга байсангүй. Дайсны цэргүүд газар сайгүй харуул хамгаалалтанд гарсан байж. Балдан яах учраа мэдэхгүй тээнэгэлзэж явтал замд нь нэг барга авгай тугалтай үнээ туугаад явж байна гэнэ. Тиймээс Балдан энэ авгайг дагаад явжээ. Гүүрэн дээр ойртож ирмэгц Японы цэргүүд хүмүүсийн баримт бичгийг шалган оруулж байгаа харагджээ. Энэ үед үнээ тууж явсан авгай өврөөсөө нэг бичиг гаргаж үзүүлээд Балдан руу заасан байна. Балдан ч хариу нэг дохиод авгайг дагаад дотогш яваад орчихож. Тэгээд дайсны цэргийн бүхий л нууцыг мэдээд авчихаж байсан гэдэг. Тэрбээр гарамгай сайн бууддаг тагнуулчаас гадна гартаа бугуйл атгаад л дуртай морио унаж явдаг шилийн эр байж. Энэхүү домогт эр 76 настайдаа Дорно зүгийн хилийн 10-р заставт уригдаж очсон бөгөөд түүнтэй шөнийн замд хамт явсан хүмүүс “Таныг мундаг бууддаг гэж сонссон. Алив та шөнө гэлтгүй зээр буудаатах” гэжээ. Тэгтэл Балдан машины гэрэлд хараачилж байгаад хоёр сумаар хоёр зээрийг яг нарийн хүзүүгээр нь буудсан гэдэг. Шөнө хүртэл байгаа алддаггүй ийм л мэргэн буудагч байж. Түүний тухай өлсөхийн эрхэнд япончуудын гуанзанд орж баригдах шахсан, хойноосоо мөрдөгдөж явахдаа ганц бие хүүхний өвөрт орж амь гарсан гээд домог шиг олон яриа нутгийн ард түмний дунд тархжээ. Хилийн цаана авгай хүүхэдтэй ч болж үзсэн байгаа юм. Хожим тэрбээр “Даалгавараа биелүүлээд нутаг буцах үед намайг дагаж уйлсан бяцхан хүүхдийг хараад их өрөвдөж билээ. Хүний нутгийн ч гэлээ өөрийн үр болохоор аргагүй л сэтгэл шимширсэн дээ” гэж хуучилдаг байж. Тухайн үед түүнийг Халхын гол хавиар эсэргүү хэрэгтэн илрүүлэхээр доншуучилж явсан До яамны ногоон малгайтанууд бас баривчлах гэж оролджээ. Ер нь тухайн үед урагшаа явж тагнуул хийдэг байсан хүмүүс бүгд л эх орноосоо урвасан гэдэг хилс хэргээр баривчлагдсан байдаг. Зарим нь ч үнэхээр эх орноосоо урваж Японы талд ажиллаж байгаад

баригдсан байдаг. Гэвч ногоон малгайтанууд үүгээр шалтаглан бүхий л тагнуулчдыг мөрдөн мөшгиж, нийтээр нь шахуу хэлмэгдүүлсэн нь харамсалтай. Балданг ч бас ногоон малгайтанууд энэ маягаар баривчлахаар улайрсан бөгөөд харин домогт эр Балдан тэднийг нэг их ойшоосон шинжгүй “Та нар чинь шилийн эрчүүдийг бас баривчилдаг болоо юу. Бидний эх орноосоо урвах, япончуудын талд орох гэж юу байхав дээ. Харин ч тэдний мал хуй, буу зэвсэгийг хулгайлаад монгол цэргүүддээ авчраад өгч байна. Ийм даалгаварыг би маршалаас авсан хүн шүү” гэж томроод, одоогийнхоор бол тэдний өөдөөс бараг л салаавч өгсөн байгаа юм. Эх орондоо зохих ёсны гавьяа байгуулж, дарга цэргүүдийнхээ дунд нэрд гарсан, хэлэх гэснээ хэнд ч зоригтой хэлчихдэг Балдан мэтийн баатарлаг эрсийг нагаан буугаар хүн айлгахаас өөрийг мэдэхгүй ногоон малгайтанууд зөнд нь орхидог байсан бөгөөд тэд сайндаа ч биш хожим хэл аманд орно гэж айдаг байсан бололтой.

## Дөрөв: Амжиж оргоод адуу хөөх болсон Амарбилэгийн Чулуунсэд

Өвөрхангай аймгийн Зүйл сумын харьяат Шадавын Дамдинсүрэн гэдэг хүн доорхи түүхийг хүүрнэсэн юм. Сэцэн хан аймгийн Ёст бэйсийн хошууны бичээч байсан Амарбилэгийн Чулуунсэд 1937 оны хэлмэгдүүлэлтэд өртөх шахжээ. Тэрбээр 1916 онд хошууныхаа захирагч Эрдэнэсамбуугийн хамт худалдаа наймааны ажлаар Бээжин хот орж нэлээд ажил амжуулжээ. Гэтэл Богдын засгийн газраас Эрдэнэсамбууд нэгэн бичиг ирсэн байна. Уг бичгийн агуулга нь “Хошуу ноён Эрдэнэсамбуу Богд хааны өмнөөс хятадуудтай дур мэдэн холбоо тогтоож худалдаа наймаа эрхлэх болсон нь таалалд нийцэхгүй байна. Бээжингийн том хөрөнгөтнүүдээс холбоо сүлбээгээ даруйхан тасалж Нийслэл хүрээнд ирнэ үү” гэсэн байж. Эрдэнэсамбуу Богд хааны ирүүлсэн бичгийг үзээд тэр даруйдаа Нийслэл хүрээнд иржээ. Тэгтэл Богд хаан түүнийг хошууны захирагчаас халж хэргэм зэрэг, хөрөнгө зоорийг нь хураагаад жирийн малчин болгосон байна. Уг нь Эрдэнэсамбуу хятадуудтай тийм айхтар нууц хуйвалдаан зохиосонгүй. Ердөө л малын арьс шир, ноос ноолуур Бээжин рүү гаргах талаар ярьж тохиролцжээ. Тухайн үед Богд хаан аймаг, хошуудаас татвар авч улсын ажил албыг залгуулдаг байсан тул Эрдэнэсамбууг хятадуудтай нууцаар наймаа хийж их орлого олох гэж байна гэж хардаж сэрдсэн ухаантай юмсанж. Энэ хэрэг ингэсхийгээд дуусгавар болсон бөгөөд төдөлгүй 1921 он гарч ардын хувьсгал дэгдэхэд Эрдэнэсамбуу Ардын засгийн газар дахиад байцаагджээ. Учир нь тэр үед Хятадын гамин цэрэг манайхныг түйвээсэн болохоор хятадуудтай дотно харилцаатай байсан хүмүүсийг нэг бүрчлэн шалгасан юм байх. (Яг л өнөө цагийн С.Зоригийн хэрэгт эсэн бусын хүмүүсийг шалгаж байцаасантай адилхан юм болж) Гэхдээ Эрдэнэсамбууг шалгаж байцаасаны дараа нэг их сүртэй юм болсонгүй. Ардын засагт үнэнч байх ам өчгийг нь аваад л явуулчихаж. Харин Эрдэнэсамбуугийн гэх хэрэг 1937 оны хэлмэгдүүлэлтээр дахин сэдэрчээ. (Яг л сонгууль дөхөөд ирэхээр С.Зоригийн хэргийг сөхөж тавьдаг улс төржилт шиг) Учир нь Эрдэнэсамбуу хошуу ноён байсан болохоор нутаг орондоо нэлээд нэр хүндтэй, хөрөнгө зоорио хураалгасны дараа ч мал сүрэг нь их өссөн, ёстой л нударган баян байсан юмсанж. Ногоон малгайтанууд түүний мал сүргийг хураахын тулд аль 1916 оны юмыг сөхөж тавьсан байгаа юм. Тухайн үед Ёст бэйсийн хошуунд байсан Тангад гэгч этгээд ногоон малгайтануудад мэдээлэл өгч өс хонзонтой хүмүүсээ тэдний гарт атгуулдаг байж л дээ. Тангад тэдэнд өгсөн мэдүүлэгтээ “Эрдэнэсамбуу болбоос нударган феодал мөнөөс мөн. Тэр 1916 онд хятадуудтай худалдаа хийх нэрээр тэнд байсан Японы тагнуулуудтай нууц хуйвалдаан зохиосоныг би сайн мэднэ. Тэр үед би түүний бараа бологчоор явж байсан. Эрдэнэсамбуугийн бичээч байсан Амарбилэгийн Чулуунсэд бас Японы тагнуулуудтай холбоотой байлаа. Ер нь энэ Японы тагнуулын асуудал чинь аль 1916 оноос үүдэлтэй юм шүү дээ” гэх зэргээр бурж гарчээ. Ингээд ногоон малгайтанууд тэр даруйдаа Эрдэнэсамбууг баривчлан хот руу авчраад Батцагааны шоронд хорьчихож. Энэ үед Чулуунсэдийг хамт баривчлах байсан боловч Ардын хувьсгалаас хойш олон жил өнгөрсөн болохоор түүний хаана байгаа сураг нь гарсангүй. Тэгтэл нэг өдөр ногоон малгайтнууд аймгуудын ард иргэдийн нэрсийн жагсаалтыг үзэж байгаад Амарбилэгийн Чулуунсэд хэмээх бусдаас содон овог нэрийг олоод харчихаж. Уг нь Доржийн Бат, Гончигийн Дамдин гэх мэтийн түгээмэл нэртэй байсан бол мань эр анзаарагдахгүй өнгөрөх байж л дээ. Тэгтэл Амарбилэгийн Чулуунсэд хэмээх хэн хүнд баймгүй содон овог нэртэй байсан болохоор захын ногоон малгайтаны хараанд өртсөн байгаа юм. Чулуунсэд тухайн үед Өвөрхангай аймгийн Есөнзүйл суманд амьдарч байсан байна. Төдөлгүй До яам хавиар “Хувьсгалын эсэргүү



Эрдэнэсамбуугийн бичээч байсан Чулуунсэд Өвөрхангай аймагт байгаа нь тогтоогдлоо. Түүнийг даруйхан баривчлах хэрэгтэй” гэсэн яриа гарчээ. Энэ яриа Чулуунсэдийн хамаатан болох цэргийн дарга Нямдаш гэгчийн сонорт хүрсэнээр тэр Өвөрхангай аймгийн Есөнзүйл суманд ногоон малгайтануудаас түрүүлж ирээд Чулуунсэдэд хал дамжуулсан байна. Энэ тухай сонссон Чулуунсэд “За тэгвэл ч би хилс хэрэгт орж баларлаа шүү. Ерөөсөө До яамныхныг ирэхээс өмнө хаа нэг тийшээ дүрвэж зугтаая” гээд Өлзийт сумын нутагт байх Сангийн далай тийш хос морь хөлөглөөд арилж өгчээ. Ингээд тэр хээрээр гэр хийж, хэцээр дэр хийж Өвөрхангай, Дундговь, Баянхонгор аймгийн нутгаар долоон жилийн турш хазаар гүйлгэсэн гэдэг. Тэгж байтал 1950 он гарч гэмгүй ард иргэдийг гэсгээн цээрлүүлдэг байсан мөнөөх ногоон малгайтанууд нь ч өөрсдөө баригдаж хоригдоод Амарбилэгийн Чулуунсэд мэтийн оргодол босуулыг огт хайхрахаа байсан байна. Гэсэн ч тэр хээрээр гэр хийсэн хэвээр л байсан бөгөөд харин жараад оны үед нутгийн нь хоёр гурван хүн түүнийг эрж сурагласаар яваад зориуд очиж уулзахдаа “Хөөе, чи өнөө маргаашгүй хөгшрөөд үхлээ. Нас чинь жар дөхлөө. Нөгөө Чойлбалсан чинь аль хэдийн явчихсан. Ногоон малгайтай цэргүүд нь ч бас дашийн шог болсон. Чам руу одоо халдах дайсан байхгүй болсон. Цаана чинь Цэдэнбал гэдэг том дарга гарч ирээд Чойлбалсангийнхаа бөгсийг ухаж маш олон хүнийг хэлмэгдүүлсэн болохыг уудлан илчлээд байна. Одоо чи хазаар гүйлгэхээ болиод энгийн амьдралдаа эргэж ор” гэснээр Чулуунсэд хээрийн амьдралаа дуртай дургүй орхиод Есөнзүйл сумандаа очиж амьдарсан гэдэг. Тэрбээр нутагтаа мал маллан, нэгдэл нийгэмдээ үр бүтээлтэй ажиллаж байгаад 1966 онд таалал төгсчээ. Энэ мэтээр ногоон малгайтануудаас бултаж зугтаж явсаар шилийн эрийн замаар хэсэг манаргаад авсан хүн олон байдаг аж. Гучаад оны үед өмнө зүгийн аймгуудад нэрд гарч явсан “Ээмэгт лам” гээч нь мөн л ногоон малгайтануудаас бултаж зугтаад шилийн эр болж явсан гэдэг. Сүүлдээ тэр бүр цагаандаа гарч эсэргүүнүүдийн талд орж цэрэг командалж яваад улааны цэргүүдэд бут цохигдсон байдаг. Эсэргүү нар зөвхөн Монголын хувьсгалыг устгаад зогсохгүй улмаар Тагна Тува улсын хувьсгалыг устгах зорилго тавьж байсан нь ялладагч “Бор гэгээн” Самдан, Түгж, “Буриад” Шагдар нарын мэдүүлгээр илэрчээ. Эсэргүү нарын бутарсан хэсгээс үлдсэн хүч нь Тэсийн чиглэлд “Бишрэлтийн хувилгаан” хэмээх Ээмэгт лам ба буссад эсэргүү нараар удирдуулсан таван мянга гаруй хүнтэй болж Монгол-Тувагийн хил Дордогой, Агар, Зайгал зэрэг газруудаар хүчээ бөөгнөрүүлж Хатгал, Мөрөнгийн баруун хойт талаас довглохоор бэлтгэж байсан аж. Гэвч улааны отрядууд эдгээр дайсныг мөрдөн хөөж Тэсийн хүрээний баруун талд Шагдарын удирдсан эсэргүү нарыг бут цохиж, Тагна Тувагийн хилийн ойролцоо Ээмэгт ламын удирдсан эсэргүү бүлгийг Тувагийн цэргийн ангитай нийлж бут цохьсон гэдэг. Ээмэгт лам жараад хүний хамт зугтааж явсан бөгөөд Дорлиг даргатай салаа мөрдөн хөөж түүнийг 25 хүнтэй нь алж, 28 хүнийг амьдаар нь барьж, агт морь 400 гаруйг буу зэвсэгийн хамт хурааж байсан түүхтэй юмсанж.

## “Босоо” Бадарчийг босохгүй болтол нь залхаасан “Чоно” Цээтуяа

Гучаад оны их хэлмэгдүүлэлийн үед зарим аймгийн шилийн сайн эрчүүд аль нь улаантан, аль нь цагаантан, аль нь аврагч, аль нь дайсан болохыг сайтар ухаараагүйн улмаас хувьсгалын эсэргүүнүүдийн талд орж явсан баримт цөөнгүй байдаг. Тэр ч байтугай аварга цол хүртэж чадаагүй нэгэн алдар цуутай бөх хүртэл маршал Х.Чойбалсанд гомдсондоо эсэргүү босогчидтой нийлчихсэн “цохиж” явсан байдаг шүү дээ. Үүн лүгээ ногоон малгайтанууд ч бас зарим нэг шилийн эрийг эсэргүү босогчдын эсрэг ашиглаж байсан байх юм. Жишээ нь гучаад оны үед баруун аймагт нэг хэсэг алдаршсан “Чоно” Цээтуяа хэмээх шилийн эрийг ногоон малгайтанууд зориуд дуудаж уулзаад “За хө, чи бодвол эх орондоо хайртай л биз дээ. Шилийн эрчүүд бол дан ганц амин хувийнхаа төлөө биш нийтийн төлөө тэмцдэг. Тийм болохоор чинь та нарыг шилийн сайн эр гэж ард түмэн хүндлэн биширдэг юм. Танай нутагт гадаад дотоодын дээрэмчид их болсон байна. Ялангуяа “Босоо” Бадарч гэдэг дээрэмчин бүр дийлдэхээ байлаа. Бид өмнөөс нь машинтай очиж болохгүй байна л даа. Машины дуу сонсонгуутаа л уул хаданд ороод бүгчих юм. Тэгэхээр чамд буу бариулаад түүний өөдөөс явуулмаар байна” хэмээжээ. Хариуд нь “Чоно” Цээтуяа “Миний авьяас гэвэл чоно шиг ульж чаддаг. Бас морин дэлэн дээр хэд хоногийн турш хийсч чаддаг. Харин амьд яваа насандаа буу шийдэм барьж үзсэнгүй. Тэр дундаа амьд хүний өөдөөс буу шагайж явсангүй. Та нарын хүсэлтийг биелүүлж чадахгүй” гэж адарсан байна. Тэгтэл ногоон малгайтанууд “За тэгвэл зуун бодын хэрэгтэй таныг “Бат гүн” шоронгийн зэвүүн өрөө хүлээж байна даа. Тэнд очиж хэвтэх үү, нутгийнхаа уул хадаар энэрэлгүй дайснуудтай хөөцөлдөж давхих уу, өөрөө л мэд дээ” гэсэн гэдэг. Ингээд “Чоно” Цээтуяа аргагүй эрхэнд буу шийдэмтэй нөхөрлөх болжээ. Ногоон малгайтануудын зангаанд орсон “Босоо” Бадарч гэдэг нь үнэхээр л болж бүтэхгүй этгээд байсан бололтой. Тухайн үед Амарбуянтын хийдээс лам хар нийлсэн хориод өрх айл Өвөр Монголын Альшаагийн нутаг Шармаанз руу дүрвэсэн гэдэг. Тэд аль болох хүн хар нутагладаггүй газраар явахыг хичээж байсан ч усаар дутагдахын эрхэнд говийн бага шиг бүрд бараадан буудалласнаас хамаг лай ланчигийг өөрсөд дээрээ дуудчихсан байгаа юм. Ийнхүү буудалласнаас болж шөнө нь буу шийдэм агссан арав гаруй морьтон гэнэт дайран орж ирээд алаан хядаан, дээрэм тонуулыг чухам л бахаа ханатал хийжээ. Харамсалтай нь тэдгээр дээрэмчдийн дунд анх Амарбуянтаас хамт дүрвэн нүүсэн ч “Бид нутгаа орхиж үнэхээр чадахгүй юм байна. Эндээ үлдье дээ, та нар биднийг өршөөгөөрэй” гээд хоцорсон “Дорсгой” Пунцаг, “Босоо” Бадарч нарын гурав дөрвөн хүн байсан гэдэг. Дүрвэн зугтаж яваа нутаг нэгтнүүдээ харийн хүмүүстэй хамтран дээрэмдэж бусниулна гэдэг яавч эрүүл саруул үйлдэл биш. Хожим “Босоо” Бадарч гэгч нь хувьсгалын эсэргүү “Барон” Дамдинсүрэнгийн отрядад нэгдсэнээр олон арван эх орончийн зүрхээр туг тахисан байгаа юм. “Тунгалаг тамир” кинонд хувьсгалын эсэргүү Бадарч тахар гэж гардаг. Магадгүй зохиолч Ч.Лодойдамба эх орноосоо урваж, элгэн саднаа хүйс тэмтэрсэн “Босоо” Бадарчийн тухай дуулж сонсоод Бадарч тахарын дүрийг гаргасан байх үндэстэй. Олон арван хүний зүрхээр туг тахисан “Босоо” Бадарч төдөлгүй үйлийнхээ үрийг эдэлж, ногоон малгайтануудын бэлтгэж явуулсан “Чоно” Цээтуяагийн суманд оногдож хүндээр шархадсан байгаа юм. Тэрбээр шархандаа халууран хэвтэхдээ “Би ингэж зовж чадахгүй нь. Алив намайг буудаад өгөөч” хэмээн хамсаатнуудаасаа гуйснаар тархиндаа сум зоолгоод тамын орон руу илгээгдсэн гэдэг. Харин “Дорсгой” Пунцаг нь ногоон малгайтнуудаас амь зулбан зугтаж Өвөр Монголын Альшаагийн нутаг Шармаанз руу дүрвэсэн ажээ. Ёстой л нөгөө “Лам олдохгүй бол буцахдаа зална” гээч нь л болсон байна.

Тэрбээр Шармаанзад дүрвэж очсон нутаг нэгтнүүдийнхээ өмнө сөхрөөд “Би гэдэг хүн ухааны мунхаг, шуналын гайгаас болж бүтэлгүй муухай хүмүүстэй нийлж та нартаа том нүгэл үйлдсэн. “Босоо” Бадарч намайг хүчээр дагуулж явсан. Би амь гарахын эрхэнд “Босоо” Бадарчтай хамт та нарыгаа дээрэмдсэн өчүүхэн муу нүгэлтэн билээ. Та нар маань намайг ивээлдээ авч хайрлаач” хэмээн уйлан дуулж байсан гэдэг. Ямартай ч “Чоно” Цээтуяа ногоон малгайтануудын өгсөн үүргийг ягштал биелүүлж, “Босоо” Бадарч гэгч дээрэмчинийг босохгүй болтол нь залхааж нутгийнхаа ардуудад бяцхан буян үйлдсэн байгаа юм. Гэвч тэр хожим “Би дээрэмчин алж буян үйлдэх биш эрдэнэт хүний амийг хөнөөж нүгэл үйлдсэн хүн шүү” гэж ирээд л өөрийгөө зүхдэг байсан гэдэг. Хүн болгоныг “Эрдэнэт хүн” гэж дүгнээд байх нь бас учир дутагдалтай л даа. Жишээ нь олон зуун хүний аминд хүрсэн Осама Бен Ладен агсаныг эрдэнэт хүн гэж дүгнэж болох болов уу. Ингэж дүгнэж болохгүй учраас л америкчууд хэдэн жилийн турш түүнийг эрж хайсаар байгаад алж устгаж санаа амарсан шүү дээ. Дашрамд хэлэхэд “Чоно” Цээтуяа нь энд тэндээс адуу хөөж мэргэшихээс гадна яг л чоно шиг ульдаг нэгэн байжээ. Тэрбээр уул хаданд очиж чоно шиг улиад өөр дээрээ чоно дуудаж ирүүлээд л яндан саарал мориндоо яргай ташуураа барьж мордоод цугларсан чононуудыг цувуулж хөөгөөд сарьсан хоншоорыг нь тас цохьдог байсан гэдэг. Хожим харин ногоон малгайтануудын буянаар буу шийдэм хэрэглэдэг болсоноор уул хаданд очиж чоно шиг ульж өөр дээрээ дуудаж ирүүлээд л өөдөөс нь гал нээдэг болж. Тийм ч учраас мань эр 1942 онд 60 настайдаа өөд болох хүртэлээ чоно агнаж улсын бэлтгэлийн төлөвлөгөөг нэг хэсэг давуулан биелүүлсэн байгаа юм. “Чоно” Цээтуяа шиг ульдаг төрөлхийн авьяастай хүн дээхэн үед мэр сэр байсан гэдэг. Жишээ нь Хөвсгөл аймагт “Алиа” Гаваа гэдэг хүн байж. Энэ хүн чоно шиг улихаас гадна нохой шиг хуцдаг, адуу шиг янцгаадаг, алиа наргианч, хошин шогч, ардын аман билэг авьяастан байсан гэдэг. Ямар сайндаа л гэрээсээ гараад нохой болж хуцахад ойр хавийн нь нохойнууд дагаж хуцаад сүйд болдог байж. “Алиа” Гаваа гэж нутгийнхандаа алдаршсан энэ хүн 1906 оны улаан морин жил Засагтхан аймгийн Эрдэнэдүүрэгч вангийн хошуунд төржээ. Хүмүүс түүнийг хаана л очно “Чоно болж улиач, нохой болж хуцаач, тарвага болж хошгирооч, буга болж удамдаач” гэж гуйж шалгаадаг байж. Түүнийг чоно болж улихад уяан дээр байсан морьд чихээ сортолзуулан, хамраа тачигнуулж, уяагаа тасдан давхиж байсан удаатай аж. “Алиа” Гаваа бас хөөрхөн зальтай нэгэн байжээ. Тэрбээр нэг удаа Хатгал сумын нутгаас Мөрөн орох гэж унаа эрээд цөхрөнгөө баржээ. Тэгээд аргаа барахдаа нэг айлаас хариугүй туранхай морь гуйж унаад навсархай дээл өмсөөд замд гарсан байна. Гэвч яваандаа морь нь эцэж сульдаад, өөрөө ч өлсч цангаад замд тааралдсан нэг айлд буутал гэрийн эзэгтэй унаж ирсэн мориндоо тохсон эмээл, өмссөн хувцасыг нь хараад жихүүрхэж байгаа бололтой “За энэ чинь хаанаас хаа хүрч яваа хачин хүн бэ?” гэхэд “Алиа” Гаваа “Ах нь үнэнийг хэлэхэд шоронгоос оргож яваа хүн. Хоол цай л хэрэгтэй байна даа” хэмээжээ. Тиймээс гэрийн эзэгтэй түүнд хоол цай бэлтгэх зуураа айлынхаа хүнтэй сэм үгсэж “Манайд ирсэн хүн шоронгоос оргож яваа юм гэнэ. Унаж яваа морь, өмссөн хувцас нь авахын тамтаг алга. Өнөө шөнө биднийг түйвээх нь ойлгомжтой боллоо. Хурдан явж цагдаагийн газар хэл хүргэ” гэж шорджээ. Нээрээ ч төдөлгүй машинтай хүмүүс давхиж ирээд “Алиа” Гавааг баривчлаад аймгийн төвд авчирсан байна. Тэгтэл мань эр дарга нартай нь золгоод дал мөрийг нь алгадангаа “Эцэнхий морьтой яаж аймгийн төв орьё доо гэж шаналж байлаа. Харин шоронгийн хоригдолын дүрд тоглоотохсон чинь тун ядах юмгүй машин ирээд авчихдаг байна шүү” гэж хэлээд инээж байсан гэдэг. “Алиа” Гаваа нэг удаа харуй бүрий болсон хойно уулын орой дээр гараад чоно болж улихад тал талаас нь олон чоно цугларчээ. Гэвч буруу хэрэг хийснээ мэдээд хадны орой дээр гарч үе үе шүдэнз зурж байсаар өглөө нар тустал аргацааж

байсан гэдэг. Чоно шиг ульдаг авьяас нь өөрийг нь ингэж айдаст живүүлсэн байгаа юм. Харин шилийн эр “Чоно” Цэетуяа бол өөр дээр нь хүрээд ирсэн чоныг яндан саарал морь, яргай ташуур хоёроороо бужигнуулаад хаячихдаг байж.

## Засагт ханы Дампил панз

Ч.Лодойдамбын “Тунгалаг Тамир” романд Луу гүний баян Итгэлтийн ганц хүү Хонгор шилийн сайн эр болох юмсан гэж өдөр шөнөгүй мөрөөдөж, зүүд нойрондоо хүртэл Дарьгангын Шилийн Богд уулан дээр гаран “Цахиур” Төмөр, “Царцаа” Намжил, “Торой” Банди, “Тогос” Чүлтэм, Дампил панз, Дансран Чирэгдэл хэмээн дуржигнуулсаар тангараг өргөж байдаг билээ. Ийнхүү ном зохиолын баатрын зүүд нойронд хүртэл нэр нь дурдагдан гардаг шилийн сайн эр Дампил панз гэгч 1950-иад он хүртэл амьдарч байсныг олон хүн гэрчилдэг юм. Энэ тухай Говь-Алтай аймгийн харъяат, Их мянган овогт Жанцангийн “Жаахан” Болд өгүүлэхдээ “Би Дампил панзын талаар нутгийнхаа хөгшдөөс болон өөрийн ээж Ядамын Бадамгараваас их асууж шалгаадаг байлаа. Буурлуудынхаа ам хэлийг нь сугалах нь холгүй шалж байсны хүчинд Дампил панзыг амьд сэрүүнд нь уулзаж явсан Рагчаагийн Бэгз, Дампилийн өргөмөл хүү Жоног Цэдэндамбаагийн үр удам болох өнөө цагийн томоохон бизнесмен Гомбын Пүрэвсүрэн, Өвгөний голын зээ “Хар хацарт” хэмээх Дамбадаржаагийн эхнэр Бямбажав нарын сургийг гаргаж байсан юм” гэж билээ. Ингээд тэдний дурсамж яриаг үндэслэн хошуу нутгийнхаа сайн эрийн тухай хүүрнэсэн “Жаахан” Болдын яриаг сийрүүлэе.

Бэгз гуайтай уулзаж Дампил панзын тухай асуухад тэрбээр “1940-өөд оны үед Дампил гуайтай нэг их сайхан хуучилж билээ. Тэрбээр надад “Буянтай айлын адууг будантай уулын оройд хураачихаад эргэн тойрноо дурандаж байсан өдрүүд олон байсан даа. Урд нэг удаа намрын эхэн сарын дундуур Хан Хөхий тийш хүлгийн жолоо заллаа. Тэгээд их сайхан төө чихтэй халиун адууг сүрэгтэй нь хамт нутгийн зүг өдөр шөнөгүй хөөсөөр байгаад авчирсан юм. Тэр халиун морь үргэлж адууны захад хөрвөөнө. Гүйнхар алхаатай, сугандаа гуурстай юм уу гэмээр маш хөнгөн шалмаг, хурдан морь байж билээ. Гурван жилийн дараа нэг өдөр унаа сойлгийг нь тааруулж байгаад халиуныгаа унаад нутагт нь очиж том цагаан гэрийн гадаа буулаа. Гэрийн гадаа эсгий хийж байгаа бололтой хүн малын хөл ихтэй байв. Тэгтэл ч нэг залуу уяан дээр байсан миний халиун морь луу нүд унагаад л, эргэн эргэн тойрч хараад л байгаа харагдав. Би ч гэр дотор юу болох бол доо гэж бодоод л сэрхийж суулаа. Гэрийн эзэгтэй миний өмнө архи дарс, идээ будаа өрөөд л дайлангуй янзтай байв. Удалгүй морин төвөргөөн нижигнэж, хүмүүс хүүе хаая болж гэрийн тотгоор буу цухуйн “Гараа өргө!” гэсэн дуу гардаг юм байна. Би ч сандарлаа. Ийш тийш хартал орон дээр өлгийтэй хүүхэд хэвтэж байнаа. Тэр хүүхдийг шүүрч аваад хутгаа сугалан хоолой орчимд нь бариад “За хөгшин толгойг залуу толгойгоор сольчих уу?” гэтэл авгай хүүхнүүд уйлалдаж бөөн юм боллоо. Тэгсэн удалгүй гэрийн хаалга онгойж нөгөө халиун морь луу нүд унагаад байсан залуу та морио ав гээд халиун морины минь цулбуурыг өглөө. Би ч та нар надаас холд гэж хашгирсаар гэрээс гарсан. Хүмүүс ярагдаад хүүг минь өгч хайрлаач, өршөө гэж мөргөж сөхрөөд сүйд болж байлаа. Би тэр хүмүүсийн дундуур хүүг тэвэрсээр мориндоо мордуугаа ташуур өгөн ухасхийж билээ. Халиун морь минь тоос татуулан талийхад морьтой бугтай хүмүүс миний хойноос цуварсаар элдсэн дээ. Халиун минь хэдэн саахалтын зайтай тасарч хүмүүсийн бараа тасрах үед би мориныхоо амыг татаж хэсэг зогсоод хүмүүсийн бараа бөртөлзөн тоос нь харагдаж эхлэхээр нь нөгөө нялх хүүг үнсээд хэт хутганаасаа 10 лангийн ембүү авч бугуйд нь зүүж орхиод мориндоо мордон ташуур өгч билээ. Ингэж нялх хүүхдийн ачаар амь аврагдаж байсан даа” гэж яриад санаа алдсан юм. Тэгсэнээ “Тэр үед манайх хойд Цахиурт байсан юм. Гэрийнхээ гадаа буух үед төмөр дөрөө хангинаж, архи сэнхийгээд халиун минь пидхийтэл

савж унасан даа. Хожим сонсох нь ээ миний хойноос хар архиар сэржим өргөсөн юм билээ. Морь минь үхэхэд би их л гутарч нүдний нулимс аяндаа бөмбөрч халиуныхаа толгойг тэвэрч мөн ч их гашуудаж билээ. Их эвгүй байсан шүү. Түүнээс хойш муу үйлээс татгалзаж ариун шударга хөдөлмөрийг эрхэмлэх болсон” гэж хэлээд гунигтайгаар шүүрс алдан дуугаа хурааж билээ. Бас нэг удаа хууч хөөрч байгаад “Залуу цагт шилийн эр гэж явахдаа Завханы шоронд мөн ч олон удаа орсон доо. Нэг удаа олон бодын хэрэгтэй цааз сонсч үзсэн юм. Шүүхийн дарга “Таньд эцсийн хэлэх үг байна уу?” гэдэг юм байна. Би жаахан бодсоноо “Мөнхрөх толгой биш өнхрөх толгой. Мөнгөн толгой биш ясан толгой” гэж хэлээд “Эр бор харцага жигүүрхэндээ хүчтэй, идэр залуу насандаа даанч ажиггүй явжээ” хэмээн дуулаад амь хэлтэрч явсан юм шүү” гэж хэлээд нуг нуг хөхөрч билээ. Мөн нэг удаа “1947 оны үед сумын сургуулийн бариатай гэрээс туурга алдагдсан юм. Тэр хэрэгт нэгдүгээр багийн Нанжийжав гэдэг эр холбогдсон байв. Сумын захиргааны урд жижиг гэр бариад Нанжийжавыг хорьсон байлаа. Би тэр гэрт ороод “Чи ямар хэрэг тариа вэ? Сургуулийн туурга авсан чинь үнэн юм уу” гэж асуутал Нанжийжав тийм гэж сулхан дуугарч байна. Би тэгэхээр нь “Чи муу ханан дээр тохих эсгийн хэрэгтэй ингэж түмний булай болж байхаар ханан бөхтэй ат, хагалбар дэлтэй атны хэрэгт суух нь яасан юм бэ?” гэж хэлээд алгадаж орхив оо. Тэгсэн чинь хүн зодож танхайрсан хэргээр өнөө Нанжийжавтайгаа хамт хоригддог байгаа. Үгүй бас хатуу цаг байсан шүү” гэж хэлээд залбирч байлаа” хэмээн дурссан юм. Дампил панз их сайхан исгэрдэг хүн байж. Халх дөрвөн аймаг Дөрвөн Ойрадад хазаар гүйлгэж азаргаар нь адуу хөөж зам зуурын ядуу ардад тараан явсаар хэдэн толгодын цаанаас исгэрэн ирэхэд Дампил панз ирж байна гэж нутгийн ардууд таньдаг байжээ. Нэг удаа Дампил панз ардуудад буян хийнэ гээд Усан зүйлийн хүрээний /одоогийн Тонхил сум/ жасыг тонохоор бэлтгэж хоёр сайн морио сойж байгаад битүүний орой хошуу ноён Баатар ванд орж битүүлээд тэр чигээрээ Усан зүйлийн хүрээний зүг мордож шөнөжин явж жасыг ухаад үүрээр нутгийн ардуудын тотгон дээр хадаг ембүү тавьж явсаар нар мандахад хошуу ноён Баатар ванд очиж золгожээ. Сар шинэ өнгөрөх үед Усан зүйлийн хүрээний жасын хөрөнгө алдагдсан гэдэг шуугиан тарж, ойр хавийн хошуудын сайн эрсийг сэжиглэн дуудаж шууд л хар гэрт хорьжээ. Тэгтэл Дампил панз “Намайг гэрчлэх хүн байгаа. Манай хошууны захирагч Баатар вантай нүүрэлд” гэж мэлзэж байгаад гэрчлүүлсэн бөгөөд Баатар ван Зүйлийн хүрээний их гэсгүйтэй уулзаж “Орой нь надтай битүүрчихээд өглөө дөнгөж нар мандаж байхад өглөөний нар битүү босч дадсан босоо заяат сайн эрсийн ёсоор хэдэн өртөө газраас хамгийн эхэнд ирж золгосон” гэж нотлон Дампил панзыг хар гэрээс гаргаж байсан аж. Дампил панзын тухайд дурсамж яриа сийрүүлэхийн ялдамд түүний уугуул нутаг Засагт хан аймгийн Баатар вангийн хошууны тухайд өгүүлэх хэрэгтэй болов уу. Энэхүү хошуу нь эзэн богд Чингис хааны удам Жалайр Гэрсэнзээс улбаатай цэрэг дайны хар сүлдийг үе дамжин дахиж байсан нутаг бөгөөд хошуу ноён Со захирагчийн Базарваань нь залуу зандан насандаа Богд хаант засгийн үед Нийслэл хүрээний цэргийн захирагч бүх цэргийн дэд жанжинаар тохоон томилогдож явсан төрийн томоохон зүтгэлтэн хүн юм. Ер нь Баатар вангийн хошуу нь халх дөрвөн аймаг болон өвөрлөгч хошууд, дөрвөн Ойрадын ихэс дээдэс баяд ноёдууд, Манж хятадын пүүсүүдийг тонон дээрэмдэж, ханан бөхтэй ат, хагалбар дэлтэй агтуудыг сүрэг сүргээр нь “хазаар гүйлгэж” явсан олон сайн эрчүүдийн өлгий нутаг билээ. Тэднээс дурдвал “Оготор цэнхэр” Дэлгэр, “Муу хүү” хэмээх Нагч Раднаабазар, “Ихэр шар” хэмээх Шархүү, “Соотон” Сүх, “Цөлх” Ааяа буюу Сэтэв баяны ганц хүү Чоймбол зэрэг шилийн сайн эрчүүд байжээ. Эдний зарим нэгнийх нь тухай нутгийн ард түмний дунд домог мэт яриа их байдагаас цухас дурдмаар санагдлаа. “Оготор цэнхэр” Дэлгэрийг хулгай хийгээд байхаар нь хошууны тамгын

газраас барьж хорихоор болжээ. Тэр аргагүй баригдахаа мэдсэн болохоор үхсэн мэт хэвтэж байна гэнэ. Хөөцөлдөж явсан хүмүүс ирээд хамар дээр нь хомоол тавьж унгаалаад хараад байж. Хамар нь түлэгдэж цэврүү үсрэн писхийн хагарахад хүртэл “Оготор цэнхэр” ер хөдөлсөнгүй гэнэ. Тэгэхээр нь түшмэлүүд түүнийг босгоод “Баатар вангийн хошуунд нэг ийм сайн эр байхад яахав дээ” гээд явуулсан гэдэг. Нагч Раднаабазар гэгч сайн эр нь нэг харахад хамаргүй болчихсон давхиж явдаг, нэг харахад хамартай болчихсон давхиж явдаг, улаан дээл нь саарал болчихдог, эсвэл яах аргагүй эмгэн болчихсон бээвийж явдаг элдэвтэй нэгэн байсан гэдэг. Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутаг Замын худаг, Адуун чулуугаар нутагладаг байсан энэ сайн эр явдал суудал нь мэдэгдэхгүй, яриа хөөрөө нь цэцэн цэлмэг, хошуу өртөө дамжин наймаа арилжаа хийдэг, хулгай худал мөрийтэй тоглоомонд гаргуун нэгэн байсан гэдэг. Нагч Раднаабазар олон бодын хэрэгтэй Улиастайн шоронд хоригдож байгаад оргожээ. Гудамжаар хуягууд явж байгааг харсан Раднаабазар гудамж тойронгуутаа хамраа чихчихээд дуу аялаад сууж байж гэнэ. Хуягууд түүнийг харчихаад “Хамартай бол өнөө гайхал гэхсэн. Үгүй бас ийм адилхан хүн байдаг аа” гэж шогшроод өнгөрч байсан гэдэг. Мөн “Ихэр шар” Шархүү хэмээх сайн эр хошуу нутаг дамнан хазаар гүйлгэдэг байж. Нэг удаа тэрбээр эмнэг хангал морь уначихсан Баян-Уулын бэл, Шарын гол, Гангат Бадархайгаар нутагтай баян хүний ганц хүү Ядам гэгчийн хот айлд бууж “Танайхаас алс хол явах аяны богцны хүнс авна даа” гэж аархжээ. Баян Ядам аргагүй л юм үзэж, нүд тайлсан цөлх эр байсан болохоор “Чаддаг юм бол буурлын маань булхаж байгаа буянаас аль олигтойг нь шүүрч аваад яв даа” гэж. Тэгтэл “Ихэр шар” шарлахан мориныхоо цавь руу гараа хийн булгиулж хар хурдаар нь давхиулан бэлчиж яваа хонин сүрэг рүү нь дайрч ороод хулсан ташуураар хонины хоншоор дээр цохиж цоройх мөчид нь шүүрч аваад явж байсан гэдэг. Энэ яриаг Баян Ядамын галын зээ Барын Махбариад гэж буянтай буурал өгүүлсэн билээ. Дашрамд өгүүлэхэд дээр хальт дурьдаад өнгөрсөн Чингисийн хар сүлдийг Засагт хан аймгийн Тарган Баатар вангийн хошууны гол хийд Нуур могойн хүрээнд 1930 он хүртэл тусгай гэрт харуул хамгаалалттай тахиж байсан бөгөөд 1937 онд Дотоод яамны ажилтан Намсрайжав гэгч Завханы Улиастай руу авч яваад сураг тасарсан гэдэг. 2010 онд Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд хар сүлдийг хуучин ном журмаар нь албан ёсоор дахин сэргээж, наадам хийж сумын төвийн хийдэд тахьсан билээ. Мөн хошуу ноён Баатар ван С.Базарваанийн хүрэл хөшөөг босгож, сумын төвийн төв цэцэрлэгт байрлуулж гэгээн дурсгалыг нь мөнхжүүлсэн юм.

## Дунганы дээрэмчдийг явгалж орхисон халхын сайн эр Жунайн Цогбадрах

Жунайн Цогбадрах нь бидний сайн мэдэх “Цахиур” Төмөрөөр жишвэл бараг л түүний өвөө гэгдэхээр хүн байсан гэдэг. Тэрбээр яг хэдийд хаана төрсөн нь тодорхойгүй ч 1908 оны үед Ховдын амбаны шоронд 72 настай байхдаа гурван амбан шарын хэрэгт сэрдэгдэн бүтэн гурван сар суухдаа нэг ч үг хэлж улайлгүй тас гүрийсээр суллагдаж байсан гэдэг яриа бий. 1860-70 оны хооронд Ховд, Улиастайн амбаны заргачийн түшмэд болон арван тавны цагдаа нарын үг хэлийг барж, үс гэзгийг сэгсийтэл нь хээр хонуулж байсан зартай сайн эрсийн нэг болох түүний уг гарлыг хөөгөөд үзэхээр өнөөгийн Хөвсгөл аймгийн Түнэл хавьцаа очих юм уу эсвэл Булганы Уул-Алтаадын голынх юм шиг бүдэг бадаг хэдэн янзын хувилбар яриа гарч ирж байгаа билээ. Ямар ч байсан Хангайн нуруу Хөвсгөлийн тайгын уулзвар хавьцаа Идэрийн голтой холбоотой нь тодорхой мэдрэгдэж байгаа юм. “Хулга” Нацаг хэмээх шилийн сайн эр басхүү алдартай бөхийн тухай нэгэн ярианд Сэлэнгэ мөрний хөвөөнд хонож байсан Дайчин Жонон вангийн хошууны бөхчүүдийн морьдыг өглөө сэрэхэд нь Жунайн Цогбадрах туугаад аваад явчихсан байсан тухай гардаг билээ. Хошуу ноён нь үүнийг мэдээд араас нь хөөцөлдсөөр арай гэж нэг юм барааг нь олж хараад Идэрийн голын хөвөөнд айлын гадаа морьдыг нь хашчихсан нэрмэл архи халаалгасан шигээ ууж суухад нь очиж барьсан тухай энэхүү аман ярианд гардаг юм. Жунайн Цогбадрах нь манж амбаны хууль Монгол газарт ид хүчтэй ноёрхож байсан тэр цаг үед баруун урагшаа гарч хазаар гүйлгэх дуртай хүн байсан нь түүнтэй холбоотой яриануудаас тодхон мэдрэгддэг билээ. Засагт хан, Сэцэн хан, Түшээ хан аймгийн эрчүүдийн дийлэнхи нь сав л хийвэл Хар дэл жанжин бэйсийн хурдан удамт адуу, Манжийн хааны сүрэгчин хошуу болох Дарьганга тийшээ хазаар гүйлгээд явсан тухай нэр холбогддог бол харин Жунайн Цогбадрахын түйвээж явсан сураг нь гол төлөв баруун хязгаар Сагсайн гол, Толбо нуураас цаашаа бүр Кашгар Яркендын хар зах, Бархөл, Цонжийн зах, Хөх нуурын хойд бэлээс дуулддаг байсан гэдэг. Нэг үгээр хэлбэл тэрбээр баруун аймгийн шилийн сайн эрчүүдтэй гар нийлэн Шинжааны нутаг руу гарч тэндээс адуу хөөн ирж халхдаа шингээдэг жинхэнэ их хөлийн эр байсан нь тодорхой байгаа юм. Гэхдээ түүний баруун хязгаараас хөөж ирсэн өндөр том биетэй зэгзгэр цээжтэй морьд зүүн хязгаарын Сан бэйсийн хүрээ, Баргын нутаг руу ч гарч зарагддаг байсан гэх яриа бас бий. Тэгэхээр Жунайн Цогбадрах нь яахын аргагүй Монголын баруун хязгаараас зүүн хязгаарт хүртэл хүлгийн шандас, хүний шөрмөсийг шалгаж явсан зартай сайн эрсийн нэг байсан нь ч илт болж байгаа юм. Түүнтэй холбоотой олон яриа байдгаас хамгийн зартай нь 1870 оны үед манай улсын баруун хязгаараар цөмрөн орж ирж бараг л Улиастай хүрэх дөхсөн Дунганы хасаг дээрэмчдийг Завхан голын хөвөөнд явгалж орхисон тухай яриа билээ. 1870 онд Манжийн хааны эзэмшилд байсан Шинжааны хойд нутагт Дунганы босогчид хэмээх киргиз, казах, туркмен нийлсэн томоохон бослого гарч сүүлдээ дийлдэхээ байгаад дээрэм тонуул хийхээр Монголын нутаг руу цөмрөн орж ирдэг болсон гэдэг. Дунганы дээрэмчид их олуулаа бараг л 15 мянган хүнтэй байсан учир Ховд хот дахь Манжийн амбан хэрэмнээсээ ч толгойгоо цухуйлгалгүй дотор нь бүгсээр амиа аван үлдэж байсан гэдэг. Мэдээж Дунганы дээрэмчид үхэр буугаар зэвсэглэж, 5000 цэргээр сахиулсан Ховдын хэрэм рүү дайрахыг урьтал болгосонгүй. Тэд Монгол улсын гүн рүү цөмрөн орж замдаа тааралдсан айл амьтаны эд агуурс, мал хөрөнгийг дээрэмдэн цөлмөсөөр Улиастай руу ойртжээ. Харин энэ үед халхын Түшээт хан болон Сэцэн хан нарын цуглуулсан 6000 цэрэг тэдэнтэй тулалдахаар Улиастайн орчимд цуглараад байсан аж. Дунганы дээрэмчид Улиастай хотод ойртон ирж түр зуур



буудаллаад маргааш нь довтлохоор шийдэж одоогийн Завхан аймгийн Цагаанхайрхан сумын нутгаар урсах Завхан голын хөвөөн дээр ярайтал түүдэг асаан сүрийг үзүүлж хоносон байна. Гэвч тэднийг өглөө босоход агт морьдын нь тэн хагас нь байхгүй, адуу манаж байсан гурван цэрэг нь амандаа алчуур чихүүлчихсэн модноос өлгөөстэй сарваганаж байсан гэдэг. 15 мянган дээрэмчний унаж явсан хүлгийн тэн хагас нь алга болсон гэхээр 7000 шахам адууг шөнө дөлөөр хэн нэг нь хөөгөөд явчихсан гэсэн үг. Явган нүцгэн голдуу хоцорсон дээрэмчид Улиастай хот руу довтлох санаагаа орхиод Алтайн зүг хөдлөхөд араас нь Түшээт ханы цэргүүд нэхэн хөөсөөр өнөөгийн Хасагт хайрхан хэмээх ууланд хөөн оруулж хиар цохьсон гэдэг юм. Харин Завхан голын хөвөөн дээр 15 мянган дээрэмчнийг явгалж орхисон этгээд нь халхын зартай сайн эр Жунайн Цогбадрах байсан гэдэг. Тэрбээр гар ганзага нийлсэн гурван сайн нөхрийн хамт шөнө сэм ирж харуулуудыг нь эд бад хийгээд адууг нь чимээгүйхэн босгоод туугаад явчихсан тухайгаа өөрөө хожим ярьж байсан гэдэг. Жунайн Цогбадрахын энэ үйлдэлээс сэдэвлэн зохиолч Ч.Лодойдамба “Тунгалаг тамир” романдаа “Цахиур” Төмөр цагаантаны генерал Бакичийн агтыг хөөж ирдэг үйл явдлыг оруулсан ч гэж ярьдаг юм. Жунайн Цогбадрахтай гар нийлсэн гурван сайн эрийн нэг нь мөн л халх дөрөв, шавь тавд алдаршсан “Уурга” Дампил хэмээх Засагт хааны сайн эрсийн нэг байсан гэдэг. Хамгийн гол нь Жунайн Цогбадрах, “Уурга” Дампил нарын сайн эрс Дунганы дээрэмчдийг Завхан голын хөвөөн дээр явгалахдаа “Муусайн амьтадыг эх орондоо алхам ч гишгүүлэхгүй ална тална” гэсэн уриа лоозун хашгирч сүрийг үзүүлээгүй бөгөөд агт морьдоо шөнө цөөхөн хүнээр мануулдагийг нь анзаараад л чимээ аниргүйхэн очоод “туучихсан” байгаа юм. Эндээс тэдний ажигч гярхай байдал мөн даруу төлөв зан анзаарагдаж байгаа билээ. Дунганы дээрэмчидээс салгаж авсан 7000 адууны зарим нь Богдын санд орж дийлэнх нь халхын нутгаар тараагдсан гэдэг. Шилэгдэж үлдсэнийг нь Өвөр Монголын Ордос хошууны ноёд баядад худалдан алт мөнгө болгосон гэдэг яриа ч бий. Манжийн хааны хатуу цаазанд захирагдалгүй хүлэг морины дэлэн дээр салхи шиг хийсч, гал шиг дарцаглан бадарч эгзэгтэй цагт эх орон ард түмнийхээ төлөө эрслэн босч явсан Жунайн Цогбадрахтай холбоотой өөр нэг баримт байдаг нь 1880 оны үед Шинжааны цөлийн дээрэмчин Аскасгар буюу “Талын хар чоно” хэмээх нөхөртэй холбоотой домог гэмээр яриа юм. Шинжааны цөлийн дээрэмчин Аскасгар нь Турфанаас хөөж ирсэн Томск маягийн морьдыг Жунайн Цогбадрахын гараар дамжуулан Бээжин рүү оруулж Өвөр Монголын Удай, Бинт зэрэг томоохон баячууд зарж ашиг олдог байсан гэх итгэмээргүй яриа бий. Тухайн үед сайн эрсийн хазаар гүйлгэн хөөж дамжуулдаг нутаг нь халхад дөрвөн өртөө буудалтай байсан гэхээр энэ яриа оргүй биш байж болох юм. Баруун хязгаарын сайн эр Жунайн Цогбадрах Турфанаас гаргасан урт хөлтэй, өндөр биетэй томск морьдоо өөрөө хөтлөн халхын нутгаар хөндлөн гулд дамжаад Өвөр Монголын нутгийг дайран гарч Бээжин хүргэдэггүй байсан ч байж болох. Тэрбээр томск морьдыг Засагт хааны нутагт Ламын гэгээний хийд дээр авчрахад тэр хавийн нэгэн сайн эр уг морьдыг тосч аваад цааш нь авч явсаар Дарьганга хавьцаа нэгэн сайн эрд дамжуулдаг цаадах нь хил давуулан өөр нэг сайн эрд шилжүүлэх зэргээр нүдэнд харагдаж үзэгдэхгүй шахам хурдан алга болгодог байсан байж мэднэ. Ер нь ч ийм өртөө улааны сүлжээ сайн эрсийн дунд байсан гэдэг. Баруун аймгийн хөгшчүүдийн дунд үлдсэн яриагаар бол Жунайн Цогбадрах нь морин дээрээ хөндлөн сууж явахдаа хөглөрсөн том хөх хад шиг харагддаг тун сүрлэг ханхар том биетэй хүн байсан гэдэг. 1870 оны орчим Кашгар хотноо баригдан Манжийн амбаны есөн эрүү шүүлтэнд ороод ажралгүй даван гарч ирсэн энэ эр хааяа нэг барилдчихдаг ер нь хэн ч харсан бөх гэж андуурмаар хангай шиг сайхан эр байсан гэдэг юм. Тэрбээр 1870 оны эхээр Илдэн бээлийн хошууны наадамд Дугар аваргыг ид гарч ирж байх үед хазаар гүйлгэж яваад тэнд түр саатсан

тухай нэг яриа бас бий. Дугар аварга тухайн үед арван засгийн наадамд анх удаа үзүүлэж заан цол дөнгөж авчихсан, хүн амьтанд нэг их танигдаагүй үе байж. Энэ үед Жунайн Цогбадрах өөрийгөө Дөрвөд далай ханы Цогбадрах заан хэмээн бичүүлж барилдаад таарсан учраа болгоноо түвэггүй орхиж явсаар үзүүр түрүүнд хүрч алдарт Дугар аваргатай анх удаа гар зөрүүлжээ. Дугар аварга түүнтэй нэлээд удаан ноцолдож байгаад гутлынх нь баглаа уяа тайлагдсан мөчийг ашиглан ганцхан тэвхдээд гэдрэг нь харуулсан гэдэг. Хожим нь Дугар аварга даншигийн цуутай бөх болчихсон хойноо баруун аймгийн бөхчүүдээс “Дөрвөд далай хааны Жунайн Цогбадрах заан гэж ямар хүн байдаг вэ?” асууж сурагласан гэх бөгөөд нөгөөдүүл нь “Тэр чинь бөх биш шилийн сайн эр байхгүй юу” гэж хариулж байсан гэдэг. Нэгэн цагт халх дөрөв, шавь таваар тогтохгүй Зүүнгарын хаант улсын буурийг тонгочуулж, цөлийн сайн эрчүүдтэй уялдаа хэлхээ тогтоож, уурганы үзүүрээ Алтайн уулнаас Цагаан хэрэмний цаад талд хүртэл сунгаж явсан Ар халхын сайн эр Жунайн Цогбадрах нь 1911 онд Богд хаант Монгол улс мандан бадрах үед 75 настай өвгөн Ханхөхийн өвөр бэлээр нутаглаж яваад өөд болсон гэдэг.

## “Бөх-хулгайч” гэж цоллуулж явсан “Хулгар” Нацаг

Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошуу, өнөөгийн Булган аймгийн харъяат улсын арслан “Хулгар” Нацагийг шилийн сайн эр явсан гэдгийг мэдэхгүй хүн ховор биз ээ. Тэрбээр бөхийн хувьд ч тэр, шилийн сайн эрийн хувьд ч тэр, баялаг намтартай, бахдам дурсамжтай хүн. Түүний ач Дэлгэрэх эдүгээ Булган аймагт амьдардаг бөгөөд саяхан тэрбээр Улаанбаатарт ирэхдээ өвөг эцгийнхээ тухай ийнхүү хүүрнэсэн юм.

...Би Булган аймгийн уугуул “Хулгар Нацаг” овогтой Очирданзангийн Дэлгэрэх гэдэг хүн байна. Өвөөгийн овгийг юу гэдэг байсныг сайн мэдэхгүй юм. Би өвөөгийнхөө барааг хараагүй л дээ. Харин эмээгээ бол харсан. Эмээг маань Бат гэдэг байсан. Нэлээн бие томтой хүн байлаа. Намайг бага байхад цуг байдаг байсныг муухан мэддэг юм. Миний өвөө “Хулгар” Нацагийг мянга есөн зуун арван хэдэн онд жаран хэдтэйдээ өөд болсон гэж ярьдаг. Ардын хувьсгалыг үзэж чадаагүй юм билээ. Барилдааны зах зух нь Монголын түүхэнд тэмдэглэгдэж үлдсэн байдаг. Өвөөг маань цуутай шилийн эр байсан болохоор барилдах гээд очиход засуулууд “Бөх-хулгайч” гэж цоллодог байсан гэдэг. Өвөө маань даншигийн наадамд барилдчихдаг, түрүүлэе гэвэл түрүүлчихдэг, өөр хүнд унаад өгье гэвэл унаад өгчихдөг гүндүүгүй эр байсныг дээр үеийн хүмүүс дурсдаг байлаа. Жишээ нь “Ар халхын шилийн сайн эрчүүд” номонд “Начны найрааг “хулгар” Нацаг анх санаачилсан” гэдэг бүлэг байх юм. Энэ нь үнэн юм шиг байна лээ. Даншиг болон арван засгийн наадамд ирсэн бөхчүүд “Хулгар” Нацаг өвөөгөөс маань их эмээдэг байж. Тиймээс өвөө маань гурвын даваанд ам авах үеэс эхлээд л бөхчүүдийн майхан хэсч, шинэ цол горьдож байгаа дөмөгхөн бөхчүүдээс “За дүүгийн алдар хэнсэн билээ” гэж асуудаг, цаад хүн нь нэрээ хэлэхэд “За сонслоо. Дараагийн даваанд ах нь чамайг хүртчихье” гэж айлгадаг байж. Цаад хүн нь айхын эрхэнд өвөөг наадамчин олноос нууцгайхан дагуулж холдуулаад “Та намайг битгий аваач” гэж гуйх жишээтэй. Хариуд нь өвөө маань “Өгөх л юм мэднэ дээ. Шилийн хулгайч “Хулгар” Нацагт ямар сайн нэр байх биш. Ахиухан юм өгвөл ах нь чамайг авахгүй ч байж мэднэ” гэдэг байж. Энэ мэтээр гурав, дөрвийн давааны үед шинэ залуу бөхчүүдээс баахан юм цуглуулж аваад зургаа, долоогийн даваанд ёстой л хэн нэгэн бөхөд жинхэнээсээ бууж өгөөд начин юмуу харцага төрүүлдэг байж. Тийм ч учраас өвөө маань томоохон наадамд түрүүлж байсангүй. Тэртэй тэргүй ард олонд “Шилийн хулгайч” гээд цоллуулчихсан болохоор наадамд түрүүлж тэгтэлээ алдарших сонирхол ч байгаагүй бололтой. Нэг удаагийн хошуу наадамд өвөө маань нэг залуу бөхтэй үзүүр түрүүнд үлдчихэж. Тэгээд түүнтэй барилдахаасаа өмнө майханд нь орж байдлыг ажиглатал тэр залуу бөх “Нацаг гуай та бол тэртэй тэргүй ард олны дунд нэртэй хүн. Энэ наадамд түрүүлсэн ч Нацаг, түрүүлээгүй ч Нацаг. Харин би бол нэрд гарах гэж ядаж яваа залуу хүн. Та надад буугаад өгчих” гээд тавин лангийн ембүү, дээлийн хуй торготой барьсан гэдэг. Өвөө түүнийг нь гардаж авсанаа “Уг нь эзэн ноён намайг энэ наадамд заавал түрүүлнэ шүү гэж захисан юмсан. Улайм цайм буугаад өгчихвөл намайг банздах байх даа. Тэгэхээр би эхлээд хэд хэдэн удаа халж туйлсан дүр үзүүлэе. Харин чи сайн тогтооно шүү. Тэр үед намайг хутгачихаарай” гэж захисан байгаа юм. Ингээд хоёр бөх барилдах болж, өвөө ч хэлсэн ёсоороо халж туйлсан дүр үзүүлсэн байна. Тэгтэл цаад бөх нь өвөөгийн туйлах дүр үзүүлсэнийг тогтоож чадалгүй уначихсан гэдэг. Наадам тарсаны дараа залуу бөх “Та надад бууж өгнө гэж амлаад шан харамж аваа биз дээ” гэж гомдол мэдүүлэхэд өвөө огт тоосон шинжгүй “За дүү минь. Эхлээд ахынхаа хэлсэн үгийг саначих. Би туйлсан

дүр үзүүлнэ гэж чамд сануулсан байх аа. Харин чи өөрийнхөө муугаас болоод миний халж туйлахыг тогтоож чадсангүй. Эр хүний ганц хоёр халааг даахгүй байж миний дүү наадамд түрүүлэх тухай бодож болохгүй. Ам бол ам. Ах нь авдаг юмаа авчихлаа, чи ч өгдөг юмаа өгчихлөө” гэсэн гэдэг. Өвөө маань их том биетэй, ямар сайндаа л өнгөрсөн хойно нь цээжинд нь чоно гөлөглөж байсан гэдэг юм. Нэг удаа өвөө маань говийн наадам барилдах гээд явж байтал замд нь нэг айл тааралдаж. Яваад ортол нэг их том биетэй эмэгтэй хүн байж. “Хаа хүрч явна вэ” гэж асуухаар нь өвөө говийн наадамд барилдах гэж яваагаа хэлсэн байна. Нөгөө хүүхэн “Наадам долоо хоногийн дараа болно. Хоёулаа хамт явъя” гэхэд нь өвөө “Би түрүүлээд очих ёстой” гээд явахаар болж. Тэгээд худаг дээр нь очоод морио услах гэсэн чинь амыг нь нэг их том хавтгай чулуугаар таглачихсан байж. Өвөө тэр тагийг авах гэтэл хүчирсэнгүй. Тэгтэл нөгөө эмэгтэй хүрч ирээд худгийн амнаас хавтгай чулууг өргөж холдуулаад “Ээ, чааваас даа. Хол газраас наадамд барилдах гэж явдаг. Эмэгтэй хүний өргөөд тавьчихдаг энүүхэнийг өргөж чадахгүй байж барилдах хэрэг байна уу даа” гэх зэргээр ёжлоод хоцорсон гэдэг. Долоо хоногийн дараа наадам эхэлж өвөө маань нэгийн даваанаас эхлээд барилдсаар байгаад үзүүр түрүүнд үлдсэн байна. Тэр үед бөхийн зодог шуудаг өнөөгийнх шиг задгай биш битүү байж л дээ. Өвөө маань үзүүр түрүүний бөхтэй зодоглох гээд очтол нөгөө худгийн амсар дээрээс хавтгай таг өргөж тавьсан хүүхэн зогсч байсан гэдэг. Тиймээс өвөө түүнтэй барилдалгүйгээр өөрийгөө давсанд тооцоод хошуу ноён дээр дэвээд очсон байгаа юм. “Яагаад барилдсангүй вэ” гэхэд нь “Эмэгтэй хүнийг толгой дээрээ гаргасан хошуу нутаг танайхаас өөр байдаг юмуу. Би эмэгтэй хүнтэй барилдахгүй” гэсэн байна. Тэгтэл хошуу ноён шууд л зарлигдаад өвөөг маань шоронд хорьчихож. Үзүүр түрүүнд үлдсэн тэр бөхийг хошууных ард иргэд эмэгтэй хүн гэдгийг өмнө нь ерөөсөө мэддэггүй байж л дээ. Тиймээс яв ийв болоод явчихаж. Нөгөө бөхийг эм, эр алин болохыг мэдэх гээд баахан асуудал үүссэн юм байгаа биз. Тэгээд эмэгтэй болохыг нь мэдсэнээр хошуу ноён “Хулгар” Нацаг гэдэг тэр бөхийг шоронгоос гарга” гэж зарлигдаад оронд нь нөгөө том биетэй хүүхнийг хийчихсэн байгаа юм. Тэр хүүхэн шоронд орохдоо “Нацаг аа, чи намайг эндээс гарахад тус болоорой” гэсэн ч өвөө маань юу ч дуугаралгүй гараад явчихсан гэдэг. Хойноос нь нөгөө хүүхэн “Чиний цээжинд чоно гөлөглөх юм байна даа” гэж хэлээд хоцорсон гэдэг. Хожим үнэхээр л өвөөгийн цээжинд чоно гөлөглөсөн байгаа юм. Булган нутгийн дээхэн үеийн хөгшчүүл ч “Хулгар” Нацагийн цээжинд чоно гөлөглөсөн гэж ярьсаар ирсэн. Булганы Хангал сумын ойролцоо “Хөх өндөр” гэдэг газрын баруухан талд цогцосыг нь тавьсан гэдэг юм. Тэгсэн хэд хоногийн дараа цээжинд нь чоно гөлөглөсөн араг яс нь алга болчихож. Морин тэрэгний мөр гарчихсан, шарилыг нь ачаад явчихсан байсан гэсэн. Баруун зүгт л явчихсан гэж манай аав ярьдаг байлаа. Аав маань “Хулгар” Нацаг өвөөгийн хамгийн том хүүхэд нь. Аавын дүү Очир барилддаг байсан. Нөгөө хоёр дүү нь бөх болоогүй. Аав маань харин Булганы наадам, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэнгийн наадам зэрэгт ноцолдож байсан аймаг, сумын цолтой хүн. “Хулгар” Нацаг өвөөг шилийн сайн эр байсан гэдгийг эмээ маань ярьдаг байлаа. “Өвөө чинь богцонд аргамж хийгээд л гардаг. Тэгээд олон хоног сараар явдаг. Баруун тийшээ гарахад зүүн талаас орж ирдэг, зүүн тийшээ гарахад баруун талаас орж ирдэг. Ирэхдээ нөгөө л аргамжтай богцтойгоо ирдэг байсан. Холоос туусан адуу малаа замдаа ядуу ардуудад тараачихдаг байсан” гэж ярина. Өвөөг ингэж олон хоногоор яваад ирсэний дараа хошуу тамгын газраас хүмүүс ирээд бариад явчихдаг байж. Дандаа хошуу дамнуулж хулгай хийдэг байсан байгаа юм. Тэгээд замдаа тараачихдаг. Өөрөө тийм баян байгаагүй юм гэнэ лээ. Цайны сүүний ганц үнээтэй, хэдэн хоньтой, унааны хэдэн морьтой л байж. Томоохон хулгай хийгээд ирэхээр нь хошууны тахарууд бариад авчихна. Хошууны наадам дөхөөд ирмэгц өвөө маань “Манай хошууны

наадмыг гадны бөх авах гээд байна. Би барилдаад наадмыг чинь авч өгье. Хэрвээ түрүүлж чадахгүй бол толгойгоо тавья, түрүүлж гэмээнэ би суллагадад явья” гэж амладаг байж. Хошууны наадамд бол төвөггүй түрүүлдэг байж л дээ. Тэгээд л ийм том ам гарч байхгүй юу. Харин даншиг наадмаас бол арслан цол л авсан байдаг. Аварга болоогүй. Уг нь аварга цолыг өлхөн авах байж л дээ. Ер нь аварга болж байсан гэдэг юм. Даанч шилийн хулгайч байсан, тэгээд шоронгоос гарахын тулд толгойгоороо дэнчин тавьж түрүүлсэн зэргээс нь болоод аварга цол өгөөгүй юм гэдэг. Албан ёсоор аварга цол хүртээгүй ч гэлээ аваргын хэмжээнд барилдаж түрүүлээд нөгөө л шилийн хулгайч гэдгээрээ тавигдаад явчихдаг байж. Харин аварга болоогүй үедээ бөхчүүдээс дандаа хээл хахууль авдаг байж. Олон хоногоор нутаг хошуу дамнан адуу хөөж яваад ирэхдээ гэртээ адуу малтай ирж байхыг нь үзээгүй гэж манай эмээ ярьдаг байсан. Намайг уг нь “Хулгар” Нацагийн шийрийг хатаах бөх болно гэж эмээ маань ярьдаг байсан юм гэнэ лээ. Гэвч би барилдаа ч үгүй. Манай Булган аймгийнхан шилийн сайн эр, сайн бөх гэдгээр нь “Хулгар” Нацаг өвөөг их хүндэлдэг юм. Гэхдээ хөшөө мөшөөг нь босгоогүй л байна. Харин улсын арслан “Хулгар” Нацагийн залгамж халааг авсан Ардын хувьсгалын үеийн аваргууд бол Булган аймгаас нэлээд хэд төрсөн. Булган аймгийн Хангал сумын нутаг “Улаан толгой”-н хойхон талд, хуучин Ламын хийдийн бааз гэж байсан газарт өвөөгийн өргөж тавьсан тээрмийн чулуу гэж байдаг юм гэсэн. Одоо манай нутагт Өсөхбаяр гэдэг өндөр настай хөгшин байгаа. Энэ хөгшин ноднин жил надтай уулзаад “За хүү минь. Чи сайн бөхийн удам байна. Улс амьтаныг албан ёсоор цуглуулаад өвөөгийнхөө өргөж тавьсан чулуу байгаа нутгаар нэг явмаар юм даа” гэж хэлж байсан. Энэ хөгшин тэр чулууг нь сайн мэддэг юм гэнэ лээ. Хагас тонн шахам жинтэй, 40 см-ийн зузаантай том дугуй чулуу байдаг юм гэсэн. Тэр чулуу нь голоороо хугараад нэг нь газар уначихсан байна гэнэ лээ. Энэ зунаас тэр чулууг нь очиж үзнэ дээ. Өвөөгийн маань жинхэнэ нэр нь Баянмөнх. Сүүлдээ адуу мал хөөж яваад л “Хулгар” Нацаг гэж дуудуулдаг болж. Нэг үе бүр “Хулгар” Нацаг Баянмөнх гэж дуудуулдаг байсан байгаа юм. Өвөө маань мундаг том биетэй хүн байж. Завилаад суучихсан байхад нь манай аав дүүтэйгээ суган доогуур нь орж гараад л хөөцөлдөж тоглодог байсан гэдэг. Арав гаруй настай байхдаа шүү дээ. 1955 онд байна уу даа. Өвөөг маань аварга том биетэй бөх гэдэг утгаар нь судалж сурвалжлахаар Унгараас баахан улс ирсэн гэдэг. Тэр үед аав маань Цэргийн госпиталд хэвтэж байж. Тэгээд Унгараас ирсэн улс аавтай уулзаад баруун аймаг руу дагуулаад явж байсан гэдэг. Тэр үед би жаахан байсан болохоор энэ тухай мэдэх юм алга.

## Энэрэнгүй сэтгэлтэй эрт цагийн хулгайч “Сээтэн” Жалбаа

Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын уугуул, ахмад зохиолч Д.Лувсандэлэг гуай дээхэн үед нутаг орондоо алдартай явсан шилийн эр “Сээтэн” Жалбаагийн тухай хүүрнэснийг толилуулж байна.

Урьдын Түшээт хан аймгийн Говь Түшээ гүний хошуу, одоогийн Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Өнгөт тэнгэлэг багийн нутагт “Сээтэн” Жалбаа хэмээх шилийн сайн эр амьдарч байсан юм. Энэ хүнийг сахилынх нь нэрээр Лувсаншарав гэж нэрлэж байсан. Жалбаа гуай нас ахисан хойноо Эрдэнэдалай сумын 5-р багийн нутаг Довын хөндий, Таван толгой, Хайсандаа, Хөтөөн-Улаан хавиар нутагладаг байлаа. Энэ хүн одоогийн Архангай аймгийн Өгийнуур, Батцэнгэл, Өлзийт сумын нутаг хавиар буюу тухайн цаг үеийнхээ Саруул гүн, Мэргэн гүн, Бишрэлтийн хошуу хүртэл явж ноёд баядын адууг хөөдөг байсан гэдэг. 1940-өөд оны үед Улаанбаатар хот руу Жалбаатай хамт найман хүнтэй аянчин хөдөлжээ. Хүмүүс шөнийн турш Жалбаа гуайгаар хулгай хийж байсныг нь яриулж явдаг байж. Яриа нь дуусахгүй өдрийн турш дэргэд нь тэмээн дээрээсээ хажууд нь наалдан чагнацгааж явсан гэдэг. Жалбаа гуай сөөнгө бүдэгхэн дуутай, хажууд нь явсан гурав дахь хүнд үг нь муу дуулдаг байсан гэдэг. Нэг удаа Жалбаа гуай хүмүүст “Та нар миний явж хийж байсныг бүрэн яриульа гэвэл манайд хонуут өнжүүтээр очоод яриулсан нь дээр биз дээ. Хулгай хийнэ гэдэг муу ажил шүү дээ. Ид бах болгемоор юм ер биш. Харин би ядуувтар айлын мал хуйг авдаггүй байсан. Одоо насны эцэс ойртохоор хийсэн нүглээ наминчилж буян хийж явна даа. Ямар сайндаа энэ Оросын улаан армид таван сайхан морио бэлэглэх санаатай. Буруугаа зөв нь дардаг дайн юм чинь зөвийн талд нь туслахаар буян болно биз дээ” гэж ярьж байсан гэдэг. Тэр жижигхэн биетэй, улаан шар хүн байсан. Залуудаа нэлээд царайлаг, дөрвөлжин банди байсан гэж хуучуул ярьдаг байлаа. Жирийн ядуу ардад элэгтэй ханддаг, зөв сайхан сэтгэлтэй хүн байсан гэнэ лээ. Нэг удаа ой модон дотор аргамжаатай байсан хүрэн морийг аваад явтал араас нь эзэн нь “Ганц чөдрийн морийг минь үлдээж хайрлаач ээ. Би ядуу амьдралтай хүн. Аргамжааг нь аваад яв. Гурав эгшээсэн гунан үхрийн сур юм шүү” гэж хашгирч гэнэ. Гурав эгшээсэн гэдэг нь гурав дахин элдсэн, элдүүр нь бүрэн ханасан хамгийн зөөлхөн бөгөөд хамгийн бөх сур. Тэрхэн үед “Сээтэн” Жалбаад өрөвдөх сэтгэл төрж “Энэ хүн ганц сайн аргамжаагаа надад өгчихөөд ганц морио юугаараа аргамжих билээ” гэж бодоод гурав эгшээсэн аргамжааг нь морьтой нь хамт орхиод явахад эзэн нь “Еэ буян чинь дэлгэр. Чи жинхэнэ шилийн эр байна” гэж хашгирсаар үлдсэн гэдэг. “Өөрөөсөө баян хүнээс хулгайлбал арай бага нүгэл, өөрөөсөө ядуу хүнээс хулгайлбал бүр ч их нүгэл” гэсэн ийм нэг хуулийг урьдын хулгайч нар ухаан бодолдоо сахиж явсан байдаг. Жалбаа бас нэг удаа бөөн адуун дундаас хөөрхөн алаг зүстэй морь барьж авч хөтлөөд орой нар жаргахын өмнөхөн овоон дээр түр амраад сууж байж гэнэ. Гэтэл нөгөө алаг морь нь байн байн эргэн харж санаа алдаад нүднээс нь нулимс асгараад, нутаг ус, ижил сүрэгтээ хоргодсон янзтай байж гэнэ. Цаашаа мордож яваад худаг тааралдахаар нь бууж услах гэтэл нөгөө алаг морь нь ус ч уухгүй улам л санааширсан янзтай нутаг руугаа хараад янцгаагаад байж. Тиймээс Жалбаа алаг морийг өрөвдөөд суллаад тавьчихсан гэдэг. Үүнээс улбаалаад би бээр

“Хуучин сайхан тэр цагт

Хулгайч нь хүртэл энэрэнгүй байж

Хуншгүй муухай өнөө цагт

Хууль зохиогчид нь хүртэл хулхи болж” гэж шүлэглэж байлаа.

“Сээтэн” Жалбаа нэг нөхөртэйгээ алс хол хулгай хийж явахдаа олон хоног юм идэхгүй маш их өлсч гэнэ. Тэгээд хоёулаа айлын хотонд орж нэг хонь авчраад муулж идье гэж хэлэлцжээ. “Чи бид хоёр хэн хэн нь хонь муулж сураагүй, үзээгүй. Гэхдээ ёсоор нь амийг нь таслахаа байг гэхэд ядаж амыг нь бариад муулчихаж дөнгөх байлгүй. Амьтаныг хөөрхий бага л зовоох юмсан” гэж ярилцаж гэнэ. Юуны төлөө сурсан “эрдэм” билээ. Ядаж цөхөх юу байхав. Шөнийн харанхуйд айлын хотноос нэг нь мундаг том эр хонь шүүрээд ирж гэнэ. Тэгээд муулах гэтэл хэн хэн нь тэр хонинд гар хүрч зүрхэлсэнгүй. Сүүлдээ бүр арга ядаад нөгөө хонио буцаагаад хотонд нь аваачаад тавьчихсан гэдэг.

“Аргагүй өлссөн ч урьдын хулгайч

Амиа аврахын төлөө мал алж зүрхлэдэггүй байж

Ажил хийхээс залхуураад одоогийн хулгайч

Арав таван цаасны төлөө хүн алж зүрхэлдэг болж” гэж мөн л шүлэглэмээр санагдаж байлаа. Нэг удаа “Сээтэн” Жалбаа аглаг эзгүй уулан амны буйд газарт ганц гэр айлд буугаад эзнийг нь гэрээсээ гарах хооронд авдарны нь араар өнгийтөл шинэхэн элдсэн боодолтой сайхан хар сурыг дугуйлж эвхээд хананаас өлгөчихсөн байж гэнэ. Тэр сур өлгөсөн чигийг сайн ажиглаж аваад шөнө болмогц сэмээрхэн ирж гэрийнх нь гадаа буугаад хаяагаар нь гараа оруулж нөгөө сурыг нь тайлж авах гэтэл гарынх нь бугуйг айхтар бяртай гар атгаад авч гэнэ. Тэрхэн үед Жалбаагийн толгой ажиллаж “За чи ашгүй унтаагүй байгаа юмуу. Эхнэр хүүхэддээ мэдэгдэлгүй сэмхэн гараад ир. Ярих юм байна” гэж аминчлан шивнэтэл гарыг нь тавьчихлаа гэнэ. Тэгмэгц Жалбаа мориндоо үсэрч мордоод зугтаж одсон гэдэг. Эзгүй буйд газар нутаглаж байсан тэр гэрийн эзэн мөн л янз бүрийн хүнтэй нөхөрлөдөг явдалтай эр байж л дээ. Нэг удаа Жалбаа хошууныхаа хойд биеийн Сангийн далай хийд дээр ирээд явж байтал түүнийг холын хошууны тамгын албатан хүмүүс барих гэж тандаж яваа нь дуулджээ. Хар авсан Жалбаа хийдээс баруун хойшоо гарсан замаар ергүүлэхийн хөдөлтөл отоож байсан нөгөө хүмүүс мэдчихээд араас нь нэхэн хөөсөн байна. Жалбаа ч мориндоо ташуур өгч ухасхийн хурдалж гэнэ. Тэгээд Эрдэнэ-Овооны (Сүүлдээ Далайн-Овоо нэртэй болсон) баруун хоймор дахь өндөр хадны дэргэдүүр гаруугаа хажуу тийшээ булгаж хадны ард морьтойгоо наалдан зогсчээ. Төдөлгүй мөнөөх хөөж яваа хүмүүс хадны хажуугаар давхиж өнгөрөхөд Жалбаа хадны нөгөө талд орж нуугдаад эсэн мэнд хоцорч чадсан гэдэг. Тэр цагаас хойш уг хадыг “Жалбаагийн хад” гэж нэрлэх болсон гэдэг. Одоо ч тэр нэрээрээ байгаа. Эрдэнэдалай сумын төвөөс баруун хойш 20-иод км газарт Дарцагт хэмээх бэсрэг уул байдаг. Энэ уулын баруун талд адуу мал нуухад зориулагдсан гэлтэй тэрүүхэндээ мушгирч дугуйрсан доголтой жаахан сархиа байдаг. Энэхүү сархиаг “Жалбаагийн ам” гэдэг юм. Жалбаа энд алс холоос хөөж ирсэн адуу малаа нууж байсан гэдэг. Тэрбээр 1940-өөд оны үед нутгийнхандаа ярихдаа “Хөрөв том адуу арваадыг нуучихаж болдог байсан. Харин арваас илүү адуу нуухад багтаж өгөхгүй ил гарч баригдуулчих гээд байдаг байлаа” гэж ярьдаг байж. Жалбаа гуай аливаа юманд нарийн аргатай, их ухаалаг хүн байсан. Энэ нь олон газар олон хүнтэй уулзаж

учирч элдэв бэрхийг туулсан шилийн сайн эрийн амьдралтай нь холбоотой болов уу. Жалбаа гуайнх нь Таван толгой, Ил-Энгэр, Улаан хошуу гэдэг бууцнуудад голдуу өвөлждөг байлаа. Ширүүн цас шуурга тавихад таван хошуу малаа бүгдийг нь гаднаа хурааж хөдөлгөлгүй тогтоож хонуут өнжүүт адгуулж өнгөрөөдөг байж билээ. Бусад айлын мал шуурганд уруудаад явчихдаг, харин Жалбаа гуайн мал огт шуурганд урууддаггүй тийм нэг ид шидийн гэмээр явдал олон тохиосон байдаг. Энэ нь ердөө л эцэг өвгөдөөсөө уламжилж ирсэн малч ухаан байлаа. Мань хүн хоттой хониныхоо өмнө үхрээ бөөгнүүлж хураагаад, бууцныхаа хөлд тэмээгээ хэвтүүлж, түүний өмнө хоёр азарга адуугаа урагш нь гонзгой байрлалаар цувруулсхийн зогсоогоод аль ч малаа хөдөлгөөнгүй болгоод тогтоочихдог адтай нэгэн байж билээ. Ингэхдээ гэрийнхээ үүдэнд зогсоод янз бүрийн аялгаар “Хаая, хүүе, аая, үүе” гэсэн дуу авиа гаргана. Ингээд л хэдэн минут болоход тэмээ, үхэр нь хэвтээд, халз өмнө нөмөрт нь адуу нь тогтож зогсоод хөдөлгөөнгүй болох жишээтэй. Нэг ёсондоо таван хошуу мал нь аль алиныхаа нөмөрт, амьсгааныхаа илчинд, бас гэрийн утааны илчинд хорогдож тогтоод удаан үргэлжлэх цасан шуурганд бүгд уяатай юм шиг хөдөлгөөнгүй байцгаадаг байв. “Сээтэн” Жалбаа хэмээх ийм нэгэн элдэвтэй эр Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт галтай цогтой амьдарч явсан бөгөөд түүний адал явдал, арга туршлага өдгөө ч говь нутагт дуурсагдсаар байдаг билээ.



## Хэнтийн ян хөвчөөр гэр хийсэн “Бозлог” Даш

Соц нийгмийн үед “Бозлог” Даш хэмээх сайн эр байсан бөгөөд тэрбээр адуу хөөсөн хэргээр шоронд хоригдсон ч ганцхан сарын дараа оргож босоод Хан Хэнтийн ян хөвч рүү гараад явчихсан гэдэг. Энэ тухай түүнтэй хамт хоригдож байсан Хан Хэнтийн унаган хүүхэд Цэндийн Тайван гэгч эр доорхи зүйлийг хүүрнэсэн юм.

“Бозлог” Даш ян хөвчид арваад жил бүгэхдээ Японы нинжа нарын хийдэг үйлдлийг төгс эзэмшсэн байгаа юм. Хожим засангийнханд баригдаад шоронд ирсэн хойноо нинжа нарын хийдэг үйлдэлүүдээсээ ялтануудад хийж үзүүлдэг байлаа. Хамгийн наад захын жишээ гэхэд л утасны модонд дөрөө хэрэглэлгүй авирч гараад тасарсан утсыг залгачихдаг байсан. Яг л муур шиг. Ер нь хүн нэг л юмаар дагнан хичээллээд байвал тэр нь гарт нь орчихдог юм гэсэн. Залуу байхад хоол унд сайтай бол ялны ажилд адуу шиг л тачигнадаг байлаа. Миний хувьд гэвэл ууланд мод цагаалж үзсэн. Гал тэргэнд жонш ачиж ч үзсэн. Харин Туул голоор сал урсгаж үзээгүй. Дээхэн үеийн хоригдолууд сал урсгах хүнд ажилд амь бие хайрлалгүй зүтгэдэг байсан гэдэг. Надад бол ууланд мод цагаалахаас жонш ачих л их хүнд байсан. Гар цэврүүтээд улаан нялга болчихно. Сүүлдээ бүр эвэршиж хатуураад яг л мод шиг болчихдог. Нэг ёсондоо модон гартай хоригдолууд жонш ачдаг байлаа. Ийм гараар хүн цохиж унагавал ёстой нам авна биз дээ. “Бозлог” Даш ян хөвчид бүгэж байхдаа яг л бозлог шиг өнхөрч сурсан байгаа юм. Тэр ч байтугай ар нуруугаараа хэвтчихээд агаарт хий үсэрдэг байсан. Түүнийг ялтанууд “Орчин үеийн шилийн сайн эр” гэж хүндэлдэг байлаа. Мөн “Дэлт” Сумъяа гэгч эрийг зарим ялтан шилийн эр гэж хүндэлдэг байсан. Харин би бол түүнийг байдаг л нэг дээрэмчин мэтээр үздэг байсан. “Дэлт” Сумъяа бол шилийн эр биш хогийн амьтан. Мань эр далаад оны үед өөрийн хам хэрэгтэн “Хар” Банди тэргүүтэй гурван хоригдолын хамт шоронгоос оргоод Төв аймгийн нэг модтой ууланд бүгэж л дээ. Тэгээд Энхнамжил ч билүү нэг бүсгүйг хонь хариулж явгал тэдний нэг нь цохиж унагаад морин дээр дүүрч явсаар бүгэж байсан ууландаа авчирсан гэдэг. Эхнэр хүүхдийн бараа хараагүй тэдэнд эмэгтэй хүн хэрэгтэй л байсан байлгүй. Эдэлж хэрэглэхээс гадна хоол цайгаа хийлгэж, хиртэй хувцасаа баахан угаалгаа биз. Ямар ч байсан арваад жил эдэлсэн гэдэг юм. Сүүлдээ юу болсон юм бүү мэд. “Хар” Банди гэгчийн нэрийг би дуулсанаас цаашгүй. Оргож босоод огт сураггүй болсон аль олон ялтаныг хэлж барах билээ. Харин Хөвсгөлийн тайгад арван жил бүгсэн “Уулын” Төмөртэй шоронд нэлээд дотно байлаа. Мөн дээр өгүүлсэн “Бозлог” Даш гэдэг өвгөнтэй нэлээд дотно байсан. Түүнийг зохиолч Сономын Удвал гуай батлан дааж шоронгоос суллаж байлаа. Яагаад гэвэл Даш гуай ууланд байхдаа зохиол оролддог байж л дээ. Тэгээд баригдсаныхаа дараа шоронд ирээд Удвал гуайд захидал бичиж зохиол мохиолоо танилцуулсан юм билээ. Гэхдээ түүний зохиол хэвлэгдээгүй. Зохиол бичих гэж оролддог байсан болохоор нь Удвал гуай үнэлээд харж үзсэн юм байлгүй. Миний хувьд гэвэл тэр зохиол мохиолоос хол хөндий байсан. Харин манай Хан Хэнтийн “Доён” Ганбаа агсан шоронд байхдаа шүлэг зохиолыг ёстой урсгаж өгдөг байлаа.

“Хэрвээ би чамд хэрэгтэй юм бол

Сүүдэр талаас чинь илчээр төөнөх

Сүнстэй шүлэгчийн хийморьтой явья

Хэрвээ би чамд хэрэггүй юм бол

Эргэж хэзээ ч биесээ харахгүй

Эмээлийн хоёр бүүрэг шиг явья аа” гэж “Доён” Ганбаа хоригдолуудыг хөгжөөдөг байлаа. Гэвч хянагч нар түүнийг хориотой шүлэг уншлаа гээд байнга л гүд үзүүрлэдэг байсан. Мань эр

“Шилмүүсний үнэр ханхалсан үртэс үүрч явж үхсэнээс

Шил дээр гарч адуу дурандан салхи залгилж яваад ялаа нэмүүлсэн нь дээр” гэдэг байж билээ.

## Засаг ноёнтгойгоо хамтарч хятадуудыг тоносон “Яргай” Дугаржав

Өвөрхангай аймгийн харъяат “Цахиур” Жанчив хэмээх жар гаруй насны өвгөн дээхэн үед Түшээт хан аймагт зард гарч явсан шилийн сайн эр, өөрийн өвөг эцэг болох “Яргай” Дугаржав хэмээгчийн тухай өгүүлсэнийг сийрүүлэе.

Бүрэн засагчийн дөрөвдүгээр онд Түшээт хан аймгийн ван Лувсандорж жил болгон хятад пүүсэнд өр тавьсаар 20 мянга гаруй лан мөнгөнд хүргэжээ. Тэрбээр энэ их өрөө төлөх нь бүү хэл улам нэмсээр байсан тул хятад худалдаачид ихэд бухимдаж Түшээт хан аймгийн чуулган даргад гомдол мэдүүлсэн байна. Энэхүү зарга нэлээд сунжирсаны эцэст чуулганы ноёд Лувсандоржид “Хятад худалдаачдын өрийг төл” гэж тулган шаарджээ. Ингээд тэрбээр их өрөө төлөхийн тул өөрийн хамжлагат ардуудаасаа хоёр жилийн дотор гурван мянга гаруй үхэр, хонь, адуу татварлан авчээ. Гэхдээ энэ бүгд нь өрийнх нь талыг ч дарж чадаагүй бөгөөд ердөө л 6000 лан мөнгө болсон байна. Тиймээс Лувсандорж дахиад их хэмжээний татвар цуглуулж эхэлтэл хамжлага ард Самбуу-Ёндон, Пэрэнлэй, Дамиран гэгч гурван хүн “Ноёны өрнөөс төлөлцөөд малаа барав. Дахиад өгөх өнчин ишиг ч байхгүй” гэж адарчээ. Үүнийг сонссон вантан ихэд хилэгнэж тэр дор нь цэрэглэн очиж тэр гурвыг баривчлаад хар гэрт хорьж орхисон байна. Гэтэл маргааш орой нь шоронгийн хар гэр хоригдогсодын хамт шатаж үнснээс өөр юм үлдсэнгүй. Энэхүү эмгэнэлт явдал болоод удаагүй байтал Пэрэнлэйн 25 настай хүү Дугаржав татвар хураагчдыг харж байхад гэрээ шатааж орхиод “Намайг үхсэн эцгийнхээ өшөөг авна гэж тэр вандаа хэлээрэй” гээд давхиад явчихсан байна. Тэр энэ өдрөөс эхлэн уул хаданд бүгж, Вангийн адуун сүрэг рүү үе үе довтлон орж аль хурдан удамтай адууг нь ийш тийш тараан хөөж эхэлжээ. Мөн пүүсний хятадуудыг тонох болж, улмаар хэд хэдэн хятадын толгой руу яргай ташуур буулгаснаас болж “Яргай” гэдэг хоч зүүх болсон байна. Дугаржав эцгийгээ даган багаасаа аян жинд явсан болохоор хүдэр чийрэг, хэр баргийн хүнд дийлдэхээргүй, ямар ч эмнэг хангал адууг уурга бугуйл хэрэглэлгүй ноцоод барьчихдаг нэгэн байж. Дугаржав иймэрхүү маягаар гурван жил хулгай зэлгий хийж хаана л бол хаана явдаг нэгэн болсоноор нутгийнхаа ард олонд шилийн сайн эр гэж хүндлэгдэх болжээ. Тиймээс Лувсандорж ван түүнийг эцгийнхээ өшөөг авч болзошгүй хэмээн сэрэмжилж гэр өргөөгөө гурав дөрвөн хүнээр тогтмол мануулдаг болсон байна. Тэгтэл нэг бороотой өдөр юүдэн цувтай хүн вангийн өргөөний гадаа морио тушчихаад шууд гэрт орсон нь “Яргай” Дугаржав байлаа. Тэрбээр шууд л хэт хутгаа сугалаад “Эцгийг минь шатааж алсаны төлөө амийг чинь эрлэгт тушаахаар ирлээ” гэхэд Лувсандорж ван айснаасаа болоод золтой л ухаан алдчихсангүй. Гэсэн ч тэр өчүүхэн сэхээ авч урт цэнхэр хадган дээр тавин лангийн ембүү тавиад “Энэ хятад худалдаачид манай хошууг мөн ч их зовоож байна. Чи бол манай нутаг хошууны сайн эр. Чам шиг ийм сайн эр манай нутагт урьд хожид төрж байсангүй. Чи надаас эцгийнхээ өшөөг авахаасаа өмнө нутаг хошууны ардуудыг өрөнд баригдуулж хэргийн эх үндсийг тавьсан хятадуудаас өш хонзон аваач ээ. Дараа нь намайг чи яасан ч болно. Зүрхийг маань сугална уу, амьдаар минь өвчнө үү, чиний л дур” гэх зэргээр дуржигнуулж гарчээ. Хариуд нь “Яргай” Дугаржав “Надад чиний наад хадаг, ембүү хэрэггүй. Гэхдээ яахав чиний амийг өршөөе. Харин нутгийн ард түмнийг өрөнд баригдуулсан хар хятадуудыг тонон дээрэмдэхэд засаг ноён чи тусална шүү. Тус хүргэж чадахгүй бол харин амийг чинь авна” гэж хэлээд гарч одсон байна. “Яргай” Дугаржавыг хэд хоног ууланд хэвтэж байтал Лувсандорж вангийн хиа нар хүрч ирээд “Нөгөөдөр өглөө хятад худалдаачид гурван түмэн малаа

Хүйтэний хөндийгөөр Жанчхүү рүү туух гэж байна. Манай хошууны хэдэн хүн малаас нь туулцана. Тэд чамд эсэргүүцэл үзүүлэхгүй. Чи зөвхөн хятадуудтай л тэмцэлдэнэ. Чамд үүнийг дуулга гэж Лувсандорж ван биднийг явууллаа” хэмээжээ. Тиймээс Дугаржав хоёр сайн морио шавхрааж унаад Хүйтэний хөндийн ойролцоох модонд очоод хэвтчихсэн байна. Хоёр хоногийн дараа хүсэн хүлээсэн өдөр болж Хүйтэний хөндийг бүрхсэн их мал шаагилдсаар орж иржээ. Тэрхүү малыг дөрвөн хятад, таван монгол хүн тууж яваа харагдсан байна. Дугаржав тэднийг өдөржингөө дагаж харуй бүрий болохын алдад дөхөж очвол хоёр хятад малаа тойрон алхаж байв. Мань залуу нэг хятадынх нь араас дөхөж очоод ташуураар ар дагз руу нь цохьтол пидхийтэл унаад өгсөн байна. Тэгээд цааш гэтсээр нөгөө хятадын нь толгой руу ташуураа буулгах гэтэл тэр эргэж хараад муухай хашгирчээ. Тэгмэгц Дугаржав дайран очиж тэр хятадыг нам цохиж унагатал хамт явсан хүмүүс нь мэдчихэж. Тиймээс тэр арга буюу зугтсан байна. Тэдгээр мал туугчид түүний араас хөөлгүй хоёр хятадаа дамжлан майхандаа оржээ. Энэ үед Дугаржав 500 гаруй үхэр, хонь тасалж туугаад хөдөлтөл мал туугчид майхнаасаа гарч ирээд “Ланжуу” бугаар толгой дээгүүр нь буудаад түүний араас хөөх аядсан ч төдөлгүй буцаад явчихаж. Эд нар Лувсандорж вангаас даалгавар авсан хүмүүс байсан нь тодорхой. Тиймээс Дугаржав тасалсан малаа аажуу тайван тууж явсаар ойролцоох айлын малд нийлүүлчихээд буцаж нөгөө тууварчдыг дагасан байна. Төдөлгүй тэднийг үдлэх үед шууд л гэмгүй царайлан давхиж очтол нөгөө хоёр хятад хэвтэрт орчихсон хүн танихын аргагүй болчихсон байж. “Яргай” Дугаржавыг мордох үед нэг монгол дөхөж ирээд “Чи өнөө шөнө манаанд гарах хоёр хужааг балбачих. Бид бусдыг нь аргалъя” гэж шивэгнэжээ. Дугаржава шөнө болмогц морины хар гүйхээр манаач хятад руу нь давхин очиж ташуураараа нам ширвэж орхиод, нөгөө хужааг нь унаж яваа мориороо дайртал монгол тууварчид “Дээрэмчид ирлээ. Амь амиа бодоорой” гээд тал тал тийшээ зугтсан байна. Дугаржав нөгөө хоёр хятадыг барьж авч хүлээд дөрвүүлэнг нь майхнаар нь дарж орхиод дараа нь бүх малыг нь туугаад хөдөлжээ. Түүнийг дөнгөж гүвээ давтал нөгөө хэдэн тууварчин дөхөж ирээд “Лувсандорж вантан чамд туслаарай гэж бидэнд хэлсэн юм. Энэ олон малыг хэд хэдэн айлд тараан байрлуулна” хэмээжээ. Үүнээс хойш хэд хоногийн дараа Лувсандорж вангийн өргөөнийхөн “Засагт ханы шилийн эр “Ногоон” Дампил тэргүүтэй тав зургаан хулгайч манай хошуунаас гурван суурь мал туугаад гарсан гэнэ. Тэр нь хятад пүүсийн мал бололтой” гэсэн цуурхал тараажээ. Энэ үед хятад худалдаачид тал тал тийш нь баахан эрэлчид давхиулсан ч нуур далай шиг их мал нь газрын гаваар орсон мэт сураг алдарсан гэдэг. Ингэж шилийн сайн эр “Яргай” Дугаржав засаг ноёнттойгоо хамтарч хятадуудын малыг тонон дээрэмдэж байсан түүхтэй ажээ.

Үүнийг өгүүлэгч “Цахиур” Жанчив нь өвөг эцгийнхээ шийрийг хатааж байна уу гэлтэй соц нийгмийн үед нэг хэсэг бужигнуулжээ. “Тунгалаг тамир” кино анх дэлгэцнээ гарч байсан 1974 онд тэрбээр уг киног үзчихээд “Цахиур” Төмөрийг дууриаж шилийн сайн эр болох гэж хөглөөд олон жил шоронгоор гэр хийжээ. Тэрбээр залуу зандан насныхаа алдаа завхралын талаар доорхи түүхийг хүүрнэсэн юм.

“1974 онд би “Тунгалаг тамир” киног үзсэн биш шилийн сайн эр болох гэж хөөрцөглөөд “Цахиур” гэдэг хочтой болж байлаа. Тэр үед өвөг эцэг “Яргай” Дугаржавынхаа тухай дуулж сонссон байсныг ч хэлэх үү, шууд л шилийн хулгайч болохоор шийдэж Өвөрхангай аймгийн хэдэн сумдын малыг нааш цааш нь болгож ядарсан ардуудад тусалж эхэлсэн. 1974-1976 он хүртэл баригдалгүй явсан. Гэхдээ дандаа баячуудын малыг хулгайлна. Би голдуу уул хаданд

орогнодог байлаа. Амьхандаа “Цахиур” Төмөрийг дуурайж байгаа нь тэр. Гэвч социалист засгийн хууль намайг “Цахиур” Төмөр шиг байлгаагүй. Надад нөгөө шилийн сайн эр явах орон зай, цаг хугацаа нь таараагүй. Би өөрийгөө 1900-гаад оны үед төрчихгүй яв даа гэж боддог юм. Тэр үеийн нийгэм л надад яг таарах байж. Харин “Цахиур” гэдэг хочийг би өөртөө өгөөгүй, нутгийн ардууд надад хайрласан юм. Би энэ хочиндоо их хайртай байдаг. Гэсэн ч би өөрийгөө шилийн сайн эр болж чадаагүй гэж үздэг. Шилийн сайн эр, социалист хууль хоёр нэгэн тогоонд хамт буцалдаггүйг би олон удаа мэдэрсэн. Гэхдээ би өөрийнхөө туулсан амьдралд гутардаггүй. Хэдий олон жил шоронд тарчилсан ч би морины сайныг унаж, хүүхний сайхныг эдэлж үзсэн. Анх би зургаан жилийн ялтай шоронд орсон ч хорь гаруй жил ял эдэлсэн. Яагаад гэвэл би гурав дөрвөн ч удаа оргож боссон хүн. Ер нь халхын шоронгоос оргоход амархан шүү дээ. Одоо харин хэцүү болчихсон юм билээ. Би сайндаа ч оргоогүй юм. Надтай хамт мал нааш цааш нь гаргадаг байсан хоёр нөхөр туувар тууж явах далимаараа намайг эргэсэн юм. Энэ хоёр л миний сэтгэлийг урвуулчихгүй юу. Тэр үед би Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын хорих газар байлаа. Энэ анги Хархорин руу шилжээд олон жил болж байна. Би хоёр найзыгаа дагаад бүтэн жил мал нааш цааш нь болгосон. Тэгээд баригдахгүй явсаар Өмнөговь аймгийн Гурвантэс хүртэл яваад тэндээс гэв гэнэт л баригдсан. Уг нь цаашаа хил давчих бодолтой байлаа. Би Дундговь аймгийн нутгаас мөнөөх хоёр тууварчинаар нэлээд олон тооны мал туулгаад эхнэр хүүхэд рүүгээ явуулсан. Тэднийхээ амьжиргааг бас бодох хэрэгтэй биз дээ. Тэгээд би өмнөд хил рүү хөдөлсөн. Монголд надад ямар гишгэх газар байх биш. Гэтэл цагдаагийнхан намайг гэрт маань отоож байсан юмсанж. Нөгөө хоёр маань манайд очоод малтай юутай хээтэйгээ баригдаж, цагдаагийнхны эрүү шүүлтэнд тарчлахдаа миний хаана байгааг хэлээд өгчихгүй юу. Цагдаагийнхан миний хойноос нэхэмжилсээр Өмнөговийн Гурвантэсийн ойролцоо намайг гэв гэнэт л бариад авчихсан. Би эхнэр хүүхдээ бодолгүй зөвхөн хар амиа бодсон бол аль хэдийн хил даваад явчих байлаа. Нинжин сэтгэл гэдэг заримдаа хүнийг ингэж л алдаг юм даа. Хэрвээ би тэр чигтээ хил давчихсан бол өвөрлөгч нутгийнханы ёс заншилыг дагаж амиа аргалаад амьдарчих л байсан байх. Гэхдээ бас л хазаар гүйлгэн амьдарч таарна. Хазаар гүйлгэхэд хүний газар байх тусмаа л сайн шүү дээ”.

## Хятадуудтай орооцолдсон монголчуудын “Түүхэн гэмт хэрэг”-ийн тойм

Монгол хүнийг хамгийн ихээр хохироодог байсан хүмүүс бол Хятадын доншуур наймаачид. Тэднээс болж монголчууд хятад хүмүүст дургүйцэх болсон гэхэд хилсдэхгүй. Энэхүү дургүйцэл нь 1921 оны Ардын хувьсгалаар тод илэрч зарим ухуулах хуудаст “Хятадын шунахай худалдаачдаас эх нутгаа цэвэрлэе” гэсэн уриа бичигдэж байжээ. Энэ нь өнөө цагийн Хятадын эсрэг үзэл сурталтай адилхан ч юм шиг. Үнэхээр ч 1920-иод оны үед Монголын дөрвөн аймаг Хятадын өр зээлэнд баригдаж торонд орсон загас шиг амь тэмцэж байлаа. Богд хааны засгийн газар хятад худалдаачдыг янз бүрээр хяхаж хавчиж байв. Жишээлбэл ноёдын хатгаасаар лам нар “Гандангийн ойролцоох Хятадын пүүс дэлгүүрүүд Майдар эргэхэд саад болж байна” хэмээн Богд эзэнд гомдол мэдүүлэхэд эрхэм дээдэс хүсэлтийг нь хүлээж аваад хятад худалдаачдыг Амгаланбаатар хот руу хөөж байсан гэдэг. Одоогоор бол газарт оруулсан хэрэг. Тэгээд наймаачдыг Амгаланбаатар хот руу нүүж очиход газрын татвар гэж нэг худалдаачнаас 600 лан мөнгө авч байжээ. Үүний хажуугаар арван тавны цагдаа нар орчныг бохирдуулсан гэдгээр байсхийгээд л торгодог байж. Тэгсэн хэдий ч хятад худалдаачид ард иргэдийг шулсаар л байв. Одоогоос зуугаад жилийн өмнө монголчууд доншуур хятадуудтай тун дажгүй тэмцэл хийж байсан байгаа биз. Гэтэл өнөөгийн манай төр засаг, хууль хяналтын байгууллагууд, цагдаа нар даварсан хужаа нарын толгойг ёстой илэх шиг болж байгаа. 1920-иод оны үед хятадууд монгол иргэдийн өгсөн түүхий эдийг жинхэнэ цалин цагаан мөнгөөр бус зэс, гуульны холцтой “дуутуур” мөнгөөр сольдог байж. Энэ тухай “Ацаг шүдний зөрүү” уран сайхны кинонд тодорхой гардаг билээ. Ер нь хориод оны үед Монголын зах зээл дээр цэвэр мөнгө үзэгдэхээ байжээ. Хятад наймаачид өөрсдийн оруулж ирсэн бохир мөнгөө иргэдээс буцааж авахаа байснаар монголчуудын дургүйг хүргэж эхэлсэн байна. Мөн тэр үед Дай Шин Хүү-гийн пүүс гэхэд л арван мянга гаруй малаа монголчуудаар хариулуулдаг байж. Гэвч 1920 оноос эхлээд тэр их малнаас нь шилийн эрчүүд хөөж туугаад амар заяа үзүүлсэнгүй. Тиймээс хятадууд өөрийн гэсэн мөрдөгчийг Бээжингээс авчирч тэднийг шилийн эрчүүдийн эсрэг турхирч эхэлжээ. Энэ бүхнээс болж хятад худалдаачдыг хяхан хавчих үзэгдэл Монгол даяар өрнөсөн бөгөөд ямар сайндаа л Богд хааны засгийн газар Япон, Америк, Оросын пүүсүүдийг Да хүрээнд сууршихад илтээр дэмжиж, харин хятадуудад цаанаа л нэг ёозгүй хандаж эхэлсэн байдаг. Гэсэн хэдий ч хятад худалдаачдыг бүрмөсөн шахан зайлуулж чадсангүй. Харин ч хятадууд үйл ажиллагаагаа улам идэвхжүүлж томоохон яамдад тавьсан өрөө нэхэх болжээ. Энэхүү дарамтаас болж тэр үеийн сайд ноёд хятад пүүсийн эздийн өмнөөс үг хэлж чадахаа байсан бөгөөд харин тухайн үед Да хүрээ болон Богд хааны “Шавь таван аймаг”-т ихэд алдаршиж байсан шилийн хулгайч “Солгой” Пүрэв хэмээх эрээр толгойлуулсан цөс ихтэй, эх оронч сэтгэлгээтэй арав гаруй монгол Хятадын пүүсүүдийг галдан шатааж эхэлжээ. Тухайн үеийн арван тавны цагдаа нар тэдний үйлдлийг зогсоох нь байтугай араас нь огт хөөцөлдөлгүй зөнд нь орхисон гэдэг. “Солгой” Пүрэвийн бүлэглэл нь одоогийнхоор бол “Хөх Монгол”, “Даяар Монгол” хөдөлгөөнийхөнтэй төстэй ч юм шиг. Гэвч энэ хоёр хөдөлгөөнийг хужаа нарт элэг зүрх, ходоод гэдсээ тушаачихсан манай “новшийн” цагдаа нар яг дураар нь тавьж харагдаач. “Солгой” Пүрэв тэргүүтнийг хэд хэдэн хятад пүүс дээрэмдэн тоночихоод байхад тухайн үед Да хүрээний аюулгүй байдлыг хариуцдаг байсан Чин ван Ханддорж хүртэл битүүхэн дэмжиж “Богд хаант улсын иргэн Далхжавын Пүрэв Хятадын пүүсүүдийг галдан шатаасан гэх баталгаа алга” гэж мэдэгдэж байсан гэдэг. Тэгмэгц хятад худалдаачид тусгай бэлтгэгдсэн алуурчдыг Бээжингээс авчирсан

байгаа юм. Тэгээд тэд шилийн эр “Солгой” Пүрэвийг элдэв арга хэрэглэн барьж аван хэрцгийгээр хөнөөгөөд толгойг нь шонд өлгөж орхижээ. Гэвч хужаа нар иймэрхүү үйлдэл хийснээр монголчуудыг дарж авах биш харин ч дургүйцлийг нь улам төрүүлж, энэ нь яваандаа хувьсгал болж “ноцсон” түүхтэй. Ер нь хувьсгалаас өмнө ч гэлээ, хойно ч гэлээ хятад худалдаачдыг Монголын төр зохих хэмжээнд хяхаж хавчсаар ирсэн байдаг. Манжийн дарлалын үед Төр гэрэлт хаан “Монголын нутагт хятад хүн тариа тарьж болохгүй. Тэр уудам талд Манжийн их сүрэг бэлчиж байх ёстой” гэдэг байжээ. Манж нар Монголын тал нутгийг мал аж ахуйн бааз сууриа болгохыг чармайж байсан хэрэг л дээ. Аль ч цаг үед хятад худалдаачид, тариачид Монгол улсын эдийн засгийг хараат байлгаж чадсан юм. Харин өнөөдөр бол хятад наймаачид ямар ч хориг саадгүйгээр Монголд чөлөөтэй худалдаа наймаа хийж, пүүс компани эрхэлж байна. Тэд хувьсгалын өмнөх арга барилаараа ажиллаж манай түүхий эдийг өөрийн нутаг руугаа шоргоолж шиг зөөсөөр хорь гаруй жил болж байна. Монголчууд бид зам тавьж чадахгүй, барилга барьж чадахгүй, үйлдвэрлэл эрхэлж чадахгүй, өмд оёж чадахгүй гэж үглэсээр л сууна. Гэтэл хятадууд “Бид бүгдийг бүтээнэ, бид бүгдийг сөнөөнө” гэсээр Монголын тал нутгийг бүрхэж эхлээд байгаа. Өөр нэг асуудал гэвэл 19-р зууны эхээр монголчуудын дунд, ялангуяа эрх чөлөөний төлөө тэмцэгчид болон шилийн эрсийн дунд Хятадын шулаач пүүсүүдийн өрийн дансыг устгах явдал газар авсан байдаг. Монголчуудын дунд Буянтын пүүс, Настын пүүс, Дай Шин Хүү-гийн пүүс гэж алдаршсан Бээжингийн болон Хөх хотын эдгээр пүүс 1920-иод оны дунд үе хүртэл манай улсын эдийн засгийг өнөө цагийн Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг шиг хянаж байсан байдаг. Тухайн үед Настын, Буянтын гэх хоёр пүүсийг Амгаланбаатар хотод байрлуулахад иргэд болон лам нар “Газраа худалдлаа” хэмээн ноёдтойгоо тэрсэлдэж байсан гэх бөгөөд энэ нь өнөөгийнхөөр бол иргэний хөдөлгөөнүүдийн зүгээс тэмцэлдээд байдаг Оюутолгой, Тавантолгойн асуудалтай төстэй ч юм шиг. Хориод оны үед Да хүрээний нэгэн эрх мэдэлтэн Дэлэгдорж гэгч Хятадын худалдаачдаас газрын түрээсэнд жилд 600 лан мөнгө авдаг байж. Энэ нөхөр хятадуудтай худалдааны нарийн холбоотой байсан учир амин хувьдаа эдлэн газартай, эд агуурс ихтэй нэгэн болж хувирсан байх бөгөөд одоогийнхоор бол авилгач түшмэд, төрөөс төрсөн тэрбумтануудын л нэг байсан бололтой. Үүний зэрэгцээ зарим нэг хөнгөмсөг ноёд наадам цэнгэл, тансаг хэрэглээгээ хэтрүүлсэнээс болж Хятад пүүсүүдэд өртэй болж, тэр ч байтугай зарим нэг хошуу дийлдэшгүй өрөнд баригдсанаар сарнин бутрахад хүрч байжээ. Жишээ нь Сайн ноён хан аймгийн нэгэн хошууны ноён Балдан гэгч Буянтын пүүсэнд их хэмжээний зээл тавиад түүнийгээ өгөхгүй луу унжсанаас болж тус пүүсийн бичээч Баярт гэгч хужаад алуулах дөхсөн байдаг. Одоогийнхоор бол шүүхийн шийдвэр гүйцэтгэгч царайлсан Баярт хужаа Балдан ноёныг зодож нүдээд зогсохгүй эхнэрийн нь толгойг галын хайчаар хага цохиж байсан гэдэг. Тус хошууны зарим иргэд Буянтын пүүсэнд их хэмжээний өртэй байсан учир арга буюу нутгаасаа дүрвэхэд хүрч байсан байна. Бид бүхэн “Бадарчин” хэмээх хавчиг үүрсэн, хоёр мод барьсан хүний тухай зөндөө л сонссон. Тэд уг чанартаа өрөнд идэгдэж хоосорсон хүмүүс байж. Одоогийнхоор бол банкнаас зээл аваад гадаад руу дүрвэж одсон нөхөд. 1911 онд Хятадын томоохон данжаад нар Хөх хотод цугларч “Ар монголчуудын ядуурал улам гүнзгийрч байна. Хэрвээ зарим нэг дүрэм журмыг халахгүй бол ядууралд нэрвэгдсэн монголчуудыг буцаагаад тэнхрүүлэхэд бэрх” гэж ярилцжээ. Тэд сайндаа ч бус малчин удамтай монголчууд дампуурвал түүхий эдийн нь томоохон бааз болох мал сүргийг нь өсгөж үржүүлэх хүнгүй болно гэж айсанд байлаа. Тиймээс тэд зээлийн хүүгээ багасгаж гурван фунгаас хэтрүүлэхгүй байх, ноос ноолуур, арьс ширний үнийг өсгөх талаар ярилцсан нь тун сонин. Хятад хүн гэдэг ийм алсын хараатай, нарийн бодлоготой

байсан байх юм. Монголчууд малаа маллаад байвал өлсөхгүй, цангахгүй гэж ярьцгаадаг. Гэвч ямар нэгэн үйлдвэрлэл явуулахгүй бол баян данжаад нарын эрхшээлд орох нь гарцаагүй. Учир нь тухайн үед монголчууд өмсөх дээлийн даавуунаас эхлээд татах тамхиа хүртэл хятадуудаас авдаг байв. Лам, иргэд, малчид, ноёд, хутагтууд өрөндөө голдуу малаа өгнө. Хятадууд монголчуудаас авсан түүхий эдээ Чуулалт хаалга гэдэг газарт угааж цэвэрлээд Тянжин боомтоор дамжуулан гадаадын зах зээлд гаргадаг байж. Ингэснээр тэд Монгол улсыг зүгээр л нэг түүхий эдийн баазаа болгож чадсан бөгөөд 1921 он гэхэд Монгол улс бүх малаа хятад худалдаачдын өрөнд тавиад туух аюулд нэрвэгдсэн гэж судлаачид үздэг билээ. Орос, Хятад хэмээх хоёр том гүрэнд улс төрийн байдал тогтворгүй болоод ирүүт Да Шин Хүү, Тянь Юй Да зэрэг Хятадын томоохон пүүсүүд Монголын төрийг барьж асан хаад ноёдоос өрөө нэхээд эхэлсэн байна. Хятадын өрөнд манай улс бүх малаа өгөөд ч төлж дийлэхээргүй тийм их зээлийг монголчууд аваад идчихсэн байх жишээтэй. Тиймээс эх орончид бослого үймээн дэгдээж, үүнийг далимдуулаад шилийн хулгайч нар хятад пүүсний адуу малыг хөөх, эд агуурсыг нь дээрэмдэх зэргээр бужигнуулж эхэлсэн байдаг. Хятадын эрдэмтэн Ли гэгч нэгэнтээ “Монголчуудын 1921 оны эрх чөлөөний хувьсгал нь яг үнэндээ ард түмнээ Да Шин Хүү, Тянь Юй Да, Буянт, Настын пүүсүүдийн өрнөөс гаргах арга нь байлаа” гэж доош нь хийсэн байдаг. Ер нь ингэхэд монголчууд болон монгол ноёд хятад худалдаачдад хэдий хэрийн өр тавьсан юм бол... Гучаад оны үед До яамнаас гаргасан мэдээнд “Хятадад төлөх мөнгөний өр дөрвөн аймгийн 104 хошууны нийт 11 сая лан хүрсэн бололтой” гэж тооцоолсон байдаг. Үүнээс үзэхэд чамгүй өртэй байсан ч эд бүгдийг цайруулж чадсан нь гайхалтай. Манай улсын иргэд өр зээлээсээ зугтаах, бүр болохгүй бол үхэх, тэгээд бөөнөөрөө үхэхээр болвол хувьсгал хийгээд замруулчихдаг байсан гэлтэй. Хятад худалдаачид зээл өгсөөр байгаад өрөөр нь эргүүлээд боомилдог бөгөөд энэ нь дотор хүний “Ямхын онол” гэгч нь ажээ. Нэг ёсондоо тэд өнөөдөр малыг нь залгиад, маргааш гэрийг нь залгиад, эцэст нь газрыг нь залгих бодлого өвөрлөж явдаг гэсэн үг. Үүн лүгээ хятад лангууны наад цаад талд Монгол улсын хувь заяа дэнсэлж явсан үе бий. Монголчууд үеийн үед Орос, Хятад хоёрт өртэй явж ирсэн түүхэн шалтгааныг олоход тун амархан. Энэ нь ердөө л баялаг бүтээдэг бус баялагаа гадагш нь урсгадаг, үйлдвэрлэгч бус бэлэнчилдэг залхуу хойрго зан араншинтай маань холбоотой. Монголчууд бид “Өргүй бол баян, өвчингүй бол жаргал” гэсэн үгийг түүхийн эргэлтэнд яс махандаа хүртэл мэдэрсэн улс. Гэвч үүнийг жаахан өөр өнцөгөөс харвал туйлын буруу сургаал юм. Өнөө цагт хэн нэгэнд өр зээлгүй мөртлөө ядуу зүдүү, дутуу гучуу амьдарч байгаа олон зуун айл өрх байна. Үүнийгээ тэд “Өргүй бол баян” гэж тунхаглаваас залуучуудын хэлдэгээр “Том тэнэгтэж” байгаа нь тэр дээ. “Өргүй л бол баян” гээд л зөвхөн өдөр тутмынхаа хэрэгцээнд тааруулан ажиллаж хөдөлмөрлөдөг, хэрвээ өрөнд баригдчихвал боож үхэхээс наахнуур авирладаг ийм зан суртахуун монголчуудыг хойд, урд хоёр хөршийн эрхшээлд үеийн үед сөхрүүлсээр ирсэн түүхтэй.



## Хан хөхий уулын савдаг гэгдэж явсан Шагжийн Шарав

Увс аймгаас төрж гарсан Улсын начин М.Мижиддорж эдүгээ Ар гүнтэд ойн байцаагч хийхийн зэрэгцээ фермерийн аж ахуй эрхлэн амьдарч байна. Тэрбээр “Ар халхын шилийн сайн эрчүүд” ном гарсанд талархал дэвшүүлээд дээхэн үед нутаг орондоо алдартай явсан Шагжийн Шарав гэгчийн тухай хүүрнэсэн юм.

Би шилийн сайн эрчүүдийн намтар түүхийг шимтэн сонирхдог хүн. Гэхдээ шилийн эрчүүд гэдэг бол ганц миний сонирхдог зүйл биш л дээ. Хийморь золбоотой эр хүн бүрийн сонирхдог зүйл. Сайн эрсийн сайхан явдал суудал, намтар түүхийг уншиж, сонсох мөн ч гоё шүү дээ. Дүү хүү Ар халхын шилийн сайн эрчүүдийн тухай маш сайхан ном бичсэн байна. Манай энэ Гүнтэд чиний ном нэг хэсэгтээ л од боллоо. Эндхийн арваад хүн дамжуулаад уншлаа. Тэдний дотор чөлөөнд гарсан хурандаа хүн ч бий. Манай энэ Ар гүнт бол бичиг номын хүмүүст их энерги сайтай газар байгаа юм л даа. 1920-иод оны үед Сүхбаатар, Чойбалсан, Бодоо нар яг энэ Ар гүнтээр даваад Зөвлөлт улсаас тусламж гуйхаар явж байсан гэдэг юм. Мөн Богд хаан Ар гүнтэд үе үе тухлан саатдаг байж. Тиймээс бид энэ сайхан намтар түүхтэй газар нутагтаа шилийн эрсийн тухай сайхан ном бичсэн чамайг урьж авчраад өөрсдийнхөө мэдэх шилийн эрсийн тухай ярьж өгье гэж хоорондоо ярилцсан юм. Нөхөд маань энэ асуудлыг зохион байгуулахыг надад даалгасан юм. Надад ч бас шилийн сайн эрсийн тухай ярих юм бий. Манай Увс аймаг, Хан хөхий нутагт шилийн сайн эрчүүд олон байсан. Юуны өмнө би бөх болсон тухайгаа товчхон ярья. Би 1970 онд 22 настайдаа Ардын армид ирсэн. Цэргийн дарга нар намайг том биетэй, бяр тэнхээтэй цэрэг гэж үнэлдэг байлаа. Яагаад гэвэл би цэрэгт ирэхээсээ өмнө сумын наадамд гурван ч удаа түрүүлээд сумын заан цол хүртчихсэн байлаа. Тиймээс намайг “Алдар” нийгэмлэг шууд авсан. Тэр үед надтай цуг Цэрэнтогтох, Хадбаатар, Цэнд-Аюуш гээд мундагууд байсан. Бүгдээрээ манай оны цэргүүд. Биднээс Цэрэнтогтох маань дархан аварга цол, Хадбаатар маань аварга цол, Цэнд-Аюуш маань улсын заан цол, би улсын начин цол хүртэх шив дээ. Бас Өвөрхангайн Даваасүрэн гээд сүрхий барилддаг аймгийн начин байлаа. Би сартуул хүн л дээ. Мөнхбат аварга намайг ид барилдаж байх үед “Энэ муу улаан дөрвөдийг дээш нь гаргаж болохгүй” гэдэг байсан. Баянмөнх аварга ч бас ийм бодолтой байсан юм шиг байгаа юм. Би ч аваргуудтай ач тач арсалдаж тэрсэлддэг байсан. Энэ их муу юм болсон. Аятайхан байж байгаад аль далаад онд улсын начин болчих байсан би гэдэг хүн арав гаруй жил аварга, арслангуудад дарагдаж байгаад 1984 онд улсын начин цол хүртсэн дээ. Мөнхбат аварга “Энэ Мижиддорж жинхэнэ эр хүн байна. Дамдин гуай та энийг нэг авч үзээч” гэснээр би улсын начин болж байлаа. Тэр үед бидний багш Дамдиншарав дасгалжуулагч “Үеийнхнээсээ хамгийн сайн нь чи байсан. Би чамайг улсын наадамд долоо найман удаа түрүүлнэ гэж боддог байлаа. Гэтэл чи улсын начингаас хэтэрсэнгүй шив дээ” гэж миний амыг таглаж билээ. Миний үндсэн мэргэжил гэвэл прокурор. Хэнтийд болон Бэрлэгийн колонид арван жил хяналтын прокурор хийсэн. Ингэж явахдаа оргож боссон ялтан эрж хайхаар уул хадаар бишгүй дээ л нэг явлаа. Аль эрт уул хаданд үхээд хатчихсан улстай зөндөө л тааралдаж байлаа. Ер нь дээхэн үеийн шилийн эрчүүд орогнож байсан уул хадандаа ясаа тавих нь их байж. Хориод оны шилийн эр “Улаан” Дамаагийн орогнож байсан Минжийн хангайд “Ноён уулын ногоон өвгөн” гэдэг айхтар шилийн эр амьдарч байсан гэдэг юм. Энэ хүн Нямсүрэн гэдэг Хөвсгөлийн ялтаныг шоронгоос оргуулж байлаа. “Ноён уулын ногоон өвгөн” өөрийнхөө

туг сүүл ч байхгүй, хариугүй туранхай яндан цагаан морийг түүнд унуулаад “За чи Засангийн хониноос нэгийг шүүрээд ир” гэж гэнэ. Цаадах нь ч хэлсэн ёсоор нь болгож. Тэгээд хоёулаа нэг сайн гэдэс гарч аваад уул руу хөдөлсөн байгаа юм. Гэтэл төдөлгүй Засангийнхан тэдний хойноос гүйцээд ирж. Нямсүрэн Засангийн алдартай хурдан хул морийг унаж явсан болохоор айх аюул байсангүй. Шууд л амыг нь тавиад пижигнүүлчихэж. “Ноён уулын ногоон өвгөн”-ийг хамт зугтаах юм бодсон чинь нөгөө муу туранхай цагаан морьтойгоо хойно нь үлдсэн байгаа юм. Нэлээд явж байгаад эргээд харсан чинь “Ноён уулын ногоон өвгөн” Засангийнхан руу өөрөө яваад очиж байх юм гэнэ. Тэгсэн чинь гэв гэнэтхэн цагаан тоос татаад өвгөн алга болчихож. Засангийнхан мөр хайгаад олсонгүй. Нэг ёсондоо тэднийг тоосон дунд төөрөлдүүлж байгаад л аль нэг сугаар нь гараад явчихгүй юу. Унаж явсан тэр туранхай цагаан морь нь юунд ч гүйцэгддэггүй хурдан хүлэг байж. “Ноён уулын ногоон өвгөн”-ийг ууландаа уусан шингэсэн гэж ярьдаг юм. Минжийн хангайн халуун рашаан, цаашлаад Ерөөгийн халуун рашаан хүртэл би явж үзсэн. Хэн хүний олж очмооргүй ойн гүнд жаахан модон амбаар барьчихсан, тэнд нь орохоор нааран дээр нь аль хэдийн үхээд арьс мах нь хатчихсан хүний араг яс байдаг байлаа. Уул хаданд явж байхад иймэрхүү юм бишгүй дээ л нэг тааралдана. Бодвол нөгөө хөвч тайгад орогнодог байсан шилийн хулгайч нарын л араг яс биз. Шоронгийн атаман нааран дээрээ үхдэг гэсэн яриа байдаг. Үүн шиг шилийн эрчүүд уул хадандаа ясаа тавьдаг байж дээ. Иймэрхүү яс арьс болсон хүнийг хэн болохыг нь мэдэх арга байхгүй. Харин Засангийн хоригдолууд үхлээ гэхэд бүхэнд илэрхий байдаг. Бэрлэгийн мянган хоригдолоос долоо хоног бүр нэгээс хоёр хүн хад, модонд цохигдож үхдэг байлаа. Хоригдол хүний амь нас нохойныхоос дор байсан цаг. Ямар сайндаа л тусгай хяналтын дарга Гэндэндаржаа гэдэг хүн надад хандаж “Чи энэ ялтануудыг сайн харж хамгаалж бай. Эд нарын эрх ашгийг хамгаалах хүн чамаас өөр байхгүй шүү” гэж захидаг байлаа. Тун шалихгүй асуудлаас болж хүний амь бүрэлгэчихсэн хүн олон байдаг байсан. Жишээ нь нэг хор шартай нөхөр дал орчим насны өвгөнтэй шатар тоглож л дээ. Гэтэл өвгөн хожчихож. Нөгөө шартай эр “Яасан их хүн хождог өвгөн бэ” гээд шатрын бэрсээр толгой руу нь зөөлхөн тоншчихсон чинь тархинд нь цус харваад мажийчихсан байх жишээтэй. Ингээд л хүн амины хэрэгтэн болчихож байгаа юм. Би энэ хүнийг зөв талаас нь хянаж өмгөөлөөд шоронгоос суллаж байлаа. Манай нутагт Хан хөхийн нуруу гэж хоёр гурван сумын нутгийг хамарсан их сайхан урт нуруу байдаг юм. Соц нийгмийн үед Шаазанхүү гэдэг шилийн эр энэ нуруунд бүгдэг байлаа. Хан хөхийн нурууг 33 савдагтай гэж ярьдаг. Дөчөөд оны үед Хан хөхийн нуруунд Зул гэдэг шилийн хулгайч бүгдэг байсан гэнэ лээ. Нэг орой түүнийг урцандаа цай чанаад сууж байтал ногоон торгон дээлтэй эмэгтэй хүн ороод ирж гэнэ. Тэгээд Зул руу ойртож очоод “Цайнаасаа аягалаад өгөөч” гэхэд мань эр “Өө, энэ хог чинь бас цай уудаг байсан юмуу” гээд хэлчихэж. Тэгсэн нөгөө хүүхэн чимээгүйхэн гараад явчихаж. Гэтэл Зул тэр шөнөдөө унтаж чадсангүй. Араатнуудад бүслэгдэж байна, аварга могойд хатгуулж байна гэж янз бүрийн юм зүүдлээд, эцэст нь арга ядахдаа ээж дээрээ очихоор урцаа орхиод гэрийн зүг хөдөлсөн байна. Тэгээд үүр хаяарахаас өмнө гэртээ ирээд ээждээ болсон явдлыг ярьж л дээ. Ээж нь Хан хөхийн савдагийг хилэгнүүлчихлээ гээд л загнасан байна. Төдөлгүй Зулыг сэргийлэхийнхэн барихаар гэрийнх нь гадаа хүрээд ирж. Ээж нь гараад нохой хорих зуур шилийн эр Зул өөрийнхөө хоолойг хэрчээд амиа егүүтгэчихсэн гэдэг. Увс аймгийн алдартай шилийн эр Шагжийн Шарав Хан хөхийн нуруунд олон жил бүтсэн хүн. Шагжийн Шаравыг алагдсанаас хойш Хан хөхийн нуруунд олигтой зун болсонгүй гэж манай нутгийн хөгшчүүд ярьдаг байлаа. Намайг бага байхад манайх Хяргас нуурын хойд талаар нутагладаг байлаа. Аав маань лам хүн байсан. Нэг өдөр сайхан цагаан саарал морьтой, өндөр хээр морьтой хоёр хүн манай хажуу талын Нялхаа

баян гэдэг дөрвөд айл буудаг юм. 30 гаруй насны яралзсан цагаан шүдтэй сайхан эр нь Шагжийн Шарав. Увс нутагт домог болсон шилийн эрийг би нүдээрээ харсан. Нэг их гоё минжин малгайтай, булган нударгатай хурган дээлтэй, 32 угалзтай монгол гуталтай. Урт цагаан соруул бүхий гаанстай. Түүнийгээ ганц нэгхэн сорно. Босоод явахад аварга том мөнгөн хэт хутга нь санжигнаад аргагүй л сүртэй. Тэр хүний төрх надад жараад жил хадгалагдаж явна. Ийм л сайхан эр байсан юм. Тэр үед Шагжийн Шарав Ховд руу цэргийн хүүхэд эргэхээр явж байсан юм билээ. Хамт яваа хүн нь Чөтгөрийн Гаадан гэдэг шилийн хулгайч. Энэ хоёр сайхан эр манай хот айлыг нэг хэсэг бишрүүлж байгаад Ховд руу хөдөлсөн. Тэгсэн намар нь Шагжийн Шарав, Чөтгөрийн Гаадан хоёр дахиад манай нутгаар дайрч өнгөрдөг юм. Энэ үед мань хоёрыг сэргийлэхийнхэн ид хайж явсан байдаг. Нэг өдөр тэднийг сэргийлэхийнхэн олж харчихаад хойноос нь хөөтөл Чөтгөрийн Гаадангийн унаж явсан хул морь гэнэт булгиад шидчихэж. Ингээд Шагжийн Шарав цаашаа зугтаад Чөтгөрийн Гаадан баригдчих нь тэр. Шарав зугтаж явахдаа Нялхаа баяныхаар бас ороод гарсан байгаа юм. Түүнийг цай амсаад гарах гэж байтал манай сумын Гончиг, “Ногоон булгийн” Таг хоёр хүрч ирээд барих гэтэл Шарав амжиж мориндоо мордоод зугтчихаж. Тэр зугтаж явахдаа манай нутгийн “Лүд” Дандар гэдэг ламтай тааралдаад “Таньтай хэдэн үг сольё. Би Шагжийн Шарав байна. Дүү нь засгийн ялнаас оргоод есөн жил зургаан сар болж байна. Энэ жил 37-ны жил орж байгаа. Надтай цуг явсан хүн баригдаад хоцорчихлоо. Бид хоёр Мянгадын нутгаас сэтэртэй хул морь барьж аваад, нэг том эр хонь алж идсэн юм. Мянгадууд хараалтай гэдэг нь үнэн юм байна. Сэтэртэй хуль морь нь манай хүнийг булгиад шидчихлээ. Одоо би сэргийлэхийнхэнд баригдалгүй хагас жил болох юм бол арван жилийн орогнол болж хөөн хэлэлцэх хугацаа дуусах юм. Тэгээд уулнаасаа бууна даа” гэхэд “Лүд” Дандар “Миний дүү сайн яваарай. Гэхдээ чамайг цуг явсан хүн чинь цагдаа нарт барьж өгөх юм байна даа. Мэдээтэй яваарай” гэж захисан гэдэг. Нээрээ ч нөгөө Чөтгөрийн Гаадан нь аймгийн сэргийлэх дээр очмогцоо Шагжийн Шаравын орогнодог газрыг заагаад өгчихөж. Шагжийн Шарав хүн амьтан барагтай бол очиж чадахааргүй Цагаан хайрхан сумын нутагт байх “Сонгино цахир” гэдэг битүү модтой ууланд орогнодог байж л дээ. Тал талаасаа элгэн улаан хадтай. Хойноосоо гарч урагшаа буудаг. Орой дээрээ агуйтай. Тухайн үед түүнийг баривчлах даалгаварыг Цэдэнбал дарга өгч байсан гэдэг юм. Ингээд бодохоор Шагжийн Шарав сүрхий газар авчихсан байгаа биз. Гэсэн ч Увс нутгийнхан түүнийг сүрхий хамгаалдаг байсан. Шагжийн Шарав сайхан саарал морь уначихсан Улаангомын төвд улсын наадам үзээд явж байдаг, хүмүүс түүнийг мэдсэн ч цагдаа нарт хэлэхгүй. Ер нь түүнийг хамгаалж хаацайлдаг тавиад өрх айл байсан байгаа юм. Зарим айл нь орон доороо гүнзгий нүх ухчихсан, хэрвээ Шаравыг баригдахад хүрвэл тэр нүхэндээ хийж аргацаадаг байж. Түүнийг цагдаагийнханаас хамгаалж хаацайлсан хэрэгт Баруунтурууны сангийн аж ахуйн дарга хүртэл холбогдож байлаа. Цагдаа нар Чөтгөрийн Гаадангаас Шаравын орогнодог газрыг мэдэж аваад нэг л орой шууд бүслээд авсан байгаа юм. Энэ үеэр сэргийлэхийн дарга Доржсүрэн түүний гар луу буудчихаж. Шарав ч өндөр өвсөн дунд ороод алга болчихож. Гэсэн ч цагдаагийнхан нэгд нэггүй самнаж түүнийг бүсэлж аваад моринд нь мордуулан хоёр хөлийг нь дөрөөтэй нь хүлээд Цагаанхайрхан сумын төв рүү хөдөлсөн байна. Тэгтэл Шагжийн Шарав хажууд явсан хүнийхээ бүсэнд байсан хутгыг сугалж аваад өөрийнхөө хоолойг хэрччихсэн гэдэг. Түүний гар луу буудаж баривчилсан Доржсүрэн ёстой өөдлөөгүй. Сүүлдээ бүр галзуу өвчтэй болчихсон. Увсынхан түүнийг мөрөөрөө явсан сайн эрийг хохироосон хогийн муу цагдаа гээд үздэггүй байлаа. Олон ч хүний ад болсон байх. Манай нутгийн өвгөчүүл Шагжийн Шаравт хир халдаадаггүй байлаа. Зарим нь түүнийг Хан хөхийн савдаг гэж шүтэн биширдэг байсан

юм. Үнэндээ ч савдагтай орооцолдсон Доржсүрэн галзуу өвчин тусаад өөдлөөгүй. Бас Шаравыг цагдаа нарт барьж өгсөн Чөтгөрийн Гаадан өөдлөөгүй. Гаадан тэр үед долоо найман хүүхэдтэй байсан юм билээ. Гэтэл Шагжийн Шаравыг үхсэнээс хойш долоо хоноход авгай хүүхэд нь бүгд байхгүй болсон. Бүгдээрээ гэв гэнэт чацга алдаад л долоо хоногийн дотор зүйл дуусч байлаа. Эмчилгээ байдаггүй. Гаадан ч өөрөө төдөлгүй нүд аньсан. Харин манай нутгийн ардууд Шагжийн Шаравыг ийм ид шидтэй, савдаг энэ тэртэй холбоотой болохыг нь мэддэг байсан болохоор түүнд муу юм хийдэггүй, дандаа сайнаар тус болдог байлаа. Ямар сайндаа л тэр үеийн сум нэгдэлийн дарга, намын байгууллагын дарга нар Шагжийн Шаравыг явж байвал гараа даллаад л, Шарав ч ташуураараа даллан мэнд мэдэлцээд л зөрцгөөдөг байлаа. Шарав нутаг орноосоо хулгай хийдэггүй, ихэвчлэн Шинжаан, Тувагаас адуу хөөдөг, тэгээд нутгийнхаа ядарсан зүдэрсэн зуу гаруй айлыг тэжээдэг байсан юм. Үүнийг нь сум нэгдэлийн дарга нар ч гадарлана. Шагжийн Шаравыг нас барсанаас хойш Хан хөхийн нурууны өвс ургамал муудаж, өчнөөн жил ган болж байлаа. Түүнээс хойш Хан хөхийд өөдтэй шилийн эр төрөөгүй. Зул гэдэг оргодол Хан хөхийн савдагийг танилгүй өөрийгөө хорлочихсон. Бууяа, Тавхай гээд хоёр оргодол байсан ч сүүлдээ чимээ тасарсан. 1968 онд Ургамал сумын уугуул “Хээрийн” Дамиран гэдэг хүн шоронгоос оргоод Хан хөхийд нэг жил өвөлжсөн юм. Энэ хүн хоёр гурван ч хүний араг ястай тааралдаж байсан гэдэг. Бодвол Бууяа, Тавхай хоёрын араг яс байж таарна. Одоо бол Хан хөхийд ямар ч хүн очсон нээлттэй болсон. Шагжийн Шарав сайхан дуулдаг хүн байсан. Дээхэн үед уртын дуучин Долгоржав гэж алдартай дуучин байлаа шүү дээ. Шагжийн Шарав яг л энэ хүн шиг дуулдаг байлаа. Сайхан дуулахаас гадна яг л хөхөө шиг донгоддог, хэрээ шиг гуагладаг байсан гэдэг. Мянгадын Дамдинжамц гэдэг хүний Ховдын наадамд түрүүлсэн дэлтэй саарал мориор Шагжийн Шарав нэг хэсэг гангарсан гэдэг юм. Түүнийг нас барсаны дараа Ёндонжамц гэдэг хүн “Сайн эрийн унаж явсан саарал мориог би авна” гээд авч байлаа. Ер нь дээхэн үед алдартай хүлэг морьд сайн эрсийн гараар орох нь их байж. Номун хан Дамбийжаа хүртэл шилийн сайн эрчүүдээр энд тэндхийн алдартай хурдан хүлгийг авчруулдаг байсан гэдэг. Миний өвгөн өөв Ховдын дайнд сайн байлдаж тавдугаар зэргийн жинс авч байсан хүн. Өвөө маань олон сайхан хурдан хүлэгтэй байж. 1912 оны намар болсон Дамбийжаагийн наадамд Дорж тойны бор морь, өвөөгийн “Аалзан бор” хоёр тасархай ирж байсан гэдэг. Өвөөгөөс маань үлдсэн бор зүсмийн олон сайхан адуу манайд 1970 он хүртэл байсан. Даанч би 1970 онд цэрэгт явсанаар тэр сайхан адуу үгүй болсон доо.

## Сэтгүүлч, найрагчдын урлан дахь Засагт ханы хөх харчууд

Зүүн аймгийн зохиолч, сэтгүүлч нар Дарьгангын шилийн сайн эрчүүдийг зохиол бүтээлдээ оруулах нь их байдаг. Харин баруун аймгийн зохиолч, сэтгүүлч нар Засагт ханы хөх харчуудаараа бахархаж, тэднийгээ шүлэг зохиолд мөнхөлсөн нь олонтаа. Жишээ нь “Засагт ханы хөх харчууд зангаа тавихгүй шазруун, завилж суусан хоймортоо зайгаа өгөхгүй шазруун” гэх зэргээр шүлэглэсэн байдаг. Ингээд баруун аймгаас төрөн гарсан сэтгүүлч, яруу найрагчид Засагт ханы хөх харчуудынхаа тухай хэрхэн өгүүлсэн талаар толилуулъя.

Соёлын гавьяат зүтгэлтэн, яруу найрагч Үржингийн Хүрэлбаатар “Засагт ханы хөх харчууд” хэмээсэн шүлэг бичиж, үүнд нь хөгжмийн зохиолч Г.Жаргалсайхан ая хийж, дуучин Ц.Оюунцэцэг олон түмэнд толилуулсан билээ. Жишээ нь,

“Үүлэнд умбан ханхайх өндөр хөх уулс шиг

Засагт ханы хөх харчууд алсын бараатай

Үг нь ивлэж нутгаа дуулах омголон найрагч шиг

Засагт ханы хөх харчууд оюун билэгтэй

Тэнгэрийн өнгө солонгорон гялалзаж чулуунд нь шингэсэн

Тэр зүгийн нутаг-уулсын эх орон

Тэргэл саран гүн шөнийг гэрэлтүүлэх шиг

Тэр зүгийн нутаг-ухаантаны эх орон

Засагт ханы хөх харчууд

Зартай нутгийн сайн эрчүүд

Дэлтэй чоно шиг эрмэг харчууд

Дэлхийд цуутай монгол эрчүүд” гэж уянгалуулсанаар уг дуу баруун аймгийнханы шүтээн болсон байх жишээтэй. Ялангуяа төгсгөлийн бадаг нь эрт цагийн шилийн сайн эрчүүдийнн үр удам гэдгийг яруу тодоор харуулсан байх аж.

“Наран цуцаж өнжих өргөн их тал шиг

Засагт ханы хөх харчууд шулуухан зантай

Начин шонхор тэртээ алсад тэмүүлэн шумбах шиг

Засагт ханы хөх харчууд шударга удамтай

Тэнүүн талын цэцэгсийн үнэр салхинд нь шингэсэн

Тэр зүгийн нутаг–Алтайн хөх салхи

Тэмцэлийн дуулал зүрхэнд эгшиглэх аялгуу шиг

Тэр зүгийн нутаг-зоригтоны эх орон” хэмээжээ. Аргагүй л Алтай нутгаас төрж гарсан найрагчийн үг мөн дөө. Түүнчлэн Алтай нутгаас төрж гарсан яруу найрагч Б.Даваацэрэн “Засагт ханы хөх харчууд” хэмээх шүлэг туурвисан байдаг. Жишээ нь,

“Залгаа аймаг, хотол хошуундаа

Зартай цуутай хөх харчууд , Засагт ханых

Зарлиг тушаал, түүх шастирт

Замтай мөртэй хөх харчууд, Засагт ханых

Зөрүүд гээд адлаж болдоггүй

Зөнтэй шидтэй хөх харчууд, Засагт ханых

Зөөлөн гээд аархаж болдоггүй

Зүстэй нэртэй хөх харчууд, Засагт ханых

Бөгд төр, алтан сэнтийд

Бодолтой суудалтай хөх харчууд, Засагт ханых

Булт олон, их Монголд

Буянтай хүндтэй хөх харчууд, Засагт ханых

Бүрэг гээд гоочилж болдоггүй

Билигтэй номтой хөх харчууд, Засагт ханых

Барлаг гээд голж болдоггүй

Бурхантай сахиустай хөх харчууд, Засагт ханых

Мэдэж ав, энэ засагт ханыхныг

Мэндэлж яв, тэр хөх харчуудтай

Таньж ав, энэ засагт ханыхныг

Танилцаж яв, тэр хөх харчуултай” гэх зэргээр аархах, бахархах хоёрыг хослуулсан байх аж. Баруун аймгийн зохиолчдоос хөх харчуудаараа хамгийн их аархаж бахархсан хүн бол нэрт зохиолч Ч.Лодойдамба агсан билээ. Тэрбээр “Тунгалаг тамир” романдаа “Цахиур” Төмөрийг амилуулсан бол “Алтайд” романдаа “Ганган” Төгсийг амилуулсан. Зохиолч, яруу найрагчдаас гадна баруун аймгаас төрж гарсан сэтгүүлч, нийтлэлч нар Засагт ханы хөх харчуудынхаа талаар өгүүлсэн нь олонтаа. Жишээ нь нийтлэлч Б.Номинчимэд “Засагт ханы хөх харчуулын нутаг” хэмээх хөрөг найруулалдаа ийн өгүүлжээ.

...“Тунгалаг тамир” кинон дээр Цахиур Төмөр Түгжилтэй хамт адуу хөөж яваад тэнгэрийн хаяанд торолзогч алсын уулсыг зааж “Тэр уулыг харж байна уу, тээр, тэнгэрийн хаяанд “Тайшир хан” гэдэг уул байна даа” гээд хэнгэнэтэл санаа алдаж байдаг даа. “Цахиур” Төмөрийн тэр үгэнд нутгаа гэсэн тэмүүлэл, хайр, тэр нутагт нь аргамжсан хувь тавилангийн дурсамж, амь амьдралынх нь утга учир, тэр ч бүү хэл үхэл, мөхөл нь хүртэл багтан шингэсэн мэт санагддаг сан. Тэр уулыг манайхан Хантайшир гэдэг. Алтай хотын баруун урдуур энэ нурууны яг зоогоор Ар Цагаан Ендэрт, Хүн чулуу, Хамар даваа зэрэг хэд хэдэн даваагаар давна. Мацсаар дээр нь гарахад чухам тэнгэрийн зулай дээр гарсан мэт дөрвөн зүг, найман зовхис цэлсхийн үзэгдэх 3200 метр орчим өндөрт өргөгдсөн тэдгээр давааны алинаар нь ч давсан нутгийнхны дууддагаар Овоон нуруу гэх салбар нурууны эх рүү орно. Шарилын чулуу, Дашинчилэнгийн нуруу ч гэх. Энэ нуруу нэгэн цагт гэлэнгээс дээш санваартан, тайж язгууртнаас дээш хэргэмтэн л жилдээ нэг удаа ёслолын зэрэг ямбаны дагуу гардаг, бусад нь дунд бүсээс дээш гардаггүй хоригтой, ихийн их онгон тахилгат уул байлаа. Тэргүүн дээр нь хааш хааш хоёр метр гаруй том бунхан бий. Миний багад бунхны эргэн тойрон олон чулуун бурхадын сийлбэр, маанийн үсэгтэй хавтгай хаднууд, өмнөх налуугаар нь цөөнгүй жижгэвтэр бунханууд байдаг сан. Тэдгээр нь тэнгэр язгуурт алтан ургийн ихэс болох үе үеийн Засагт хануудын шарил. Магад түүнээс ч илүүг оршуулсан байж болох талтай. Өнөөдөр “Засагт ханы хөх харчуул” гэсэн хэллэг ихэд дэлгэрчээ. Манай Алтай нутгийнхан ч энэ нэрэндээ сэтгэл нэн хангалуун байдаг. Зарим хүмүүс энэ бол Ч.Лодойдамба гуайн бичсэн зохиолын хэллэг төдий зүйл, үнэн хэрэгтээ тийм зүйл байгаагүй гэж үгүйсгэдэг нь харин ч оргүй мухар үгүйсгэл юм. Үнэхээр “Засагт ханы хөх харчуул” байсныг нутгийнхан хэлдэг бөгөөд Лодой зохиолч маань харин түүнийг “шинжлэх ухааны эргэлтэнд” оруулж өгсөн хүн. Лодойдамба гуайн аав Чадраабал өөрөө “Засагт ханы хөх харчуул”-ын нэг бөгөөд нутгийнхныхаа үүх түүхийг гаргуун мэддэг хүн байсан гэдэг. Гэвч яг үнэндээ “Засагт ханы хөх харчуул”-д энэ Засагт ханыхан бүхэлдээ хамрахгүй төдийгүй Говь-Алтайхан ч бас бүгдээрээ биш юм. Өвгөдийн яриагаар бол хуучны Засагт хан аймгийн Эрдэнэбишрэлт Засагт ханы хошууныхныг л зөвхөн “Засагт ханы хөх харчуул” гэж нэрийдэж байжээ. Энэ нь одоогийн Говь-Алтай аймгийн Халиун бүхэлдээ, Дэлгэрийн баруун тал, Бигэрийн хойд хэсэг, Шаргын урд нутгийг хамарсан бүс нутаг юм. Өөрөөр хэлбэл Хантайшир уулыг бүхэлд нь дамнан тойрч, Чингис хааны онгон тахилгын харуул хамгаалалт байдалтайгаар аж төрж асан энэ хошууныхан юм. Чухам энэ Эрдэнэбишрэлт Засагт ханы хошууныхан нь Итгэлт баяны тодорхойлсон тэр “Хэцүү” хөх эрс байжээ. Хэрсүү чанга бодол санаатай атлаа гэнэхэн, эрэмгий оргилуун атлаа дөлгөөхөн, овсгоо самбаатай, хөдөлмөрч шударгуу атлаа тайван, хамгийн гол нь хүнлэг голч нуруутай, холч бодолтой хүмүүс байж. Яг л “Тунгалаг Тамир”-ын Эрдэнэ лугаа адил. Чухам ясны энэ л давтагдашгүй чанараараа ойр холынхондоо гайхагдан “Засагт ханы хөх харчуул хэцүү, хэцүү” гэгддэг байж. Нутгархаж, бүлгэрхэж, явцуурна гэж огт үгүй. Ийм зан бол голч, шударга хүмүүсийн нэг араншин билээ. Анхны Үйзэн Засагт ханууд

ер нь нэлээд дайчин нөхдүүд байсан бололтой байдаг юм. Ялангуяа Засагт ханы Субадай бол урагшаа Хөхнуур, баруун тийшээ Яркенд хүртэл цэрэглэж явжээ. Тэдгээр дайнч Засагт хануудын шадар торгон цэргүүд нь чухам өнөөгийн энэ хэдэн сумдын хүмүүсийн өвөг дээдэс байжээ. Тэгэхээр бас ястай байхаас ч аргагүй. Энэ нутаг бол үлгэр домог, хууч ярианы орон. Хэрвээ сонсч чадвал бараг чулуу бүхэн нь түүх хүүрнэнэ. Аав маань “Энэ уулсын чинь цэцэг бүхнээс үлгэр сонсч өссөн юм даа, аав нь” гэж хэлдэг байж билээ. Нэрнээсээ эхлээд л үлгэр домог. Нэг эхэлчихвэл дуусах аргагүй, өнжин хонон хүүрнэнэ” гэсэн бол Увс нутгаас төрж гарсан сэтгүүлч Г.Бадамсамбуу “Манай Засагт ханы Ачит вангийн хошуу сайн эр, хурдан морь, сайхан хүүхнээрээ алдартай нутаг. Вандан, Ламжав гээд хуучны алдартай бөхчүүд чинь энэ хошууных юм шүү дээ. Манай Зүүнхангай сум хурдан мориороо алдартай. Баруун нутагт хоёр л хурд эртнээсээ зартай байсаар ирсэн. Хөнхөхий хурд, Хотгойд хурд энэ хоёр угшил одоо ч улсын наадамд түрүү авч байна. Мөн дээр үеэсээ алдартай, домог болж үлдсэн Луу гүний “Сайвар халтар” гэж сайхан хурд байлаа. Богдын даншигт гурван удаа түрүүлж байсан гэдэг. Манай Ачит вангийн хошуунд Манжийн эсрэг тэмцдэг шилийн сайн эрчүүд олон байсан гэдэг юм. Завханыхан өөрсдийгөө Засагт ханы хөх харчуул гэж их ярих болж. Үнэндээ бол Засагт ханы хөх харчуул гэдэг чинь манай Ачит вангийнхан байгаа юм. Ер нь их тэмцэгч хүмүүс байсан. Хошуу ноёд нь хүртэл энэ чанараараа тээхэн хэрэг явдалд оройлж байсан түүхтэй юм. Өнгөрсөн зууны эхээр гарсан Улиастайн 2000 цэргийн бослого гэж алдаршсан томоохон бослогыг Энхтайван гүн гэж том түшмэл толгойлж байсан. То ван, Лу гүн хоёрыг аваад үзье л дээ. Энэ хоёрыг Монгол төрийн төлөө их юм хийсэн хүмүүс гэж үздэг. Ачит ван Гончигдамба, зоригт ван Наваанцэрэн хоёр Ховдыг чөлөөлөх дайнд их гавьяа байгуулсан. Дараа нь Гончигдамба нь Дотоод яамны дэд сайдаар, Наваанцэрэн нь баруун хязгаарыг тохинуулах сайдаар томилогдож байсан юм билээ. Засагт ханы хөх харчууд юм юм хийдэг, ямар ч хэрэг явдалд оройлж байдаг хүмүүс. Хэрэг зарга шийдэхдээ ч нэлээд рольтой байсан юм байна лээ. Засагт ханы “Махан товъёог” гэдэг хочтой Буянжаргал тайж гэж байсан. Тухайн үед хэрэг шийдүүлэх гэсэн хүмүүс энэ хүнээр л асуудлаа шийдүүлэх юмсан гэдэг, тэгээд заргаа аваад л буцдаг байсан юм гэнэ лээ. Хожим нь энэ хүн хошуу захирагч болсон. Нутгийнхан нь Буваа захирагч гэдэг байж. Миний элэнц өвөг юм. Ер нь манай нутаг эрдэмтэн мэргэд ч олонтой” хэмээжээ. Мөн нийтлэлч Ч.Алтанхуяг “Алтайд” хэмээх нийтлэлдээ “Ч.Лодойдамбын “Тунгалаг тамир” романд “За даа, Тайшир хан, Тарлан бух гээд Засагт ханы хөх харчуулыг хэцүү гэлцдэг. Эр улсууд эвтэй дээрээ эртхэн салсан нь дээр биз дээ” гэж Луу гүний баян Итгэлт, хүний газар явгарч ягдахын эрхэнд хүн царай алдахдаа тулсан цагаач Эрдэнээс үтэр салах үүднээс ихэд бачирхан өчдөгийн учрыг олохыг эрмэлзэв. Засагт ханы хэцүү хөх харчууд гэдгийн учир юув. Анзаараад байхад нээрээ л алтайнхан хэцүү хөх харчуудаар дүүрэн гэдгийг ойлгосон билээ. Хэцүү гэж тодотгоод анзаараад, ажаад байхаар үнэндээ л хотын эрчүүдээс нэг л өөр. Монголчуудын нутгархаад, жалгархаад байдагийн тайлал нь өөр өөр араншинтай байдгаас нь үүдэлтэйг мөн л Алтайгаас ойлгож авлаа. Хэцүү хөхийн утгыг нутгийн нэгэн сэтгүүлч ингэж тайлсан байхыг харав. “Дүн нуруутан дүнхэр уул мэт хөдлөшгүй зарчимаараа, дүнсгэр нухацтан дөлгөөн мөрөн адил хувиршгүй зангаараа дол цохисон хөрөнгө саган исэх, дам хөөргөдөх салхин арга сэнсрэн улихуйн балчигт үйлийг цэглэж өгдөг нигууртай” хэмээжээ. Минийхээр бол уурласан ч юм шиг уурлаагүй юм шиг царайлаад хамаг учрыг ойлгохын дээдээр ойлгочихоод юу ч ойлгоогүй мэт царайлж байгаад хүн сорьсон огцом гэнэт асуултаар ярилцагчаа мадлаад авдаг. Дүнсгэр мөртөө ярихаараа маш их нээлттэй хирнээ үнэн санаагаа хэзээ ч ил хэлэхгүй. Нуруугүй юм шиг харагдавч амьдрал дээрээ хэзээ ч ганхашгүй бат бөх нуруутай. Тийм л эрчүүд юм билээ.



Хэцүү гэдэг нь ер нь анзаарагдана. Миний тайлбарлаж чадаагүй сонин, сонин чанар байгаа. Энэ нь муу гэж байгаа биш хэцүү л гэж байгаа юм. Хэцүү гэдгийг Ч.Лодойдамба гуай яг оноод хэлчихсэн. Хэцүү гэдгийг тайлбарлахад ч хэцүү юм. Хэцүү араншингийн учир хаанаас бий болов гэдэг асуулт удаачаар нь урган гарав. Уулынхан дүнсгэр байдаг гэдгийг Расуль Гамзатовын “Миний Дагестан”, Эдвард Радзинскийн “Сталин” зэрэг номоос гадарлаж байна” хэмээжээ. Хэцүү гэдгийн хувьд ийм байж. Харин хөх гэдгийн хувьд тэр жил манай нэг сулхан орчуулагч гадаадын зочин төлөөлөгчидтэй цуг Алтай нутагт очихдоо “Засагт ханы хөх харчууд” гэдгийг хөрвүүлэхдээ “Цэнхэрүүд” гэж мэдэмхийрээд тус нутгийн хоёр залууд алуулах шахсан гэдэг. Алтай нутгийн адуучин Д.Шархүү гуай Засагт ханы хөх харчуудын талаар өгүүлэхдээ “Хөрслөг даардаггүй, шантардаггүй шилийн сайн эрс байсан юм гэнэ билээ. Энэ нь “Цахиур” Төмөрөөс эхтэйдэг шүү. “Цахиур” Төмөр чинь Говь-Алтайн Тайширын хүн гэж байгаа. Нутгаар нь хөндлөн гулд бишгүйдээ л явлаа. Ядууст гараа сунгасан өгөөмөр нэгэн ч гэдэг. Хошуунаасаа авдаггүй, харин хэдэн хошуу давж адуу тууж ирээд тусламж хэрэгтэй ядууст өгнө. “Цахиур” Төмөрийг Архангайн Тоглохын талаар хөтөлгөө морьтой явж байх үед мориных нь гишгэсэн газарт чулуу ургаж, чулуунаас нь гал гарч байсан гэдэг домог бий. Засагт ханы хөх харчуудаас энэ мэтчилэн домог түүхээ үлдээсэн хүн олон бий” гэсэн юм.

## Есөн зоосны мэргэнд ээрэгдсэн шилийн эр Наваантаяа

Түшээт хан аймгийн харъяат Ярингийн Цэнд Автономит төрийн цэрэгт хоёр дүүгийнхээ хамт алба хаасныхаа дараа их хүрээнд Түшээт хан аймгийн хэмжээт газарт арван тавны морьт цагдаа болжээ. Тэрбээр аливаа хэргийг илрүүлэхдээ өөрийн гэсэн аргатай, хулгайч, хэрэгтэн хүнийг анддаггүй таньдаг, баривчлахдаа шууд яваад очдог, есөн зоосоор сайн мэргэлдэг хүн байж. Нэг удаа тэрбээр Сэцэн хан, Түшээт хан аймгийн нутгийн заагт нуугдаж байсан олон зуун бодын хэрэгтэй Оргойн Дамдин гэгчийг барихын тулд есөн зоосоор мэргэлээд нуугдаж байсан газарт нь шууд очоод баривчилж байсан гэдэг. Мөн тэрбээр 200 бодын хэрэгтэй шилийн эр Наваантаяа гэгчийг есөн зоосоор мэргэлэн баривчилж байжээ. Эхлээд тэрбээр Наваантаяагийн гэрт ортол эхнэрээс нь өөр хүн байсангүй. Тиймээс буцаж гараад есөн зоосоороо мэргэлж үзтэл гэмт этгээдийг гэртээ байна гэдгийг есөн зоос нь хэлээд байж. Тиймээс тэр буцаж гэрт ороод хоймортоо адсага дэвсээд сууж байсан эхнэрийг нь босгоод адсагыг нь сөхөж үзтэл доор нь модон таглаа бүхий бяцхан нүх харагдсан байна. Модон таглааг нь ховхолж автал тэрхүү нүхэнд шилийн эр Наваантаяа хэвтэж байх нь тэр. Ийнхүү тэрбээр олон жил баригдалгүй шилэрч явсан Наваантаяаг баривчилж байсан гэдэг. Ер нь дээхэн үед зарим нэг шилийн эр гэрийнхээ орон доор газар ухаад арван тавны цагдаа нар болон тамгын газрын тахаруудад баригдахад хүрвэл ухсан нүхэндээ ороод хэвтчихдэг байсан гэдэг. Эхнэр хүүхэд нь ч иймэрхүү явдалд бүр гаршчихсан гэлтэй тамгын газрын тахаруудыг орж ирэхэд “Манай хүн өчигдөр л гараад явсан” гэх зэргээр юу ч болоогүй юм шиг сууж байх жишээтэй. Тавиад оны шилийн эр “Хагархай” Намжил гэгч орон доороо яг иймэрхүү нүх ухчихсан, заримдаа тэндээ орж нуугддаг, алт, мөнгөн эдлэлээ нуудаг байж. Тэрбээр далан настай эх Янжингийнхаа хамт амьдардаг байсан бөгөөд шөнө орой цагдаа нар баривчлахаар ирж магадгүй гээд тулганыхаа өмнө нүх ухчихсан, түүнийгээ шөнө унтахдаа таглахгүй онгорхой орхидог байжээ. Нэг ёсондоо цагдаа нарыг орж ирээд нүхэнд ойчиход гараад зугтах гэж тэр. Гэвч мань эр гэрээсээ биш уул хаданд тэнүүчилж яваад цагдаад баригджээ. Үүнийг зэргэлдээх сумын нь “Нармиан” Болоож, Төгсийн Ишханд гэгч хоёр хулгайч мэдсэнээр шилийн эр “Хагархай” Намжилын 70 настай эх Янжинг дээрэмдэхээр шийдсэн байна. Шилийн хулгайчийн авдранд алт эрдэнэс байгаа гэж итгэсэн хэрэг. Гэвч мань хоёр Янжин чавганцад айхтар чадуулсан гэдэг. Шилийн хулгайчийн ээж Янжин чавганц хэн хүнд дээрэмдүүлэхээргүй маш яхир, ямар сайндаа л өөрийнхөө амийг хамгаалах гэж шувууны буу хүртэл гэртээ хадгалдаг байж. Айл амьтанаас зайдуу ганц гэр өвөлжинө. Болоож, Ишханд хоёр эхлээд байдлыг нь ажиглахаар чавганцынд оройхон хэрд буужээ. Янжин чавганц тэднийг сайтар ажиглан харсанаа хаа хүрч явааг нь асуухад “Бид хэдэн адуугаа алдчихаад хайж явна. Өнөө шөнөдөө багтаж Дундговийн Сайхандулаан сум орж хонох ёстой. Хэдэн адуу маань тэнд яваа сурагтай. Цасан шуурга уруудаад тийшээ явчихсан бололтой” гэж тун үнэмшилтэй ярьжээ. Тэдний байдал нэг л сэжигтэй байгааг хашир чавганц төвөггүй мэдсэн байна. Гэвч ямар ч гэсэн хоол унд хийж өгөөд мордуулжээ. Тэднийг шөнө эргэж ирж дээрэм хийнэ гэдгийг чавганц гадарлаад бэлтгэл ажилдаа оржээ. Нээрээ ч шөнө дундын үед ноход нь хуцсан аж. Бараг л хүний хэлээр ярих шахам сургагдсан том банхар нохойгоо чавганц “Дуугүй бай” гэж чимээгүй болгоод өөрийнхөө орыг хүн унтаж буй мэт засч том банхараа орон доогуураа оруулаад хэвтүүлчихэж. Чавганц өөрөө нөгөө нохойгоо аваад гэрийнхээ гадаах бараан дотор ороод суучихаж. Мөнөөх хоёр гэрийн үүд рүү сэмхэн гэтэж явсаар үүд онгойлгон гэрт явж оржээ. Шүдэнз зураад харвал баруун талын орон дээр хүн

унтаж буй мэт байсанд Болоож барьж явсан тэнзэн ташуураараа толгой дундуур нь буулгатал тэр нь модоор зорж хийсэн хүний толгой байжээ. Энэ чимээнээр орон доогуур хэвтсэн том банхар нохой ярхийтэл дайрч Болоожийг зуугаад авчээ. Үүдэнд байсан Ишханд гараад гүйтэл гадаах бараан дотроос жижиг банхар нь ярхийтэл дайрч түүнийг хонгодоод авсан байна. Хоёр хулгайч арай гэж нохойноос мултраад гэрээс хойш тушсан мориндоо арай гэж хүрээд ум хумгүй зугтжээ. Гэвч тэд хаширсангүй. Болоож Ишхандад хамаг буруугаа тохож “Чи бид хоёр арай дэндүү арчаагаа алдаж байгаа юм биш үү. Яахаас ч буцахгүй хулгайч нар байж нэг муу чавганц, нохой хоёрт чадуулаад байхдаа яадаг юм бэ? Чиний гэрээс гарч зугтаадаг буруу байхгүй юу. Бушуухан ирээд надад туслахын оронд хүн хаячихаад гараад зугтчихаж байгаа юм даа. Маргааш шөнө хоёулаа нохойг нь шууд цохиж алаад чавганцыг тононо” гэж омогджээ. Тэгээд маргааш нь бүрий болмогц чавганцынх руу зүглэсэн байна. Энэ удаад чавганц ямар ч сэжиглэсэн шинжгүй нохойгоо хорьж өгөөд, тэр ч байтугай хоёр нохойгоо сайн гэгчийн уяд мөнөөх хоёрыг гэртээ оруулсан байна. Гэтэл мөнөөх хоёрыг яг гэрт оронгуут үүдний шал цөмөрч хоёр метр гаруй нүх рүү унах нь тэр. Энэ нь шилийн эр “Хагархай” Намжилын уран бүтээл байсан бөгөөд тэрбээр гэнэт “зочилсон” цагдаа нарыг аргацаахын тулд гэрийнхээ хаалганы дотор талд нүх ухаад оньсоор мултардаг модон таглаа хийсэн нь тэр байж. Гүнзгий нүхэнд ойчсон Болоож, Ишханд хоёр чавганцаас уучлалт гуйж, бүтэн шөнийн турш уйлан хайлсан боловч тэр огт тоосонгүй. Харин ч бүр модон таглааг нь зуугийн поошигтой усаар даруулжээ. Тэгээд үүр цайхын алдад чавганц босч “Та хоёр намайг алах гэж байсан улс. Өнөөдөр би аймгаас сэргийлэх дуудаж та хоёрыг тушаана. Оргодол босуул ч юм билүү, хэн мэдлээ. Харин өлсч байгаа бол энийг идээрэй” гээд модон таглааны завсраар мах хөшиглөж өгсөн байна. Янжин чавганц үд өнгөрч байхад саахалт айлаас хүн дуудаж аймаг руу хэл хүргүүлсэн бөгөөд төдөлгүй цагдаагийнхан ирж Болоож, Ишханд хоёрыг нүхнээс гаргаж авчээ. Тэднийг нэгжиж үзтэл хоёр ширхэг хутга, дээрэм тонуулаар олсон бас бус зүйл гарсан бөгөөд “Бид адуугаа хайж яваад аяга цай уух санаатай энэ чавганцынхаар ортол шууд л нүхэнд уначихлаа” гэж хээв нэг өчиж байсан гэдэг. Дээхэн үеийн шилийн сайн эрчүүдийн ар гэрийнхэн хүртэл сайн эрийн жишгээр чамгүй арга зальтай, авхаалж самбаатай байсан нь энэ.

## Ванчин гавжийн агуй Оросоогийн агуй болж хувирсан нь

Баянхонгор аймгийн харьяат Хорлоогийн Ванчин хориод оны үед нутгийнхан дундаа “Шилийн сайн эр Ванчин” гэж хэлэгдэж явсаар гучаад оны үед “Ванчин гавж” гэж дуудагдах болжээ. Тэрбээр эрхиэр мэрэг төлөг тавихдаа гаргууд нэгэн байсан бөгөөд аль аймгийн аль хошуунаас адуу хөөхөд аюулгүй болохыг эрхиэр мэргэлж үзээд л тэр зүг рүү хос морьтой давхиж оддог байж. Харин хориод оны сүүлчээр түүний мэргэлж түргэлдэг авьяасыг тухайн үед Баянхонгор аймагт нэр цуутай явсан Лу цорж буюу Лувсанцэрэн цорж гадарласнаар нэг өдөр түүнийг хийд дээрээ дуудаад “Бурханы авшиг шингэсэн бумбан эрхиэр буцалтгүй мэргэлдэг хүн хол ойроос адуу хөөдөг шилийн хулгайч байж таарахгүй. Чи бол хийдэд шавилан сууж ард нийтийн буян заяаг мэргэлж суух тавилантай бурхан номын хүн байна” гэснээр шилийн эр Ванчин ташуу энгэртэй дээл өмсч буян номын мөр хөөх болжээ. Төдөлгүй тэр бусад лам нараасаа эрдэм чадлаараа ялгарч нутгийнхаа ардуудад “Ванчин гавж” гэж хүндлэгдэх болсон байна. Гэвч түүний шашин номоор олныг түвшитгэх хувь тавилан хэмжээ хязгаартай байжээ. 1932 оноос эхлээд лам нарыг хавчин хяхах үзэл бодол улс орон даяар өрнөх болсоноор Ванчин гавж өөрийнхөө заяа төөргийг мэргэлж үзээд “Бурхан шашныг газрын хөрстэй тэгшлэх цөвийн цаг хаяанд ирсэн байна. Миний цаашдын хувь заяаны эргүүлэг хуваргын зам биш хулгайчийн зам болж надад үзэгдлээ. Ер нь би төрөхөөсөө л шилийн хулгайчийн замаар явсан хүн. Одоо тэр л замаараа явья даа” гээд орхимжоо тайлж хаяад морин дэлэн дээр дарцаглах болсон гэдэг. Гэхдээ тэр ганцаараа биш, амьдрал хувь заяа нь дээсэн дөрөөн дээр байсан арваад хүнийг өөртөө элсүүлжээ. 1932 онд Баянхонгор аймгийн Хүрээмарал сумын хоршоог дээрэмдэн тонож, сумын захиргааны ажилтаныг барьцаалж өөрийнхөө талд орохыг ятгасан хэмээх хилс хэрэгт гүтгэгдсэн Хорлоогийн Ванчин гавжийг До яамны комиссар Содномын отрядын Амгай захирагч баривчлах гээд чадаагүй гэдэг. Учир нь Ванчин гавьж хамтран зүтгэгчидтэйгээ ногоон малгайтануудаас зугтаж явахдаа эрхиэрээ мэргэлж үзээд л зам мөрөө буруулдаг байж. Нэг удаа тэрбээр ногоон малгайтануудаас зугтаж яваад Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутагт байх Бага Богд хайрханы оройд гарч “Зандан мод” гэж шүтэгдсэн хадаг яндар бүхий ургаа модтой овооны өвөрт амрахаар шийджээ. Тэгээд өөрийнхөө итгэл сэтгэл нэгтэй арваад хүний хамт морьдоо чөдөрлөн идээшлүүлж, хоол цай хийж идээд сайхан амарч хоносон байна. Ванчин гавж өглөө наран ургахад нөхдөөсөө түрүүлж босоод эрхиэ татаж үзсэнээ “Хөөе нөхөд минь. Нэг л биш болоод явчихлаа. Миний эрхи эвлэж өгөхгүй сондгой буугаад байна. Одоохон хөдөлцгөөе” гэж бусдыгаа шавдуулжээ. Нөхөд нь ч түүний үгэнд ороод тэр даруйдаа босч мориндоо мордоод Бага Богд хайрханы арын асга хад руу буугаад бэлд нь орж явахад Амгай захирагч тэргүүтэй хүмүүс зүүн талаас нь морьдоо давирсаар “Зандан мод”-ны овоон дээр ирж байсан гэдэг. Ванчин гавж ийм л мэргэн хүн байж. Амгай тэргүүтэй хүмүүс Ванчин Гавжийг Бага Богд хайрханы ар руу дөнгөж хөдөлсөнийг мэдмэгцээ хойноос нь хөөцөлдсөн боловч тэднийг баривчилж чадсангүй. Учир нь Ванчин гавьж мөр буруулахдаа гаргууд нэгэн байж. Нэг газраас явахдаа хүрэх ёстой зүг рүүгээ бус эсрэг зүг рүү нь явсан мөр гаргаж чулуу хөөлгөдөг байж. Бас элдэв уншлага тарнитай цацлагыг мөрөн дээгүүрээ цацаад “Буруу номтонууд долоон уулын цаагуур, дов шороон доогуур ор” гэж тарниддаг байжээ. Тиймээс ногоон малгайтанууд түүний чулуу хөөлгөсөн мөрөөр ороод л хад мөргөх жишээтэй. Шилийн эр Ванчин Лувсанцэрэн цоржийн тэргүүн багийн Чээжүү жасын гавж ламтан байхдаа Суваргын хийдэд байн байн заларч эрхиэрээ төлөг татдаг байж. Лу цорж түүний мэргэн

түргэн авьяасыг шүтдэг байсан бөгөөд тэрбээр шашин төрийн хэргээ нууж хаалгүй хэлэлцэж зарлиг тушаал буулгахдаа Ванчин гавжийн санаа оноог заавал тусгадаг байжээ. Ванчин гавж 1930-аад онд Лу цоржийнд нэг удаа залрахдаа эрхиэ татаад “Бидний явдал суудал ч нэг их удахгүй нь бололтой. Ноёд, лам нарт ихээхэн халгаатай цаг үе айсуй. Баруун хойд зүгээс төмөр тэрэгтэй, хүнд зэвсэгтэй, буруу энгэртэй хувцастай олон хүн ирж ноёд, баяд, лам хуваргуудыг амьдаар нь газарт булах юм байна. Ер нь манай лам хуваргууд тамын оронд зуурдаар явахгүйгээ эртнээс бодууштай болсон байна” гэж сануулж байсан гэдэг. Үнэхээр ч түүний хэлсэнээр 1932 онд Ванчин гавжийн шавилан сууж байсан Дарь-Эхийн хүрээний бүх лам хуваргыг ногоон малгайтанууд хоморголон баривчилж ихэнхийг нь амьдаар нь газарт булж байжээ. Харин Ванчин гавж ийм зүйл болохыг эрхиэрээ мэргэлж мэдсэнээр ногоон малгайтануудыг ирэхээс өмнөхөн шилийн эрийн замаар явчихсан хэрэг. Тэрбээр 1932-1937 он хүртэл нөхдийнхөө хамт ногоон малгайтануудыг чулуу хөөлгөж Эхин усны говь хавьцаах Алтайн нуруунд орогнож, мөн Баянхонгор аймгийн Жинст сумын нутагт байх гэрийн чинээ том агуйд хоёр гурван ч жил бүгжээ. Ангийн арьсыг тэр чигээр нь хувцас маягтай болгож өмсдөг байсан түүнийг малын эрэлчид алсаас харчихаад “Алмас үзлээ” хэмээн нэг бус удаа дуулиан дэгдээж байснаар 1935 онд түүнийг судалж сурвалжлахаар Оросын геологич Виктор гэдэг хүн Эхин усны говь руу зүглэж байжээ. Гэвч түүнийг цангаж үхдэгийн даваан дээр хэвтэж байхад нь Ванчингийн хоёр хүн тааралдаж худаг бараадуулаад орхиж байсан гэдэг. 1937 оны намрын нэг өдөр Ванчин гавж эрхиэ татаж үзээд “Миний хээрээр гэр, хэцээр дэр хийх хоногийн тоо гүйцжээ. Одоо үхэх цаг минь болж. Лу багшийг маань Дотоодыг хамгаалахынхан баривчлаад авч явсан байна. Би өөрийгөө барьж өгч багшийнхаа амийг аварна” гэж шийдээд хамт байсан хүмүүсээ тараагаад өөрөө Баянхонгор аймгийн Дотоодыг хамгаалах хэлтэс дээр очиж “эсэргүү” хэргээ хүлээж Лу цоржийг суллахыг шаарджээ. Уг мэдээг хүлээн авсан До яамныхан “Наад аюултай эсэргүү хэрэгтэнээ хатуу хамгаалалтан дор Улаанбаатарт авч ир” гэсэн нууц тушаал өгчээ. Ванчин гавжийг ингэж явах хооронд ногоон малгайтанууд Лувсанцэрэн цоржийг буудаж алсанаа тас нуусан байгаа юм. Ийнхүү Ванчин гавж Лу багшийгаа аврах гэж зүтгэсэн биш өөрөө 1938 оны 1-р сард цаазаар авахуулжээ. Тэр үед үнэн юм гэж үнэхээр байсангүй. Лам бол эсэргүү, ноёд бол тагнуул болж байсан цаг болохоор арга ч үгүй юм. Ванчин гавжийн хэргийг Монгол улсын Дээд шүүхийн цэргийн коллегийн 1992 оны 6-р сарын 20-ны 97 дугаар хурлаар цагаатгаж нэр төрийг нь сэргээсэн байна. Түүний орогнож байсан Баянхонгор аймгийн Жинст сумын нутагт байх гэрийн чинээ том агуйд гучин жилийн дараа буюу 1970-аад оны үед Шинээгийн Оросоо хэмээх шилийн эр найман жил орогносон гэдэг. 30 гаруй насны, булчин шөрмөс нь зангирч, бие хаа нь тэгширсэн Шинээгийн Оросоо хол ойроос адуу хөөсөн хэргээр арван жилийн ял авчээ. Гэсэн ч тэр Туул голоор сал урсгах хүнд хүчир ажилд дайчлагдаж байсаар нэг л өдөр оргочихож. Тэрбээр дамнуурга модоо эрэг дээр гаргаж чулуудаад улаан хоормогоор үеэрлэн байсан гол руу үсэрч ороод урсгал даган сэлж оджээ. Төдөлгүй орой болж хянагч нар хоригдолуудаа жагсааж бүртгээд Оросоог алга болсоныг мэдсэн байна. “Ялтан Оросоо оргочихлоо” гэсэн ойлголт тэднийг эзэмдэж, бөөн эрэл хайгуул болох нь тэр. Эцэст нь түүний хувин модонд өлгөөстэй, дамнуурга нь уснаас зайтай шидэгдсэн зэргийг хараад живж үхжээ гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Оросоо бүрий болсон хойно уснаас гарч, ой дундуур хэсэг гүйжээ. Өлссөн гэж жигтэйхэн. Гэвч шантралгүй явсаар л байлаа. Гэтэл нохойн дуу аниргүй орчныг эвдэж Оросоогийн зүрхийг түгшээх нь тэр. Нохойн дууг чагнаад байвал яавч мөрдөгч нохой биш айлын хоточ нохой болох нь мэдрэгджээ. Оросоо тэр зүгийг чиглэн явсаар айлын бараа олж хараад хамгийн баруун захын айлд явж ортол нэг ланжгар эр хурхирч байсан байна.

Оросоо алган дээрээ элс үрээд мөнөөх эрийн нүүр лүү жигдхэн үлээхэд цаадах нь шуурга тавьж байна гэж санасан бололтой хөнжлөө толгой дээгүүрээ нөмөрчээ. Өлссөндөө болоод эрэгнэгэн дээр байсан түмпэнтэй хоолноос идэж өл залгаад гадаа уян дээр байсан морийг эмээллэж унаад баруун зүг жолоогоо залсан байна. Энэ цагаас хойш Оросоо Баянхонгор аймгийн Жинст сумын Богд ууланд найман жил бүгсэн гэдэг. Харин дараа нь чухам юу болсон нь тодорхой бус. Ямартай ч тэрбээр нутгийн иргэдэд хандаж “Надад найман жилийн ял дугуу байсан. Тэр найман жилээ би агуйд бүгэж өнгөрөөлөө. Нутгийн та бүхэн надад маш хүндэтгэлтэй хандаж найман жилийн турш амаа жимийж явсан. Үүнд чинь би насан туршдаа баярлаж явах болно. Одоо би нутагтаа очиж амьдарна” гээд Өмнөговь аймгийг зорьсон гэдэг. Харин тэр цагаас хойш тус нутгийнхан Богд ууланд байх гэрийн чинээ агуйг “Ванчингийн агуй” гэдэг байснаа болиод “Оросоогийн агуй” гэж нэрлэх болсон гэдэг.

## Домог зүйч, судлаачдын урлан дахь Хонгор нутгийн шилийн эрчүүд

Эрт цагт Дарьганга нутаг шилийн сайн эрчүүд олонтой байсан нь түүхийн шарласан хуудаснаас төвөггүй ойлгогддог. Үүн лүгээ Баянхонгор аймаг Манжийн үед ч тэр, Ардын засгийн жилүүдэд ч тэр, социализмын үед ч тэр шилийн сайн эрчүүдээр “хахаж” байсан байх юм. Жишээ нь “Бөх” Ванган, Гүндсамба, “Лан хар” Бадарч, “Хулгар” Зундуй, “Ягаан” Гончиг, “Царай” Цамба, “Нохой” Дугар, Ядам, Бондой, Цагаан, Балж, “Бөгтөр хүрэн”, “Хэрзгэр” Лувсандагва, Хөөт, “Өөхөн” Памбага нарыг дурдаж болно. Социализмын үед Баянхонгор аймгаас Гүнсэнжавын Шаазанхүү, Түмэнгийн Дашдаваа, Галдайн Хүүхэнхүү зэрэг алдартай шилийн эрчүүд төрөн гарсан байдаг. Баянхонгор аймгийн Галуут сумын харьяат Галдайн Хүүхэнхүү нь УИХ-ын гишүүн асан Г.Занданшатарын нагац ах юмсанж. Энэ удаад Баянхонгор аймгаас төрж гарсан “Гүнийн хөндий”-н Гүндсамба, “Ягаан” Гончиг, “Царай” Цамба, Балж, “Бөгтөр хүрэн”, “Хэрзгэр” Лувсандагва, “Нохой” Дугар, Бондой нарын тухай өгүүлсү. Дашрамд хэлэхэд шилийн эр Гүндсамба, “Ягаан” Гончиг нарын тухай Баянхонгор аймгийн уугуул Г.Дашчирэвийн судалгаа, “Царай” Цамба, Балж, “Бөгтөр хүрэн”, “Хэрзгэр” Лувсандагва нарын тухай Ч.Ядамын гар бичмэл, “Нохой” Дугар, Бондой нарын тухай Э.Дашцэрэнгийн яриа энд зонхилсон болно.

### “Гүнийн хөндий”-н Гүндсамба

Эрт цагт хятадууд Баянхонгор нутгийн ард олноос авсан малаа шөнө голдуу туудаг байжээ. Үүнийг мэдсэн шилийн эр Гүндсамба хятадуудын явах зам дээр хонь, ямаа багтахуйц олон арван нүх ухаад дэлс, хулсаар өнгөлж орхидог байж. Хятадууд шөнө малаа тууж гарахад Гүндсамбын ухсан нүхэнд хонь, ямаанаас нь унаж хоцрох бөгөөд мянган хонь туугаад гарлаа гэхэд дор хаяад зуун хонь үлдэх жишээтэй. Хятадуудыг шөнө яваад өнгөрмөгц Гүндсамба дэрс, хулсаар өнгөлж орхисон газартаа давхиж ирээд нүхэнд унасан малыг татаж гарган нутгийнхаа ядууст тараадаг байжээ. Хятад тууварчид адуу, үхэр мэтийн бод малыг ч гэсэн Гүндсамбын нутагладаг “Гүнийн хөндий”-гөөр тууж гаргадаг байж. Тэднийг “Гүнийн хөндий” уруудуулаад адуу тууж явахад нь Гүндсамба тэргүүтэй шилийн эрчүүд хөндийн хоёр талын ууланд гарч дээрээс нь янз бүрийн навтас хийсгэж адуу малыг нь үргээгээд тасдаж хөөдөг байсан гэдэг. Тийм учраас нутгийн ардууд түүнийг “Гүнийн хөндий”-н Гүндсамба гэж авгайлах болжээ. Түүнчлэн манж, хятадууд “Гүнийн хөндийг яаж туулна, Гүндсамбын давааг яаж давна” гэж бэрэгшээдэг байж. Ер нь тэрбээр нутаг хошуу, ард түмнийхээ төлөө өөрийн хүч чадал, оюун ухаанаа харамгүй зориулж жинхэнэ шилийн эр болохоо олонтаа харуулсан байдаг. Нэг удаа Гүндсамба Утай Гүмбэнд очиж мөргөл үйлдэхээр болжээ. Хамт явсан хүмүүс нь түүнд хандаж “Буян үйлдэж яваа хүн Утай Гүмбэнгийн ариун дагшин газраас хулгай хийж л болдоггүй юм шүү” гэж захисан байна. Буцаж явахдаа нөгөө хүмүүс Гүндсамбаас “Чи хулгай хийгээгүй биз дээ” гэж асуухад мань эр “Би өөрийн хийдийг өөдтэй байлгах гэсэндээ бурхан, бэрээ, жавдан зэргийн гурван зүйлийг авсан. Бурханыг нь хийдийн сахиус болгох гэж, бэрээг нь хийдийн шавь нарыг сахилга, дэг журамтай болгох гэж, харин жавданг нь лам нарыг тогтвортой суулгаж их ном сургах гэж авсан. Энэ бол хулгай биш буян номын үйл хэрэг” гэж өчиж байсан гэдэг. Нэг удаа Гүндсамба хятад худалдаачдаас баахан торго дурдан хулгайлжээ. Үүнийг мэдсэн хятадууд хошуу ноёноос Гүндсамбын гэр оронд нэгжлэг хийх зөвшөөрөл өгөхийг хүссэн байна. Төдөлгүй хошуу ноён Гүндсамбыг дуудаж

ирүүлээд “Танай хонь хаашаа бэлчсэн бэ?” гэж асуухад мань эр “Уул руу бэлчсэн” хэмээжээ. Хошуу ноён ч ойлгож, түүний гэрийн дотор тал, дээврээс доошхи бүх газрыг нэгжих зөвшөөрөл өгчээ. Гэвч хятадууд нэгжлэг хийгээд юу ч олсонгүй. Учир нь Гүндсамба хятадуудаас хулгайлсан торго дурдангаа гэрийнхээ дээврийн завсар хийж нуусан байсан бөгөөд үүнийг ухаалаг ноён “Танай хонь хаашаа бэлчсэн бэ?” гэх битүү асуултаар тандаж мэдээд сайн эрийг аварсан нь энэ. Гүндсамба нэг үе Хятадын жингийн цувааг шөнөөр дагаж явсаар сүүлчийн тэмээг нь хөтөлж оддог байж. Үүнийг хятадууд мэдчихээд сүүлчийнхээ тэмээн дээр өөжингөө ачаалаад эзэн данжаадаа унтуулж явдаг болж. Харин Гүндсамба үүнийг анзаарсангүй. Нэг шөнө тэрбээр сүүлчийн тэмээг нь хөтөлж давхиад нэлээд хол очоод тэмээгээ хэвтүүлэн ачаагаа буулгах гэтэл “Хай буух болсон баа” хэмээн хятад хүн дуугарчээ. Тэгмэгц Гүндсамба “За би хүний амь хороох гэж тэмээ авч зугтаагүй, ховор бараа авах гэж л тэмээ авч зугтсан. Данжаад таны амийг өршөөлөө” гээд тэмээтэй нь орхиод явж байсан гэдэг. Нэг удаа тэрбээр хятад худалдаачдын буудалласан газар шууд давхиж очоод мэнд усаа мэдэлцэхэд эзэн данжаад нь “Чи нөгөө сайн эр Гүндсамба мөн байх шив дээ. Тийм сайн эр юм бол чи өнөө шөнө бидний энэ ваадантай данс, мөнгийг хулгайлаад ав. Эс чадвал бид чиний толгойг авья” хэмээжээ. Гүндсамба ч тэдний саналыг хүлээж аваад морджээ. Төдөлгүй бүрий болмогц хятадууд Гүндсамбыг хаагуур ирэх бол хэмээн нүд салгалгүй харуулдаж эхэлжээ. Тэгтэл ойролцоох толгод дээр Гүндсамба гаансныхаа цогийг байн байн улалзуулаад тамхи татаад суугаад байж гэнэ. Хятадууд ч тэр зүг ээлж ээлжээр хараа бэлчээсээр байж. Харин Гүндсамба хэсэгхэн хугацаанд тамхины оронд өвс асааж орхиод хятадуудын майхан руу гэтэж ваадантай мөнгө, данс зэргийг нь аваад мөнөөх толгод дээрээ эргэж очоод суучихаж. Маргааш өглөө нь тэрбээр хятадууд дээр морьтойгоо давхиж очтол эзэн данжаад нь “За чи толгойгоо авахуулахаар ирэв үү?” гэж бардамнажээ. Хариуд нь Гүндсамба ваадантай данс, мөнгийг гаргаж үзүүлээд “Манай нутгийн ардууд та нарт өргүй болсон шүү” гэж хашгирахад эзэн данжаад толгойгоо салаавчлаад унаад өгсөн гэдэг. Гэхдээ мань эр хятадуудыг байнга ялан дийлээд байсангүй. Хятадуудыг дээрэмдэх гэж яваад тэдний гарт орж хөдөө хээр хүлээстэй хаяулах, хөлийнхөө шөрмөсийг тасдуулах зэргээр эсэн бусын зовлон амсч байжээ. Нэг удаа Гүндсамба алт, эрдэнэс ачсан нэгэн хятадын ачаанаас авах гээд дагасан боловч хятад эр буунаасаа ер салсангүй. Харин орой болмогц хятад эр буугаа хажуудаа тавиад хооллохоор болж. Гүндсамба яг энэ үед нь араас нь бууж ороод бууг нь шүүрэн авч хятад эр лүү тулгахад “Та миний бүх барааг ав. Ганцхан амийг минь л өршөө” гэж уйлан дуулжээ. Гүндсамба ч түүний амийг өршөөгөөд ачаа бараанаас нь аль өнгөтэйг нь авахаар шуударсан байна. Гэтэл нөгөө амийг нь өршөөсөн хятад түүний сэрэмжгүй байдлыг ашиглаад толгой руу нь хүнд юмаар цохиж унагаад дангинатал хүлж орхих нь тэр. Тэгээд мань хятад Гүндсамбыг хэдэн өдөр хүлээтэй нь ачиж яваад хүнгүй цөлд хаяж орхижээ. Харин аз болж Гүндсамбыг хатаж үхдэгийн даваан дээр нутгийн жинчид тааралдаж амийг нь аварсан гэдэг. Олон жил мал, эд хөрөнгөө дээрэмдүүлсэн хятадууд Гүндсамбад ихэд өширхдөг болж, улмаар нэг өдөр түүнийг гэнэдүүлэн барьж аваад “Чи ингээд хол ойр хулгай хийж бай” гээд хөлийнх нь шөрмөсийг тас огтолж байсан гэдэг. Гэсэн ч хазгар доголлон болсон тэрбээр үхэн үхтэлээ хятад худалдаачдыг янз бүрийн аргаар дөнгөсөөр байгаад таалал төгссөн гэдэг билээ.



## “Хэрзгэр” Лувсандагва

Баянхогор аймгийн баруун сумдын сайн эрс болох Балж, “Бөгтөр хүрэн”, “Хэрзгэр” Лувсандагва нарын тухай домог яриа цөөнгүй байдаг. Зуд турханд малаа барсан хүмүүс хоол унд олж идэх чадал мөхөсдөж, үүний улмаас эртэй сэргэлэн эрчүүд тэдэнд тусалж алс хошуунаас адуу мал хөөж ирдэг байжээ. Ялангуяа Балж, “Бөгтөр хүрэн” хоёр иймэрхүү ажилд ихэд гаршсан байна. Нэг удаа мань хоёр алс холоос хэсэг адуу хөөж иртэл тэр адуунд нь хэн ч харсан нүд унахаар ганган цэмцгэр цоохор морь дүүхэлзэж байсан байна. Энэ морийг хараад “Хэрзгэр” Лувсандагва “Наад морь чинь над шиг бөх хүнд л баймаар хүлэг байна. Ерөөсөө надад өгчих” гэж гуйсаар байгаад авчээ. Гэвч онцгой содон цоохор морь бусад адуугаа “хөөдсөн”-өөр Балж, “Бөгтөр хүрэн” хоёрын хулгай илчлэгдэж Улиастайн шоронд хүргэгджээ. Тэд шоронгоос гарах ямар ч бололцоогүй болоод сууж байтал хэрэг нь улам хүндэрч цаазаар авахуулахаар болсон байна. Чухам энэ үед үхтэлээ үхэр буугаа тавив гэгчээр мань хоёр “Хэрзгэр” Лувсандагвыгаа хам хэрэгтэнээр татсан байна. Төдөлгүй Лувсандагва шоронд орж ирээд “Та хоёр яах гэж гэмгүй хүнийг гөрдөж шоронд хийлгээ вэ. Би та хоёроос ганц морь л авсан болохоос биш хамтарч хулгай хийгээгүй” гэж гомдоллоход Балж “Бид хоёр хэзээ мөдгүй цаазаар авахуулах болчихоод байна. Чи л бид хоёрт тус болох ёстой. Юун төлөө чи хошууны наадамд олон түрүүлсэн бөх хүн билээ дээ. Бид хоёрын хоригдож байгаа энэ жижигхэн дүнзэн байшинг бяраа чадалтай чи л өргөж хөндийрүүлж чадна. Толгой багтах зай төдийхөн гарахад л бид хоёр шургаад гарчихна” хэмээжээ. Хариуд нь Лувсандагва “Би барахгүй биз дээ. Манжууд л болсон хойно халх эрчүүдийн мөрлөөд гарчих шоронд та хоёрыг хорив гэж дээ. Гэсэн ч яахав би шөнө болмогц нэг оролдоод үзье. Харин та хоёр тэр үед миний цолыг дуудаж зол оруулна шүү” хэмээжээ. Зол гэдэг нь онгод бяраа оруулахыг хэлж байгаа хэрэг. Үнэндээ ч “Хэрзгэр” Лувсандагва маш их тэнхээтэй, ялангуяа цолыг нь дуудахад цочир бяраа ордог, наадамчин олныг уухайлаад ирмэгц улм бяраатай болж хэнбугайг ч аваад чулуудчихдаг хүн байж. Ингээд шөнө болмогц Малж, “Бөгтөр хүрэн” хоёр түүний цолыг баахан дуудаж байгаад тавьсанд зол нь орсон бөх Лувсандагва байшингийн зүүн өнцөгөөс өргөсөнд багавтар дүнзэн байшин хөндийрөөд ирсэн байна. Энэ хооронд Балж хажуудаа байсан үхрийн булууны ясыг давхарлан шургуулсанаар хүний толгой багтах зайтай болж, улмаар хоёр хулгайч түүгээр шургаж гараад шөнийн харанхуйд уусан шингэх нь тэр. Харин янхигар том биетэй Лувсандагвад шургаж гарах арга байсангүй. Ер нь ч тэгээд Лувсандагва зориуд тэнд үлдэж өөрийнхөө амийг аргалахаар шийдсэн байв. Тэрбээр хоёр нөхрөө оргож одсоноос хойш хоёр цагийн дараа шоронгийн хуягуудыг дуудан орилж гарчээ. Хуягуудыг “Юу болов, яав ийв” гээд орж ирэхэд Лувсандагва “Танай тэр хүн гөрдсөн хулгайч нар чинь намайг нам цохиж унагаад оргоод алга болчихлоо. Та нар тэр хулгайч нартай сэм хуйвалдаж намайг алуулахаар тохиролцсон байна” гээд л цамнаж гарчээ. Тиймээс хуягууд хэл ам ихтэй Лувсандагвыг хилсдүүлсэн хэрэгт унах вий гэж айсандаа түүнийг суллаж тавьсан гэдэг.

## “Ягаан” Гончиг

Баянхонгор нутагт дээхэн үед “Ягаан” Гончиг хэмээх шилийн эр амьдарч байжээ. Эхнэр Тойг нь түүнийг хулгай хийгээд ирэхэд ямарваа нэг сэжиг бүхий хүн ирсэн байвал хантаазаа буруу харуулан өмсөөд гаднаа явж байдаг байж. Харин гаднаас элдэв хүнгүй бол хантаазаа зөв харуулан өмсдөг байжээ. Хэрвээ эхнэр нь хантаазаа буруу харуулаад өмсчихсөн байвал “Ягаан” Гончиг гэртээ оролгүйгээр замаа буруулдаг байж. Нэг удаа “Ягаан” Гончиг азарга адуу хөөж ирээд ойролцоох уулын хавцалд нуучихаад худаг дээр эхнэртэйгээ хонио усалж байтал адууны эзэн ирж яваа харагджээ. Тэгтэл эхнэр Тойг нь “Ягаан” Гончигийг барьж аваад юу юугүй зодож жанчаад хониныхоо хойноос хөөгөөд явуулсан байна. Төдөлгүй адууны эзэн түүн дээр ирж “За авхай та яагаад зарцыгаа зодоод байна даа. Ингэхэд танай нөхөр хаачсан юм бэ?” гэж асуухад “Хэн мэддэг юм бэ. Зүүн хошуунд надаас өөр эхнэртэй болсон сураг дуулдсан. Тэрнийхээ өвөрт л хэвтэж байгаа биз. Ядаж байхад энэ муу зарц үгэнд орохгүй уур хүргээд байх юм” гэж жишим ч үгүй хэлж байсан гэдэг. “Ардын элч” кинон дээр Ариунаа Дүлзэнгээс зугтаж явах үедээ Галсан мээрэнгийн эхнэр болж жүжиглээд хонь хариулж явсан жаахан хүүхдийг дээрхи маягаар зодоод амь гардаг билээ. Магадгүй энэ сэдвийг зальтай сэргэлэн Тойг авхайн явдлаас ургуулсан байж ч мэднэ. Нэг удаа шилийн эр “Ягаан” Гончигтой нутгийн нь “Могдгор” Гончиг хэмээх хүн тааралдаад Хятадын агт туусан агтчин цэргүүдээс адуу хулгайлахаар үгсэн тохирчээ. Ингээд мань хоёрыг “Халзангийн цахир” хэмээх агуйд бүгэж байтал хятад цэргүүд ойролцоох Баянхөөвөрийн талаар адуугаа туугаад гарч иржээ. Төдөлгүй бүрэнхий болж хоёр Гончиг бөөн адуу руу дайрч ороод тав зургаан сайн хүлэг уургалж аваад холбож байтал хятад цэргүүд мэдчихээд давхиад ирсэн байна. Энэ үед “Ягаан” Гончиг холбосон морьдоо “Могдгор” Гончигт хөтлүүлэн зугтаалгаад өөрөө тэнд үлджээ. “Могдгор” Гончиг морьдоо хөтлөн зугтааж явахдаа эргэж хартал хятад цэргүүд “Ягаан” Гончигийг морьтой нь хамт уургалаад авчихсан чаргуулдаж байгаа харагдсан байна. Үүнийг хараад тэрбээр ихэд айж сандарчээ. Ямар сайндаа л унаж явсан морь нь юмнаас үргээд гэнэт зогтусахад тэр учиргүй айгаад хөтөлж явсан хэдэн сайхан морио хаяад цааш ганцаараа зугтжээ. Ингэж явахдаа тэрбээр “Би ч яахав амьд гарлаа. Харин нөгөөхийг маань хятадууд бариад авсан. Шууд л алчихсан байх даа” гэж бодсоор агуйнхаа ойролцоо иртэл “Ягаан” Гончиг аль хэдийн ирчихсэн “Нөгөө морьдоо яасан бэ” гэж асууж байна гэнэ. “Могдгор” Гончиг учир явдлаа хэлтэл “Ягаан” Гончиг “Хэдэн адуу хөтлөөд ирж чадахгүй яасан заяа нь орхисон эр вэ” гээд маш их уурлажээ. Түүнийг жаахан тайтгарсаны дараа “Могдгор” Гончиг “Тэр хэдэн адсага яах вэ. Чи бид хоёр амьд мэнд гарсан нь том аз шүү дээ. Чи яаж тэр хятад цэргүүдийн гараас мултрав аа” гэж асуухад “Ягаан” Гончиг “Яах юу байдаг юм бэ. Жаахан зүтгэж байгаад уурганы нь хуйвыг тас огтолчихсон чинь нэг муу хятад цэрэг гэдэргээ саваад мориноосоо унаж байгаа харагдсан. Ингэнэ гэдгийг би төсөөлөөд л чамайг зугтаалгасан юм шүү дээ. Чи ч олхио муутай эр юм даа. Цаашид энд тэндээс адуу мал хумслах талаар битгий донгосч байгаарай” гэж сануулж байсан гэдэг.

## “Царай” Цамба

Дээхэн үед Баянхонгор нутагт “Царай” Цамба хэмээх аварга том биетэй, ойгүй бяр тэнхээтэй, ядуу зүдүү амьдралтай, царай зүс муутай, бусад сайн эрс шиг энд тэндээс адуу мал хөөхгүй ч гэлээ ган зуданд нэрвэгдсэн айл хотлоо өлсгөлөн, ядуурлаас аварч чаддаг гүндүүгүй сайн эр амьдарч байжээ. Нэг өвөл мань эрийн хот айл зуданд нэрвэгдсэнээр хавар нь хоол хүнсгүй хүнд байдалд орсон байна. Тиймээс “Царай” Цамба нэлээд зайтай бэлчиж явсан жасын адуунаас нэг тарган гүү барьж аван баглаж үүрээд гэртээ иржээ. Тэгээд түүнийгээ нядлаад хот айлынхаа хүмүүсийг нэг сайн цатгаж авсан байна. Төдөлгүй жасын адуучин түүний мөрийг мөшгиж явсаар гүү хулгайлсаныг нь мэдмэгцээ жасын няравтаа очиж айлтгажээ. Жасын нярав “Царай” Цамбыг дуудаж ирүүлээд “Гүү хулгайлаад үүрээд явчихдаг яасан айхтар хулгайч вэ. За яахав чиний бяр тэнхээг, бас жасын адуунд халдсан зоригийг чинь үнэлье. Чи үүнээс хойш жасын адуунаас хулгайлж авч идэж болохгүй. Жил болгон чамд жасын адуунаас нэгийг өргөл болгон өгч буян үйлдэж байя” гэсэн гэдэг. Нэг удаа Цамбын хот айлынхан зуд турханаас болоод хоол ундаар тун тааруухан өвөлжсөн байна. Зуднаас болж хамаг малчид говь руугаа нүүгээд явчихсан тул Цамбын хот айл тусалж дэмжих малчидгүй ихэд зутарчээ. Тиймээс Цамба нэг өдөр хот айлынхнаа өлсгөлөнгөөс аврахын тулд нэлээд хол явж зэргэлдээх хошууныхаа ноёны мал руу халдаж нэг гунжин үхрийг шууд цохиж унагаад үүрээд алхчихсан байна. Үхрийн мөр гаргаж өөрийгөө барьж өгөхгүй гэж үүрч яваа нь энэ. Тэгээд маш хол зайд үүрсээр яваад гэрийнхээ хаяанд ирж мөн л хот айлынхаа хүмүүсийг нэг сайн цатгаж авсан байна. Гэтэл маргааш нь ноёны сүргийг хариулдаг Гармаа, Жамбалдорж хэмээх ах дүү хоёр бөх “Царай” Цамбынд хүрч ирээд “Энэ нутагт үхэр үүрээд хол газар туулдаг хүн чамаас өөр байхгүй. Үхрийн мөр гаргалгүйгээр хичнээн явсан ч бид хоёр чамайг хулгайлсаныг мэдэж байна. Одоо хэдүүлээ хошуу тамгын газарт очиж зарга хэлэлцэе, алив бушуул, түргэл” гээд шалаад суучихжээ. “Царай” Цамба ч үхэр хулгайлсанаа тэр даруйдаа хүлээгээд “Та хоёр юун төлөө хошуу нутагтаа алдартай бөх улс билээ. Чаддаг юм бол намайг та нар өөрсдөө аваад яв. Чадахгүй бол та нарын хохь” гээд хотондоо дөрвөн мөчөө дэлгээд хэвтчихсэн байна. Гэвч ах дүү хоёр бөх түүний дөрвөн мөчийг нугалж боох гээд хүчирсэнгүй. Сүүлдээ хоёр талаас нь жийж дэвсээд “Царай” Цамбын хоёр гурван ч хавиргыг хугалаад хаячихжээ. Тиймээс Цамба уурлан босч ирээд ах дүү хоёрыг шилэн хүзүүдэж аваад хооронд нь мөргөлдүүлж орхитол хошуу нутагтаа алдартай хоёр бөх золтой л ухаан алдаад уначихсангүй. Төдөлгүй Гармаа, Жамбалдорж хоёр ичсэн нэрэндээ бушуухан мордоод явчихсан байна. Гармаа нь явах замдаа “Нэг муу гунжин үнээнээс болж ингэж ч нүдний булай болох гэж. Хошууны нэртэй бөхчүүд байж ингэж хүний дор орно гэж байх уу даа. Цамбыг хэрвээ тамгын газарт мэдэгдэх юм бол чи бид хоёр нүдний булай болно. Түүний идсэн гунжийг би л хувиасаа төлөхөөс дөө” гэж үглэж явсан гэдэг. Нэгэн хавар “Царай” Цамба хаврын тарвага барих санаатай “Тэгшийн ар” хэмээх газраар явж байтал нэг морьтон утаа униар савсуулан сууж байгаа харагджээ. Түүн дээр явж очтол өөрөөс нь биеэр том, хүзүүндээ цэнхэр хадган зангиа намируулсан эр урт цахиур буу дэргэдээ тавиад аяны тогоонд ууц чанаад сууж байсан байна. Цамба түүнтэй амар мэндээ мэдэлцтэл сайхь эр түүнийг нэг их тоож авч хэлэлцсэнгүй. Төдөлгүй тэр чанаж байсан ууцаа гаргаж иджээ. Цамба түүнээс хишиг горьдож суусан ч түүнд ганц зүсэм өөх ч хялайлгасангүй. “Ууц чанасан шөлнөөс чинь ууя” гэсэнд мөнөөх эр Цамбад өгөлгүйгээр шууд асгачихсан байна. Тиймээс Цамбын зэвүү хүрч цэнхэр хадган зангианаас нь шүүрч аван хоолойг нь боож ухаан алдуулаад, улмаар

мориных нь ногтоор хүлж орхиод унаж явсан морь, буу зэргийг нь аваад гэртээ харьжээ. Тэгтэл шөнө дундын үед мөнөөх эр хүлэгнээсээ мултраад Цамбын гэрт гэв гэнэт ороод ирсэн байна. Энэ үед Цамба “За одоо ч би алуулах нь тодорхой боллоо” гэж бодож хэвтгэл мөнөөх эр “Чамайг би сайн эр юм болов уу гэж бодсон юм. Гэтэл чи хүн алах зүрхгүй муу эр байна. Гэхдээ би чиний аминд хүрэхгүй. Харин хоёулаа ах дүү бололцье. Хойд хаданд холын хошуунаас хөөж ирсэн хэдэн адуу байгаа. Чи тэрийг авч амьжиргаагаа залгуул” гэснээр “Царай” Цамба хол ойроос адуу хөөж ирдэг нэг сайхан шилийн эр дүүтэй болсон гэдэг.

## “Нохой” Дугар

Баянхонгор аймгийн Байдраг, Цагаан голын уулзварт “Улаан хуц” хэмээх уул байдаг бөгөөд энэхүү ууланд дээхэн үед “Нохой” Дугар хэмээх шилийн эр амьдардаг байжээ. Тэрбээр нутаг олондоо тустай, харин манж ноёд, хятад худалдаачдын эрлэг байж. Ялангуяа хятад худалдаачдыг нэг нүдээрээ ч үздэггүй, сав л хийвэл эд юмсыг нь тоноод ядууст тараачихдаг байж. Мань эр нэг удаа “Гүнийн хөндий”-н Гүндсамбын аргыг хэрэглэж тухайн үед Байдраг голын хөвөөн дээр мандан бадарч байсан “Хотын булан” хэмээх пүүсийн баян данжаадын өрийн дансыг хулгайлж нутгийнхаа ард олныг өр ширнээс ангижруулж байсан гэдэг. Нэг удаа тэрбээр “Улаан хуц” уулынхаа орой дээр цагаан морио уяад дэргэд нь мануухай босгож орхисон байна. Үүнийг харсан пүүсний данжаад “За энэ болохоо байлаа. Нөгөө шилийн хулгайч “Нохой” Дугар чинь бидэн рүү довглохоор шийдсэн байна. “Улаан хуц” уулнаас хараагаа салгаж болохгүй шүү” хэмээн зарц нартаа үүрэгджээ. Гэтэл цагаан морь, “Нохой” Дугар хоёр бүтэн гурав хоног уулын орой дээр байсанд пүүсийнхэн “Шилийн хулгайч Дугар галзуурсан баа. Эсвэл суугаагаараа үхсэн баа. Морийг нь тавьж явуулбаа” гээд л шуугилдацгаасан байна. Төдөлгүй баян данжаад “Улаан хуц” уул руу туслахуудаа явуултал цагаан морины хажууд мануухай сууж байх нь тэр. Тэд яаран сандран пүүсэн дээрээ ирээд эд юмсаа бүртгэж үзтэл үлэмж хэмжээний алт эрдэнэс, өрийн дансын хамт алга болсон байжээ. Ингэж шилийн эр “Нохой” Дугар нутгийн олноо нэг удаа өрнөөс гаргаж байсан гэдэг. Мөн манж, хятадуудад халтай, нутгийн олондоо ээлтэй Бондой хэмээх шилийн эр Баянхонгор нутагт амьдарч байсан байна. Түүний тухай олон янзын домог яриа байдаг юм. Нэг удаа тэрбээр Улиастай орох Манжийн амбаны их хөсгөн дээр улайм цайм давхиад буучихжээ. Гэтэл өмнө нь Бондойд тонуулж явсан нэгэн баян данжаад хэдэн туслахынхаа хамт байж байх нь тэр. Гэхдээ мань данжаад Бондойг танихгүй, зөвхөн сургаар л мэддэг байж. Тэрбээр Бондойд хандаж “Хай, танай нутгийн шилийн хулгайч Бондой хаагуур явна вэ” гэж асуухад Бондой “Хай, тэр үхсэн баа. Хятадуудыг дээрэмдэж байгаад тархи хага яруулсан баа. Сүнс нь там руу талийсан баа” хэмээжээ. Үүнийг сонсоод данжаад учиргүй баярлаж “Хай, тэр хулгайч үхвэл таарна. Там руу очсон баа. Сайхан мэдээ дуулгасан чи сайн идбаа, ууваа” гээд Бондойг амтат хоол, архи дарсаар дайлж гарсан байна. Түүнийг явахад бас хөөрхөн шан харамж өгсөн байгаа юм. Харамсалтай нь шөнө дундын үед Бондой баян данжаадын хэдэн туслахын аманд алчуур чихэж орхиод, хамаг юмыг нь тоноод арилж өгсөн гэдэг. Нас дээр гарсан хойноо шилийн эр Бондой залуу цагийнхаа явдал суудлыг тавилгүйгээр Хятадын жинчдийг Баянхонгор нутгийн Цагаан голын орчимд явж байхад нь сүүлчийн хонхтой тэмээг нь урагшлуулан уячихаад хоёр тэмээ ачаа аваад Мандалын хавьд ирсэн байна. Гэтэл тэрхүү хоёр тэмээ ачаа нь хөөрөг, гаансны соруул хийдэг цагаан хаш чулуу байсанд Бондой “Хүн өтөлнө гэдэг муухай юм. Олон жил хар хятадуудыг тонохдоо хэнд ч хэрэггүй ийм чулуу авч байсангүй” гээд ихэд гутарч түүнийгээ хадны ганга руу асгаж орхисон гэдэг. Дээр үед “Сайн эрсийн уяа” гэж Монголын аль ч нутагт байсан бөгөөд Баянхонгор аймгийн Баянбүрд, Наран, Зүрүү, Ханан, Хөндлөнгийн ууланд Бондой, Гүндсамба, “Өөхөн” Памбага нарын олон арван сайн эрийн уяа байдаг байж. Эдгээрийн нэг Зүрүү, Хөндлөнгийн орчим байсан шилийн сайн эр Ядамын уяа нь 2000 орчим адуу оруулахад адууны эрэлчдэд анзаарагддаггүй, тошлой, жимс ургасан байгалийн үзэсгэлэн төгс газар байсан бөгөөд энд Манжийн хааны агтнаас зуу зуугаар нь таслан авч оруулаад хэд хоногийн дараа гаргаж нутгийн ардуудад тараан өгч буян үйлддэг сайн эрчүүд олон байжээ.

## Шаргиатын гарамын “Жууз” Молом

Хориод оны үед жинчин хятадуудыг дээрэмддэг байсан “Жууз” Молом хэмээх шилийн эрийн адал явдал хожим чөтгөр шулам, хий үзэгдэлтэй холбогдож байсан нь сонин. Харин ард олны дунд ам дамжин яригддаг байсан энэхүү адал явдлыг тавиад оны гэмт хэрэгтэн “Хоовон” Дангаа гэгч эр бусдыг дээрэмдэх үедээ ашигладаг байжээ. Ингээд эрт урьдын тэрхүү адал явдлаас өгүүлсү.

Өвөрхангай, Архангай аймгийн зааг хавьцаа байх нэгэн гармыг дээхэн үед “Шаргиатын гарам” гэдэг байж. Гэтэл уг гарман дээр нэгэн хүн амины хэрэг гарсанаар “Шаргиатын гарам” гэдэг сайхан нэр “Амь солилцох гарам” хэмээх таагүй нэртэй болсон байна. Гучаад оноос эхлээд Өвөрхангайн аянчид Улаанбаатар хот руу тэмээн хөсгөөр жин тээж эхэлсэн бөгөөд тэгэхдээ зөвхөн “Шаргиатын гарам”-аар гардаг байжээ. Гэтэл аянчдыг энэ гармаар шөнө гарах тоолонд цав цагаан морьтой, улаан дээлтэй, ширүүн харцтай, хүдэр чийрэг хар хүн хөндөлсөн зогсоод “За амь солилцох уу” гэдэг болжээ. Харин аянчид тэр хүнээс айн ширвээтэж гармаар гаралгүй буцаад явчихдаг байж. Тэгээд бүр холуур тойрч нэлээд гүнзгий усаар ачаа хөсгөө тээж гаргадаг болж. Эсвэл өдрийн цагаар тэр гармаар гарна. Ийм байдал хэдэн жил давтагдсан бөгөөд сүүлдээ аянчид “Шаргиатын гарам”-ыг чөтгөртэй гэж ярих болсон байна. Зарим нэг зориг зүрхтэй аянчин тэрхүү улаан дээлтэй хүнийг зориуд үзэх гэж шөнийн цагаар гарман дээр очдог байж. Тэгтэл нөгөө хүн мөн л гарч ирээд “За амь солилцох уу” гэнэ. Энэ цагаас хойш энэ гармыг “Амь солилцох гарам” гэж нэрлэх болжээ. Нэг удаа Өвөрхангайн “Шар” Дэмчиг гэгч нэлээд зоригтой эр “За өнөө шөнө Шаргиатын гармаар гарч улаан дээлтэй амь солилцоно. Яадгийм, юу л болбол болог” гэхэд хамт явсан хүмүүс нь “За тэгж л болохгүй шүү. Аягүй бол лус хилэгнүүлсэнээс болж ачаа хөсөгнөөсөө салж мэднэ. Эндээ хоноглоод өглөө эрт хөдөлцгөөе” гэж эрс хоригложээ. Тэгтэл “Шар” Дэмчиг “Би яадаг ч байсан энэ гармаар өнөө шөнө гарна. Та нар эндээ хоноглоод намайг өглөө болтол хүлээж бай. Чөтгөр гэж юу байдгийг өөрийн биеэр үзчихээд ирье. Улаан дээлтэй тэр хүн үнэхээр чөтгөр л юм бол хий хоосон л юм байгаа. Хоосон юмнаас айна гэдэг чинь юу гэсэн үг вэ” гэж зөрсөөр байгаад явахаар болжээ. Тэгээд тэр шөнийн хоёр цагийн үед “Амь солилцох гарам”-ын захад хүрч ирсэн байна. Тэгтэл сарны гэрэлд үнэхээр л цав цагаан морьтой, час улаан дээлтэй, тас хар царайтай бадриун эр гараад ирэх нь тэр. Дэмчигийн дотор жаахан арзасхийсэн боловч тэрбээр зоригондоо эрдээд шууд өөдөөс нь морио давиртал мөнөөх хүн “За амь солилцох уу” гээд цулбуураас нь атгаад авах шиг болжээ. Тэгтэл Дэмчиг гар руу нь тэнзэн ташуураараа маш хүчтэй цохьтол хий юм руу цохиж мориныхоо урд хөлийг ташуурдаад өөрөө эрчиндээ гарман дээр унажээ. Хамаг хувцас нь шалба норж, усан хулгана болтолоо чичирсээр босч иртэл хажууд нь мөнөөх улаан дээлтэй хүн байсангүй. Тэрбээр гармын цаад эрэг дээр морио хөтөлж ирээд “Хэ цэс. Манай жинчид ийм л өчүүхэн юмнаас айдаг байсан байна шүү дээ” гэж амандаа гүвтнээд бусад дээрээ очихоор хөдөлжээ. Тэгээд тэр даруйдаа давхин ирж бусдыгаа нойрноос нь сэрээгээд “За өнөө шөнө бүгдээрээ хөдөлнө. Үүр цайхаас өмнө тэр “Амь солилцох гарам”-ан дээр чинь очицгооё. Би сая тэр улаан дээлтийг чинь алчихаад ирлээ. Одоо тэр гарч ирэхгүй. Хэрэв дахиад гарч ирэх юм бол би дахиад ална, та нар харж байгаарай” гэж аархсан байна. Ингээд тэднийг ятгасаар байгаад ачаа хөсгийг нь хөтлүүлээд авч явжээ. Тэгээд тэд үүр цайхаас өмнө мөнөөх гарман дээр иртэл улаан дээлтэй хүн мөн л гарч ирээд “За амь солилцох уу” гэсэн байна. Энэ үед Дэмчиг

бусдаасаа түрүүлж морио давирсаар “Хоёулаа амь солилцье л доо. Чамд ер нь амь байгаа юмуу” гээд ташуураа далайгаад гар руу нь цохьтол тэр алга болчихож. Ингээд аянчид гармаар саадгүй гарчээ. Гэвч тэднийг цааш явж байтал гэв гэнэт ширүүн бороо цутгаж, аянга цахилгаан тас хийж хамгийн сүүлд явсан ачаатай хөсгийг нь аянга ниргэж орхижээ. Энэ үеэс хойш аянчид “Шар” Дэмчигийг лус хилэгнүүлсэн гээд үзэхээ байсан бөгөөд Дэмчиг ч нэг их удалгүй нас барсан байна. Үүнээс цэрвэсэн аянчид хожимынхоо зам мөрийг цэвэрлэхийн тулд нутгийн номтой лам нарыг урьж “Амь солилцох гарам”-ан дээр авчраад ном гүрэм уншуулсанаар мөнөөх улаан дээлтэй хүн дахин үзэгдэхээ байсан гэдэг. Харин энэ гарман дээр хориод оны үед болсон нэгэн явдлыг Өвөрхангай аймгийн уугуул “Ёдор” Шарав гэгч номтой лам мэддэг байсан бөгөөд тэрбээр “Манай нутагт цав цагаан морьтой, улаан дээлтэй шилийн хулгайч байсан юм. Түүнийг “Жууз” Молом гэдэг байлаа. Тухайн үед Молом жууз тэрэг хөлөглөсөн хятадуудыг дээрэмдэж ихээхэн нэрд гарсан хүн. Тэгтэл Молом өөрийн найз “Долоон булдруу” Цэвээнжав гэгчтэйгээ яг тэр гарман дээр муудалцаад “Амь солилцох уу” гэж түүн рүү дайрч байгаад алуулсан гэдэг. Тэр цагаас хойш Шаргиатын гарам гүйдэлтэй болсон. Ер нь гарман дээр муудалцах нь битгий хэл хоорондоо ч юм ярьж болдоггүй гэдэг. Ямар сайндаа л гарман дээр морио сольж болохгүй гэдэг үг гараа биз дээ” гэдэг байж. Номтой лам нар уг гарман дээр гүрэм уншсанаас хойш аянчид чөлөөтэй нэвтрэх болсон ч 1950-иад оны үед мөнөөх улаан дээлтэй хүн дахин мэр сэр үзэгдэх болсон гэдэг. Гэхдээ тэр нь ганц нэгээрээ яваа хүнд л үзэгдэх болжээ. Тийм ч учраас аянчид бас л айн ширвээтэж “За нөгөө улаан дээлт чинь дахиад гараад ирсэн байна шүү. Лус хилэгнэж мэднэ. Холуур явцгаая” гээд дөлж зугтдаг болжээ. Тэгтэл тус нутгийн Осоржамц гэдэг хүн шөнө явж байгаад төөрч будилан гарман дээр иртэл өмнөөс нь цагаан морьтой, улаан дээлтэй хүн гарч ирээд “За амь солилцох уу” гээд юу юугүй цулбуураас нь атгаад авчээ. Осоржамц айсандаа ташуураараа гар руу нь цохьтол хий юм биш бодит хүний гар таарч улаан дээлтэй хүн гараа бариад гарман дээр ёолон ойчжээ. Тэгэнгүүт Осоржамц морио давираад хар хурдаараа зугтсан бөгөөд маргааш нь энэ тухай хүмүүст ярихад “Чи худлаа ярьж байна. Тэр чинь бодит хүн байх учиргүй. Манай нутгийн жинчид сайн мэднэ. Ялангуяа үүгээр олон жил жин тээсэн Дагвадорж гуай тэр хий үзэгдлийг чинь биеэрээ мэдэрсэн хүн. Ер нь чи түүнтэй уулз” гэхэд цаадах нь “Тэрэнтэй уулзаж элэнцэгээ хийдэг юм бэ. Яах аргагүй бодит хүн байсан. Худлаа гэвэл хэдүүлээ өнөө шөнө тийшээ очиж хий үзэгдэл үү, бодит хүн үү гэдгийг мэдэж авъя. Хэрэв чөтгөр байх юм бол би та нарт арван адуу өгнө. Бодит хүн байх юм бол та нар надад арван адуу өгөөрэй” хэмээжээ. Ингээд тэд мөрий тавилцаад харуй бүрий болуут мөнөөх гармын ойролцоо ирсэн байна. Тэгэхдээ Осоржамц мөрийгөө батлахын тулд бусдыгаа наахан талд нь нуугдуулаад “За та нар тэр хүнийг надтай ноцолдоод эхэлбэл шууд хүрч ирээд надад тусална шүү. Хэрвээ намайг нэг цохиход тэр алга болчих юм бол түүнийг хий үзэгдэл гэж итгээрэй” гэж хэлээд өөрөө “Амь солилцох гарам” руу дөхөж очжээ. Тэгтэл цаанаас нь мөнөөх улаан дээлтэй хүн гэнэт давхин гарч ирээд “Чи цаад шөнө намайг гэнэдүүлж байгаад миний гар руу ташуурдсан хүн мөн байх шиг байна. Хоёулаа одоо ёстой жинхэнээсээ амь солилцоно доо” гээд түүн рүү улаан галзуу юм давхиж ирээд мориноос нь гуд татан унагаж, өөрөө хойноос нь буугаад гарман дээр ноцолдож гарчээ. Энэ үед наана нуугдаж байсан хүмүүс тэр зүг рүү хуйлраад Осоржамцад тусалсан бөгөөд мөнөөх улаан дээлтэй хий үзэгдэл гээчийг тэд барьж аваад бодит хүн болохыг нь мэдээд ихэд гайхаж байсан гэдэг. Тэр хүн нь шоронгоос оргож боссон “Хоовон” Дангаа гэгч цуутай хулгайч байж. Мань эр эрт цагийн улаан дээлтэй хий үзэгдлийн дүрд тоглож ганц нэгээрээ яваа хүнийг айлгаж цочоон дээрэм хийх санаатай байсан юмсанж. Ингээд тэд “Хоовон” Дангааг цагдаад барьж өгсөнөөр тэр

цагаас хойш Шаргиатын гарман дээрхи улаан дээлтэй хий үзэгдэл ч бай, бодит хүн ч бай бүрмөсөн арилсан гэдэг.



## Дарьгангын сүүлчийн сайн эр “Төлгөн” Жамбалдорж

“Төлгөн” Жамбалдорж нь эрт цагийн Дарьгангын шилийн эрчүүдийг бодвол харьцангуй сүүлийн үеийнх, бараг орчин үеийнх ч гэж хэлж болохоор... Гэхдээ л дөч, тавиад оны үед ид шижигнэж явсан, наяд оны үед нас барсан гэж бодохоор бас л эртний хүн болоод явчихна. Сүхбаатар аймгийнхан түүнтэй холбоотой элдэв адал явдлын тухай олон зүйл хүүрнэсэн байдаг. Жишээ нь нэгэн цагт “Төлгөн” Жамбалдоржтой уулзаж учирч явсан Дарьганга нутгийн уугуул, өндөр настан С.Дамдинсүрэн гуай “1930-аад оны үед намайг Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын бага сургуульд сурч байхад “Төлгөн” Жамбалдоржийнх гэж нэлээд олон малтай баян айл байсан. Харин Жамбалдорж гэдэг хүн нь шоронд байдаг байлаа. Тухайн үеийн албан тушаалтанууд нэг өдөр энэ айлын малыг хурааж сумын төв дээр дуудлага худалдаагаар зарж байхыг би нүдээрээ үзэж билээ. Эх нь Унидаа гэдэг ануухан хөгшин байсан. Тэр л гэрээ авч явдаг байсан даа. Жамбалдорж бол яах аргагүй Дарьгангын цуутай шилийн эр. Түүний тухай хот хүрээгүй л ярьдаг байлаа. Мань хүн 1950 оны дунд үеийг хүртэл шоронд байсан. Жамбалдорж гуай 1970-аад оны үед надад хуучлахдаа “Би Батгүн шоронгоос гурван удаа оргосон. Гол шалтгаан нь ээжтэйгээ уулзах зорилготой. Шоронгоос оргосон хүнд бэлэн юм юу ч байдаггүй. Хувцас хунар, унаа морь, эмээл хазаараас эхлээд юм юм хэрэгтэй болно. Тэр бүхнийг хулгайлж авахаас өөр аргагүй. Би оргоод шууд нутаг явдаггүй байлаа. Зүгээ буруулаад голдуу Архангай чигт гардаг байсан. Миний хойноос гарсан эрлийнхэн дан зүүн урагшаа Дарьганга руу чиглэнэ. Тэгээд би тэднийг Дарьгангад очоод эрэл нь мухардаад наашаа хөдлөх үед нь зөрөөд нутаг руугаа явдаг байлаа. Ингэхийн тулд гурав дөрвөн сайн морь хагсрааж, Шаргаморьт, Чингэлтэйн модтой уулаар орогнож байгаад нэг шөнө, хоёр өдөр давхиад л ээж дээрээ яваад оччихдог байлаа. Гэртээ очоод хэд хонож байтал төлөөлөгч хүрч ирээд л намайг бариад явна. Би эсэргүүцдэггүй байсан. Ээжтэйгээ уулзана гэсэн зорилгоо биелүүлчихсэн болохоор цаашаа оргож босно гэж үгүй. Нэг ёсондоо төлөөлөгч хэзээ ирэхийг хүлээгээд л гэртээ сууж байдаг байлаа. Тэгээд шорондоо ирээд л хэдэн жил нэмүүлнэ дээ. Би айлын адуунаас сайн морийг шууд олж барьж чаддаг байсан. Андашгүй дээ. Харин нутгийн гол усыг гатлахад нутгийн морьд л гатална. Сэлэнгэ, Тамирын голыг гаталдаг морь Туул руу орж өгөхгүй. Харин Туул орчмын морь бол бусдыгаа дагуулаад л гараад явчихна. Би ингэж явахдаа ганц ч хүний аминд хүрээгүй юм шүү. Оргож яваад шорондоо буцаж ирэхдээ нөхөддөө тамхи тариа, идэж уух юм авчирна. Хуягууд тамхи оруулдаггүй байлаа. Гэсэн ч би бүхэл бүтэн дүнсэн тамхийг үстэй дээлэнд задалж тараагаад ордог байсан. Тэгээд дээлээ гүвж сэгсрээд л тамхитай болчихно. Миний сүүлчийн орголт бол хэн хүний санаанд ормооргүй, санаанд орлоо ч гүйцэтгэж чадахааргүй айхтар орголт байлаа. Тэр нь юу гэвэл шоронгийн пийшингийн яндангаар гарсан явдал юм. Тэгээд байшингийн дээвэр дээрээс гяндангийн хашааны төмөр торны цаана ойрхон байсан гэрлийн шон руу үсэрчихэж билээ” гэж дурсч байлаа. Дөч, тавиад оны архивын материалыг шүүж үзвэл “Төлгөн” Жамбалдорж гуайн хэрэг явдал лавтай гарах байх. Жамбалдорж гуай тавиад оны үед шоронгоос суллагдаад нутагтаа очиж өөрөөсөө 20-иод насаар дүү Норжмаа гэдэг бүсгүйтэй гэр бүл болж арваад хүүхдийн эцэг болсон. Мань хүн бүрэн томоожоод нэгдэлд мал маллан амьдарч байгаад 1970-аад оны үед нас барсан даа” гэж өгүүлсэн юм. “Төлгөн” Жамбалдорж хэмээх шилийн эрийн өргөмөл дүү Галсан-Осорын Аюуш хэмээх 80 орчим насны өвгөн эдүгээ Сүхбаатар аймагт амьдарч буй бөгөөд тэрбээр саяхан Улаанбаатарт ирэхдээ ахынхаа тухай доорхи яриаг өрнүүлсэн юм.

“Ар халхын шилийн сайн эрчүүд” гэдэг номыг уншлаа. Сайхан ном байна. Энэ номонд миний ах “Төлгөн” Жамбалдорж орох ёстой хүний нэг. Уг нь би ахынхаа тухай өөрөө ном бичих гэж бодож явдаг хүн. Даанч нас дээр гарчихлаа даа. Дээхэн үед манай Дарьгангад “Бух” Далай гэдэг сайн бөх байсан. Түүний хүү Галсан-Осор гэж мөн л сайхан барилддаг, Алтан-Овооны наадамд хэд хэдэн удаа түрүүлсэн бөх хүн байлаа. Галсан-Осорын хүү “Төлгөн” Жамбалдорж. Би болохоор Жамбалдоржийн өргөмөл дүү. “Бух” Далай гэдэг овогтой. Урьдын бидний үеийн улс насны улс өөрийн эцгээр овоглодоггүй, эцгийнхээ эцгээр овоглодог байлаа. Миний эцэг Галсан-Осор хорь, гучаад оны үед урагшаа жин тээж өөрийнхөө чадлаар баяжсан хүн. Харамсалтай нь гучин хэдэн онд нударган баян гэдгээр хамаг хөрөнгөө хураалгаад До яамныханд баригдаад явсан. Эргэж ирээгүй. Яаж нас барсаныг нь бид одоо болтол мэддэггүй юм. Эцгийгээ баривчлагдаад явсаны дараа 18 настай Жамбалдорж ах маань цэрэгт татагдсан. Дараа нь нутагтаа очоод Дорнод руу ердийн хөсгөөр жин тээсэн. Тэгээд нэг өвөл жин тээж явахдаа таньдаг хүнийхээ калибрь бууг авч яваад алга болгосоноор хэрэгт татагдсан. Тэр үед дайн байлдаантай, цаг түгшүүртэй байсан болохоор хууль чанга байж. Ах маань галт зэвсэг үрэгдүүлсэн гэдгээр гурван жил зургаан сарын ял сонссон. Ингэж л анх буруу замаар орсон хүн. Тэрнээс биш хүн алж, хүрээ талаагүй. Үүнийг бас тодруулах нь зөв байх. Дээхэн үед Дорнодоос хойш Онон голын хөвөөн дээр, Орос, Монголын хилийн зааг дээр нэг том хатуу чанга шорон байсан. Ах маань энэ шоронд хоригдож байхдаа хэд хэдэн удаа оргож ялаа нэмүүлсээр байгаад 20 гаруй жил ял эдэлсэн хүн. Түүнийг Сүхбаатар аймгийн дээхэн үеийн хөгшчүүл “Дарьгангын сүүлчийн сайн эр” гэж үнэлдэг байлаа. Шоронгоос оргож босч явахдаа шилийн эрийн замаар явчихдаг байснаас ийм алдрыг хүртсэн болов уу. Гэхдээ наранд биш шоронд илүү алдаршсан хүн л дээ. Тэр үеийн чанга дэглэмтэй шоронд 18 аймгаас цугларсан жинхэнэ сайн эрчүүд ял эдэлдэг байж. Энэ айхтар шилэгдмэл эрчүүдээс “Төлгөн” Жамбалдорж гэдэг хүн ганцаараа онцгойрдог байсан тухай хожим олон хүн ярьж байхыг би дуулж сонссон. Магадгүй бараг үүгээрээ сайн эр гэж алдаршсан байх. Ах маань чангалангийн хорих газраас гурван удаа оргож нутагтаа очсон хүн. Ээжийнхээ дэргэд хоёр гурав хоночихоод л аймгийн сэргийлэхэд хүргэгдээд очдог байлаа. Тэгсэн хэрнээ өөрөө шорондоо байх дуртай. Ардын хувьсгалын үе үеийн ойн баяр наадмаар түүнийг суллах тушаал хэд хэдэн удаа гарч байсан гэдэг. Гэвч ах маань өршөөлөөр суллагдахаа мэдмэгцээ наадмын урд орой ямар нэгэн хэрэг хийчихдэг байв. Гэхдээ хүн алж, хүрээ талаагүй. Хамт ял эдэлж байсан хүмүүс нь “Маргааш суллагдах гэж байж чи яаж байгаа юм бэ” гэхэд “Миний гарах цаг болоогүй ээ” гэдэг байж. Цаанаа чухам ямар санаа агуулдаг байсныг бүү мэд. Ямар ч гэм зэмгүй эцэг нь хилсээр баригдаад сураггүй болсонд өширхдөг ч юмуу, тухайн үеийн нийгэмтэй тэмцэнэ гэдэг ч юмуу тийм нэг үзэл бодол сэтгэл зүрхэнд нь шингэчихсэн юм шиг байгаа юм. Тэгээд л орон шоронгоос дахин дахин оргож ялаа нэмүүлээд, нэг ёсондоо үүнийгээ бурангуй төрд тэрсэлж байна гэж боддог байсан бололтой. Манайх тийм ядуу айл байгаагүй. Ээж маань мал маллаад Сүхбаатар аймагтаа баян айлын тоонд ордог байсан. Ахад бол дутагдах гачигдах юм байгаагүй. Тэгсэн хэрнээ шоронгоор яваад байдаг. Нэг удаа би ээжээсээ “Манайд мал хуй гээд юм юм л байна. Ах яагаад шоронгоор яваад байдаг юм бэ” гэж асуухад “Ахын чинь буруу биш ээ. Энэ ерөөсөө удмын юм. Аавын чинь аав “Бух” Далайн төрсөн дүү “Хар” Дугарсүрэн гэж Дарьгангын цуутай шилийн эр байсан юм. Ах чинь удмаа дагаж байгаа нь тэр” гэдэг байлаа. Ээж маань ахыг чангалангийн хорих ангид байхад нэг удаа эргэж очиж л дээ. Тэгээд өлсгөлөн хоригдолуудыг хараад сэтгэл нь шимширч дарга дээр нь ороод “Энэ хүүхдүүд миний хүүгээс ялгаа юу байхав. Хүнд ажил хийгээд их өлсдөг юм байна. Би арван аттай ирсэн. Эд нарыг нэг сайн

хоолломоор байна. Танай хорих анги миний арван атыг нядалж янзлаад хоригдолуудыг хооллочих арга байна уу” гэхэд шоронгийн дарга “Та л өөрөө арван атаа өгнө гэж зөвшөөрч байгаа бол бид зохицуулаад өгч чадна” гэсэн байна. Ингээд ээж маань чангалангийн мянгаад хоригдолыг арван атаараа нэг сайн цатгаж байсан гэдэг. Үүнээс хойш ээж маань хоригдолуудыг хэд хэдэн удаа ингэж хооллосон. Жилд хоёр ч удаа эргэж очдог байлаа. Тэр болгонд баахан ат хөтлөөд явна. Ямар сайндаа л чангалангийн хоригдолууд “Дарьгангын Төлөгний ээж ирээсэй. Нэг сайн гэдэс гарах юмсан” гэж ярих болсон гэдэг. Ах маань өөрөө бас өлсгөлөн хоригдолуудыг хооллохдоо гаргууд байж. Шоронгоос түр оргож гараад л баахан хүнс олоод ирдэг, ялтанууд түүнийг нь идэж гэдэс гардаг байсан байгаа юм. Сүүлдээ түүнийг хуягууд ч тоохоо байж. Өглөө нь “Дарьгангын Төлгөн явчихсан уу” гэснээ оройхон “Дарьгангын Төлгөн ирчихсэн үү” гэх жишээтэй. Ах маань олон хоногоор оргож явах үедээ хэд хэдэн аймагт танил талтай болж, нэрд гарсан байдаг. Ялангуяа зүүн аймгуудад бол их нэртэй байсан. 1956 онд шоронгоос суллагдаад хань ижилтэй болж арван хүүхдийн эцэг болсон. Мал маллан амьдарч байгаад 1982 онд өөд болоход нь би ясыг нь барьж байлаа. Нас барсаных нь дараа намайг ажлын шугамаар зүүн аймгуудаар явж байхад тэр үеийн хөгшчүүд “Дарьгангын сайн эрчүүд манай муу “Төлгөн” Жамбалдоржоор л дууслаа даа” гэдэг байлаа. Эрт цагийн Дарьгангын сайн эрчүүдээс хамгийн сайн нь “Ухаа” Балжир гэж манай нутгийн хөгшчүүд ярьдаг байсан. Энэ хүн залуу байхдаа амьдрахын эрхэнд нутгийнхаа нэг том хийдээс алтан бурхан хулгайлчихаж. Хийдийн жасын нярав нь даншигийн цолтой Намсрай гэдэг бөх хүн байж. Тэгээд энэ хүн бурхан дутаасан хэрэгт орж л дээ. “Чамд бурханыг авсан гэж багцаалах хүн байна уу” гэж асуухад Намсрай “Манай энд Балжираас өөр бурхан хулгайлах хүн байхгүй” гэснээр “Ухаа” Балжир баривчлагдсан байна. Балжир төрөлхийн гүйлгээ ухаантай, сэргэлэн хүн байсан гэдэг. Түүнийг байцаахад “Тиймээ, би бурхан авсан. Гэхдээ би авах юу байхав, танай нярав Намсрай ах л надад нэг бурхан өгөөд намайг борлуулаад аль гэсэн. Би бурханыг нь зараад өөрийн хувиа авсан. Тэрнээс биш би бурханыг хулгайлж аваагүй” гээд мэлзчихэж. Намсрай мэдээж үгүйсгэж таарна. Тиймээс тамгын газрын тахрууд Балжир, Намсрай хоёрт есөн эрүү тулгахаар болж. Тэр үед Балжир хорин хэдтэй, Намсрай дөчин хэдтэй байж. Хэн хэн нь хэрэг хүлээхгүй байсаар есөн эрүүний зургаа, долоо хавьцаа ирж. Тэр нь нөгөө “Хонгор азарга” гэдэг нь юмуу даа. Зальтай, сэргэлэн хүн чинь ухаанаар л бүгдийг дийлдэг юм байна шүү дээ. “Ухаа” Балжир “Хонгор азарга”-нд орох үедээ яг л адуу шиг хангинатал янцгаагаад толгойгоо хаялаад сүйд болжээ. Тэр үед Намсрай бодож л дээ. “Хөөрхий энэ залуу хүүхэд дэмийрч байх шиг. Надад хурааж хуримтлуулсан жаахан юм байна. Ерөөсөө би хэрэг хүлээгээд тэр бурханыг нь төлье” гэж бодоод алтан бурханы хэргийг өөр дээрээ авч “Ухаа” Балжирын аминд орж байсан гэдэг. Энэ түүхийг манай Дарьгангын хөгшчүүд байнга л ярьдаг юм. “Ухаа” Балжир хийдээс хулгайлсан алтан бурханаа зараад мундашгүй баяжиж хөлжсөн гэдэг. Хорь, гучаад оны үед Дарьгангын хамгийн баян хүн байж. Сүрхий ухаантай, наймааны одтой, арга зальтай. Мал сүрэг гэж тоймгүй олон. Хэд хэдэн айлаар малаа хариулуулдаг. Нэг айлд гэхэд л гурав дөрвөн зуун мал байх жишээтэй. Намар арван сард хот руу мал нийлүүлэхээр тав зургаан зуугаад хонь тууж явдаг. Тэгэхдээ хонь болгоны хүзүүнд жижигхэн хүүдий уяд арван ширхэг хурууд ааруул хийчихдэг байж. Тэгээд хотод хонио тууж ирээд хүзүүнээс нь ааруулаа авахад гурав дөрвөн тэрэг ачаа болох жишээтэй. Энэ их цагаан идээгээ Да хүрээний зах дээр аваачаад зарчихна. Хэрвээ хаа холын Дарьгангаас дөрвөн тэрэг цагаан идээ хотод авчирлаа гэхэд хүн хөлслөхөөс эхлээд маш их зардал гарна шүү дээ. Тэгэхэд ердөө тууж яваа хонио ашиглаад л цагаан идээгээ хотод авчраад зарчихдаг байсан байгаа юм. Ардын хувьсгалын үед “Ухаа” Балжир

дарьгангачуудад их том гавьяа байгуулсан хүн. Тэр үед цагаантаны цэргүүд улаантануудаас зугтаагаад замдаа дайралдсан хот айлаас унаа мал авч унаад, нохойг нь буудаж алаад, авдар савыг нь онгичиж өнгөтэй өөдтэйг нь хамаад, зарим газарт бүр аллага үйлддэг байж. Ингэж зугтаж явсан цагаантанууд Сүхбаатар аймгийн нутгаар дайрч өнгөрсөн байдаг. Тэр үед “Ухаа” Балжир жинхэнэ ухаан зааж цагаантануудыг өөрийнхөө нутаглаж байсан газраас холуур тойруулаад цөлөөр хил давуулж байсан гэдэг. Өөрөө лут баян хүн болохоор хувиасаа унаа мал бэлдэж нутгийнхаа хамаг л эрчүүдийг дайчлаад морин өртөө маягийн юм зохион байгуулсан байгаа юм. Тэд нар нь “Цагаантан одоо тийшээ явж байна, наашаа зүглэж байна” гэж мэдээлэх жишээтэй. Тухайн үед Дарьгангын шилийн эр “Хангай” Базарын хүү “Хавчиг” Саарай буюу Базарын Хавчиг Мөнххаан сумын нутагт байх Далай вангийн шоронд ял эдэлж байсан байна. Түүхээс үзэхэд Базарын Хавчиг шоронд орохоосоо өмнө Өвөр Монголын нутгаар хөндлөн гулд тэнэж явсан байдаг. “Цагаантанууд манай нутгаар дайрч өнгөрөх гэж байна, яанаа, ийнээ” гээд шуугилдаад явчихад Базарын Хавчиг “Би ямар хүн алж хүрээ талсан биш. Намайг суллаад тавьчих. Би цагаантануудад зам зааж өгье. Тэднийг нутгаараа дайруулалгүй цөлөөр гаргаад хаячихаж чадна” гэсэн байна. Ингээд “Ухаа” Балжир, Базарын Хавчиг гэдэг хоёр сайн эр цагаантануудыг цөлөөр гаргаж байсан гэдэг. Энд “Ухаа” Балжир мөн л ухаан зарсан байгаа юм. Өглөө дөнгөж нар ургаж байхад нарны эсрэг талаас гарч ирж байгаа хүнд нарны тоос их хачин харагддаг юм байна. Балжир цагаантануудын замд үүнийг ашигласан байдаг. Нарны тоосон дунд хүмүүсээр адуу мал хөөлгөж туулгаад, баахан ингэ ботгыг салгаад, нөгөөдүүл нь туйлж, буйлалдаад яг л дайн болж байгаа юм шиг харагдуулсан байгаа юм. Тэр үед цагаантанууд монгол газарчинтай, хэлмэрчинтэй явдаг байж. Тэгээд яг дайн болж байгаа юм шиг тоос татаад ирмэгц “Ухаа” Балжир зайдан морь унаж цагаантануудын өөдөөс давхиж очоод “За ахан дүүс минь, манай хот айлыг аварч хайрла. Улаантанууд бөөнөөрөө дайрч орж ирээд манай хот айлыг сүйд хийж байна. Та нар тэрийг хараач. Мал хөрөнгө бол өнгөрсөн. Хүүхэд, хөгшидөө авармаар байна. Та нар зэр зэвсэгтэй улс байна, туслаач” гээд л сөхрөөд ойчсон гэдэг. Улаантануудаас зугтаж амь гарах гэж явсан цагаантануудын нүд орой дээрээ гарна биз дээ. Тэгээд “Улаантан” гэдэг үгийг сонсоод, дайн болж байгаа мэт тэр их тоос, тэмээ малын тэр их бужигнааныг холоос хараад цагаантанууд шууд л замаа буруулсан байгаа юм. Энэ үед нь тэднийг Базарын Хавчиг замчлаад цөл рүү аваад орсон байдаг. Үүний ачаар дарьгангачууд цагаантануудаас ямар ч хохирол амсаагүй гэдэг. Энэ бол “Ухаа” Балжир, Базарын Хавчиг хоёрын гавьяа байлаа. Харин Базарын Хавчиг цагаантануудыг замчлан урагшаа гараад эргэж ирээгүй гэдэг юм. Энэ тухай Дарьгангын хөгшчүүд ярьдаг байлаа. Мөн 16 настай байхдаа “Хангай” Базарын дагалдан адуучинаар орж байсан Өлзийбаяр гэдэг хүн ярьдаг байлаа. Д.Маамын “Газар шороо” романд Өлзийбаяр гэдэг адуучин залуу гардаг. Энэ чинь бодит хүн. Өлзийбаяр гуай 90 хүрч байж нас барсан. Мөн “Газар шороо” романд гардаг шилийн эр Орлойн хөх Доодой гэдэг чинь бодит хүн. Миний ахыг өргөж авсан ная гаруй настай Даадяа гэдэг эрдэмтэн хүн одоо хотод байна. Энэ хүнийг өргөж авсан Жамсрандорж гэдэг хүний авга ах нь Орлойн хөх Доодой. Жамсрандорж өвгөн далан есөн естэйдөө нас барсан. Хөгшин нь саяхан 93-тай нас барлаа. Би хоёулангийнх нь ясыг барьсан. Ер нь Дарьгангын шилийн эрчүүд гэвэл учиргүй олон. “Торой” Бандиас өмнө Дарьгангад Орлойн Шар гэж цуутай шилийн эр байсан юм байна лээ. Мөн “Хажиг” Хар, “Хув” Хар гэж байсан. Эд нар Хятадаас орж ирдэг жингийн цувааг дээрэмддэг байж. Энэ хоёрыг гараад ирмэгц хятадууд бүх юмаа хаяад зугтдаг байсан гэдэг. Дарьгангад нэг үе дандаа Т-гээр холбогдсон “Торой” Банди, “Тогос” Чүлтэм, “Торгон” Лхамсүрэн гээд долоон сайн эр байсан байгаа юм. “Тогос” Чүлтэм Дарьгангынх, “Торгон” Лхамсүрэн Хэнтийнх. “Ар

халхын шилийн сайн эрчүүд” номонд гуч, дөчөөд оны үед Хятадад тагнуул хийж явсан “Богино” Жалхааг ойр дотны хүмүүс нь “Дарьгангын сүүлчийн сайн эр” гэж онцолсон байна лээ. Тийм ч биз, үгүй ч биз. Гэхдээ “Богино” Жалхаад манай Дарьганга сумынхан жаахан тааруухан ханддаг юм. Энэ нь цаанаа бас учиртай. Жалхаагийн үед Дарьгангад “Хөх” Ханд гэдэг цуутай шилийн эр амьдарч байсан юм. Хоёулаа нэг хошууных. Энэ хоёрын дунд нэг хүүхний асуудал байдаг юм. “Хөх” Ханд нь гучаад оны үед эсэргүүний хэрэгт холбогдоод Өвөр Монгол руу дүрвээд явчихаж. Энэ үед “Богино” Жалхаа түүний эхнэрийг богтлоод авчихаж. “Хөх” Ханд үүнийг мэдмэгцээ улсын хилээр нууцаар орж ирээд “Богино” Жалхааг эзгүй хойгуур хүүхнээ аваад буцаад урагшаа гарчихсан байгаа юм. “Хөх” Ханд бол Дарьганга нутагт домог болсон шилийн эр байлаа. Тиймээс нутгийнхан нь түүнд их сайн. Харин До яамныхан түүнийг эсэргүү гэмт хэрэгтэн гээд үзэхгүй. Тийм учраас хэд хэдэн удаа тагнуулд яваад гаршчихсан “Богино” Жалхаа Дотоод яамны даалгаварыг биелүүлэх маягаар “Та нарын дайсан “Хөх” Хандыг би Өвөр Монголоос барьж ирье. Барьж ирж чадахгүй бол толгойг нь авчиръя” гэсэн байгаа юм. Нэг талаар эх орны даалгавар, нөгөө талаар богтлогдсон, булаалгасан хүүхнээс болсон өс хонзон байсан биз. Тэгээд ч тухайн үед хувьсгалын эсэргүүнүүдийг баривчлах кампанит ажил ид өрнөж байсан болохоор До яамныхан “Хөх” Хандыг баривчлах юмуу, устгах сонирхол их байсан байж таарна. “Богино” Жалхаа эндээс явахдаа Дарьгангын нэг сайн бөх Лувсаншарав билүү, хэн билээ нэг хүнийг даглуулж явсан байдаг. Хожим энэ хүн Дарьгангынханд бүх нууцыг дэлгэсэн. Мань хоёр Өвөр Монголд очоод “Хөх” Хандын байгаа газрыг мэдэж аваад шөнөөр барьж авахаар болж. “Хөх” Ханд таван ханатай гэртээ биш гадаах чингэлэг тэргэн дээрээ эхнэртэйгээ унтдаг байж л дээ. Тэгтэл “Богино” Жалхаа түүнийг гаднаас нь буудтал эхнэр нь тэр дороо нас барж, “Хөх” Ханд шархдангуутаа гэрээсээ бугаа авахаар босоод гүйж. Энэ үед Жалхаа түүнтэй барилцаад авгал “Хөх” Ханд бөх Лувсаншаравт хандаж “Чи энэ хэрэгт битгий оролцоорой. Бид хоёр нэг нутаг усны улс. Эр хүний ажил тусдаа. Бид хоёр халз үзнэ. Хэн нь яахыг харж бай” гэж хэлсэн байгаа юм. “Хөх” Хандын хувьд биедээ шарх авчихсан их л хэцүү байдалтай байсан гэдэг. Гэсэн ч тэр Жалхааг бараг дийлчих гээд байж. Лувсаншарав “Хөх” Хандыг дотроо хэдий өрөвдөж байсан ч нэгэнт улс орны даалгавар биелүүлж явсан болохоор яах ч арга байсангүй. Тэгээд тэр аргагүйн эрхэнд “Хөх” Хандыг ташуураараа цохиж унагасан гэдэг. Ингэж Жалхаа “Хөх” Хандын толгойг авчирсан байгаа юм. За тэгээд ярьж болохооргүй өөр юм бас бий. Бүгдийг тоочих аргагүй. Ер нь үнэн юм үнэнээрээ сайхан л даа. “Хөх” Хандын хүү Өлзийхутаг ч билүү, Өлзийбаяр ч билүү жар гаруй насны нэг хүн одоо Дарьгангад байдаг юм. Энэ хүн залуу байхдаа бөх Лувсаншаравын ярианаас эцгийнхээ тухай дуулж сонсчихоод “Богино” Жалхааг ална гэж занаж байсан удаатай. Тиймээс Жалхаа ийм тийм юмнаас болоод Дотоод яамны хамгаалалтанд орж Улаанбаатарт ирж суурьшсан гэдэг юм. “Хөх” Ханд, “Богино” Жалхаа хоёрын энэ явдал бол жинхэнэ үнэн түүх. Миний насны улс бол андахгүй. Одоо харин миний үеийнхэн цөөрчихлөө. Гэхдээ үр хүүхдүүд нь мэднэ. Ер нь аливаа нэг сонин содон, дуулиан шуугиантай үйл явдал нутгийн олны дунд үе дамжин яригдсаар байдаг шүү дээ.

## Хятадын эсрэг үзэлтэн “Хэлэмгий” Жамц

Эрт цагаас эхлэн Монгол улсын газар шороонд эзэн суухыг санаархсаар ирсэн хятадуудыг манай өвөг дээдэс янз бүрээр нэрлэж, тэдэнд зориулж олон арван зүйр цэцэн үг зохиосоор ирсэн байдаг. Хятадын хорон санаат бодлогыг илчлэн үр хойчдоо учирч болзошгүй аюулаас сэрэмжүүлсэн тэдгээр зүйр цэцэн үгс одоо ч бидний зүрх сэтгэлд хадгалагдсаар байдаг билээ. Өвөг дээдсийнхээ үлдээсэн зүйр үгсийг өнөө үетэй харьцуулан бодоход тэд ирээдүй цагийг аргагүй л зөгнөж хэлсэн гэлтэй. Буруу санаа өвөрлөсөн хятадуудыг өвөг дээдэс маань янз бүрээр нэрлэдэг байв. Тухайлбал “Цагаач”, “Хужаа”, “Хунхууз”, “Шушмаа”, “Жунгаа”, “Жанаг”, “Луухаан”, “Зангууд”, “Данжаад”, “Доншуур”, “Амбан”, “Гамин”, “Маймаа”, “Дотор хүн” гэх мэт. Хятадууд манай ард түмнийг хэрхэн доромжилж, хэрхэн зальдаж, хамаг л муу муухай юмаа шингээсний илрэл нь дээрхи нэрс болой. Хэрвээ хятадууд эрт цагаас эхлэн манай улсад үнэнчээр тусалж, сайхан сэтгэлээр хандсаар ирсэн бол монголчууд тэднийг юу боллоо гэж ингэж олон янзаар нэрлэх билээ дээ. Дээрхи нэрсүүдэд олигтой үг ганц ч үгүй. Зарим нь бүр хараалын үг мэт сонсогдохыг яана. Эртнээс янагш манж, хятадуудад ийнхүү нэр хоч өгч, зүйр цэцэн үгс зохиосоор ирсэн хүмүүсийн томоохон төлөөлөл нь тэдний өстөн дайсан болох шилийн сайн эрчүүд, Манжийн эсрэг тэмцэж явсан эх орончид байдаг. Гэхдээ чухам хэн гээч шилийн эр, хэн гээч эх оронч ямар үг хэлж, ямар зүйр үгс зохиосон нь тодорхой бус. Яг л нөгөө ардын дууг зохиосон хүний нэр нь тодорхойгүй байдаг шиг. Ямартай ч гучаад оны үед амьдарч асан “Хэлэмгий” Жамц хэмээх шилийн эр өөрийнхөө болоод өөрийнхөө өмнөх үед зохиогдсон хятадуудтай холбоотой зүйр цэцэн үгсийг цээжээрээ мэддэг, түүнийгээ хаа явсан газраа хашгирч явдаг Хятадын эсрэг үзэлтэн байсан тухай сонирхолтой мэдээлэл олдсон юм. Түүний зээнцэр болох Т.Долгормаа хэмээх тавь гаруй насны эмэгтэй эдүгээ Чингэлтэй дүүргийн 10-р хороонд амьдарч байна. Долгормаагийн эцэг Ж.Төмөрбаатар тавь, жараад оны үед өгүүллэг, туужийн хоёр гурван ч ном хэвлүүлж явсан манай ахмад зохиолчдын нэг байж. Ж.Төмөрбаатар агсан эцэг Жамцынхаа үүх түүхийг сайн мэддэг, тэр ч байтугай гуч, дөчөөд оны үед цээжээрээ хэлдэг байсан зүйр цэцэн үгсийг нь тэмдэглэж аваад үлдчихсэн байх бөгөөд тэдгээр үгс нь өнөө цагт ч үнэ цэнээ алдаагүй байна. Ингээд “Хэлэмгий” Жамцын хэлж ярьдаг байсан зүйр цэцэн үгсээс сийрүүлье. “Хятад хүнд ханийн жаргал үгүй, өвөрлөгч хүнд өврийн жаргал үгүй” гэдэг зүйр үг байна. Хорь, гучаад оны үед монгол хүүхнүүдийг хөгшин луухаанууд өнгө мөнгөөр өөртөө татаж янхан, хар тамхичин болгоод эцэст нь гудамжинд хөөж гаргаж байсан баримт олон бий. Өнөө үед ч энэ үг биелэлээ олсоор байгаа билээ. Баян гэлтгүй хоосон хятад эрийг дагаж Хятадад очоод хаягдсан явдал 1990 оноос хойш олон удаа гарсан. Ер нь хужаануудтай суугаад сайн сайхан амьдарсан монгол бүсгүй тун ховор байдаг. “Хятад хүн дэлхийн бөөс, эрлийзүүд бол хуурс нь. Тэд бүхний биеийг загатнуулдаг” гэсэн зүйр үг өнөө үед мөн л биелэлээ олоод байгаа. Бидний өвөг дээдсийн сануулсанаар хятадууд эдүгээ дэлхийн бөөс болж хувираад бүхний биеийг загатнуулсаар байгаа билээ. “Чоно дагасан жингэр аюултай, хужаа дагасан хүүхэн аюултай” гэдэг зүйр үг байна. Дээхэн үеийн хужаа дагасан хүүхэн есөн шидийн муу юм сурч цэвэр ичимтгий монгол эмэгтэйчүүдийг хүртэл өөрсдийнхөө эгнээнд татан оруулсан гашуун туршлага зөндөө бий. “Хар хятад хаягаа хадрахаас буцахгүй, хамтрах бол сэрэмж хэрэгтэй” гэдэг зүйр үг Монгол улсын тусгаар тогтнолын төлөө тэмцэж асан Амарсанаа, Чингүнжав нарын үед үүссэн болов уу. Өнөө цагт энэ үг бидэнд хамгийн сэрэмжлүүштэй сургаал болж байгаа ч манайхан хятадуудтай сүжрэх

нь их болсон. “Данжаад бараа зээлдүүлж, дажныхаа хүүг хождог”. Хорь, гучаад оны үед монголчууд данжаад нараас бараа зээлж аваад зарим нь хүүгийнхээ хүүд дарагдан модоо барьж байсан түүхтэй. Харин манай эх оронч сэтгэлгээтэй шилийн эрчүүд баян данжаад нарын өрийн дансыг шатааж ядарч зүдэрсэн олон хүнд буян үйлддэг байсан гэдэг. “Ашиг бодохгүй данжаад гэж үгүй, алт хураахгүй маймаа гэж үгүй” гэдэг зүйр үг мөн л дээрхтэй адил. Монголчууд хөрөнгө зоорь хураахаасаа илүү өнөөгийнхөө амьжиргааг л боддог. Харин данжаад нар заавал алт мөнгө хурааж байж л санаа нь амарна. Зарим нь үхэхдээ хүртэл алт мөнгөө нуугаад нүд аньдаг байлаа. “Хятад хүн ханын нүхээр багасч ордог ч хаалгаар багтаж гарахгүй болдог”. Энэ ёстой үнэн шүү. Хятадууд саваа мод тулсан, дэрсэн шаахайтай амьтад л манай жинчдийг даган орж ирсэн байдаг. Тэгээд хоёр гуравхан жилийн дараа цулайтлаа баяжаад ёстой л хаалгаар багтаж гарахгүй болдог байж. Гэхдээ тэд ханын нүхээр багасч орж ирсэнээ мартчихдаг. “Хаврын тэнгэр шиг ааштай, харийн данжаад шиг санаатай” гэдэг зүйр үгийг дотуур тамиртай, өмхий санаатай хүнд зориулж хэлдэг нь яг л оносон мэт. Өнөөдөр манай нийгэмд зах зээлийн араншинг дагаад ийм хүн хэт олшроод байгаа. “Хахууль, хятад хоёр ихэр төрсөн ах дүү, хамхуул, эрэг хоёр тохирч төрсөн эгч дүү” гэдэг зүйр үг бас л нэгийг хэлээд байна. Гэмт хэрэгтэн хятадууд Монголд орж ирээд юуны өмнө цагдаагийн хурандаа нарыг хахуульдах гэж оролддог, цаадуул нь ч хятадуудаас авсан хахуулиараа хагарталаа баяжсан тухай сонин хэвлэлээр бичигдээд байгаа. Манай цагдаагийн хурандаа нар тэтгэвэрт гарахдаа Монголд үйл ажиллагаа явуулдаг Хятадын пүүс, компаниудад хуулийн зөвлөхөөр очоод тэдний бүхий л муу муухай зүйлийг хамгаалж хаацайлдаг “мода” дэлгэрээд байгаа нь “Хахууль, хятад хоёр ихэр төрсөн ах дүү” гэдэг үгийг баталж байгаа хэрэг. Ер нь хятадууд эрх мэдэлтэнүүдийг хахуульдахдаа гаргууд улс. Монголын эртний хаадыг хүртэл хахуульдаж байсан баримт бий. Дарьгангын ноёдыг хүртэл хахуульдаад Монголын нутгаас газар тасдан авч байсан удаатай. Тийм ч учраас “Гахай, Хятад хоёр олширвол газрын хөрс олдохгүй” гэдэг зүйр үг бас төрөн гарчээ. “Хятад хүн хоног хоногоор хойморт гарна”, “Данжаад давраад хойморт, нохой давраад хотонд”. Эдгээр үг бас л үнэн. Хамгийн наад захын жишээг дурьдахад Монголын нутагт газар авч хашаа хатгасан хятад хүн хашаагаа жил бүр нэг алхмаар тэлээд байдаг. Тэгээд хэдэн жилийн дараа асар том хашаатай болчихсон, түүндээ ногоо тариад, тэр ч байтугай хашаандаа худаг гаргаж, газар доогуур хүртэл оромж хийчихсэн байх жишээтэй. Энэ бол хятадуудын ажилч хичээнгүй чанар яахын аргагүй мөн. Залхуу монголчууд харин үүнийг л сурах хэрэгтэй. “Хятад хүн эхэндээ хэлэн дээр чихэр түрхээд, эцэстээ шилэн дээр хутга тавина”. Энэ үг хориод оны хүрээ хүүхнүүдэд зориулагдсан болов уу. Учир нь хужаа нарын өвөрт ороод хэлэн дээрээ чихэр түрхүүлээд, эцэст нь шилэн дээрээ хутга тавиулсан хүрээ хүүхнүүд маш олон байдаг. Тэдгээр хүүхнүүдийн харуусал өнөөдөр ч давтагдсаар л байгаа. “Зандан унаа бөгсөнд муу, зальхай хятад үйлст муу”. Энэ нь монгол хүний нэр төр, үйлстэй холбоотой. “Бурхан болсон хүнийг буянаар үд, буруу санаат хятадыг зэвсэгээр үд”. Энэ үг эрт цагт дайн байлдаантай үед л үүссэн бололтой. Харин өнөө үед хятадуудыг зэвсэгээр бус ухаанаар л ялан дийлэх цаг болчихоод байна. “Маймаа хүн бачтай, мантуу гурил хужиртай”. Дээр үед хятадууд монголчуудад хулхи бараа шахдаг байсныг энэ үг гэрчилж байна. Эрээний хулхи барааны амтанд ороод байгаа өнөө цагийн ганзагын наймаачдад өвөг дээдэс маань энэ үгийг захиж үлдээсэн байж болох юм шүү! “Дорго хэмээх амьтан малын бөгс ухахдаа сурмаг, доншуур хэмээх наймаа хүний юм салгахдаа чадмаг”. Доншуур наймаа гэдэг нь айл айлаар явж юмаа зардаг, нэг ёсондоо гүйдэг наймаа бөгөөд манай ганзагын наймаачид үүнд яг тохирно. 1930-аад онд Дүүвэй гэгч хужаа эр доншуур наймаагаар хүчээ авч байсан бөгөөд тэрбээр дөрөв таван хужаа залууд нэг нэг хонины чанасан толгой өгөөд

“Энийг та нар тэмээ болгож ир. Тэгж байж та нар наймаачин болно шүү” гэдэг байж. Нөгөө залуус хониныхоо толгойг арга заль хэрэглэн байж боломжийн үнээр өгөөд, тэр мөнгөөрөө өөр ашигтай бараа худалдан авч түүнийгээ цааш нь дамлана. Дамласан мөнгөөрөө дахиад өөр ашигтай бараа авч цааш дамласаар нэг л мэдэхэд тэмээ хөтлөөд ирдэг байж. Монголчуудыг зальдахад ийм л амархан байжээ. Одоо ч мөн ялгаагүй.

“Эеэр татах хятад бодлого өнгөөр дамжин илэрдэг, эзлэн захирах хятад санаа мөнгөөр уламжлан гүнзгийрдэг”. Энэ үг өнөөгийн манай улс төрчдөд маш их хамаатай. Хятадууд Монголын уул уурхайн салбарт хүч түрэн орж ирээд байгаа нь ерөөсөө л дээрхи зүйр цэцэн үгтэй холбоотой. Яваандаа иймэрхүү маягаар “Мөнгөөр уламжлан гүнзгийрээд” байвал хятадууд Монгол улсыг ч худалдаад авч мэднэ. “Хялмаа ихэдвэл зуд, хятад ихэдвэл дажин”. “Мэдээжийн хэрэг. Хоёр миллиард шахам Хятад хүн дэлхийгээр нэг тарвал юу болох бол. Манайд бол таван зуун мянган хятад орж ирэхэд л дажин болох нь гарцаагүй. “Саруул ч гэсэн шөнө шүү дээ, сайн ч гэсэн хятад шүү дээ”. Хичнээн сайхан ааштай хятад хүн цаанаа ямар нэгэн хар санаа агуулж байдгийг өвөг дээдэс маань эрт цагаас олон удаа мэдэрсэнээс л энэ үг гарсан болов уу. “Сиймхий ч гэсэн гэр минь, сэгсгэр ч гэсэн ээж минь” гэдэг үгтэй энэ үг огт адилгүй. “Сайн ч гэсэн хятад шүү дээ” гэж сануулж байгаа нь цаанаа л нэг учиртай. “Марал илжигний туурай, маалинга шаахайн улыг, Хаалган даваанаас хойш халхын нутагт бүү гишгүүл”. Энэ бол аргагүй л эртний үг. Өнөөдөр ч гэсэн хүчин төгөлдөр байна. “Алтай Хянганы арын адууг, азарган илжиг хурааж чадахгүй, алдарт Монголын түмэн үрсийг арзгар хятад эзэлж чадахгүй”. Энэ үг шилийн эрчүүдийн амнаас гарсан үг болох нь ойлгомжтой. “Үхэх илжиг чонын өөдөөс байн байн орилох, үгүйрэх хятад Монголын өмнөөс дахин дахин уулгалах”. Энэхүү үг Чингисээс хойшхи үед л гарсан болов уу. Харин Чингис хаан “Өмнө зүгт Алтан улс байгааг өглөө бүр надад сануулж бай” гэж захисан хэдий ч түүний хожмын үр сад энэ үгийг хайхраагүйгээс эх нутаг руугаа хятадуудыг дахин дахин уулгалан довглуулах нөхцөл бүрдүүлсэн билээ. Ингээд бодоход өвөг дээдсийн маань захиж үлдээсэн зүйр цэцэн үгс аргагүй л ортой, үнэ цэнэтэй хэвээрээ байна. “Хэлэмгий” Жамц хэмээх сайн эр энэ мэтээр үнэхээр л хэлье гэж хэлдэг ясны үндэсний үзэлтэн байсан бололтой. Гучаад оны Дотоодыг хамгаалах газрын ажилтанууд түүний энэхүү хэлэмгий доломгой байдал, Хятадын эсрэг үзэл бодлыг нь ашиглаад Өвөр Монгол руу тагнуулын ажлаар явуулсан байгаа юм. “Хэлэмгий” Жамц тухайн үед Өвөр Монголын нутгаас адуу хөөж ирдэг, тэндэхийн баян хятадуудыг тонодог байж. Тэгээд энэ хэргээрээ Нийслэл хүрээний цагдан сэргийлэх газарт хэд хэдэн удаа байцаагдаж, эцэст нь арван жилийн ял авахаар болчихож. Чухам энэ үед нь Дотоодыг хамгаалах газрынхан түүний Өвөр Монголын нутагт хаалтгүй тэнэж явдаг чадал чансааг нь ашиглан тагнуулын ажилд хүчин зүтгүүлэхээр арван жилийн ялыг нь цагаатгаж байсан гэдэг. Ингээд шилийн эр “Хэлэмгий” Жамц хилийн чандад Хонгор хэмээх нууц нэрээр тагнуул хийх болжээ. Жараад оны үед түүний хүү Ж.Төмөрбаатар эцгийнхээ тухай “Гаанс бүлэглэл” хэмээх баримтат эсээ бичиж хэвлүүлсэн байх бөгөөд энд шилийн эрийн явдал суудлын тухай биш зөвхөн тагнуулын ажиллагааны нэгээхэн хэсгээс нь дурдсаныг сийрүүлье.

“...Тагнуулч Хонгор Дотоодыг хамгаалах газарт ирүүлсэн мэдээндээ “Дорнодын Баянтүмэн хотод суух Луузан нь Монгол улсыг тагнан турших ажиллагаа хийдэг. Түүний гол зорилго нь Зөвлөлтийн цэргийн байршил, зэр зэвсэгийн тоог зөв тодорхойлох даалгавартай юм байна. Луузан өөрийн цуглуулсан мэдээгээ Улаанбаатарт байгаа суурин тагнуулдаа илгээж тэндээс удирдамж авдаг” гэсэн байв. Энэхүү мэдээг аваад Дотоодыг хамгаалах газрынхан хоёр



жилийн турш мөрдлөг хийж, Луузан гэгчийг нууцаар тагнав. Гэвч нэг өдөр Луузан гэртээ алуулсан байлаа. Түүнийг буу сум, мэс хэрэглэлгүйгээр бие хамгаалах урлагаар дадлагажсан нэгэн хоолойнх нь төвөнхийг цааш чихэж хороосон байв. Луузангийн гэрт нэгжлэг хийхэд онц анхаарал татах зүйл олдсонгүй. Харин тэр хүзүүндээ ногоон пийсүү соруул сахиуслан зүүсэн нь Дотоодыг хамгаалах газрынханы анхаарлыг татжээ. Тэр үед иргэд бурхан ном хүзүүндээ зүүхээс бус гаансны соруул сахиуслан зүүдэггүй байлаа. Мөн үүнээс хэдэн сарын дараа “Чоно харайхын гол”-ын хилийн отрядын зурвас газраар хоёр этгээд хил зөрчиж яваад хилчидтэй буудалцаад нэг нь газар дээрээ алуулж, нөгөөдөх нь хөлдөө шарх аван хилчдэд баригдав. Амьд үлдсэн эрээс газрын зураг болон хятад гаансны толгой олджээ. Дотоодыг хамгаалах газрынхан энэхүү гаансны толгой нь талийгаач Луузангийн хүзүүнээс олдсон соруултай ямар нэгэн сэжмээр холбоотой байж магадгүй гэсэн дүгнэлтэнд хүрсэн байна. Тэгээд нягтлан үзвэл ямар нэгэн сэжигтэй зүйл олдсонгүй. Луу ороосон шармал толгойных нь чулуун нүд нь солонгорон гэрэлтэнэ. Харин тэр шархдаж баригдсан этгээд гаансны талаар юу ч ярилгүй байж байгаад судсаа ханаж амиа хорлох нь тэр. Энэхүү хэрэг ингээд мухардаад байж байтал Улаанбаатар хотын Усны гудамжинд Сандууз гэдэг хятад эр бусдад алуулсан байлаа. Түүнийг мөн л Луузангийн адил хоолойнх нь төвөнхийг чихэж алсан байхаас гадна гаансны мод хүзүүндээ сахиуслан зүүсэн байв. Дотоодыг хамгаалах газрынхан гурван цогцосноос олдсон бүхэл бүтэн гаанстай болоод бас л таг суучихав. Удалгүй Хятадын Тянжинь хотоос суурин тагнуул Хонгор ирүүлсэн нэгэн мэдээндээ “Улаанбаатар хотод суугаа Хятадын иргэн Сантыг шалгах нь зүйтэй. Түүний жинхэнэ нэрийг Пү Жи Шин овогтой Лү Лү гэдэг. 1880 оны хавар Бээжин хотын зүүн дүүрэгт төрж хийдэд шавилан сууж монгол, түвд бичиг сурсан. Нөгөөтэйгүүр Сантын тухай үүнээс өөр мэдээ баримт үгүй ч нэг сэжигтэй зүйл гэвэл түүнийг Японы Токио хотод сөрөг тагнуулын газар ажиллаж байсан гэсэн баттай бус мэдээ байгаа юм” гэсэн байв. Дотоодыг хамгаалах газрынхан ямартай ч нэгэн барих гогцоотой болоод Цантыг судалж эхлэв. Сант нь 1919 онд гамин цэргийн хамт Нийслэл хүрээнд ирээд 1921 он хүртэл Сю Шү Жан генералын зарцаар ажиллаж байсан байна. Тэгээд эзнээ нутаг буцахад нь хүрээнд суурьшин үлдэж бага шиг ногоо тарин амьдрах болсоныг Дотоодыг хамгаалах газрынхан судлан тогтоожээ. Төдөлгүй Сантыг баривчлахад гэрээс нь гаансны уут олдов. Дотоодыг хамгаалах газрынхан түүнийг нэг сарын турш эрүүдэн шүүхэд тэсэлгүй хэргээ хүлээж эхэлсэн байна. Сант анх Монголд Сю Шү Жан генералын суурин тагнуул болж үлдээд мэдээ материалаа Хятад руу тогтмол явуулж байтал Сю Шү Жаны чимээ сураг алдарчээ. Тэгтэл Хятадын Ардын Чөлөөлөх Армийн хурандаагаас тусгай удирдамж ирж цаашид Сантын ажиллагааг өөрийн биеэр удирдаж явуулахаа мэдэгджээ. Сант хожим шинэ эзнээ Японы Квантуны армид мэдээ материалаа худалддаг болохыг мэдсэн байна. Тэгэнгүүт мань эр өөрийн тагнуулч болох Луузан, Сандууз, Энх-Амгалан нарын тусламжтайгаар япончуудтай холбоо тогтоохыг оролджээ. Тэр үед Си Ду Хуа Сантаас мэдээ материалаа шаардаж удаа дараа холбоочин явуулаад эцэст нь сануулга болгож Сандууз, Луузан нарыг тусгай бэлтгэгдсэн алуурчинаар алуулсан нь тэр байж. Ингэснээр Сант Си Ду Хуагаас харилцаагаа бүрмөсөн тасалж япончуудад мэдээ материалаа зарахыг санаархаж эхэлсэн байна. Харин тэр шинэ эзнээ ч, түүний явуулсан алуурчныг ч мэдсэнгүй. Ийм нэгэн ээдрээтэй хэргийг Дотоодыг хамгаалах газрынхан Хонгор гэдэг нууц нэрээр хилийн чанадад ажилладаг өөрийн сөрөг тагнуулчийн хүчээр илрүүлж чаджээ. Харин гаансны хувьд гэвэл Хятадын тагнуулчдын таних тэмдэг, харилцах пороль нь байлаа. Сантын хувь заяа яасан нь тодорхойгүй. Харин Тянжинь дахь манай тагнуулч Хонгор хэмээх нууц нэртэй Жамцын цогцос 1939 оны хавар тэндхийн муу усны сувгаас олдсон байна. Ямартай ч түүний ачаар

Монголд “Гаанс” гэдэг нууц нэрээр үйл ажиллагаа явуулж байсан Хятадын томоохон тагнуулын бүлгийг До яамныхан илрүүлж устгасан билээ...”

## Дорноговийн домогт эрс “Тэлмэн” Зундуй, “Хилэн хормойт” Ашуу

Дорноговь аймгийн түүхийн музейн захирал, яруу найрагч, зураач Гончигдоржийн Цагаандэрэм саяхан Улаанбаатарт ирэхдээ нутгаасаа төрж гарсан “Тэлмэн” Зундуй, “Хилэн хормойт” Ашуу нарын тухай доорхи яриаг өрнүүлсэн юм.

Дорноговьчуудын дунд “Тэлмэн” Зундуй, “Хилэн хормойт” Ашу гэж хоёр шилийн сайн эр эртнээс яригдсаар ирсэн. Ер нь манай нутгаас нэрд гарсан нь энэ хоёр. Өөр бусад шилийн эр байсан л байх. Гэхдээ энэ хоёр шиг нэр алдарт хүрсэн нь үгүй. “Тэлмэн” Зундуй нь миний дээд өвөг. Миний аав Гончигдорж, түүний ээж Цэвэгжав гэж хүн байсан. Цэвэгжав эмээгийн өвөө нь даншигийн начин Түдэв гэж хүн байж. Түдэв начны дээд үе нь шилийн сайн эр “Тэлмэн” Зундуй юм билээ. Тэгэхээр би “Тэлмэн” Зундуйн зургаа дахь үе болж таарч байгаа юм. Хэнтий аймгаас төрж гарсан Тавдугаар Хүүхэн хутагт Найдансүрэнг шилийн эр байсан гэдэг шүү дээ. “Тэлмэн” Зундуй, Хүүхэн хутагт хоёр хамт адуу хөөдөг, Хятадын пүүсийн ачаа хөсгийг дээрэмдэж ард олонд тараадаг байсан байгаа юм. Тухайн үед энэ хоёрын адуу хөөж байсан талаар дуу хүртэл зохиогдсон байдаг. Жишээ нь,

“Бор борын бялзуухай

Босоо суугаа жиргэлээ

Болзоо нь үгүй Хүүхэн хутагт

Боломжийг нь олж дэргэлээ

Тардагийн талын манаач нь

Яасан хэцүү манаач вэ

Хоёр шөнө отлоо шүү

Хойнох шөнө нь гэнэдүүлж хөөлөө шүү

Гучин гурван шаргын маань

Гурваас бусад нь жороо доо

Оорцог бүрдийн усанд нь

Оноот сумаар намнав аа хө” гэсэн дууг Хэнтий, Дорнод, Дорноговь чигийн дээхэн үеийн хөгшчүүд андахгүй. “Тэлмэн” Зундуйг манай Дорноговийнхан “Тэсгэлгүй тэлмэн” Зундуй гэдэг байсан. Тэснэ тэснэ гэхэд даанч тэссэнгүй гэдэг үг байдаг шүү дээ. “Тэсгэлгүй” гэж хочлохыг бодоход хятад жинчдийг тэсэлгүй дээрэмдчихдэг, энд тэндээс тэсэлгүй адуу хөөчихдөг хүн байсан бололтой. Зохиолч Ч.Лодойдамба гуайн “Торой” Банди, “Тогос” Чүлтэм гээд шилийн эрийн жагсаалт байдаг. Энэ жагсаалтын бүрэн эхэд “Тэсгэлгүй тэлмэн” Зундуй гэж бий. Дорноговийн Дэлгэрэх, Өлзийт сумдын зааг дээр Ноён хутагт

Данзанравжаагийн аав Дулдуйтын өвөлжиж байсан бууцаар нэрлэгдсэн “Дулдуйтын хар овоо” гэж байдаг. “Тэлмэн” Зундуй энэ овоон дээр гарч суугаад маш том түүдэг асаадаг, нутгийн улс энэ түүдгийг харчихаад “Өө, манай “Тэсгэлгүй тэлмэн” Зундуй ирчихэж” гээд явж очоод түүнээс хунз цайнаас эхлээд хуйгаар торго авдаг байж. Ухаандаа “Тэлмэн” Зундуй хятад жинчдийг дээрэмдчихээд л түүдэг асааж нутгийнхаа ардуудад дохио өгч байгаа хэрэг шүү дээ. Энэ хүний удам судар яах аргагүй даншигийн начин Түдэвтэй холбогддог. Бидний эмээ Цэвэгжав зургаан хүүхдээ Түдэвийн Гончигдорж, Түдэвийн Лувсанчүлтэм, Түдэвийн Гомбожав гээд ааваар нь биш өвөөгөөр нь овогложихсон байдаг. Ер нь тухайн үед өвөг дээдсийнхээ овгийг авах нь их байж л дээ. Би ч гэсэн энэ уламжлалыг дагаад шинэчилсэн паспорт авахдаа “Боржигон тэлмэн” гэдэг овог авсан. Тэлмэн гэдэг нь шилийн сайн эр “Тэлмэн” Зундуйг мөнхжүүлэх гэсэн хэрэг л дээ. Манайханы зарим нь “Яагаад шилийн хулгайчаар өөрийгөө овоглож байгаа юм бэ” гэж үг хаяж л байсан. Би тоогоогүй. Яагаад гэвэл “Тэлмэн” Зундуй тухайн цаг үедээ бол нутгийнхаа ард түмэнд ээлтэй буянтай сайн эр явсан. Хувьдаа ганц ширхэг бөгж аваад зүүчихдэггүй, гаднаа адуу мал багшруулаад ганцаараа баяжиж дэвжээгүй, олсон олзоо ерөөсөө л ядуу олондоо тараагаад өгчихдөг хүн байсан гэдэг. Ядуу олондоо туслах гэсэн сэтгэл нь сайхан, харин арга нь жаахан буруу байсан юм болов уу. “Тэсгэлгүй тэлмэн” Зундуй гэдэг хүний тухай Хэнтий чигийн хөгшчүүл сайн мэддэг. Хүүхэн хутагт Найдансүрэнтэй холбоотой байсан болохоор тэр шүү дээ. Ер нь Хүүхэн хутагттай холбоотой түүхийн баримтуудаас “Тэлмэн” Зундуй гэдэг хүний нэр тодроод ирдэг тухай хүмүүс надад хэлж байсан. Би өөрөө бас үүх түүх сонирхож судалдаг хоббитой. Ер нь миний ажил алба ийм л дээ. Манай нутгаас тодорсон өөр нэг шилийн эр гэвэл “Хилэн хормойт” Ашуу. Энэ хүнийг ноён хутагт Данзанравжаатай дотно харьцаатай байсан тухай яруу найрагч О.Дашбалбар агсан нэг нийтлэлдээ цухас дурдсан байдаг юм. Ер нь “Хилэн хормойт”-ын тухай домог түүхийг Дорноговьчууд сайн мэднэ. Ноён хутагт 1820-иод оны үед 18 настайдаа Хамрын хийдийн шавыг тавихаар газар шинжээд явж байтал асар их буяны сав бүхий товцог дээр үс сахалдаа баригдсан мундаг том хар хүн гурван тийш нь цахиур буу чиглүүлээд тавьчихсан, түүдэг асаагаад мах шарж идээд сууж байсан байна. Ноён хутагт түүнтэй амар мэндээ мэдэлцээд юу хийж суугааг нь асууж л дээ. Тэгтэл “Өмнөөс хятадууд дайраад ирвэл буудахад бэлэн, зүүн талаас зээр гөрөөс гараад ирвэл агнахад бэлэн, баруун талаас барс гараад ирвэл тулалдахад бэлэн” гэх маягийн юм хэлсэн гэдэг. Ноён хутагт үүнд нь ихэд бэлэгшээж “Гурван талын аюулаас хамгаалах их сайхан газар байна. Яг энэ газар дээр чинь лаврин барина” гэж хэлээд тэнд нь Хамрын хийдийн шавыг тавьж байсан гэдэг юм. Одоо Хамрын хийд дээр байгаа хоёр дуганы баруун талын дуган нь шилийн сайн эр “Хилэн хормойт” Ашуугийн сууж байсан газар юм гэсэн. Энэ явдлаас улбаалаад Ноён хутагт Равжаа, “Хилэн хормойт” Ашуу хоёр сайхан анд нөхөр бололцсон гэдэг. Нэг үе хамт амьдарч байсан бололтой. Энэ нь юугаар нотлогддог вэ гэвэл Хамрын хийд дээр Ашуугийн байшингийн туурь гэж байдаг. Нэг нь халхын том хутагт, нөгөө нь халхын шилийн сайн эр. Ноён хутагт Галбын гурван хийдийг байгуулахаар хаа холын Өмнөговь, Дундговь гээд говийн нутгаар алс замд их явдаг, тэр үед нь “Хилэн хормойт” Ашуу түүнийг хамгаалж явдаг байсан байгаа юм. Хөдөө хээр газар тонуулчин дээрэмчдээс эхлээд янз бүрийн л юмтай учирна шүү дээ. Магадгүй цуутай шилийн эрээр хамгаалуулж явдаг байсан болохоор ноён хутагт маань алс хол газар сэтгэл амар зорчдог байсан биз. “Хилэн хормойт” гэдэг чинь “Хилийн хормой” гэсэн үг. Дорноговь аймгийн нутагт “Хилийн хормой” гэдэг хад бий. Ашуу тухайн үед хилийн хормойг барьдаг сайн эр байж. Хятадуудаас хилийн хормойгоо хамгаалдаг, хилийн хормойг атгадаг, орчин цагийнхаар бол атаман нь байж л дээ. Тэгээд хилийн хормой нь

яваандаа “Хилэн хормойт” болж өөрчлөгдсөн байгаа юм. Ашуу нас ахисан хойноо ч томоожилгүй өөрийнхөө зоргоор хятадуудтай наана цаань болж байгаад үйлийнхээ үрээр хятадуудад баригдаад урагшаа ачигдсан гэдэг. Тэгээд хоёр гараа гавлуулаад урагшаа явж байхдаа замдаа нутгийнхаа жинчидтэй тааралдаад “Алив миний энэ гаванд идэгдсэн хоёр гарыг сэлмээр тасдаад аль. Гэм хийсэн гарыг минь ноён хутагтад аваачиж өгөөрэй” гэсэн гэдэг. Жинчид түүний захиасын дагуу хоёр гарыг нь ноён хутагтад аваачиж өгсөн байгаа юм. Ноён хутагт “Хилэн хормойт”-ын гарыг ихэд бэлэгшээж аваад шившиж аравнайлаад жил бүрийн цагаан сарын шинийн нэгэнд нохойн амны зүгт сайн эрийн гараар дохиж муу юмыг зайлуулах зан үйлийг биечлэн үйлддэг байж. “Хилэн хормойт” Ашуу урагшаа ачигдаж яваад буцаж ирээгүй гэдэг. Бодвол эртний өс хонзонт хятадууд нь түүнийг цаазалсан биз. Ашуугийн тэр хатсан гар ноён хутагт Равжаагаас хойш их олон жил хадгалагдсан байдаг. Энэ тухай ахмад зохиолч А.Шартолгой сайн мэднэ. Шартолгой гуай энэ гарыг бүр өөрийн биеэр барьж үзсэн гэдэг. Мань хүн тавиад оны үед Зүүнбаянгийн нэгдэлийн үйлдвэрт жолооч хийж байхдаа Хамрын хийдийн нэг амбаарт орж л дээ. Гэтэл тэнд хадгаар ороочихсон нэг юм байж. Задлаад үзтэл хүний хатаж хорчийсон гар байсан гэдэг. Энэ тухай зохиолч Шартолгой гуайгаас асуугаарай.

Би бээр яруу найрагч Г.Цагаандэрэмийн хэлсэнээр Дорноговь аймгийн уугуул, ахмад зохиолч Авидын Шартолгой гуайтай уулзсан юм. Тэрбээр тавиад оны үед хориод настай байхдаа “Хилэн хормойт” Ашуугийн хадганд ороосон хатсан гарыг барьж үзсэн тухайгаа хуучилсан бөгөөд нутгаасаа төрж гарсан энэхүү шилийн эрийн тухай “Ашуу хэмээх Хилэнхормойн дууль” хэмээх найраглал бичсэнээ надад гардуулсан юм. Гэвч энд тэрхүү найраглалыг бүтнээр нь багтаах аргагүй бөгөөд эхлэл, өрнөл, төгсгөл хэсгээс нь тоймлон хүргэе.

Найраглалын эхлэл хэсэгт “Ашуу минь чи тэгээд, Аль болгон хээршиж, Аглаг зам тосох вэ, Авралын орон хийдэд, Амьтаны тусыг зохиож, Аруисч явбал өлзийтэй бус уу, Хүрээ зам тосч, Хүний олсоныг тоноод, Хүсэл биелэх нь юун, Буруу замаар олсоноо, Буурай ядууст тараалаа ч, Буянд бодох нь эндүү” гэх Ашууд хандсан хутагтын сургааль гарах бөгөөд хариуд нь сайн эр Ашуу “Хээрээр гэр хийж тайвшрах, Хэцээр дэр хийж амрах, Хэрмэл явсан би чинь, Сайн эрийн шийр хатаах, Саваагүй зан минь хөдлөөд, Санаа давчдаад байх юмаа, Өвөр газрын шулаачдыг, Өнчин ишиггүй буцааж, Өвсөн шаахайтай нь явгалаад, Тэн ачааг нь хурааж, Тэмээ малыг нь суллаад, Тэнзэн ташуур амсуулмаар, Задгай галын дэргэд, Замагт буугаа шийрлээд, Завьжиндаа тос савируулсан шигээ, Зээрийн мах шарсан шигээ, Зэгст нуураас ундаалж, Зэм халгүй явмаар байна” гэж өчинө. Тэгээд тэр хэсэг хугацаанд ноён хутагттай шадарлан нөхөрлөх авч нөгөө л шилийн эрийн явдал суудал нь зүрх сэтгэлийг нь эзэмдээд амар заяа үзүүлэхгүй. Тиймээс тэр “Өөрийн нүглийг яахаараа, Өрөөлөөр цайруулж ариусгах, Өгөө аваа байдаг билээ, Хийсэн нүглээ нимгэлэх гэж, Хийдийн газар будаалж, Хишигт багтах нь юу билээ, Хурмастын дор нүгэлтэй ч, Хутагтаар заавал хөнгөрүүлж, Хувь хүртэж суух нь юу вэ, Зөнгөөрөө тэмцэн явахад, Зөв буруугаа ялгаж таних, Зөрөг зам байхгүй юм гэж үү, Гэвч хутагт лам минь өршөө, Гэрийн хоймор эзлэн суулаа ч, Гэгэлгэн сэтгэл тогтож өгөхгүй нь, Талын хязгаар нутагтаа, Тахь шиг хулжиж явмаар, Тас шиг гуурсалж нисмээр, Олон хоногоор тээнэгэлзэж, Орох гарах минь олширч, Орондоо хөрвөж хэвлээ би, Хэзээнээс хийж явсан ажил, Хээр зам руу дуудаад, Хэдэн сараар тэвчлээ, Хүрээ хийддээ хоргодож тэвчлээ, Хүмүүний сайнд жаргаж тэвчлээ, Хүүхний сайханд уярч тэвчлээ, Хүлгийн шандастайг сойж тэвчлээ, Хүслийн адгууг дарж тэвчлээ, Хүлээстэй мэт хүлцэнгүй тэвчлээ, Зоригондоо би

эрдсэнгүй ээ, Зовлондоо би дурласангүй ээ, Зоргоор би чинь алдуурлаа” гээд хүрээ хийдийн газраас дайжиж, хутагт найзынхаа халамж дэмжлэгээс алдуурч одно. Хилэн хормойтыг одсоны дараах хутагтын харууслыг найраглалд доорхи байдлаар өгүүлжээ. “Хөөрхий дөө энэ минь, Хөл алдаж яваа болохоос, Хөдсөнд боодолтой эрдэнэ, Заяа төөрөг нь юм байлгүй дээ, Замын хүзүү нийлэхгүй нь ээ, За яахав ээ, хүслээрээ болог, Дэргэдээ авч явахгүй бол, Дээшлэх заяа үзэхгүй, Дэнгийн эрвээхий шиг шатах, Хажуудаа авч явахгүй бол, Хазгай нэг гишгэхдээ, Халгайд унаж мэдэх хүн, Нохой занг нь номхотговол, Ноцомхой ааш нь зөөлөрч, Номын ухаан суух хүн, Тэнгирлэг явбал гэрэлтэйг, Тэнэглэж будилбал харанхуйг, Тэгтлээ би түүнд хэлээгүй гэж үү, Эрийн сайн эр юмдаг, Эргэцүүлж нэгийг бодно биз, Элдвээр түүнийг хясаад яах вэ” гэх мэтээр шилийн сайн эр Ашууг зөнгөөр нь орхино. Найраглалын өрнөл хэсэгт “Ашуу яваад гурван намар, Ажиг сураггүй гурван хавар, Аяндаа хэн хэнгүй мартагдав, Хошуу нутаг дамнан, Хоноггүй яаран довтолгосон, Хоёр хүн ирж буув, Гэгээнтэнд заавал бараалхана, Гэдрэг буцахгүй хүлээнэ гэж, Гэнэтийн айлтгал барив, Ханхар цээжтэй эрийг, Халх жинчиний хөсөгч, Хайдав заан гэнэ, Дагаж яваа өвгөнийг, Давхар гэрчээр яваа, Дамчаа бууч гэнэ” гэх мэтээр өрнөх бөгөөд энэ нь урагшаа ачигдаж явсан Ашууг замдаа тааралдсан жинчдэд хоёр гараа тасдаж өгөөд “Гэм хийсэн гарыг минь ноён хутагтад аваачиж өгөөрэй” гэсэн захиас бүхий эмгэнэлт хэсэг юм. Ноён хутагт Равжаа Ашуугийн мутарыг гардаж аваад “Ганц мутар юм бол, Гаргаж хая цаашаа, Галд хайлж орхино биз, Хоёр мутар юм бол, Хоймор залаад үлдээ, Хожим учрыг нь олно” гэхэд мутрыг хүргэж ирсэн хүн “Үлгэрийн баатар шиг эртэй, Үхлийн туйлд уулзана гэж, Үнэндээ би санасангүй, Гэгээнтэн минь болгоо, Гэнэдэж осолдсон түүний, Гэрээслэлийг хүргэж ирлээ, Хар дарсан зүүд шиг, Хариг хатуу хорвоогоос, Хагацахын өмнө захихдаа, Гандан шуутай гар, Ганц байвал хожим нь, Гай зэтгэр учруулна, Хоногийн нас минь гүйцэхээр, Хоёр гарыг минь салгаж, Ховдол саванд битүүлээд, Говийн ламд хүргэж өгөхийг, Голт зүрхнээсээ гуйя би, Горилох юм л тэр гэлээ” гэж айлдана. Хариуд нь ноён хутагт “Хүний сайхан үр юмсан, Хүрэн тасын жигүүр юмсан. Хүсэлдээ шатах учиртай байж, Эрийн сайн эр юмсан, Эмээл дээр өссөн эр юмсан, Эргэж уулзах учиргүй байж” гэж харуусна. Найраглалын төгсгөл хэсэгт “Хилэн хормойтын хоёр гарыг, Хив хадагаар яндарлаад, Хийдэд залах юм гэлцэв, Бурхан тахил шүтээн биш, Бузрын хоёр хар гар гэж, Бухимдаж зарим нь сэжиглэв, Алтан утсаар сунтаглаж, Адис өгөх юм гэнэ гэж, Ам халахдаа зарим нь цуурав, Хутагт багш минь яалаа гэж, Хувхай гарыг дээдэлж шүтэв гэж, Хуваргууд бас хоорондоо талцав, Үнэн байжээ тэгтэл, Үзэгдээгүй хачин зан үйл, Үд сунатал үргэлжлэв, Орон хийдэд хөлсөж, Олны нүд бүлтийж, Орой болтол үйлдэв, Тэр цагаас хойш, Тэнэмэл эрийн мутар, Тэнгэрийн таалалд багтав, Үхээрийн гэж цээрлэсэнгүй, Үнэн мөнийн гэрч болгож, Үзмэрийн санд залах болов, Барцад гайг үлдэн хөөхөд, Баруун гараар нь гадагш дохих, Баринтаггүй сунтагт оршоов, Эвэр туурайнаас хүчтэй, Энэ баруун гарын шид, Эрч хүчийг агуулсан болохоор, Буруу санаатанд алдвал, Бусдыг егүүтгэх учир, Буйд чанадлан нуу гэв, Буян хишгийн зүүн гарыг, Бурхадын таалалд нийцүүлсэнд, Бусдын нүдэнд ил залаад, Зүйлийн сайхан буяныг, Зүүн гараар нь урин даллах, Зүрхэн тарнийг оршоов, Сэжигт, сүжигт хоёр гарт, Сэржим тарни зохиож, Сэтгэлийн зарлиг хүлээлгэв” гэж өгүүлжээ. Дорногов аймгаас төрж гарсан “Тэлмэн” Зундуй, “Хилэн хормойт” Ашуу хэмээх домогт эрсийн талаар цухас өгүүлэхэд ийм буюу.

## Баруун гурван аймагт домог болж явсан “Доль” Банзрагч

Засагт ханы хөх харчууд гэгддэг шилийн сайн эрчүүдийн сүүлч болох Завханы “Доль” Банзрагч дөч, тавиад оны үед баруун гурван аймагт элдэв адал явдлаараа домог болж явсан байдаг. Түүний адал явдал баруун аймгийнханы сонороос хальж зохиолч, сэтгүүлчдийн анхаарлыг татаж байсан бөгөөд жишээ нь зохиолч Ж.Зана, сэтгүүлч Л.Сэлээд нар түүнтэй уулзаж учирч явсанаа дурссан байх аж. Мөн соц нийгмийн үеийн мундаг зохиолч Даг.Жамъян “Доль” Банзрагчийн туулсан амьдралаар ном бичиж байгаад дуусгаж чадалгүй хорвоог орхижээ. Алдартай шилийн эр “Доль” Банзрагч 1999 он хүртэл энх тунх амьдарч байгаад ная гаруй насандаа таалал төгсчээ. Саяхан түүний төрсөн охин болох Б.Дагьмидмаа хэмээх тавь гаруй насны эмэгтэй аавынхаа тухай хүүрнэхийн сацуу зарим нэг баримт, материалыг гардуулсан юм. Тэр өгүүлэхдээ “Аав маань залуу зандан насандаа их л хөдөлгөөнтэй ширүүхэн явсан байдаг. Тэгээд 1956 онд ээжтэй маань суугаад л айл болж төвхнөсөн. Би 1957 онд төрсөн. Миний ээж Хорлоо одоо дал гаруй настай. Хүүхэд байхдаа аавынхаа тухай янз бүрийн үүх түүх сонсдог байлаа. Наад захын жишээ гэхэд л аавыг шоронгоос оргоод баригдахгүй болохоор нь манай өвөө аавыг “Хүүхдээ олж өг” гэж барьцаалаад шоронд хорьчихсон байгаа юм. Үүнийг аав маань сонсмогцоо шоронд өөрөө явж очоод “Би хэрэг хийсэн болохоос биш наад хүн чинь хэрэг хийгээгүй. Эцгийг минь сулла” гээд өмнөх хэргээ хүлээж байсан гэдэг. Аавд гурван удаа цааз сонсгож байсан юм билээ. Эхний хоёр цааз ялан дээр нь аав оргоод алга болсон, харин гурав дахь удаагийн цааз ялан дээр Засангийнхан өвөөг барьцаанд авчихсан болохоор аав яалт ч үгүй яваад очсон гэдэг. Аав мань маш их бясалгал хийж залбирдаг хүн байсан. Цаазаар авахуулахынхаа урьд шөнө ямар ч авралгүй болсоныг ойлгоод шар тосонд багсрааж иддэг замбай гурилынхаа жижиг уутыг задлаад эрхи зангидаж, түүнийгээ шившээд шөнөжин бясалгал хийж хоносон байгаа юм. Гэтэл үүрээр “Банзрагчийн амийг хэлтрүүлсүгүй” гэсэн одоор бичсэн үг шөнийн тэнгэрт гэрэлтэж байна гэж зүүдэлсэн гэдэг. Аав сэрээд “Ямар сайхан зүүд вэ. Миний бясалгал хийсний хэрэг гарах нь байна. Төр намайг өршөөх нь байна” гэж баярлаад, нээрээ ч төдөлгүй төрийн өршөөлөөр цагаадаад гарч байсан гэдэг. Аав маань өөрөө залуудаа хөдөлгөөнтэй явсан болоод ч тэр үү, биднийг буруу хүн болгохгүй гээд маш их хүмүүжилтэй өсгөсөн. Худлаа хэлж болохгүй, хулгай хийж болохгүй, шударга хөдөлмөрөөрөө амьдрах ёстой гэж сургадаг байлаа. Бид ч тэр сургаалийнх нь дагуу ажилч хичээнгүй, үнэнч шударга хүн болж хүмүүжсэн. Аавыг шоронгоос гарсаны дараа хүмүүс нэг хэсэг түүнээс айж зугтдаг байсан гэдэг. Үйтэн хуаран дээлтэй, торгон өмдтэй, сайхан морьтой, сайхан эр явдаг байж. Миний мэдэхээр аав маань ная хүртэлээ сайхан хувцас өмсч, сайхан эдлэл хэрэглэж сайхан чигээрээ гангарч явсан. Аавыг маань хүмүүс кино болчихоор ээдрээтэй амьдрал туулсан хүн гэж ярьдаг байлаа. Даанч бид тэр бүхнийг нь баталгаажуулж чадаагүй. Зохиолч Даг.Жамъян аавын маань тухай ном бичиж байсан ч дуусгаж чадалгүй хорвоог орхисон. Уг нь энэ хүн л аавын маань бүх түүхийг мэдэж байсан юм. Одоо аавыг ганц мэддэг хүн нь ээж маань л байх шив дээ. “Ар Халхын шилийн сайн эрчүүд” гэдэг ном гарсаныг олж харсан. Энэ номонд миний аав орох ёстой хүний нэг гэж бодоод та нарт хандаж байгаа хэрэг. Ингээд өмнө нь зохиолч, сэтгүүлчдийн бичиж байсан, Завханы сонинд хэвлэгдэж байсан зарим нэг материалыг өгье. Гэхдээ энд аавын маань дуулиант амьдралын тавин хувь нь л бичигдсэн болов уу” гэсэн юм.

## **Шилийн сайн эрсийн шийрийг хатааж явсан Шуумарын Банзрагчийн тухай тэмдэглэл**

Багахан ахуйдаа Завханы “Доль” Банзрагч хэмээх эрийн үнэн худал, үлгэр домог алин болох нь эс мэдэгдэх адал явдлын тухай бид “буу” халцгаадаг байж билээ. Гэтэл саяхан тэр хүнтэй зэрвэсхэн хэдэн үг солих завшаан тохиов. Ная дөхөж яваа гэхэд хөл гар нь чанга, үг дуу цуурайлаг, босч суусан эрийн “хуйх” байв. Хорин хэдхэн насандаа эрийн ааг омог багтаж ядаж, дөмөг морины хүслэнд шатаж явсан Банзрагч Засагт ханы хөх харчуудын шийрийг хатаахын мөрөөдөлдөө донтоод Баянхонгор аймгийн Бууцагаан, Баацагаан хавиас адуу хөөж, Ханхөхий давуулан хүмүүст тараан өгч нэг үзжээ. Мөн Осман цэргийн агтнаас 40 гаруй морь хөөж холын хүмүүст түгээж нэг үзжээ. Түүнчлэн Ховог сайрын торгуудын алд алдын жороо морь унах хүслэн болж гав ганцаар хүн танихгүй, газар мэдэхгүй ч Алтай даван тэнэж, санасандаа хүрч сайхан жороо морьтой дэрэлзүүлэн ирж нэг үзжээ. Дөчөөд оны сүүлчээр 70 бод хулгайлсан, мөн айлын эхнэр хулгайлж зарсан хэргийн эзэн Банзрагч зургаан жил “яс цоож”-нд суух ял шийтгүүлжээ. Далан бодынхоо хэргийг эс хүлээсэн гэнэ. Харин хүүхний тухайд бол аав ээж хоёр нь бэр буулгах санаатай байсан ч цаад хүүхэн нь “Чи муу нэртэй, луу данстай” гэж Банзрагчийг өөнтөглөөд өөр айлд очжээ. Гэтэл үеийн залуучууд нь түүнийг авгайгаа алддаг энэ тэр гэж хорыг нь малтаад амраадаггүй гэнэ. Тэгэхээр нь Ховд аймгийн Чандмань сумын Олзвой гэдэг залуутай үгсэн хуйвалдаж нөгөө хүүхнээ хорин банз, матигар гаанс, нэг жороо халиун мориор арилжаад “Чамайг араас чинь очиж авна” гэж хуураад явуулсан юмсанж. Тухайн цагийн хуулинд хүн хулгайлсан, худалдсан хэргийн тухай зүйл анги байгаагүй учир Банзрагч зөвхөн малын хулгайн ялаа эдлээд сууж байтал өөр хэрэгт сэрдэгдэж Ховдын шүүхэд дуудагджээ. Тэнд мөрдөгдөж дуусаад буцдагийн даваан дээр Ховдын прокурор Галсан түүнийг хэрэгт холбогдолгүй болсон тухай ганц хуудас бичгийг Банзрагчийн хавгаст хэрэгт хийгээд, хавгаст хэргийг голоор нь хоёр цоолж утас сүвлэн лацдаад берзентэн уутанд хийж Завханаар дайрч Улаанбаатар ордог шуудангийн ГАЗ-51 машины жолоочид өгчээ. Үүнийг Банзрагч мэдчихэж. Тэгээд тэр хавгаст хэргээ хулгайлж өвөртлөөд Ховдын төвөөр унаа эрээд харайж явгал золоор нутгийн танил морь айлын хашаанд уяатай байхыг үзээд түүнийг хулгайлан нутгаа тэмцжээ. Тэр нь одоо энэ Маабазар багшийн аав сээтэн Раашийн халиун морь байж. Уг морийг Дөрвөлжингийн “Доголон” Сурмаа гэгч эр Дорлиг залангийн Ламжавт дамжуулж зарсан түүхтэй аж. Эр залуу насны хад шиг биеийн хатаар хатуу явдлыг нь дааж унаж чадвал эцнэ гэдгийг мэддэггүй гүжир цөлх, үнэхээр сайн морь байжээ. Банзрагч хавгаст хэргээ өвөртлөөд нутагтаа ирмэгцээ зургаан жилийн ял үүрүүлсэн тэр олон бичиг баримтыг цөмийг нь галдаж орхиод, хэрэгт холбогдолгүйг тодорхойлсон Ховдын прокурорын ганц хуудсыг үлдээж хуучин янзаар нь дугтуйлан хадгалжээ. Банзрагийг хаана яваа, хавгаст хэрэг нь хэнд байгааг Завханы шүүхийнхэн мэдэлгүй нэг жил өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд мань эр сайн морь унаж, Сартуулын нутагт салхилж явахдаа зүгээр ч байсангүй. Эцэст нь баригдаж, хүргэгдэж, мөрдөгдөж, шийтгэгдэж дээ. Хийсэн бүх хэргээ хүлээгээгүй ч тулгаж таслуулаад ялын дээд хэмжээ сонсчээ. Цаазыг гүйцэтгэхээс өмнө хоригдож байсан 15 дугаар өрөөнийхөө пийшин дээр оргосон, боссон, бас бассан утгатай жаал юм бичээд таазаа эвдэж оргоод бүрэн хэрэглэлтэй морь хулгайлж унан Алдархааны шугуй орж, тэндээсээ “Таахай” Бандийн цэнхэр морийг сэлгэж унаад жилийж өгчээ. Ингэж будилж яваад дахин баригдаж, байцаагдаж суусаар дахиад буудан хороох ял авчээ. Цаазыг ёсоор гүйцэтгэх хоногийг тоолон хүлээх зуураа нэгэн шөнө тэнгэрт “Банзрагчийн амийг хэлтрүүлсүгэй” гэж одоор бичсэн үг яралзан



гэрэлтэж байна гэж зүүдлээд, маргааш нь 13 дахь өдрөө Улсын дээд шүүхэд давж заалдах өргөдөл, Улсын бага хуралд уучлалт гуйсан гуйлт бичиж явуулж орхисон байна. Гуч шүргэж яваа халуун залуу амийг гуйсан ёсоор нь өршөөсөнд баярласан тэрбээр Улаанбаатарт ялаа эдэлж байхдаа бас ч адал сонин учралд өртөж, нэр цуугаа гаргаж явсаар хэдэн жил сууж нэг сайхан өдөр амьд мэнд суллагаад орон нутагтаа ирсэнээс хойш зөв сэтгэлтэй, бусдад тус болохсон гэх бодолтой аж төрсөөр иржээ. “Хүүхдүүдээ миний замаар битгий ороосой гэсэндээ арай ч дэндүү даруулгатай өсгөчихөө юу даа” гэж бодож явдаг энэ өвгөн сайн морь, эр зоригийн тухай дэндүү их хууч ярих бөлгөө. Тавилан нь хүнээ хөтөлдөг юмуу, тавилангаа эзэн нь хөтөлдөг юмуу гэж гэж түүний өгүүлсэнээр энэхүү тэмдэглэлээ өндөрлөе. (Завхан аймгийн орон нутгийн хэвлэл)

## 40 жил хээрээр гэр хийсэн “Доль” Банзрагч

*(Сэтгүүлч Л.Сэлээдийн дурсамж)*

Завхан хангай нутагт минь хурдлан гүйдэг “Жороо Банзрагч” /Их-уул/, хулгай гүйлгэдэг “Доль” Банзрагч /Завханмандал/ гэж байсныг нутгийнхан сайн мэднэ. Хэнтэй ч хэл үгээ ололцож, яриа хөөрөө болж, хүнтэй амархан танилцдаг би түүнтэй бас гэмгүй нөхөд явлаа. Түүнийг нутаг усныхан нь “Доль Банзрагч” гэж хүндэлнэ. Тэрбээр залуу халуун насандаа хүлэг морины эмээл дээр дарцаглан хийсч эрийн чадал зааж хангайгаас Алтай руу, Алтайгаас хангай руу адуу хулгайлж аваачин худалдаж, баригдан “аавын хаалга” татаж гурван удаа цааз авч байсан ч арга ухаан, авхаалж самбаагаараа “амь хэлтэрсэн” азтай хүн гэдэг. Шилийн сайн эр болж явахдаа нутгийнхаа нэг бүсгүйтэй амьдралаа холбох дөхсөн ч нөгөөх нь “Чи муу нэртэй, луу данстай” гээд огтхон ч зөвшөөрсөнгүй. Нэг өдөр Банзрагч их зантай түүнийг хонь хариулж явахад нь дайралджээ. Тэгтэл банз ачсан, хоёр тэмээ хөтөлчихсөн хасаг эр дайралдахаар нь банзыг нь авч оронд нь хүүхнийг түүнд арилжиж орхижээ. Тэгээд төдий удалгүй хулгайн хэрэг нь илэрч шийтгүүлээд явчихсаны дараа хүүхний эцэг эх, төрөл саднууд сураглаж сонсоод Баян-Өлгий аймагт айлд зарцлагдаж байхад нь очиж авчирсан гэдэг. Хожим “Доль” Банзрагч гуай засарч хүмүүжин үр ач нартаа буруу зөвийг ухааруулсан, хууль ёсоо хүндэтгэн сахиж биелүүлж яваарай гэж сэнхрүүлсэн сайхан буурал болоод хэдэн жилийн өмнө “бурхан” болж билээ. Тэрбээр танил нөхөддөө “Энэ зохиолч нар, сонин хэвлэлийнхэн надтай ирж уулзахгүй юм. Хээрээр гэр, хэцээр дэр хийж 40 жил явсан миний үйл явдлаар хичнээн ч роман, тууж, кино, жүжиг биччих бэлэн материал байна даа” гэж ярьж байсан гэдэг. Үнэхээр манай хэвлэл мэдээллийнхэн хэтэрхий залхуу, аливаа юмыг хойш тавьсаар байтал ийм чухал хүмүүсээ хорвоогоос одсоны дараа уулзаж байхгүй яав даа гэж харамсан суудаг нь үнэн билээ.

## “Доль” Банзрагчийг шоронгийн дээвэр дээрээс үсрэхэд хуягийн бууны сум гүйцээгүй

(Ахмад зохиолч Жамбалын Занын дурсамж)

Энэхүү нийтлэлийг ахмад зохиолч Ж.Занын дурсамж Албан ажлын далимаар ч гэх үү, сониуч зангаасаа ч юмуу Увсын Даваагомбо, Завханы “Доль” хэмээх Банзрагч зэрэг олон сайн эрстэй нүүр тулан учирч явсан минь сэтгэлд тодхон үлджээ. Тэд өнөөгийн “Топ модель”, “Топ дуучин” гэдэг шиг тухайн цагтаа “Топ шилийн эрчүүд” байж дээ. Харин тэднийг тэртээ он жилийн өмнө бол “Мулз” гэж нэрийддэг байсан юм. “Боорцог” хэмээх Чадраабал дээхэн үед Завхан аймгийн Мандал суманд хэсгийн төлөөлөгч хийдэг байлаа. “Доль” Банзрагч л болсон хойно тэгэхэд нэг сүрхий хэрэг хийчихээд түүнийг барьж ир хэмээн аймгаас бичиг сачиг ирээд байж дээ. Банзрагч чухам ид хаагиж байсан үе. Чадраабал нь болохоор түүний чигчий хуруунд ч үгүй голгүй эр. Барья барьж чадахгүй, байяа байж чадахгүй болчихоод байсан хэрэг. Гэтэл тэр үеэр нэг тууварчин хэдэн хонь дугаачихсан хэрэг гарч л дээ. Чадраабал түүнийг байцаахчаан болж цонхоор харжээ суутал Банзрагч сумын хоршооноос гараад алхаж явна гэнэ. Тэгтэл Чадраабал төлөөлөгчийн толгойд нэг мэргэн бодол гялсхийгээд ирж. Тэр Банзрагчийг амдан гүйж очоод “За хө Банзрагч аа чи надад, надад ч юу байхав төрдөө нэг тус болж үз” гэхэд Банзрагч “Уа, гэгээн минь. Төрд Доль юугаараа тус болдог билээ?” гэжээ. Хариуд нь Чадраабал “Мал тууж явахдаа улсын өч төчнөөн хонь мал идсэн нэг том хэрэгтэн баригдсан юм. Түүнийг аймагт хүргэхэд хүчин мөхөсдөөд байна. Чадал бярау сайтайгаараа чи л хүрэх өг. Аюултай этгээд шүү. Миний гар бууг аваад яв” гэсэн байна. Банзрагчийн сагсуу зан хөдлөхгүй хаачихав. Тэр муу хулгайчийг хүргэхдээ л хүргэнэ гэж ам алджээ. Түүнийг явахад Чадраабал “Энэхүү нөхөр Банзрагчаар миний цалин, бичгийн хэрэглэлийг өгч явуулна уу?” хэмээсэн давхар бичиг шийтгэн өгчээ. Банзрагч анх удаагаа ингэж урхинд орж баригдсан гэдэг. Ингээд хээрийн зэрлэг араатан торонд орсон лугаа адил юм болжээ. Уужим тал, хангайд дураараа дургиж явсан залуу эр шавар байшинд хоргодоод ирэхээрээ дотор нь давчдаж, сэтгэл нь бачуураад яахаа алджээ. Ингээд анхны орголт, анхны ял нэмүүлэлт Банзрагчийн тухай бүхэл бүтэн үлгэр домог. Ганц жишээ татахад “Доль” Банзрагчийг шоронгийн дээвэр дээрээс үсрэхэд хуягийн бууны сум гүйцэлгүй, тэрбээр хэрмэн хашааны цаана буусан гэх мэт. Увсын Даваагомбо шиг л хуяг нараараа үдүүлэн гараад Улиастайн зээл дээгүүр хэсч явдаг байсан хэрэг. Ер нь аливаа шорон өөрийн гэсэн домогт эртэй байх сонирхолтой байсан бололтой. Тэгж гэмээнэ тэр алдартаныг номхруулан хүмүүжүүлж байгаа хуяг нарын нэр хүнд өсдөг байсан биз. Одоо ч тийм биз. Түүнээс биш Өмнөговийн “Халимаг” Дорж, “Шилэн” Дамдин, “Сансар” Нацагдорж, яруу найрагч Р.Чойном зэрэг нэрд гарсан эрс яг л бидэн лүгээ ижил махан бие цусан зүрхтэн байсан хэрэг. Лоохууз гуай ч шоронгийн Гиннесийн номонд бичигдэхээ шахсан. “Доль” хэмээх Банзрагч чухам л ийм нэгэн бөлгөө. Банзрагч хар гэрийн амьдралын харгуйд өгсөж уруудаж явсаар мөн л тавь жаран жилийн ял сонссон нэгэн байв. Суусан нь гэвэл арваад жил. Хүн алаагүй тул амьд мэнд яваад байдаг байж. Тэрбээр сэтэрхий тэвнэ, сиймгэр хадаг ч гололгүй хулуулдаг эр. Гэвч олсон долсоноо ганц биедээ шингээж байсан нь үгүй. Шоронгийнхон ч түүнийг мэднэ. Түүнийг хот хүрээний шорон гяндан руу ачаад ч, сахилга чангаланд суулгаад ч нэмэргүй. Тэр Улиастайнхаа зээл дээр уйлж, дуулж явахыг жаргал хэмээн бодно. Гэтэл бас л нэгэн өршөөл энэ тэр болж Банзрагч унасан газар Буурлын уулс, угаасан ус Завхан голдоо хүрээд иржээ. Тэрбээр өгүүлэхдээ “Нутгаа үзэхээр сэтгэл нялхардаг юм билээ. Ийм сайхан

юмаа орхичихоод явж байдаг тэнэг толгой гэсэн шиг юм бодогдоод л. Дахиад яасан ч тийшээ зүглэхгүй гэж бодож байлаа. Айл орон болж авгай хүүхэд авмаар санагдаад л. Харамсалтай нь хар багаасаа энэнтэй л сууна даа гэж боддог байсан бүсгүй маань айлын авгай болчихжээ. Нөхөр нь гэж хэвтээ хонь үргэмгүй сайхан залуу. Мал ахуйгаар ч товхийсэн айл. Би тэднийд очиж энэ тэрийг ярилцаж удаан суудаг байлаа. Ганц гэрээр байдаг болохоор тэд ч дуртай нь аргагүй. Тэр хоёр намайг их ятгана. Тэдний охин ааш аяг сайтай л гэнэ. Тэднийх царай зүсээр зүгээр л гэнэ. Тэр үйл үртсэнд сайн л гэнэ. Тэр ч байтугай нөхөр нь нэг удаа эхнэрийнхээ гарах хооронд “Пагма гуайн Сүнжээ унтахад их сайн шүү” гэж хэлэв. Гэвч би эхнэрт нь илүү шүлэнгэтэж байгааг тэр яахин мэднэ. Тэгээд нэг л өдөр миний эхнэр болох хувь дутсан тэр хүүхнийг хэдэн банз, жороо мориор зарчихаж билээ. Мөнөөх хэдэн банзаар нэг сүрхий эрээн авдар хийлгэж муу бор гэрийнхээ хойморт залаад Пагма гуайн Сүнжээтэй дэр нийлүүлээд авдаг байгаа. Өдөр хоног харвасан сум шиг өнгөрсөөр нэг мэдэхэд хагас жил болчихжээ. Жаргалтай сайхан ч байж. Гэтэл нэг өдөр нөгөө муу “Боорцог” нохой хоёр цагдаатай хүрээд ирдэг байгаа. Миний худалдсан хүүхэн хүн явах нь байтугай шувуу нисэх нь ховор Алтайн ууланд нэг эртэй зун, намрын зургаан сарыг бараад мал тооллогоор Ховд аймагт ирсэн хүмүүст явдал учраа ярьсанаар миний хэрэг илэрч хүүхэн сая нэг эрх чөлөөтэй болсон. Би ч яахав, аймгийнхаа шоронд ирлээ. Миний хэргийг аймгийн клубт их сүр дуулиантай тасаллаа. Хүн худалдсан юм чинь 10 жил авахгүй хаачих билээ. Тэр ч бага хэрэг. Сүнжээ маань бие давхар үлдсэн. Тун ч харамсалтай шүү” гээд Банзрагчийн хоолой зангирч билээ.

## Увсын дуулиант эр Харигийн Цийрэн

Увс аймгийн Түргэн сумын харъяат, эдүгээ 82 насыг зооглож буй Маасайн Аюурзана гуай дээхэн үед Увс аймагт дуулиан тарьж явсан Харигийн Цийрэн гэгчийн тухай хүүрнэсэн юм.

“Би 1930 онд Увс аймгийн Түргэн суманд төрж, энэ л нутагтаа өсч өндийсөн хүн. Тиймээс хил залгаа Тагна Тува улсын ахуй заншил, хүн зоныг андахгүй. Тува гэдэг чинь урианхай нар шүү дээ. Тува улс дээхэн үед Монголын харьяанд байсан юм. Тийм болохоор урианхай нар Увс, Баян-Өлгий, Ховдын нутгийг сайн мэддэг, энэ ч утгаараа Зөвлөлтийн харьяанд очсон хойноо Тувагийн хулгайч нар Увсын нутгаас адуу мал хөөж туух нь их байсан. Өвөл, зунгүй адуу хөөнө. Миний мэдэхийн гуч, дөчин оноос тува нар адуу хөөх нь бүр ширүүссэн. Ямар сайндаа л Увсынхан адуу малаа шөнө нь өндөр шургааган хашаанд оруулж хонодог байлаа. Гэсэн ч Тувагийн хулгайч нар шургааган хашааг нь эвдэж ороод л адуу малыг нь хөөгөөд явчихдаг байсан. Тиймээс зарим айл хурдан, жороо сайн морьдоо шургааган хашаанд хийлгүй гуу жалганд нууцаар аргамждаг байлаа шүү дээ. Тувагийн хулгайч нар гуч, дөч, тавиад оны үед ингэтлээ даамжирсан юм. Энэ байдал дал, наян он хүртэл үргэлжилсэн. Ардчилал, зах зээлийн үед ч тува нар хуучин зангаа тавиагүй. Одоо ч тэд Увс, Завханы хойд талын сумдын адуу малыг хөөж туусан хэвээр байгаа дуулдаг. Ийм нэг таагүй явдал бүр уламжлал болоод хэвшчихлээ л дээ. Намайг бага байхад манай нутагт “Бөх” Ивэг гэдэг лут чадалтай, аварга том биетэй хүн байсан. Энэ хүн ан агнаж яваад янгир буудаж унагамагцаа бүсэндээ хавчуулчихаад л дараачийнхаа янгирыг буудахаар явдаг байсан гэдэг. Бүхэл бүтэн янгирыг бүсэндээ хавчуулаад биедээ шингээж байсан гэхээр ямар хүн байсан нь ойлгомжтой. Тувагийн хулгайч нар “Бөх” Ивэгийг хараад ер бусын хүн байна гэж сүрддэг байсан гэдэг. Гэсэн ч тэд өөрсдөө айхтар чадалтай улс байсан нь ойлгогддог. Нэг удаа Тувагийн хэдэн хулгайч “Бөх” Ивэгийн шургааган хашаанд байсан адуунаас хулгайлаад зугтсан байгаа юм. Үүнийг Ивэг мэдчихээд тэдний хойноос гэрийн туурга өргөж тавьдаг ацтай бүдүүн мод бариад мориор хөөж л дээ. Тэгээд гүйцэж очоод ацтай модоороо ширвээд цохьтол огт тоосон шинжгүй мөнөөх модыг нь гараас нь суга татаад авч байсан гэдэг. Тийм чадалтай хулгайч нар байсан хэрэг. Хуучнаар Төгсбуянтын хийд болох манай Түргэн сумын 4-р багийн дарга Үрдэй гэдэг хүн Тувагийн хулгайч нартай тэмцэлдэж яваад тэдэнд алуулах шахаж байлаа. Зарим нь түүнийг шууд алаад хаячихья гээд байж. Харин ахмад настай нэг нь “Амьд гарвал аз чинь, үхвэл хохь чинь” гээд Үрдэй даргын хоолойг боогоод хээр хаячихаж байсан гэдэг. Увсынхан сүүлдээ тува нарыг дийлэхээ байгаад замыг нь тосоод буудалцаж байлаа. Тувагийн арав гаруй хулгайчийг бөөнөөрөө довтлоод ирэхэд нь манайхан өөдөөс нь буудаж, тэд ч хариу буудалцаад, цусанд будагдсан тэр газрыг нь хожим “Урианхайн хөндий” гэж нэрлэх болсон. Одоо ч энэ нэрээрээ байдаг. Арав гаруй хулгайч бүгдээрээ үхэж, харин 16 настай урианхай хүү амьд гарсан. Энэ хүү манай хүмүүсээс зугтаагаад ойролцоох өндөр хадан хясаа руу авирч гараад, манайхан дороос нь “Миний хүү буугаад ир. Бид чамайг амьд үлдээнэ” гэж хашгирсан ч хор шартай хүү хадан хясаан дээрээс шууд үсрээд амиа хорлочихож байсан түүхтэй. Түүний үсэрсэн хадыг нутгийн ардууд “Урианхай толгой” гэж нэрлэх болсон доо. Миний хувьд гэвэл 14 наснаасаа нутгийнхаа ахмад хүмүүсийг дагаж ан ав хийдэг болсон. Манай нутагт тарвага ихтэй Байрамын даваа гэж бий. Нэг удаа бид Байрамын давааны ард тарвага агнаад байж байтал дөрвөн тува залуу тарвага агнахаар ирсэн. Гэсэн ч бүрий болсон байсан болохоор тэд амарч хоноод өглөө тарвага агнахаар болсон. Тэд манай хүмүүсээс “Ганц

хоёр тарвага өгчих. Өглөө бид агнаад хариуг нь барьчихъя” гэхэд Тувагийн хулгайч нарт угийн дургүй манайхан тэдэнд ганц ч тарвага өгөөгүй. Маргааш нь тэд тарвага буудах гэж ёстой үзүүлж өгч билээ. Морин дээр давхиж явсанаа гэнэт мориноосоо буугаад л тарвага буудаж унагана. Ингэсээр байгаад үд дундын үед өчнөөн тарвага алчихаж байгаа юм. Тэгээд тэд манайханд хандаж “Танай Алтай нутаг урианхай, монгол гэж ялгадаггүй юм байна. Бид та нараас тарвага гуйхгүй” гэж шарлахаж билээ. Манай нутагт Тувагийн хулгайч нартай хэл үгээ ололцдог ганц л хүн байсан. Тэр нь алдартай шилийн эр Харигийн Цийрэн гэдэг хүн байлаа. Гурван төрийн нүүр үзсэн шилийн эр гэж Увсынханд их хүндлэгддэг байсан юм. Харигийн Цийрэн Ардын хувьсгал ялахаас өмнө Увс, Тувагийн нутагт адуу хөөж нэрд гарсан хулгайч байлаа. Арван хэдэн настайгаасаа буюу 1900-гаад оны үеэс эхлээд адуу хөөж Манжийн төрийг дуусгаад, 1911 оноос 1921 он хүртэл Богд хаант Монгол улсын төрийг адуу хөөж өнгөрөөгөөд, 1921 оноос 1952 он хүртэл Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийг адуу хөөж даажигнаад 70 гаруй насандаа цаазаар авахуулсан хүн дээ. 1952 онд түүнийг Увсын прокурор Авирмэд гэдэг бүдүүн бор хүн баривчилж байлаа. Тэр үед би 22 настай байлаа. Түүний шүүх хурал Увс аймгийн төвд гурван өдөр үргэлжилж байсныг би санадаг юм. Тэр үед дээд хэмжээ сонссон хүнийг заавал Улаанбаатарт авчралгүйгээр аймгийн төв дээр цаазалчихдаг байсан. Харигийн Цийрэн Увс аймгийн төвд цаазаар авахуулсан. Мань хүн Ардын засаг ялахаас өмнө арван тавны цагдаа нарт баригдалгүй хорин жил болсон гэдэг юм. Ардын засаг ялсаны дараа социалист төрийн цагдаад баригдалгүй гучин жил болж, нийтдээ бүхэл бүтэн тавин жил төрийн цагдаатай муур хулгана болж тоглосон хүн дээ. Хариг гэдэг нь түүний овог биш орогнодог байсан газрынх нь нэр. Увс аймгийн Сагил, Давст сумын заагт байдаг газар л даа. Цагдаа нар “Харигийн Цийрэн хот айлуудаар хэсүүчилж явна” гэсэн мэдээ сонсоод бөөн машин тэрэг болсон амьгад давхиад ирэхэд мань хүн усанд хаясан чулуу шиг л алга болчихдог байв. Ийм байдлаар олон удаа цагдаа нарыг чулуу хөөлгөсөн гэдэг юм. Тэгээд дал гарсан хойноо баригдаж байгаа юм. Уг нь хүн алж, хүрээ талаагүй л юм билээ. Цаазаар авахуулах гол шалтаг нь хоёр гурван ч эмэгтэйг хүчиндсэнтэй нь холбоотой гэдэг. Адуу малыг бол яахав хөөж л байсан юм байгаа биз. Гэхдээ голдуу Тувагаас адуу хөөж ирдэг байж. Хүүхэн хүчиндэхийн хувьд гэвэл нэг удаа Цийрэн нэлээд баян айлд яваад орж. Гэрт нь нэг царайлаг хүүхэн гав ганцаараа байж. Цийрэн хүүхэнд хандаж “Хоёулаа ганц удаа эр эмийн ажил хийчихье” гэж л дээ. Тэгтэл цаад ихэмсэг бөгөөд аманцар хүүхэн нь “Чам шиг явуулын гуйлгачингийн мунаг харыг ариун умайдаа хийлгэж байснаас халуун нурам хийсэн нь дээр” гэж тавласан байгаа юм. Хариуд нь Харигийн Цийрэн “Өө, тийм үү. Халуун нурам дээр юм гэж үү” гээд хүүхнийг барьж аваад өмдийг нь шувтлаад зуухнаас нь халуун нурам аваад нөгөөдөх рүү нь хийчихэж. Хүүхэн байдгаараа чарлаад, хярвас үнэртээд л явчихаж байсан гэдэг. Бас нэг удаа хөдөө хээр явж байтал ихэмсэг байрын хүүхэн хонь хариулаад явж байж. Өөрийн гэсэн эхнэргүй, насаараа ганцаараа хээрээр гэр хийсэн Цийрэн л болсон хойно нөгөө л эр эмийн ажил хийх тухай саналаа тавьсан байна. Тэгтэл хүүхэн түүнийг шилийн хулгайч гэдгийг мэдэлгүй “Чам шиг тэнэмэлийн дор орж хэвтдэг хүүхэн би биш” гээд хэлээд тавьчихаж. Цийрэн өөрийгөө хэн болохыг мэдүүлээд бас л хүчирхийлсэн байгаа юм. Хүүхнүүд амнаасаа болсон байдаг. Гэхдээ эсэргүүцэх нь тэдний хувьд зөв л байсан байх. Хамгийн гол нь ямар хүнд, хаана, хэзээ, юу хэлж байгаагаа бодох л хэрэгтэй байсан болов уу. Хөдөө хээр, чадал дорой бүсгүй хүн хамаа намаагүй сэмбэлзэж болохгүй гэдгийг Харигийн Цийрэн ойлгуулаад өгч л дээ. Увс аймагт хамгийн их зард гарсан нь Харигийн Цийрэн, “Хилэгнүүр” Болоож хоёр юм. Гэхдээ Болоож бол Цийрэнгийн хажууд хэн ч биш. Энэ нөхөр дуулианаар л нэр гарчихсан хүн. Далаад оны үед Болоож Увсын нэгэн хот айлыг голомтоор нь

хүйс тэмтрээд цагдаа нарт баригдалгүй ууланд гурван жил бүгэж байсаар Тува руу гарах гэж байгаад баригдаж, тэгээд цаазлагдах гэж бөөн дуулиан болж байсан хүн. Шилийн сайн эр биш нэг муу алуурчин. Харин түүний хажууд Харигийн Цийрэн бол гурван төрийн нүүр үзсэн, тавин жил хээрээр гэр хийсэн алдартай шилийн эр байхгүй юу. Баруун аймагт домог болсон энэ хүнийг дээхэн үеийн Увсынхан андахгүй.

## **Манжийн эсрэг тэмцэгч Амарсанаа, Чингүнжав нарын үеэс шилийн эрчүүд хөдөлгөөнд орж эхэлжээ**

Билгийн тооллын арван нэгдүгээр жаран буюу 1660-аад оноос, тодруулж хэлбэл Манжийн эсрэг цогтой тэмцэгч Галдан бошигтын үеэс эхлээд шилийн сайн эрчүүд “үүсч хөгжсөн” гэж хэлж болно. Үүнээс зуугаад жилийн дараа буюу Манжийн эсрэг тэмцэгч Амарсанаа, Чингүнжав нарын үеэс эхлээд шилийн эрчүүдийн үйл ажиллагаа улам идэвхжиж хөдөлгөөнд орж эхэлсэн байдаг. Учир нь яг энэ цаг үед манж, хятад болон тэдэнд урвасан ноёд баядыг муу хэлсэн, үзэн ядсан уур амьсгал халх монголчуудын дунд бий болж эхэлсэн бөгөөд хээрээр гэр, хэцээр дэр хийх дуртай омголон эрчүүд үүнийг далимдуулаад манж, хятадын хөсөг цувааг тонох, ноёд баядын адуу малыг хөөх зэргээр алдхан биеийнхээ аз жрагал, эрх чөлөөг аатай цуутайгаар эдэлж эхэлсэн байдаг. Гэхдээ тухайн үеийн шилийн эрчүүд хожмын “Торой” Банди, “Тогос” Чүлтэм нар шиг ганц нэгээрээ адуу мал хөөж байсангүй. Манж, хятадууд руу цэрэг армийн шинжтэй бүлгээрээ уулгалан довтолдог байсан тухай зарим нэг түүх бичлэгт дурдагдсан байх бөгөөд энэ тухай зохиолч Д.Цэмбэлийн “Амарсанаа”, Ж.Пүрэвийн “Зүрхний хилэн” романд тодорхой өгүүлсэн байх аж. Жишээ нь “Амарсанаа” романд “Манжийн төр Зүүнгарын хаант улсыг дахин өндийхөөс өнгөрсөн гэж үзээд их цэргийнхээ гол хүчийг татаж эхлэв. Хэдэн хоногийн турш буу зэвсэг төдийгүй дээрмийн их олз омгоо дааж ядтал ачсан Манжийн цэргийн унаа хөсөг намрын хүйтэн бороонд норж, шавар шавхай болсон Бээжин замаар тасралтгүй цувна. Энэ үед шилийн сайн эрчүүдээр толгойлуулсан нутгийн ардууд зам гудас, ой тайга, хад асганд нуугдаж байгаад уулгалан дайрч, олон сарын аян дайнд ядарч сульдсан манж, хятадын цэргүүдийг хайр найргүй хяргаж, унаа хөсөг, буу зэвсэг, дээрмийн эд хогшлыг нь цуваа цуваагаар олзлон авч байлаа. Хэсэг бүлгээрээ яваа ойрадууд манж, хятадын буу зэвсэг, тэр ч бүү хэл үхэр буунуудыг хүртэл нэгийг ч үлдээлгүй дээрэмдэж аваад ул мөргүй алга болчихно. Сүүлдээ шилийн эрчүүдийн халдаагүй цуваа хөсөг гэж нэг ч үгүй болов. Тэд тэнгэрээс унаад ирэв үү гэлтэй хэдэн зуугаараа гэнэт гарч ирээд үхэх сэхэхээ мэдэхгүй алалдан тулалддаг байв. Энэ тухай Манжийн Тэнгэрийг тэтгэсэн хаан мэдсэнсэн бол хилэгнэн уурсч, жанжин, сайд нараа зоосдож хороох байсан биз ээ. Учир нь эзэн хаан цэрэг, түшмэдүүддээ хандаж “Еэ дээ, тэдэнд ширмэн тогоо, төмөр эдлэл өгүүзэй. Ойрадууд түүнийг хайлуулж цэргийн зэвсэг цуглуузай” гэж урьдчилан сануулсан юмсанж. Тиймээс жанжин, сайд нар нь асар их хохиролоо эзэн хаанаасаа тас нууж “Ганц нэг хулгай тааралдаж байна” гэж даруухан айлтгадаг байлаа” гэж өгүүлсэн байх аж. Энэ бол Зүүн гарын хаант улсад өрнөсөн үйл явдал. Тухайн үед Чингүнжавын Хотгойд нутагт ч энэ мэтийн үйл явдал өрнөж байсан бөгөөд манж, хятадууд руу уулгалан довтолсон шилийн эрчүүд үүнийгээ Манжийн эсрэг тэмцэж байна гэж цагааруулдаг байж. Ж.Пүрэвийн “Зүрхний хилэн” романд өгүүлэхдээ “Орхон голын сав нутгаар “Манж ноёд, хятад худалдаачдыг дураараа хөөж тонилгон эд юмыг нь устгаваас төрд тус болно” гэж Шадар ван Чингүнжав зарлиг буулгаж гэнэ гэсэн үг айлаас айл, амнаас ам дамжин түгсээр нутгийн сайн эрчүүд энэ дуулианаар далдуур морио сойж, нум сумаа чангалан засч, муна бороохой зэхэх болжээ. Ингэж бэлтгэсэн хүмүүс нэгэн дохиогоор Цантын гарман дээр цугларч хоёр өдөр дараалан бөөгнөрөн шуугилдаж сур харван, шагай няслан үймжээ. Харвал тэд зугаацахаар бөөгнөрсөн хүмүүс мэт байснаа Орхон голыг уруудан бөөнөөр явжээ. Тэнд гурван зуу гаруй эрчүүд хоёр анги болон хуваагдаж “Замд буй хятад худалдаачдын юу байгааг хурааж, шаахайг нь үүрүүлээд Бээжинд нь буцаана. Манж нар биднийг даран сөнөөхөөр ирвэл голоо тасартал үзэлцэнэ. Хиагтад



байгаа Хятадын пүүсүүдийг тал талаас нь гэнэт довтолж ороод эд барааг нь хурааж авна. Дараа нь бид цаашаа Дэлгэр мөрний газар хүрч Шадар вангийн цэрэгтэй нийлнэ” гэж ярилцаад хөдөлжээ. Тэр босч хөдөлсөн олон хүний чимээгээр Орхон голыг дагаж байрласан худалдаа, тариа ногооны хятадууд сандарч мэгдэн эд юмаа уул хад, эрэг ганганд булж нуун, зарим нь орон гэрээ орхин дүрвэж эхэлсэн байна. Тэд Хиагтад суугаа манж түшмэлийн газарт очиж “Үхэр монголчууд оодогнон давхиж байна. Тэднийг дөрлөн уяж өгөөч” гэж хүсчээ. Газар бүр үүн шиг олон зуун баг сайн дураар бий болж, тус бүрдээ манж, хятадуудтай тэмцэл хийж эхэлсэн боловч тэднийг дэмжин зохион байгуулж байгаа ноёд халх газарт Чингүнжаваас өөр байгаагүй нь тэр их оргилсон хөдөлгөөнийг нэгтгэж чадахгүйд хүрч байлаа” хэмээжээ.

Хэрвээ тухайн үед халхын ноёд түшмэд Чингүнжав, Амарсанаа лугаа адил нэгэн үзүүрт сэтгэлтэй байсансан бол нутаг нутгийн шилийн эрсийн хүчийг ашиглаад манж, хятадыг нэлэнхүйд нь шар махтай нь хатааж орхих байсан болов уу. Гэсэн ч ганц дайчин ганцаардахгүй гэгчээр Чингүнжавын уриа дуудлагаар гарч ирсэн үймээн улам лавширч, сүүлдээ Монгол орон даяар түгэж, Алтайн нуруунаас Буйр нуур хүртэлх газарт нийтийг хамарсан тэмцлийн шинжтэй болж, Ховд, Завхан, Идэр, Чулуут, Хануй, Тамир, Сэлэнгэ, Орхон, Онги, Туул, Хэрлэн, Хараа, Ерөө, Онон, Балжийн сав нутгаар шилийн эрчүүдээр удирдуулсан баг, бүлэг байгуулагдаж, дор бүрнээ л армаг хүлгийн дэлэн дээр улаан залаатай ноцож эхэлжээ. Тэд хятад худалдаачдын пүүс, манж түшмэд нарын ордон өргөөг дайран довтолж, эздийг нь жанчин залхааж эхэлсэн тухай мэдээнүүд Ховд, Улиастай, Их хүрээ, Хэрлэнбарс хотуудад суугаа манж түшмэлийн газруудаар тархах болсон байна. Мөн “Түмэн газрын хулгай, төрийн бөөс нараар толгойлуулсан дээрэмчдийг барьж цээрлүүлэн, эд барааг минь нөхөн төлүүлж өгөөч” гэсэн бичиг сэлт Их хүрээн дэх Шанзодба яаманд олноороо ирж байсан гэдэг. “Төрийн бөөс” гэдэг нь шилийн эрчүүдийг хэлж байгаа хэрэг. Үүнээс гадна Түшээт ханы хошууны дал гаруй хүн мориор гэнэт бөөгнөрөн давхиад Бургалтай, Толгойт, Хүйтний голд байсан хятад худалдааны газруудыг тонон дээрэмдэж, Дархан вангийн хошууны зуу гаруй морьтон Их хүрээний газар довтолж худалдаачин хятадын найман пүүсийн эд юмсыг сүйтгэж, халх газраас бөөгнүүлсэн арьс шир, үс ноосыг нь шатааж, торго дурданг хуй хуйгаар нь усанд хаяж, зээлийн худалдааны данс бичгүүдийг нь устгаж, зарим эд барааг тонон дээрэмдсэн тухай түүхийн зарим бичвэрт тэмдэглэгдэн үлджээ. Чингүнжавын үед Хотгойдын Бүргэдбөх хэмээх шилийн сайн эр халх даяар цууд гарч байсан бөгөөд тэрбээр зөвхөн хятад, манж гэлтгүй оросууд руу хүртэл халдан довтолж адуу малыг нь хөөдөг байж. Сүүлдээ бүр Улиастайн манж амбаны занаанд орсон гэдэг. 2011 онд “Шадар ван Чингүнжавын бага нэвтэрхий толь” хэмээх ном хэвлэгдсэн бөгөөд үүнд Манжийн хаан болон Ховд, Улиастайн манж амбаны захиран шийтгэж байсан зарим нэг бичиг баримт бүрэн эхээрээ хэвлэгджээ. Энэхүү номонд “Хотгойд, Урианхайн Бүргэдбөх зэрэг хулгайч нар Оросын Агар харуулын морь малыг дээрэмдсэн тухай Улиастайн амбанаас Түшээт хан аймгийн жанжин Санзайдоржид явуулсан бичиг” гэсэн зүйл хэвлэгдсэн байхыг бодоход шилийн эр Бүргэдбөх нь Улиастайн манж амбаны хар дансан дахь шүдний өвчин, нүдний чичлүүр, түмэн газрын хулгай, “Төрийн бөөс” байсан нь тодорхой. Бүргэдбөхөөс зуугаад жилийн өмнө буюу Галдан бошигтын үед Хасагийн Янгир султаан хэмээх сайн эр хятад, манжууд руу харвасан сум шиг дайран орж бусниулдаг байсан тухай домог яриа байдаг. Өлөгчин чонын хөх дэлэн хөхөж, түүхий мах идэж, чонон сүргийн дунд дэгдэн дүүлж явсан гэдгээрээ Зүүнгарын хаант улсад цууд гарсан энэ эр Монголын уран зохиолд “Монгол цусны

хасаг эр Янгир султаан” гэж дурдагдсан байдаг. Сүүлдээ мань эр өөрийн гэсэн цэрэгтэй болж бөөн цэргийн хүчээр зэргэлдээх нутаг хошууд руугаа уулгалан довтолдог болжээ. 2012 оны өвөл хэвлэгдсэн зохиолч Д.Жамъяангийн “Чорос” романд Янгир султааны тухай цухас дурдагдсан байх бөгөөд гэхдээ манж, хятадууд руу дайран довтолсон тухай нь биш Зүүнгарын хаант улсыг захирч асан Эрдэнэбаатар хунтайжийн заналт дайсан болсон талаар бичигджээ. Цухас өгүүлбээс: “Хөх хөндийгөөр цэргүүд дүүрэв. Эрдэнэбаатар хунтайжийн цэргүүд бүрэнхийд гялалзсан зэс сэлэм, зэс дуулгатай учир цаанаа нандин бөгөөд торгон цэргийн шинж бүрджээ. Угаас Зүүнгарын нутаг усыг эзлэх санаархал өвөртөлж, малын бэлчээр, эд баялагт нь шунан дурлаж, үе үе хилийн дээс алхаж увайгүй дээрэм тонуул хийдэг Хасагийн зэрлэгүүдэд шанг нь хүртээх цаг болсон гэж Хунтайж бодно. Жагсаалын нөгөө талд тас хар нөмрөгтэй баатар эр гарч ирлээ. Түүний адил тас хар хувцастай морьтонгууд асга чулуу шажигнуулсаар хөндий дүүрэв. Энэ бол Хасагийн Янгир султааны байлдаж харвахдаа гаргууд зэрлэг мянгат ажээ. Хоёр талын уур хилэндээ автагдсан цэрэг эрс удахгүй болох ирүүл тулалдааныг хүлээж бие бие рүүгээ ассан гал мэт харц чулуудна. Тас хар хувцаст Янгир султаан бол хасгийн цуутай дээрэмчин төдийгүй багадаа чонын үүрэнд өссөн хэмээх цуурхалын эзэн бөлгөө. Түүний эрүүнд улаан сахал бавайтал ургаж, догшин ногоон нүдийг нь чимэглэнэ” гэх мэтээр дүрсэлжээ.

Манжийн эсрэг цогтой тэмцэгч Галдан бошигт, Амарсанаа, Чингүнжав нарын үед шилийн эрчүүд ганц нэгээрээ бус хэсэг бүлгээрээ, цэрэг армийн шинжтэйгээр манж, хятадууд руу уулгалан довтолдог байсан бол Амарсанаа, Чингүнжав нарын бослого дарагдаж, Чин гүрний хууль цааз илт чангарсан 18-р зууны үеэс Манжийн эсрэг довтлох цэрэг армийн хүч, цэцэн шударга жанжид, цэх шулуун баатар эрс үгүй болсоноор манж, хятадууд улам оодорч эхэлсэн байдаг. Харин тэр үед хаа очиж муу нэртэй, луу данстай шилийн сайн эрчүүд л эх оронч сэтгэлгээний хэлтэрхий болон гялалзаж, эзэрхэг манж, идэмхий хятад, эвдэрсэн баяд, ихэс ноёдтой их багаар тэмцэж, эг маггүй шоглож, эрх дархыг нь дундалж, эд малыг нь цөлмөж, зарим нь Манжийн харгис есөн эрүүнд тарчилсаар ирсэн түүхтэй билээ.

## “Өндрийн өвс” дууны эзэн ЦЭСЭР ГЭЛЭН

“Өндрийн өвс” дууны эзэн ЦЭСЭР ГЭЛЭН

“Өндрийн өвс

Өндөр богиноороо шүүдэртээд байна

Өндөр дээрээс харахад

Өнгийн чиг бараа илхэн байна

Олон адуугаа цуглуулаад

Ороо хулыгаа гэнэтхэн чиг барилаа

Уургаар чиг барьдаггүй

Уран аргаар барьдаг морь биш үү

Хорьхон чиг хоногийн газрыг

Хоногоор чиг товчлоод ирдэг биш үү” хэмээсэн эртний нэгэн сайхан дууг Өмнөговь аймгийн аль ч нутгаар явбал сонсч болох ажээ. Энэ дуу дээхэн үед тус нутгийн ардын дуу болж байсан бөгөөд зохиогч нь Өмнөговь аймгийн “Ширээ шавагтай” хэмээх нутагт амьдарч асан адуучин Цэсэр гэлэн хэмээх сайн эр юмсанж. Цэсэр гэлэн анхандаа лам байж. Гэвч хар нялхаасаа морин дэлэн дээр дэрвэж өссөн түүнд ламын амьдрал таалагдсангүй. Тэгээд гуч гарсан хойноо хар болж эхнэр авч амьдрал зохиох гэсэн ч хэдийнэ оройтсон байлаа. Ид шижигнэж явах насандаа хийдийн хоол хороож явсан түүнд хөрөнгө хогшил, мал ахуй гэхээр юм байсангүй. Гэтэл тэр нэг л өдөр баахан адуутай болчихжээ. Өвөрлөгч нутгаас хөөж ирсэн тэр олон адууных нь хойноос нэхэл дагал болж хүн амьтан ч ирсэнгүй, нутгийн ардууд нь ч өөрсдийн нь мал сүрэг бүрэн бүтэн байсан болохоор Цэсэр гэлэнг элдвээр өөлж баалсангүй. Ингээд гэв гэнэт тэнгэрээс унасан гэмээр олон адуутай нэг л их баян хүн говь нутагт хурдан морь уяж, найр наадам хийгээд нэг хэсэг манаргасан байна. Тэгж байтал нутаг оронд нь нэг бяцхан хэрэг дэгджээ. Нутгийн нь хэсэг ард Хятадын доншуур худалдаачдыг дээрэмдсэнээр хятад, монголчуудын дунд бяцхан мөргөлдөөн болж, олны олон арван цэн гэгчээр нутгийн ардууд хятад худалдаачдыг дийлсэн байна. Мөргөлдөөний үеэр хоёр гурван ч хүн амиа алдсан тул хошууны тахрууд хэргийн эзнийг олж тогтоож шийтгэхээр мөрдөн хөөцөлджээ. Тэгээд тэд эцэст нь гэв гэнэт олон адуутай болж баяжсан Цэсэр гэлэнг барьж хорихоор болсон байна. Үнэндээ ч Цэсэр гэлэн тэрхүү мөргөлдөөнд оройлон оролцсон юмсанж. Цэсэр гэлэнг хошуу тамгын тахрууд зодоонд оролцсон гэж сэжиглээд баривчлах гэж буйг нутгийн нэг ард мэдмэгцээ түүнд яаралтай ирж хэл дуулгажээ. Цэсэр гэлэн энэхүү будлиантай хэргээс мултрах арга сүвэгчлэн элдвийг тунгааж бодсоны эцэст Богдын хүрээ орох нь зөв юм байна гэж шийдсэн байна. Тэгээд сүргийн манлай болсон хул морио барьж унаад өдөржин шөнөжин галигуулаад өглөөний ургахын улаан нарнаар Богдын хүрээний өмнөх Хан-Уулын

Бурхантын даваа буюу Айдасын даваан дээр гарч иржээ. Энд бууж морио амсхийлгэх зуураа эргэн тойрноо ажиг харвал өглөөний наранд өндрийн өвс урт богиноороо шүүдэртэн, өлөн манан голын хөндий даган хөвсөлзөөд иржээ. Тиймээс түүний сэтгэл хөдөлж дээр өгүүлсэн “Өндрийн өвс” дууны үг аяндаа орж ирээд шууд л аялан дуулсан гэдэг. Цэсэр гэлэн тэр өдрөө Богдын хүрээний зах дээр очиж албаар зодоон цохион үүсгээд арван тавны цагдаа нарт баригдаж байсан гэх бөгөөд ингэснээр говь нутагт болсон хүн амины хэргээс ямар ч шийтгэлгүй мултарч байсан гэдэг. Учир нь хаа холын Богдын хүрээн дээр зодооны хэрэгт холбогдсон Цэсэр гэлэн ганц хоногийн өмнө говьд болсон зодоонд оролцсон байх үндэсгүй гэж дүгнэсэн байна. Энэ бүхэнд түүний хурц түргэн явдалтай хул морь тус болжээ. Энэ хул морийг хөгширч үхсэний дараа бас нэг хурдан хул морь түүнтэй нэр холбогдох болсон бөгөөд говийн даншиг наадамд удаа дараа түрүүлсэн энэхүү хул морийг зүүн зүгийн нэг хулгайч хулуулан авч оджээ. Гэвч Цэсэр гэлэн хурдан хул мориныхоо хойноос мөрдөж нэхсэнгүй. Учир нь тэрбээр хул мориндоо нутгийнхаа “Ширээ шавагтай”-н уснаас өөр ус амсуулалгүй нас биед хүргэсэн бөгөөд хайртай сайн морио уудаг ус, унаган нутагтаа гүйгээд ирнэ гэж бат итгэсэн хэрэг. Тиймээс тэр нутгийнхаа хүмүүст “Ширээ шавагтайн худгийн онгоцонд ус битгий дүүргээрэй. Хэрэв ус дүүргэж орхивол миний хул морь хүрч ирээд гэнэт их ус уугаад гэдэс нь хагарч мэднэ” гэж захижээ. Нутгийн нь хүмүүс ч түүний захисан ёсоор худгийн онгоцыг дүүргэлгүй жаахан ус үлдээж орхидог болж. Тэгтэл гай газар доороос гэгчээр нэг бадарчин тэнүүчилж яваад “Ширээ шавагтай”-н худаг дээр ирж цай чанаж суухдаа худгийн онгоцыг усаар дүүргэж орхижээ. Төдөлгүй зүүн хойд зүгээс онц сайхан галбиртай хул морь янцгаасаар давхин ирж худгийн онгоцонд дүүргэсэн усыг юу ч үлдээлгүй хоосолж орхиод зогссон газраасаа хөдлөлгүйгээр зогсоогоороо нүд аних нь тэр. Үүнээс үүдэж говь нутагт “Бадарчин явсан газар балагтай, батгана суусан газар ялаатай” гэдэг зүйр үг үүссэн гэдэг билээ. Цэсэр гэлэн хайртай хул морио үхэнд ихэд уй гашуу болж, улмаар мориныхоо толгойг “Өгөөмөр” хэмээх ууланд аваачиж тахиад,

“Олон агтын дотроос

Шинж төгс хул морь минь

Хагсаал юугаа гүйцээгээд

Наадамд уралддаг билээ

Газрын хол шунгахад нь

Улам л өмнөх морио

Гүйцэн гүйцэж давхисаар

Түрүүлээд ирдэг билээ” гэсэн уртын дуу зохиосон гэх бөгөөд уг дууг эрт цагийн говьчууд төрийн гурван дууны нэгэнд багтааж наадмын морь тавих болон найр өндөрлөхөд дуулдаг заншилтай байжээ. Дашрамд хэлэхэд Цэсэр гэлэн хайртай хул мориныхоо өшөөг авч байгаа нь тэр гээд зүүн зүгээс хэд хэдэн удаа адуу хөөн ирж гомдолоо тайлсан гэдэг билээ.

## Боржигон сэцэн вангийн сайн эр Гээнзий

Эрт цагт Боржигон сэцэн вангийн хошуунд Гээнзий хэмээх сайн эр байжээ. Мань эр залуу зандан насандаа нутаг хошуундаа ихэд алдартай байсан тул түүний нутагладаг байсан бяцхан уул толгодтой, бартаа ихтэй газрыг нутгийн ардууд “Гээнзий” гэж нэрлэх болжээ. Энэ нь он цагийн уртад “Хээнций” болж өөрчлөгдсөн бөгөөд Говьсүмбэр аймгийн нутагт байх тэр газрыг нь одоо хүртэл “Хээнций” гэж нэрлэдэг аж. Өөрийнхөө нэрийг ийнхүү нутаг хошууныхаа уул усанд мөнхөлж үлдээнэ гэдэг нь сайн эр явсаны л шинж болов уу. Шилийн эр Гээнзий нэлээд өндөр насалсан хойноо Чойрын уул хавьцаа явж байгаад бэлчээрт идээшилж байсан хонин сүргийн хажуугаар өнгөрөхдөө залуу насныхаа явдлыг санагалзаад нэг хонь шүүрч аван эмээл дээгүүрээ хөнтрөөд галигуулж гарчээ. Тэгтэл хонины эзэн гадарласан бололтой хойноос нь нэхэж хөөсөн байна. Үүнийг мэдсэн Гээнзий хонийг нь эмээл дээрээсээ буулгаж хаяад зугтах гэснээ “Эр хүн зорьсондоо, эмээлт морь харайсандаа” гэж өөртөө зориг өгөөд хонийг тэр чигт нь авч явахаар шуударчээ. Ингээд зугтаж явах замдаа мөнөөх хонио эмээл дээрээ төхөөрөөд гэдэс дотрыг нь жалга судгаар тарааж хаясаар махыг нь аваад гэртээ ирсэн байна. Тэгээд тэр махаа ханынхаа толгойд өлгөчихөөд гаансаа нэрээд сууж байтал хонины эзэн орж ирээд “Алив миний хонийг өгөөтөх” гэжээ. Гэтэл өвгөн Гээнзий юу ч болоогүй юм шиг “Гээнзий чоно болж, Гээнзийн хормой хонь болоо юу” гээд үзүүрсгэн дээлийнхээ хормойг сөхөж үзүүлэхэд хонины эзэн “Өө, та өршөөгөөрэй. Би таны хурган дотортой дээлийн хормойг харчихаад л бэлчээр дээрээс хонь дүүрээд явчихлаа гэж бодлоо шүү. Миний энэ муу нүд ч юм харахаа байж дээ. Ёстой эвгүй юм боллоо” гээд байдгаараа ичиж хулганасаар гарч одсон гэдэг.

## “Нугалдаг” Жамбий, түүний хүү “Гүзээ” Содном

Жамбий хэмээх хошуу ноёныхоо нэрээр нэршсэн “Нугалдаг” Жамбий гэгч эр Хятад дахь Баруун цастын халхчуудын дунд өсч ториноод 1944 онд Ар Монголд ирж суурьшжээ. 1920-иод оны үеэс Шинжааны Алтай дахь Хасагийн дээрэмчид халхын Толь гүний хошуу, Дайчин вангийн хошууны ард иргэдийг айлган сүрдүүлж, адуу малыг нь тонон дээрэмдэх болсоноор дээрхи хоёр хошууны наад захад оршин сууж байсан Жамбий хошууныхан хасагуудаас айж дүрвэн Хятадын Ганьсу мужийн Мазуншань хэмээх үржил шимт ууланд очиж суурьшсан байна. Мөн 1930 оноос Монголын Дотоодыг хамгаалах газрын ногоон малгайтанууд хар, шар феодалуудын хөрөнгийг хурааж, эздийг нь шорон гянданд хорьж, цаазаар авах болсоноор Толь гүн, Балдан засаг, Ёст бэйл, Ламын гэгээн, Дайчин ван, Жонон ван зэрэг хошуудын малчид үймэлдэн дүрвэж Мазуншань ууланд ирж суурьшсан бөгөөд ухаандаа ногоон малгайтануудын харгислал ийм олон айл өрхийг Хятадын Ганьсу муж руу тавиад туучихсан хэрэг. Тэр цагаас хойш Ар Монголоос дүрвэж очсон дээрхи хошуудын ард иргэдийг “Хятадын Баруун цастын халхчууд” гэж нэрлэх болсон байна. Харин 1940 оноос их хэлмэгдүүлэлтийн хар шуурга жаахан намдаад ирмэгц Монголын засгийн газар гадагшаа дүрвэж одсон ард иргэдээ цуглуулах ажилд шуударчээ. Ингээд 1944 онд Мазуншань ууланд Монголоос төлөөний хүмүүс очиж элдвээр ухуулан сэнхрүүлсэний хүчинд таван зуу гаруй айл өрхийг Монголд нүүлгэн ирүүлжээ. Эдний дотор гуч орчим насны “Нугалдаг” Жамбий хэмээх хаашаа л бол хашаа дэрвэж мэдэхээр ханхалзаж жавхалзсан бадриун хүрэн эр байсан бөгөөд угийн ном эрдэмгүй, уул хадаар тэнүүчилж өссөн тэрбээр амьдрахын эрхэнд газар нутаг, хүн зоньг нь арван хуруу шигээ мэддэг Өвөр Монголын Эзнээ хошуу болон Ганьсу мужийн Мазуншань уулан дахь баячуудын мал сүргээс Ар Монголд тууварлан ирж амь зогоох болсон байна. Үүнийгээ тэр “Тэнгэрийн хишиг” гэж цагааруулдаг байж. Түүнийг яагаад “Нугалдаг” гэж хочлох болсон нь цаанаа бас учиртай ажээ. Хятадын Баруун цастын халхчууд эрт цагаас эхлээд дөнгөж нядалсан эр хонины түүхий хүзүүг ардаа бариад хутгаар үелэн салгадаг заншилтай байж. Гэвч хонины нойтон ёлцгор хүзүүний үе тэр бүр олдож өгөхгүй, хутгаа жаахан эвгүй дарах л юм бол хуруу гараа зүсчих гээд байдаг, ер нь хэр баргийн эрийн чадах ажил биш байжээ. Энэ нь айлд хүргэн орох гэж буй эрийн чадал чансааг шалгадаг нэгэн төрлийн наадам байсан бөгөөд хэрвээ зургаан үе бүхий хонины түүхий хүзүүг ардаа барьж байгаад нэг нэгээр нь нугалж гэмээнэ агуу хүчит, арга ухаант сайн хүргэн гэж хүндлэгдэх жишээтэй. Дээр өгүүлсэн Жамбий эр хонины түүхий хүзүүг ардаа барьж байгаад төвөггүй нугалж орхидог байснаар “Нугалдаг” хэмээх алдрыг хүртсэн байна. Гэвч мань “Нугалдаг” сүүлдээ хонины хүзүү нугалах биш хол ойроос адуу мал нугалж, нугасладаг хүн болж хувирсан нь нэг тиймэрхүү. Гэхдээ түүнийг харь нутгийн баячуудаас адуу мал хөөн ирж халх Монголдоо хөрөнгө оруулалт хийсэн сайн эр гэж үнэлж бас болох юм. “Нугалдаг” Жамбий 1944 онд Алтай нутагт ирж суурьшихдаа тус нутгийн 18 настай Шижирмаа хэмээх бүсгүйтэй гэрлэж хүүтэй болжээ. Тэгээд мань эр Мазуншань уулнаас хамт нүүдэллэж ирсэн өвгөн лам дээр очиж хүүдээ нэр хайрлахыг хүсээд заяа төөргийг нь үзүүлсэн байна. Өвгөн лам хүүд нь Содномдаржаа гэдэг нэр хайрлаад “Адууны дэлнээс зүүгдэж, шил дээр хоноглож явах тавилантай хүүхэд байна” гэж айлджээ. Үүнийг сонсоод “Нугалдаг” Жамбий “Хүү маань аавыгаа дуурайсан шилийн эр болох нь байна шүү дээ” гэж ихэд билэгшээж байсан гэдэг. Үнэхээр ч Содномдаржаа нь адууны дэлнээс зүүгдэж, шил дээр хоноглох тавилангаа дагав уу гэлтэй шилийн эр болж хэсэг манаргаж байснаа орчин нөхцөлөө дагаад тууварчин болж

социалист төр засагт маш их будлиан хутгасан хүн юмсанж. Жамбий болон түүний хүү Содномдаржаагийн намтар түүхийг дээр өгүүлсэн Шижирмаагийн төрсөн дүү болох 80 гаруй настай Т.Өлзийбаяр гуай хүүрнэсэн юм. “Нугалдаг” Жамбий хүү Содномдаржаагаа хар багаас нь адуу малд эртэй болгож хүмүүжүүлэхийн сацуу алс холоос адуу мал хэрхэн хөөх талаар зааж сургаж, улмаар жараад оны үед хүүтэйгээ хамт өөрийн дадаж заншсан өвөрлөгч нутгаас адуу хөөх санаа агуулсан ч яг тэр үед нь Хятад, Монгол хоёр улсын харьцаа муудаж, хилийн харуул чангараад иржээ. Төдөлгүй өндөр настай “Нугалдаг” Жамбий ч өөд болж, хар багаасаа адуутай ноцолдсон Содномдаржаа эцгийнхээ шийрийг хатаахаар энд тэндээс адуу хөөх аядсан ч бүтэлтэй юм болсонгүй. Түүнийг хоёр гурван ч удаа цагдаад байцаагдаад ирмэгц дээр өгүүлсэн нагац ах болох Өлзийбаяр нь “Миний дүү шилийн эр болно гэсэн наад хачин бодлоосоо сал. Үнэхээр л чи адууны дэлнээс зүүгдэж, шил дээр хоноглох заяа тавилантай юм бол орчин нөхцөлөө дагаад тууварчин бол. Чам шиг хээрээр гэр, хэцээр дэр хийх дуртай хүнд мал тууврын ажил яг тохирно” гэж зөвлөжээ. Ингээд Содномдаржаа тууварчин болсоноор Монголын эрүүгийн ертөнцийн түүхэнд “Гүзээ” Содном гэж алдарших болсон байна. “Тууварчдын” гэх тодотголтой түүний хавгаст хэрэг ч архивт байдаг бололтой. Соц ниймийн үед улс орон даяар мал тууварлах ажил жил бүр өрнөдөг байлаа. Архангай, Дундговь, Өвөрхангайн тууварчид малаа улсын баталсан замаар тууварлан явсаар Улаанбаатарын мах комбинатад хүргэдэг байсан бол баруун аймгийн тууварчид Баян-Өлгийн Цагааннуурын мал хүлээн авах баазад, зүүн аймгийн тууварчид Дорнодын Эрээнцав, Хатгалын мал баазад малаа тушаадаг байж. Баруун, зүүн аймгийн тууварчдын мал хойшоо Зөвлөлт рүү гардаг байсан болохоор тарга тэвээрэгийг нь хатуу шалгаж авдаг байсан тул янз бүрийн булхай гарах нь цөөн. Харин Улаанбаатарын мах комбинатад ирсэн мал тэр өдөртөө л заазанд ордог байсан болохоор зарим нэг тууварчин мал хольж солих нь тоймгүй байжээ. “Гүзээ” Содном зарим үед төвийн чиглэлээр, заримдаа баруун аймгийн чиглэлээр Зөвлөлт рүү мал туудаг байж. Адууны дэлнээс зүүгдэж, шил дээр хоноглож явах нь түүнд жаргалтай байсан ч улсын мал тууварлаж явахдаа эцгийнхээ шийрийг хатааж байгаа нь тэр гээд энд тэндээс мал хөөж авчраад тууж яваа малдаа нийлүүлэх, тууврын мал сүргийг хольж солин дундаас нь ашиг унагах зэргээр жинхэнэ жаалдаг байжээ. Гэхдээ тэр өөрөө өөрийгөө цагааруулах бас нэг үгтэй байж. Тэр нь юу гэвэл “Манжийн үед Монголын мал сүрэг Хятад руу урсдаг байсан бол социалист төрийн үед Монголын мал сүрэг Зөвлөлт рүү урсдаг болсон байна. Эрт цагийн шилийн эрчүүд Манжид мал сүргээ зүгээр алдахгүйн тулд чадах чинээгээрээ тасдаж хөөдөг байсан гэнэ билээ. Одоо тэгвэл би энэ муу шар оросуудад хайран сайхан мал сүргээ үнэгүй шахам өгөхгүй шүү. Харийн муусайн баячуудын мал сүргээс чадах чинээгээрээ хумсална” гэж андгайлдаг байж. Уг нь хэлдэг л үг. Гэвч тухайн үед газар сайгүй Нийгмийг аюулаас хамгаалах яамны мэдээлэгч нар язганалдаж байсан болохоор “Гүзээ” Содном дээрхи үгийг хамаа намаагүй хашгирч байсангүй. “Зөвхөн дотроо бодчих” гэдэг шиг л зөвхөн дотроо бодож, харин ойр дотныхоо итгэлтэй хүмүүст бол чөлөөтэй хэлдэг байж. “Гүзээ” Содном мал тууварласныхаа эхний жил “Нармиан” Цэдэв тэргүүтэй нутгийнхаа хэдэн хүнтэй мянга гаруй мал туугаад наадмын дараахан малаа бүрэн бүтэн тушааж овоо мөнгө хармаалсан байна. Гэвч олон жил мал туусан зальт этгээд Цэдэвийн аргыг тэр дараа жил нь хэрэгжүүлжээ. Тэгэхдээ тэр Цэдэвийн галаас гарч өөрөө бие дааж, цэргээс халагдсан хоёр залууг туслах тууварчинаар авсан байна. Цэдэвийн арга гэвэл нутгаасаа бэлтгэлийн мал тууж гарахдаа нууцгайгаар арав хорин мал зориуд нутагтаа үлдээдэг байж. Мөн хүнсэндээ хэрэглэхээр төлөг, борлон авч гараад явцын дунд бэлтгэлийн малаар сольж холих, зориуд хээлтэй мал авч гарах зэрэг байв. Хээлтэй мал авч гарна гэдэг маань нэг мал хоёр болж өснө

гэсэн үг. Тухайн үед тооноос чанарт шилжих хууль үйлчилж байсан ч Содном түүнийг төвөггүйхэн давж гардаг байж. Мөн түүний бас нэг арга гэвэл “Тууврын зам” кинонд гардаг шиг замд тааралдсан айл хунартай сүрхий танил болж тарга хүч сайтай эр хонийг хоёр жижиг хониор сольж дундаас нь өөртөө бүхэл бүтэн нэг хонь унагах явдал байжээ. Ийм байдлаар Содном эхний хоёр жилд зуу гаруй хоньтой болсон гэдэг. Гэвч хүний шунал ямар барагдах биш. Тэрбээр малаа тушаагаад нутаг буцахдаа зальт аргаар олсон хонио тухайн орон нутагт нь үгүй хийдэг байсан бөгөөд тухайн үед хөдөө нутагт ховор тохиолддог байсан нанжин гахай гөлөм, үйтэн хуар, халуун сав, эмэгтэй хүний өндөр өсгийтэй гутал зэргийг ачаалаад явдаг байж. Энэ нь түүнд тэр жилийнх нь амьжиргаа болдог байсан бөгөөд “Гүзээ” Содном өвлийн турш ажил төрөл гэж санаа зовох явдалгүй архи, даалуу эргүүлсэн шиг л гүзээгээ илээд хэвтчихдэг байж. Тэгээд хавар болуут “Тууврын зам” буюу жинхэнэ луйврынхаа ажилд гарна. Содном ийм байдлаар таван жил мал туугаад гэв гэнэт л баяжиж эхэлжээ. Нутгийн тууварчид түүнд атаархан “Бид олон жил мал туулаа. Овойж оцойсон юм юу ч алга. Тэгтэл Содном учиргүй баяжаад байдаг. Энэ арай тууврын замд бусдын мал хулгайлдаг юм биш биз” гэж дэмий л хардаж сэрдэнэ. Тэрбээр нэг удаа мал тууж ирээд залуухан эхнэр авч, найман ханатай гэр барьж нижгэр найр хийжээ. Зөвхөн гэрээр тогтсонгүй. Мөнгөн эмээл хазаар, хаш чулуун гаанс зэргээр гангарч, морины сайныг шилж унах болжээ. Ямар сайндаа л нутгийн зарим хүн үр хүүхэддээ хандаж “Чи ер нь барилга дээр ажиллаж махаа идэж байхаар ирэх жилээс мал туу. Энэ “Гүзээ” Содномыг харахгүй юу. Мал туугаад л баяжчихлаа. Эхний хоёр гурван жилд яахав жаахан зовж зүдэрнэ л биз. Дөрөв дэх жилээс арга эвээ олоод аяндаа баяжчихна” гэж сургамжилдаг байсан гэдэг. Тийм ч учраас Содномыг дууриаж нэлээд олон залуу тууварчин болжээ. Гэтэл баяждаггүй. “Ная гарчихаад үхдэггүй ээ” гэдэг онигоо шиг л юм болж. Зарим нь бүр малаа дутаагаад төлбөрт орсон байгаа юм. “Гүзээ” Содном сүүлдээ бүр гаршиж малын эмч болон мал баазын жинлэгч нартай хуйвалддаг болсон байна. Тэдэнд зохих хэмжээний хахууль өгч малынхаа жинг нэмүүлэх, замдаа үхэж үрэгдсэнээр акт тогтоолгох, нутгаасаа авч гарсан хургатай хонинуудаа Цагааннуурын мал хүлээн авах бааз хүртэл өсгөж тордоод хургаар нь хонины тоо бөглөх, зам дагуу танилцсан хуурай ах дүү нарынхаа малд тууврын малаасаа үлдээгээд намар буцахдаа авч явах зэргээр есөн шидийн арга заль хэрэглэдэг болжээ. “Гүзээ” Содном мал баазын жинлэгч нартай хуйвалдаад тарган хонины оронд туранхай төлөг өгөх болгондоо “Хохь чинь, муусайн шар оросууд. Та нарт халхын тарган хонины мах идэх заяа дутлаа. Туранхай төлөгний яс мэрээд турж үхэцгээ” гэж далдуур харааж зүхдэг байсан гэдэг. Үүнийг эх оронч сэтгэлгээ гэх нь хаашаа юм бэ. Гэхдээ л Монголын мал сүргийг сорчлон идэж байсан час улаан коммунистуудыг ингэж занх зоригтой эх оронч тухайн үед ховор байсан болохоор “Гүзээ” Содномд баяр хүргэмээр ч юм шиг. Тэр ер нь барил нь олдохгүй их янзын хулгайч байсан ч юм шиг? 2000-гаад оны үед Намбарын Энхбаярыг Орост төлөх их өрийг 250 сая ам.доллараар тэглэх үед “Гүзээ” Содном хэрвээ амьд сэрүүн байсан бол “Хуцав аа, муу шар оросуудад юу гэж мөнгө төлж байдаг юм бэ. Тэд нар Монголын мал сүргийг далан жилийн турш сорчлон идэж, арьс үсээр нь аймаар их ашиг олоо биз дээ. Тэр бүхнийг гэрчлэх амьд гэрч би байна” гээд л хашгираад босч ирэх байсан болов уу. Ингээд бодоход “Гүзээ” Содном Монгол улсад хэрэгтэй хүн байсан ч юм шиг. Хэрэггүй ч юм шиг. Ямар ч гэсэн мань хүн шилийн эр “Нугалдаг” Жамбий эцгийнхээ орон зайг зохих ёсоор бөглөж байсан гэлтэй. Тэрбээр 1980 оны намар тууврынхаа малыг тушаагаад нутаг буцахдаа цоо шинэ мотоцикль унаж очоод нутгийн ардуудын атаархлыг хөдөлгөж орхижээ. Энэ мотоцикль л түүнд үнэхээр гай болсон гэдэг. Учир нь нэлээд хэл амтай Дамдинсүрэн гэгч эр тэр жил бас мал тууж л дээ. Дамдинсүрэн малаа бүрэн бүтэн



тушаагаад овоо мөнгө хармаалсан ч мотоцикль авах мөнгөнд хүрсэнгүй. Тиймээс тэр сумын дарга дээрээ орж “Содном бид хоёр хэн хэн нь малаа бүрэн гүйцэд тушаасан. Тооны хувьд ч адил, тарга хүчний хувьд ч адил. Тэгтэл Содном малаа тушаасан мөнгөөрөө мотоцикль унаад ирлээ. Энд ямар нэгэн учир шалтгаан байна. Содном дээгүүр танил тал ихтэй болж таарлаа. Тууварчдыг ингэж алаг үзэж яав ч болохгүй. Чадлынхаа хэрээр хийж, хийснийхээ хэрээр авна гэсэн социалист зарчим чинь хаана байна” гэх зэргээр зарга үүсгэсэн байна. Үүний дагуу дараа жилийн хавар Содномыг хуулийн ажилтанууд нууцаар шалгахаар болжээ. Түүнийг мөрдөх тусгай хэлтэсийн төлөөлөгч хүртэл томилогдсон байгаа юм. Тэр төлөөлөгч нь Содномын галд тууварчинаар орж ажилласан нь бүр ч балрахын цондон болох нь тэр. Ингээд явцын дунд бүх юмны учир тайлагдсан байна. Хэлтэсийн төлөөлөгч түүний үнэнч хамтрагч болж жүжиглэн хамаг арга залигч нь мэдэж аваад зогсохгүй замын дагуух хуурай ах дүүстэй нь ч дотно танил болж урьд өмнөх жилүүдийнх нь бүхий л хуйвалдааныг нь мэдэж авчээ. Тэгээд намар малаа тушаахыг нь хүлээсэн байна. Төдөлгүй 7-р сар шувгарч 8-р сарын налгар өдрүүд эхлэв. Содном ч яахав хэзээ язааны сурсан зангаараа мал баазын жинлэгч нарыг хахуульдаж туранхай төлөг голдуу малаа тоо ёсоор нь тушаагаад, тэдэнтэй бас архидаж цэнгэсэн байгаа юм. Тэгээд маргааш нь өөртөө сожсон малаа зарах ажилдаа оржээ. Тэгтэл гэв гэнэт цагдаа нар ирээд хоёр гарыг нь гавлаад авах нь тэр. Ингээд түүний тууврын замаас хурааж хуримтлуулсан хамаг эд хөрөнгө улсын орлого болж, хөөрхий Содном арван жилийн ял аваад шоронд морилсон байна. Гэвч тэр шоронд очоод нэг их доошоо орсонгүй. Өөрийгөө бараг л алт мөнгөөр туйлж явсан шилийн сайн эр мэтээр дөвийлгөн “Ах нь юмаа хураалгасан ч баян хүн. Би бас энд тэнд юм нуухаа мэдэлгүй яахав. Төв аймгийн нэлээд олон айлд миний мал хуй байгаа. Харин тэр муу мотоцикль л надад ёстой гай болсон. Уг нь би хүмүүст хар авахуулахаасаа өмнө хамаг хөрөнгөө зараад хот руу шилжинэ гэж бодож байсан юм. Тэгээд шинэ эхнэр авч шил дээр хоноглох заяа тавилангаа дуусгах ёстой байлаа. Адууны дэлнээс зүүгдэж явахаа болиод авто машины жолооноос зүүгдэж явах байлаа. Даанч муу атаач Дамдинсүрэн зарга үүсгэж, бууны нохой Аюурзана гэгч жандарм манай галд шургалж миний хамаг төлөвлөгөөг нураасан. Гэсэн ч эр хүн долоо дордож найм сэхдэг юм, харж л байгаарай” гэж аархдаг байжээ. “Гүзээ” Содном ерээд оны эхээр шоронгоос суллагдаад нутагтаа очсон боловч нэг их дорвитой юм бүтээж чадалгүй байсаар 1992 онд уушигны сүрьеэгээр өөд болжээ. Харин түүний үйлдсэн хэргээс хойш мал тууварчид нэлээд эмх цэгцэндээ орсон гэдэг. Мал бэлтгэлийн ажилтай холбогдуулан 1981 онд Сайд нарын Зөвлөлийн 117-р тогтоол гарч улсын мал бэлтгэлийн ажлыг Худалдаа Бэлтгэлийн Яамнаас Хөдөө Аж Ахуйн яаманд хариуцуулахын зэрэгцээ мал тууварлах, тууварласан малаа тушаах явцад байнгын хяналт тавьж, цагдаагийн гэрээт төлөөлөгчийг ажиллуулах, мал тууврыг орон нутгаас нь гарахаас эхлэн малыг нь зүслэн тоолж зам дагуу шалгах, угтуулж шалгах, замд явахад нь гэнэт малын тооллого хийх, бэлтгэлийн малыг тамга тэмдэгжүүлэх зэрэг нэлээд ажил ундарчээ. Үүний ачаар бэлтгэлийн малын тоо толгой дутах, тарга хүч буурах нь эрс багассан гэдэг.

## Хан Хэнтийн “Гайхал” Батчулуун

18 настайдаа ууланд гарч есөн жил хээрээр гэр хийгээд 27-хон насандаа буудуулж нас барсан “Гайхал” Батчулуун хэмээх цуутай эрийн тухай дал, наяд оны Хэнтий чигийн хүмүүс “Ай, мөн ч хийморлиг эр байж билээ” хэмээн хүүрнэн ярих нь бий. Хэнтий аймгийн Дадал сумын харьяат А.Азжаргал хэмээх залуу нагац ах Батчулууныхаа тухай доорхи яриаг өрнүүлсэн юм.

...Миний аавыг Алтангэрэл гэдэг. Одоо Дадал суманд амьдарч байна. Аавын маань ах “Гайхал” Батчулуун гэж цуутай эр байсныг Хэнтий аймгийнхан андахгүй. “Гайхал” Батчулуун нь 1959 онд Хэнтий аймгийн Дадал сумын “Уужим” гэдэг газар малчин ард Дуламын Доржийн 2-р хүү болж төрсөн. Гурван настайдаа Дугар хэмээх нагацындаа өргүүлсэн. Энэ Дугар нь болохоор Баян-Адаргын “Хөтөлч” гэдэг газар амьдардаг байлаа. “Гайхал” Чулуун ах “Хөтөлч”-ид бага насаа өнгөрүүлээд Баян-Адарга сумын найман жилийн сургуульд орж суралцсан байдаг. Эдүгээ тавь гаруй насыг зооглож буй ангийн нь нэг охин “Батчулуун багадаа их цовоо сэргэлэн, хурдан шаламгай хөдөлгөөнтэй, бусдаасаа өвөрмөц сэтгэлгээтэй хүүхэд байсан. Өвөл цас мөсний баяр болоход морьтой хүн байтугай явган хүн буухааргүй огцом өндөр уулын уруу руу чаргатай ганцаараа гулгаад буучихаг, айхтар овсгоо самбаатай хүүхэд байсан” гэж ярьдаг юм. Манай нутгийнхан Чулуун ахын элдэв адал явдлыг яриулах гэж манайхаар их ирдэг байлаа. Аав маань ахынхаа тухай их юм мэднэ. Хөл нь муу болохоор хотод ирж чадахгүй байна. Тэгээд л намайг Чулуун ахынхаа тухай ярьж өг гэж явуулсан юм. Ерөнхийдөө манай ах Хэнтий аймгийн Дадал, Баян-Адарга, Биндэр, Батширээт гээд хойд талын хэдэн сумдаар домог болж яригдсаар ирсэн хүн. Хэнтийн нурууны нууц агуй хонгилуудаар нэлээд явдаг байсан гэдэг. Дадал сумын хойд тайгын хэд хэдэн хадан дээр “Доржийн Батчулуун” гээд сийлчихсэн нь одоо хүртэл байж л байдаг юм. Чулуун ах маань дунд зэргийн нуруутай, бахим өргөн биетэй, чадал тэнхээ ихтэй, солгой гараараа их гоё зурдаг, сайхан барилддаг, адуунд эрэмгий хүн байсан байгаа юм. 16 настайдаа цэрэгт явсан. Яагаад 16 настайдаа цэрэгт явсан гэхээр тэр үед нөхөрлөдөг улс нь өөрөөс нь хоёр гурван насаар ах хүмүүс байж. Тэд нар нь их хөдөлгөөнтэй, тухайн орон нутагтаа нэлээд давилуун ширүүн, нэг ёсондоо атаман улс байж л дээ. Тэгээд л Чулуун ах тэд нартайгаа цуг цэрэгт мордож Эрдэнэтийн цэргийн ангид хуваарилагдсан байдаг. Гэвч тэнд очмогцоо төрөлхийн давилуун сэргэлэн зангаа гарган дээд оныхоо цэргүүдтэй ач тач зодолдоод дарга нарынхаа хараа хяналтанд орчихож. Үүний зэрэгцээ Чулуун ахын нутгаасаа хамт очсон цэргүүдийг дарга нар нь дэглэж дарамтлаад болохоо байж. Гэтэл нөгөө цэргүүд нь шөнө даргыгаа унтаж байхад нүүрэн дээр нь халуун тос дусааж шархны халуун болгоод, үүнээс болж бөөн асуудал дэгдсэн байгаа юм. Халуун тос дусаасан хүн нь олдохгүй, үүний улмаас нийт цэргүүд бөөнөөрөө дэглүүлээд эхэлмэгц Чулуун ах нөхөддөө хандаж “За энэ хэргийг би дааж та нарын аминд орёе. Одоо би оргоод тайга руу гарлаа. Та нар намайг тос дусаасан гээд хэлчихээрэй” гэж хэлээд шууд оргочихсон байгаа юм. Ингэж анх тайгын хүн болсон байдаг. Тэр хавиасаа унаа, хувцас, хоол унд залгуулж аваад Хэнтий нуруугаа дагаж явсаар байгаад Дадал сумандаа очоод тэндээсээ унах морь, идэх хоол, хувцас хунар базааж аваад Хэнтийн ян сарьдагт гарчихсан гэдэг. Ингээд есөн жилийн турш тайгад амьдарсан гэдэг юм. Хааяа тайгаас буугаад айлд хонох болохоороо хувцастайгаа газар унтдаг. Тэгээд газраас ямар нэгэн чимээ сонсдог ч юмуу зарим шөнө шууд босоод явчихдаг. Дөнгөж явсаных нь дараа цагдаа нар машинтай ирдэг байсан гэнэ лээ. Ер нь их зөн совинтой, мэдрэмтгий хүн байж. Зөвхөн

Хэнтийн нуруунд бүгээд байсангүй. Хэнтийн нуруугаар дамжаад баруун аймгуудыг дуусгаж, Архангай, Булган, Төв аймгийн нутгаар нэг хэсэг манаргаж яваад буцаад Хэнтийн тайгадаа ирсэн гэдэг. Дараа нь Өмнөговь, Дорноговь, Дорнод гээд говийн аймгуудаар хэрэн хэсч явсаар Сүхбаатар аймагт очиж Шилийн богд ууланд тангараг өргөсөн байдаг. Ер нь Монгол орныг нэлэхүйд нь тойрч үзсэн гэдэг юм. Гэхдээ ах маань хүн алж, хүрээ талж явсангүй. Мэдээж уул тайгаар хэсч явсан болохоор хүлэг сайн морийг шилж унах, адуу малыг ийш тийш нь хөөх зэрэг шилийн эрийн ёс жаягийг дагадаг л байж. Дорнод, Сүхбаатар аймгаас хурдан удмын адуу авчирч Хэнтий аймгийн Дадал, Баян-Адарга сумдаар тараадаг, найз нөхөддөө хурдан удмын адуу өгч цус сэлбэдэг, нутгийнхаа ядуу тарчиг айл хунарт адуу мал өгч амьдралд нь нэмэр болдог байж. Үүний улмаас нутгийн нь зарим нэг баян тарган, овилго муутай хүмүүс Чулуун ахад атаархаад цагдаа нарт хов хүргэж үйлийг нь үздэг байж. Тийм ч учраас есөн жилийн турш оргож явахдаа цагдаа нарт өчнөөн удаа хөөгдөж, заримдаа баригдаж Дадалын шоронд орж, Улаанбаатарын “Ганц худаг”-т хүртэл хүргэгдэж байсан. Гэхдээ эрийн сайнаар оргоод л гарчихсан байдаг. Түүнийг барихын тулд Улаанбаатараас тусгай бэлтгэгдсэн цагдаа нар ирж байсан гэдэг. Тэд Чулуун ахыг баривчлаад “Ганц худаг”-ийн шоронд авчраад “Чи ямар ч гав гинжнээс мултардаг сайн эр гэсэн байх аа. Одоо мултрах үгүйг чинь үзье” гээд хоёр гарыг нь гавлаад орхичихож. Тэгээд тамхи татаж байгаад эргээд хартал Чулуун ах аль хэдийн гаваа тайлчихсан зогсч байсан гэдэг. Тухайн үед “Ганц худаг”-ийн шоронгийн өндөр хашаан дээгүүр цахилгаантай утас гүйлгэчихсэн, давж гарах ямар ч аргагүй байж. Тэгтэл Чулуун ах нэг орой яаж ийж байгаад камераасаа гараад цахилгаантай утас гүйлгэсэн “Ганц худаг”-ийн хашаан дээр үстэй хүрэм тохонгуутаа түүн дээрээ хоёр гараараа ганцхан дараад л цаад талд нь үсэрч буугаад оргочихож байсан гэдэг. Гараараа дараад буухад цахилгаантай утсан дээр тавьсан үстэй хүрэм нь хоёр тийшээ тас үсрээд унаж байсан гэж бодохоор 220 вольтоос илүү байсан болов уу. Ялтан хүн оргож яваад тогонд цохиулаад үхэх юм бол өөрийнх нь хохь болоод л дуусах болохоор ийм хүчтэй утас гүйлгэдэг байж л дээ. Чулуун ах хойшоо уулаа дагаад явган нүцгэн гүйсээр байгаад нэг уулын аманд очтол тэнд сайхан хонгор морьтой нэг баян хужаагийнх байж. Ингээд морийг нь авахаар судалж үзтэл метр гаруй өндөр хашаанд байлгадаг, хашаанаасаа харуул хамгаалалттай гаргадаг болох нь анзаарагдаж л дээ. Орой болмогц Чулуун ах морины хашаанд дөхөж очоод тэнд байсан гүйдэг уяатай нохойд идэх юм хаяж өгөөд нөгөө хонгор морийг хашааны хаалгаар аваад гарах гэсэн чинь байшингаас хүмүүс гараад ирж. Тэгэнгүүт морин дээр үсэрч мордоод “Чүү” гэхэд нөгөө хонгор морь өндөр хашаан дээгүүр тэр чигтээ дүүлээд гарч байсан гэдэг. Цаашаа явж байгаад хүүтэйгээ хоёулаа амьдардаг нэг эмгэнийд очоод өөрийгөө шоронгоос оргож яваа гэж үнэнээ хэлж. Тэгтэл эмгэн “Манайхаас зүүн тийшээ явахад чинь хэдэн бараан адуу байгаа. Тэр адуун дотор хоёр ижилхэн хээр морь бий. Барьж чадвал унаад яв” гэсэн байна. Тэр морьд нь айхтар ороо морьд байж л дээ. Чулуун ах нөгөө хонгор морьтойгоо адуу руу давхиж ороод хоёуланг нь богинохон суран жолоогоор бугуйлдаад авсан байгаа юм. Ингээд гурван сайхан морьтой Хэнтийн ян хөвчөөр явсаар байгаад нутгийнхаа барааг харсан гэдэг юм. Үүний дараа Чулуун ах “Ганц худаг”-т хамт хоригдож байсан хоёр өвгөнөө эргэх гээд Улаанбаатарт мотоциклиэр ирж байсан гэдэг. Манай өвөөгийн хуурай дүү нь Улаанбаатарт цагдаа хийдэг байж. Чулуун ах хотод нэг л их ганган амьтан хүрээд ирж. Өвөөгийн дүү өглөө босоод хартал дарга хүний цүнх, орос хром, урт савхин дээл байж. Манайд ямар дарга нь ирж хонодог билээ гээд харсан чинь Чулуун ах. Гэрийн нь хаяг дугаарыг мэдэхгүй, тэгээд харанхуй шөнөөр гэв гэнэт л олоод ирсэн байгаа юм. Сайндаа ч ирсэнгүй. Цагдаагийн хувцасыг нь хулгайлж өмсөөд “Ганц худаг” руу орох гэж л тэр. Ингээд

нэг өдөр мань хүн цагдаагийн хувцас өмсөөд хонины мах, тамхи тариа гээд баахан юм аваад “Ганц худаг”-ийн шорон руу орсон байгаа юм. Харуул хамгаалалтын нь өмнө очоод тап хийтэл ёслоод л “Би аавтайгаа уулзъя” гээд дотогшоо явж ороод хоёр өвгөнөө эргэж байсан гэдэг. Хажуудаа байсан хянагчид итгэл төрүүлэхийн тулд хоёр өвгөний нэгийг “Аав минь” гээд тэврээд авч. Цаад өвгөн нь ч түүнийг таниад “Миний хүү” гээд сүйд болсон гэдэг. Ингэж хоёр өвгөнийг эргэж тойроод гарахдаа мөн л тап хийтэл ёслоод гарч одсон гэдэг. Хаа холоос ингэж эргэж тойрдог нь бас учиртай байж. Чулуун ахыг “Ганц худаг”-аас оргоход энэ хоёр өвгөн их тус болж л дээ. “Их замын эхэнд” кинон дээр шилийн эр Хөх чоно морьтой явахын хажуугаар заримдаа пиджак костюм өмсөөд албаны том хүмүүстэй зоогийн газар уулзаад байдаг. Үүн шиг Чулуун ах байнга морин дэлэн дээр явсангүй. Аймаг, сумдын нутгаар тэнэж явахдаа хааяа дарга хүн шиг хувцаслаад, том хар дипломат цүнх бариад галт тэрэгний тусгай суудалд үнэгүй суугаад явчихдаг, зарим сумдын албан байгууллагад хотоос яваа төлөөлөгч гээд давхиад орчихдог, ямар нэгэн том албан тушаалыг зохиогоод хэлчихдэг, тэгээд баахан дайлуулж цайлуулж байгаад явчихдаг байсан гэдэг. Дал, наяд оны үед манай суманд Дуламрагчаа гэдэг цагдаа байсан. Энэ цагдаа Чулуун ахыг барих гэж олон удаа зүтгээд чадаагүй. Машинтай хөөх үед нь Чулуун ахын нөгөө хурдан хонгор морь нь гүйцэгддэггүй байж. Үүнээс гадна “Уурганы халзан” гээд жижигхэн халзан морь байсан. Энэ морь нь Чулуун ахыг ямар ч үед орхиж явдаггүй, шүгэлдэж гууглахад гүйгээд ирдэг, араас нь дагаж явдаг сургуультай болчихсон, эр хүний түшиг болсон адуу байж. Чулуун ах өөрөө ч тэр, эцэг нь ч тэр морь их сайн таньдаг хүн байсан. Манай Дорж өвөө болохоор сумынхаа наадмаар зургаан насны морь уяад таван түрүүг нь авч байсан түүхтэй хүн. Манай аав мөн л морь сайн таньдаг, адуунд эрэмгий хүн. Адуу уургалахдаа гаргууд. Аавын урдуур босоо морь гарч үзээгүй тухай манай нутгийнхан ярьдаг юм. Залуудаа Дадал сумын Түмэн адууны баяраар адуу уургалж бугуйлдах тэмцээнд түрүүлж явсан хүн. Одоо харин хөлөө хугалаад адуу малтай ноцолдохоо байсан. Чулуун ах бол ааваас илүү адуунд эрэмгий байсан гэдэг. Ямар ч эмнэг хангал морийг уургалангуутаа угзарч унагаад, босч амжаагүй байхад нь морин дээрээсээ үсэрч буугаад бариад авдаг байсан гэдэг. Сайхан барилддаг, бас сайхан дуулдаг хүн байсан тухай манай нутгийнхан ярьдаг юм. Хөдөө хээр дуулахад нь унаж явсан морь нь гэнэт сэргээд шилгээгээд ирдэг байж. Баян-Адарга сумын нутагт “Уртын улаан” гэдэг өндөр хадан хясаа байдаг. Үүн дээрээс морьтой хүн үсэрнэ гэж төсөөлөхийн аргагүй. Нэг удаа Чулуун ах энд машинтай цагдаа нарт шахагдангуутаа шууд морьтойгоо үсэрчихсэн гэдэг. Доор нь Ононгийн гол үерлээд улаанаар эргэлдэж байхад өндөр хадан хясаанаас хөтөлгөө морьтойгоо үсрээд усанд цүл хийтэл бууж байсан байгаа юм. Тэгээд хөтөлгөө мориныхоо дунд хөвсөөр байгаад цаад эрэг дээр нь гарч байсан гэдэг. Дадалын түр хорих газарт нэг удаа баригдаад маш хурдан оргосон байдаг. Нэг удаа нутгийн нь нэг аархуу залуу Чулуун ахын дүү Тулгаагийн адуу малыг нааш нь цааш нь болгоод дарамтлаад байж. Тиймээс Чулуун ах нэг шөнө нөгөө залуу дээр давхиж очоод зодчихож. Оргож яваа хүн шүү дээ. Тэгээд аавындаа ирээд байж байтал нөгөө залуу буу шийдэм барьж ирээд ална тална гэж хашгичаад бөөн юм болж. Тэгтэл Чулуун ах гэрээс хүн гарахад сүүдрийг нь дагаж гараад нөгөө савчиж байсан хүнийг аль хэдийн дороо хийгээд суганд нь хутга тулгачихсан зогсч байсан гэдэг. Тэр хүн аргагүй дийлэхгүй нь гэдгээ мэдээд сумын төв рүү давхиад цагдаа дуудаад ирсэн байна. Нутгийн хүн арай ч цагдаад хэлчихгүй байх гээд Чулуун ах гэртээ тайван унтаж байж л дээ. Төдөлгүй бөөн хүмүүс гэрийг нь бүслээд авсан байна. Цагдаа нар нутгийнхаа бүл чадалтай залуучуудыг цуглуулаад ирсэн байж. Тэгээд “Батчулуун чи бүслэгдсэн. Гараад ир” гээд л хашгичаад байж. Чулуун ах хаалгаараа шагайж харчихаад ойр хавьд нь нөгөө хов зөөсөн хүн харагдахгүй болохоор нь

буугаа гартаа бариад ямар нэгэн эсэргүүцэл үзүүлэлгүй очсон байгаа юм. Буугаа газар тавингуут нь цагдаа нар ч түүнийг бариад авч. Гэтэл нөгөө хов зөөсөн хүн нь машины цаанаас гараад ирсэн байна. Түүнийг хараад Чулуун ахын уур дүрэлзэж “Чи энд байсан юм бол надад харагдчихгүй яасан юм бэ” гээд хоёр гараа хуу татахад цагдаа нар гарынх нь аясаар ханарч байсан гэдэг. Үнэхээр чадалтай хүн байсан юм билээ. Нэгэнт өөрөө буугаа газар тавиад цагдаа нарт эсэргүүцэл үзүүлээгүй болохоор хоёр гараа гавлуулаад нөгөө хов зөөсөн хүн рүү муухай харж байсаар машинд суугаад явсан байгаа юм. Тэгээд Дадалын мөрдөнд очингуутаа л оргочихсон гэдэг. 1986 онд ид шижигнэж явсан 27 насандаа таалал төгссөн нь харамсалтай. Үхэхээсээ өмнөхөн Хэнтийн Өмнөдэлгэр суманд явж байтал цагдаа нар морийг нь буудаад унагачихсан байгаа юм. Гэсэн ч Чулуун ах өөрийн овсгоо самбаагаараа тэдний гараас мултран Баян-Адарга сумандаа ирээд нутгийнхаа хүмүүст “Ер нь миний баригдах цаг болсон юм байна даа” гээд жаахан гутарчихсан явж байтал өөрт нь дарлуулж явдаг тус сумын гурван нөхөр амийг нь хөнөөсөн байдаг. Энэ гурван нөхөр сумынхаа хүмүүсийг хөгшин залуугүй барьж авч зоддог айхтар танхай улс байсан гэдэг. Тэднийг ганцхан Чулуун ах л дардаг байж. Өмнөдэлгэрийн цагдаа нарт морио буудуулсан тэр оройгоо Чулуун ах дээрхи гурван омголон нөхрийг барьж авч зодонгуутаа уул руугаа гарч бүгэхээр шийдэж л дээ. Гэтэл тэд түүнд өширхөөд уул руу гардаг замд нь отоож байгаад гурван талаас нь буугаар шүршчихэж. Гурвын гурван хүн гурван том буугаар шүршихэд юу үлдэх билээ дээ. Тэр үед Чулуун ах том хээтэй хар торгон дээлтэй явж байсан юм гэнэ лээ. Хар торгон дээлийг нь бууны сум сийчээд сархиаг болгоод хаячихсан байсан гэдэг. Одоо Хэнтийн аймгийн шүүхийн архивт Чулуун ахын өмсч явсан тэр дээл нь, бас эдэлж хэрэглэж байсан юмнууд нь хадгалаастай байдаг. Чулуун ахыг хэрцгийгээр хөнөөсөн тэр гурван хүн баригдаагүй. Нэгэнт зартай оргодолыг алчихсан болохоор цагдаа нар ч нэг их сүр бадруулалгүй өнгөрсөн юм билээ. Гэхдээ тэр гурван алуурчныг Чулуун ахын дүү нар, дотны хүмүүс нь жаахан оролдож байгаад орхисон гэдэг юм. Хувийн арга хэмжээ авсан ч юмуу, нарийн шириин асуудлыг нь би мэдэхгүй. Ямар ч гэсэн тэр гурван алуурчин одоо Баян-Адарга суманд амьд мэнд байдаг юм. Чулуун ахтай ижилхэн хувь заяатай, яг түүн шиг буудуулж үхсэн нэг шилийн эр манай Хэнтийд байдаг байлаа. Түүнийг Онкоты гэдэг байсан. Жинхэнэ нэр нь Бат-Эрдэнэ. Онкоты гэхээр Хэнтийн аль ч сумынхан андахгүй. Хэнтий аймагт бол домог болсон хүн. 2000-гаад оны үед цагдаа нарт буудуулж үхсэн гэхээр хүмүүс түүнийг санаж байгаа болов уу. Тухайн үед бас хөөрхөн дуулиан дэгдээгээд авсан шүү дээ. Түүнийг Монголын нутгаас өнчин ишиг ч хулгайлж үзээгүй, харин Оросын нутгаас бол өч төчнөөн морь мал Монголд оруулж ирсэн гэж ярьдаг юм. Оросын томск морьдыг Батширээтийн уулаар оруулж ирдэг ганц хүн нь Онкоты байсан гэдэг. Аав ээж хоёр нь Оросын буриад. Тэгээд Онкоты оросуудтай ямар нэгэн байдлаар өс хонзонтой болчихсон гэдэг юм. Ямар сайндаа л Оросын наад талын тосгоны айлууд хүүхдээ үгэнд орохгүй болохоор “Онкоты ирлээ” гэж айлгадаг байсан гэдэг. Ийм л цуутай хулгайч байлаа. Оросоос үхэр, адуу туугаад хоёр адуу зөрөхөд хэцүү тийм өндөр хясаан дээгүүр гаргадаг, хойноос нь хүн хөөлөө гэхэд тэр хясаан дээр нь ирээд л гацах жишээтэй. Мань хүн Дадал сумын хойд талын тайгад маш том хашаатай, түүндээ Оросоос тууж ирсэн адуу малаа хашиж байгаад ийш тийш нь тараадаг байж. Томск морьдыг ёстой баруун солгойгүй тарааж явсан хүн дээ. Улаанбаатарын том том уяачид хүртэл Онкотыд томск морь захиалж авчруулдаг байсан гэдэг. Одоогоос хэдэн жилийн өмнө манай баячууд араб адуу гэхээсээ илүү томск морьдоор чамирахж байлаа шүү дээ. Тэр бүгдийг Онкоты л оруулж ирдэг байсан гэдэг. Түүний буянаар хурдан удмын томск адуутай болсон уяач олон байдаг. Ялангуяа Баян-Адарга чиглэлийн адуу томск адууны цусаар сэлбэгдэж байлаа.

Онкоты ингэж нэг талаар Монголдоо хөрөнгө оруулалт хийсэн хүн. Даанч цагдаа нар түүнийг хойноос адуу оруулж ирэх үед нь отож байгаад цааш нь харуулчихсан. Эхлээд морийг нь буудтал Онкоты мориныхоо цаана үсэрч гараад эсэргүүцэл үзүүлэх аядаж л дээ. Тэгмэгц цагдаа нар шууд гал нээсэн байгаа юм. Онкоты Чулуун ахтай насаар тун ойролцоо. Ерөнхийдөө бие биенээ таньдаг байж. Харин Оросоос хамтдаа адуу хөөж байсан эсэхийг нь сайн мэдэхгүй байна. Онкоты манай аавын дотны нөхөр байсан. Манайхаар их бууж морддог байлаа. Хэрвээ аав энд байсан бол түүний талаар маш их юм ярих байлаа. Онкоты гайхалтай мэргэн бууддаг, моринд эрэмгий хүн байлаа. Дадал суманд “Бүдүүн” Баянмөнх гэдэг цагдаа саяхан болтол байсан. Нэг удаа манай сумын цагдаа нар Биндэрийн төлөөлөгч нартай нийлж байгаад Онкотыг барихаар гэрийнх нь ойролцоо ирж л дээ. Тэгээд зарим нь түлээний нь ард, зарим нь саравчны нь ард буу чиглүүлээд битүү бүсэлчихэж. Энэ үед цагдаа Баянмөнх “Намайг хамгаалаарай” гээд Онкотыг барихаар гэрийнх нь үүдэнд ирээд “Хөөе, Онкоты гараад ир. Чи бүслэгдсэн” гэж хашгиртал Онкоты аль хэдийн мэдчихсэн тооноороо шагайгаад Баянмөнх цагдаагийн малгайг буудаж унагаад, мөн түлээний цаана, саравчны цаана байсан цагдаа нарын дамар малгайг хийстэл буудаж, нэг ёсондоо бүгдийг нь хараандаа авчихсан байсан гэдэг. Цаадуул нь ёстой шээс нь гоожих шахсан байгаа юм. Тэгээд бүгд л салганатал чичрээд “Амь авар” гээд гараа өргөөд босоод ирсэн гэдэг. Энэ үед Онкоты “Алив миний морийг эмлээллээд үүдэнд аваад ир” гэж хашгирсан байгаа юм. Цаадуул нь хэлсэн ёсоор нь болготол Онкоты Баянмөнх цагдаагаар морио бариулж байгаад нэг гараараа сумласан буугаа атгаад мориндоо мордож, эхнэрээ араараа сундлуулаад уул руу зугтчихсан гэдэг. Цагдаа нар араас нь буудах гэхээр нэгд гэмгүй эхнэрийг нь буудчих гээд, хоёрт харанхуй шөнө яах ч учраа олоогүй гэдэг. Энэ бол жинхэнэ үнэн түүх. Хэнтийнхэн энэ тухай өнөөдөр ч ярьсаар байдаг юм. Цагдаа нар ингэж чадуулж байсныхаа өш хонзонг 2000-гаад оны үед авч Онкотыг морьтой юутай хээтэй нь буудаж цусан далайд умбуулсан гэж ярьдаг хүн ч байдаг билээ.

## Сайн эр, сайн морь хоёрын бахархаж биширмээр явдал суудал

*Манжийн үеийн эх оронч сэтгэлгээтэй шилийн сайн эрчүүдийн домог түүхийг ихэвчлэн жар, далан настай өвгөчүүд хүүрнэдэг. Өнөө цагийн гуч, дөчин настанууд бол энэ тухай тэр бүр мэдэхгүй. Амьдарч асан нийгэм нь социализм, коммунизмаар ид амьсгалж байсан болохоор арга ч үгүй юм. Харин саяхан гуч гаруй насны Сундуйн Чявгачамба хэмээх залуутай уулзаад бахархах сэтгэл төрсөн юм. Тэрбээр эрт цагийн алдартай бөхчүүд, шилийн сайн эрчүүд, алдартай хурдан хүлэг морьдыг судлан сурвалжилдаг, энэ талын домог түүх цуглуулдаг өвөрмөц сэтгэлгээтэй залуу ажээ. Ингээд түүний яриаг сонирхуулъя.*

...Миний төрсөн нутаг бол хуучнаар Зая Бандидийн хүрээ, одоогийн Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутаг. Аав маань Увс аймгийн Өндөрхангай сумын хүн. Хуучнаар бол Засагт хан аймгийн Луу жанжин Лувсандондовын хошуу, Тахилтын нуур, Батсайхан багийн нутаг. Ээж маань Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Хан-Оюут алаг уул, хуучнаар бол Сайн ноён хан аймгийн Цэцэн вангийн хошуу буюу Заябандид гэгээний хошууны хүн. Би түүх сонирхдог, ялангуяа эрт цагийн алдартай бөхчүүд, шилийн сайн эрчүүд, алдартай хурдан хүлэг морьдын домог түүхийг шимтэн сонирхдог. Гэхдээ хамгийн гол нь цаад үзэл баримтлал, сайн эрийн чанар чансаа, эх оронч сэтгэлгээг нь эрхэм болгодог. “Ар халхын шилийн сайн эрчүүд” номонд миний мэддэг шилийн эрчүүдийн талаар нэлээд орсон байна. Тиймээс би уг номонд дурдагдаагүй зарим нэг шилийн сайн эрийн тухай ярьж. Манай Архангай аймгаас Монгол улсын хэмжээнд нэрд гарсан шилийн эр гэвэл “Эгийн саарал” хэмээх номонд мөнхөрсөн “Цэхэр” Явуу л байх шив дээ. Энэ хүнийг номонд мөнхөрсөн болохоор хүмүүс мэддэг. Харин ном зохиолд дурдагдаж байгаагүй шилийн эрчүүд дээхэн үед Архангай аймагт мэр сэр байсан юм билээ. Ном зохиолд “Сайн эрийн уяа”, “Сайн эрийн уул” гэж гараад байдаг. Энэ нь сунжирсаар “Сайрын уяа” болсон байдаг. Энэ уяаны байрлал нь Архангай аймгийн төв Цэцэрлэг хотоос урагш 25 км газарт буюу урд Тамирын голын хоёр салааны дунд байдаг юм. Дээр үед энэ газрыг Тарган бэйсийн хүрээний тал гэдэг байж. Намайг бага байхад эндхийн салбар уулсын дунд манайх нутагладаг байлаа. Зая Бандид гэгээний хошуу нь урагшаа Архангай аймгийн Булган сум, хойшоо Их Тамир гээд их том газар нутгийг хамардаг байж. Энд Бумбат гэдэг уул бий. Булган сумыг хуучнаар Бумбат гэж нэрлэдэг байсан. Бумбат уул нь хэр баргийн хүн морьтой авираад гарчихааргүй бартаа саад ихтэй эгц өндөр уул. Энэ уулын тагтыг манай нутгийн хөгшчүүл “Сайн эрийн уяа” гэдэг байлаа. Хоёр гурван зуугаад адууг өлхөн нуучихаар уулын тагтанд байдаг хумбагар тогтоцтой хад. Дээр үед Архангайн шилийн эрчүүд холоос адуу хөөж ирээд энэ тагтанд нуудаг байсан юм гэнэ лээ. Адуугаа хашиж уядаг байсан болохоор “Сайн эрийн уяа” гэж нэрлэдэг байж. Тамгын газрын тахрууд, арван тавны цагдаа нар энэ уулын тагт руу авирч гарах гээд бардаггүй байсан гэдэг юм. Архангайн Зая Бандид гэгээн өөрөө шилийн сайн эр байсан гэдэг шүү дээ. Унгарын монголч эрдэмтэн Иштван гэдэг хүн одоогоос арав гаруй жилийн өмнө Монголд ирэхдээ хэлсэн үгийг энд иш татмаар байна. “Монгол нутагт онгон зэлүүд тал хязгаар нутгаар гэр хийж, морин дэлэн дээр давхиж явдаг монгол эрсийн дуу, шүлэг мөнхөрсөн бодит түүх миний сонирхолыг татахгүй байж чадаагүй. Би хүсэлдээ хөтлөгдөж анх 1999 онд Монголд ирж Дарьганга нутагт очсон билээ. Монголын Архангай аймгийн Зая Бандид хүрээний нутаг дахь сайн эрсийн ууланд 250 орчим шилийн сайн эр цугларч “Торой” Бандид дээд шагнал болох тав дахь удаагийн зангиа зүүж өгөх Монгол төрийн нууц даалгавараар Зая

Бандид гэгээн өөрийн биеэр заларч хүндэтгэл үзүүлсэн түүхэн баримт надад байна” гэж хаа холын унгар хүн мэдэгдсэн байх жишээтэй. Энэ хүний яриад байгаа тэр сайн эрийн уул гэдэг нь Бумбат уулын тагт болж таараад байгаа юм. Энд зөвхөн хол ойроос хөөж ирсэн адууг хурааж тогтоох биш шилийн эрчүүд бас цуглардаг байсан бололтой. Манай нутгийн хөгшчүүд Архангайн шилийн эр “Хагархай” Чойжилсүрэн, Дойдны Намдаг нарын тухай их хуучилдаг байлаа. “Хагархай” Чойжилсүрэн Архангайн Сангийн толгой, Баянбулаг, Гурвын даваа, Тамирын голоор нутагладаг байж. Нэг удаа мань эр Баянхонгор аймгийн нутгаас зуу гаруй адуу хөөгөөд нутагтаа иртэл хойноос нь Баянхонгорын эрчүүд хүрч ирээд эмээлийн дөрөөгөөр тархийг нь хага цохиж байсан гэдэг. Тэгээд л “Хагархай” гэдэг хочтой болж. Дойдны Намдаг нь Архангай аймагт байх Янгиртай хясааны ойр орчимоор нутагладаг байж. Энэ хүн залуу зандан насандаа холоос адуу хөөдөг байснаа хөгшрөөд ирмэгцээ ойроос мал тоншчих гээд байдаг болж. Нэг удаа мал хотлоод амьтан хүн унтсан хойно Дойдны Намдаг нэгэн баян чавганцын хоттой хонь руу харайж ороод сүүлээ дааж ядсан тарган ирэг хүзүүдээд авсан байна. Үүнийг нь чавганц мэдчихээд тэр даруйдаа чонын шөрмөс шатаасан байгаа юм. Тэгсэн чинь Намдаг хонио хүзүүдсэн чигтээ гацчихсан гэдэг. Өглөө нар тусах үед Дойдны Намдаг хонь хүзүүдээд гацчихсан байхыг адуу малдаа явахаар боссон хүмүүс хараад мэлгайхаж, харин нөгөө чавганц юу ч болоогүй юм шиг Намдаг дээр хүрч очоод хараал жатгаа суллан гэртээ оруулж цай уулгаад “Дахиж битгий хөгшин хүнийг элэг барьж байгаарай” гэж захисан байна. Үүнээс хойш Дойдны Намдаг хулгай хийхээ больсон гэдэг. Мөн нэг содон нэртэй шилийн эр дээхэн үед Архангай аймагт бужигнуулж явсан байдаг. Нэр нь орж ирэхгүй байна. Тамирын голын хоёр салаа урсгал доошоо явж нийлдэг уулзварт буюу Тамир бригадын дээхэн талд “Бор хошуу” гэдэг хадан хясаа бий. Нэр нь тодорхойгүй шилийн эр маань нас ахисан хойноо энэ хясаанаас боож үхсэн гэдэг. Энэ хүн нас ахисан хойноо алдартай хурдан хар гүү унаад газар сайгүй довтолгодог байсан гэдэг. Тэр гүү нь ерөөсөө унагалдаггүй. Үнэхээр төгс сайн адууны шинж бүрдсэн гүү унагалдаггүй тухай хөгшчүүдээс сонсч байлаа. Мань эр хар гүүгээ унаад урагшаа Дундговь руу явдаг, тэгэхдээ олон хоног явахгүй, ердөө ганц хоногт л яваад ирдэг байж. Говьд очоод бэлчээрт байсан үхэр малаас хамгийн тарганыг нь тэр дор нь унагаад хаа гуяар нь салгаж аваад мориндоо тохоод буцаад давхичихдаг, тийм нэг сонин араншинтай хүн байж. Хойноос нь хүмүүс хөөгөөд гүйцдэггүй байсан гэдэг. Тэр хар гүү нь бүхэл бүтэн үхрийн мах тээж яваа хэрнээ сул яваа юм шиг л цойлдог байж. Энэ сайн эрийг “Бор хошуу”-ны хадан хясаанаас боож үхэхэд хажууд нь байсан хар гүү нь дагаад үхсэн гэдэг яриа байдаг юм. Сайн адуу эзэнтэйгээ хүйн холбоотой байдаг юм гэсэн. Жишээ нь Луу гүний сайвар халтар морь байна. Хошуу ноён Луу жанжин гүн Лувсандондов нь их ухаантай, цэцэн билэгт яруу найрагч, ард олноо гэсэн сэтгэлтэй, нутгийнхаа шилийн сайн эрчүүдийн үйлдлийг далдуур дэмждэг сүрхий хүн байсан гэдэг. Луу гүн дөчөөд азарга адуутай байж. Нэг удаа нутгийн нь “Мээтэн” Аюур гэдэг шилийн эр Луу гүнд бараалхах үедээ “Би их Алтайг нэг даваад ирмээр байна. Та надад Алтайн уулсыг даваад ирж чадах ганц сайн морь өгөөч” гэсэн байна. Их Алтай гэдэг нь Баян-Өлгий, Ховдын заагаар даваад Шинжааны нутаг руу орно гэсэн үг. Луу гүний хошуунаас 500-гаад км газар. Луу гүн “Мээтэн” Аюурын санааг ойлгоод “За чи миний адуунаас өөрөө сонгож унаад яв” гэж хэлж. Ингээд Аюур түүний дөчөөд азарга адуунаас их Алтайг даваад ирэх мөнөөх ганц сайн унаагаа хайсан боловч олсонгүй. Өөрөө адуу маланд эрэмгий, морь сайн таньдаг хүн байж л дээ. Түүнийг сайн унаа олж чадахгүй аргаа бараад байж байтал Луу гүний адуучин “Багахан шиг үрээ азаргатай хэдэн адуу үлдсэн байгаа. Тэнд хэнд ч баригддаггүй, маш том толгойтой эмнэг хээр үрээ бий. Тэрийг сонирхох уу” гэсэн байна. “Мээтэн” Аюур тэр үрээг нь очиж



үзээд “За энэ чинь харин их Алтайг даваад ирэх хүлэг байна” гээд олон адуугаар бүчүүлж байгаад ганцхан дайраад л уургалаад авч. Гэтэл нөгөө үрээ нь түүнийг морьтой нь хамт нэлээд хол чирч давхисан гэдэг. Тийм хүчтэй. Аюур эмнэг хээр үрээгээ сар гаруй аргамжсан байгаа юм. Нөгөөдөх нь мордох тоолонд булгих жишээтэй. Ингэж байсаар нэг өглөө Аюур эмнэг хээр үрээгээ булгиулж унаад л их Алтайг зорьсон гэдэг. Тэгээд Их Алтайг давж Шинжааны нутаг руу ороод арав гаруй сайхан морь хөөсөн шигээ исгэрээд давхиж ирсэн байгаа юм. Эмнэг хээр үрээ буюу алдарт сайвар халтарын түүх ингэж эхэлсэн байдаг. Сайвар халтар нь Луу гүний унаган адуу болохоор түүгээр овоглодог байж. Нутаг орныхоо наадамд олон удаа түрүүлж алдартай хурдан хүлгээр цоллуулаад байх үедээ Богдын даншигт очиж уралдаад түрүүлж байсан гэдэг. Тэр үед Богдын даншигт түрүүлсэн морийг Богдод хүчээр өргөн барьдаг байж. Тиймээс Луу гүний хүмүүс сайвар халтарыг Богдод өгөхгүй гэж хэлж чадсангүй. Харин нутаг орон руугаа гүйлгэх нэгэн арга сэдэж яг түрүү морины цол дуудах үед сайвар халтар мориныхоо хазаарын шилийг хутгаар жаахан зүсчихэж. Нэг ёсондоо жаахан хүчтэй цовхроход л хазаарын шил тасраад морь сулрах байлаа. Тэгээд морь цоллодог хүнд “Жолоог нь жаахан өргөөд цоллочиhoорой” гэж захисан байна. Төдөлгүй морь цоллогч жолоог нь дээш өргөөд цоллох гэтэл сайвар халтар морь гэнэт цовхрон хазаарынхаа шилийг тасдаад наадмын талбайгаас тэр чигтээ давхиж одсон гэдэг. Ингээд нутагтаа нэг өдөр, нэг шөнө давхиад л очсон байгаа юм. Үүнээс үүдэж Луу гүн сайвар халтар мориндоо зориулж,

“Үүрийн гэгээний сойлготой

Үд дундын гүйдэлтэй

Тун чиг чанга гишгэдэлтэй

Сайвар халтар морь минь” гэсэн шүлэг зохиож сайн морио найраг, дуунд мөнхөлж байсан түүхтэй. Нэг удаа Луу гүний хүүхэд ан гөрөө хийж яваад нэг янзагатай согоо буудаад алчихаж. Тэгээд янзагыг нь гэртээ авчраад тэжээсэн байна. Гэтэл тэр янзага нь гурван жил хэвгээгээрээ урамдсан гэж байгаа юм. Ламд үзүүлсэн чинь “Наад амьтан чинь муу ёр дуудаад байна, одоохон зайлуул” гэж хэлж. Гэвч зайлуулахын завдал өгөлгүй нөгөө гурван настай буга чинь Луу гүний хүүгийн дөнгөж хөлд орж байсан хүүхдийг мөргөж алаад уул руу зугтчихсан гэдэг. Энэ үед сайвар халтар морь нэлээд хөгширчихсэн, угийн уяулж сурсан зангаараа уян дээр ирээд зогсч байсан байна. Луу гүний хамаг эрчүүд анд явчихсан байж. Харин тэнд үлдсэн хүмүүсээс нэг нь сайвар халтарыг унаад хүүхэд мөргөж алсан буганы хойноос хагас өдрийн турш хөөж, сүүлдээ нөгөө буга арга буюу эцэж унасан гэдэг. Сайвар халтар ийм түүхтэй морь. Дэлэм дайны том толгойтой адуу байж. Алдартай сайн хүлэг байсан болохоор үхсэний нь дараа толгойг нь Луу гүний хошууны өндөр овоонд тахиж байсан гэдэг. Дөчөөд оны үед Цэсрэнгийн “Шарваа хээр” гэдэг алдартай хурдан хүлэг Хан Хөхий нутагт байж. Эзэн нь мөн л Цэсрэнгийн Намжил гэдэг шилийн эр. “Шарваа хээр” нь сүүлээ шарваж давхидаг, харин сүүлийг нь боочихоор давхиж чаддаггүй адуу байсан гэдэг. Нэг жилд гэхэд л Завхан аймгийн наадамд, Сонгино сумын наадамд, Увсын Өндөрхангайн наадамд дараалан түрүүлчихдэг байж. Шилийн эр Намжил хол ойроос адуу хөөх гэж ёстой сүлжиж өгдөг, мал хуй сольж холих гэж сүлж өгдөг нөхөр байж. Нэг удаа мань эр цагдаа нарт баригдаад Завханы Улиастайн шүүх рүү хүргэгдэхээр болж. Цагдаа нар түүнийг “Шарваа хээр” морин дээр нь зайдан мордуулаад хоёр гарыг нь ард нь хүлж, морины гэдсэн доогуур уяа гүйлгээд хоёр

хөлийг нь холбоод авч явсан байна. Шилийн эр Намжил Улиастай хүргэгдэх замдаа цагдаа нарын гараас хэрхэн мултрах тухайгаа бодоод л явж. Гэвч цаадуул нь түүний хөл гарыг хүлээд, морийг нь хөтөлчихсөн байдаг. Улиастайд ойртоод ирмэгц Цэсрэнгийн Намжил “Миний гар өвдөөд байна. Ядаж гарын хүлээсийг минь тайлчихаач дээ. Хоёр хөлөө холбуулаад та нарт хөтлүүлчихсэн би хаа холдох юм бэ” гэсэн байна. Цагдаа нар нээрээ ч тийм юмуу гэсэн байдалтай болж ирсэнээ түүний гарын хүлээсийг тайлчихаж. Энэ үед Намжил “Миний хээр морь уг нь наадамд уралддаг хурдан морь шүү дээ. Гараа руу явж байгаа морьд эргэдэг шиг арай эргээд давхиж мэдэх юм биш байгаа” гэж бодож явсаар гэнэт урагшаа тонгоймогцоо мориныхоо хазаарыг мултлаад хоёр сэрвээ рүү нь алгадангаа “Түүг, гүүг, гүүг” гэж хашгиртал “Шарваа хээр” нь яг л гараанаас эргэж байна уу гэлтэй гэв гэнэтхэн эргээд давхичихсан гэдэг. Нөгөө цагдаа нар хойноос нь хөөсөн ч бараа сураггүй орхигдсон байгаа юм. Хамгийн гол нь морь нь сайн, эр нь сэргэлэн байхгүй юу. Мөн Увсын Өндөрхангайн сайн эр Рэнцэн гэдэг хүний хүрэн морийг энд дурдууштай. 1944 оны мичин жилийн зуднаар Рэнцэнгийн хот айл зуданд ихэнх малаа алдаж хоол ундгүй зутраад ирж. Тэр үед шилийн эр Рэнцэн нас дээр гарсан байсан тул адуу мал хөөхөө больсон байж. Гэсэн ч залуугийнх нь явдал санагдаад болж өгсөнгүй. Тэгээд ч хоол унд муутай байсан болохоор хуучны шилийн эрийн толгойд нэг юм бодогдсон л байж таарна. Ингээд нэг өглөө Рэнцэн өвлийн тарчиг цагт хариугүй турж эцсэн хүрэн морио эмээллэж унаад Өндөрхангай сумаас урагшаа 130-аад км газарт байдаг Завханы Сантмаргац сум руу арилж өгсөн байна. Мань эр морины өвдөгөнд тулсан хөр цасан дундуур шөнөжингөө давхиад Сантмаргац орж нэгэн хот айлын хониноос хоёр эр хонь шүүрч дүүрээд эргээд давхисан байгаа юм. Гэтэл хот айлынхан мэдчихээд араас нь хөөсөн байна. Тэд нэлээд хөөж байгаад орхичихож. Яасан бэ гэхээр морины өвдөгөөр татсан хунгар цасыг Рэнцэнгийн хүрэн морь цөм цөм гишгээд давхичихсан байж. Үүнийг харсан хүмүүс “Энэ бол сайн морь, сайн эр хоёрын явдал байна. Хөөгөөд хэрэггүй. Сайны шинж бүрдсэн ийм амьтадыг зөнд нь орхих ёстой” гээд буцаж байсан гэдэг. Жинхэнэ хүлэг гэдэг чинь унаж эдлэхгүй болохоор санаагаар үхээд ядраад байдаг, харин унаад, эдлээд ирэхээр цог хийморь нь бадраад явчихдаг. Унах тусам жавхаажаад өнгө ордог тал бий. Үүн шиг сайн эр аян жинд явахдаа ингэж сэргэдэг юм байна. Гэрийн мухарт шигдээд байвал улам л хийморь нь үхээд байдаг юмсанж. Шилийн эр Рэнцэнг үүрээр гэртээ ирэх үед хажуу айлын нь өвгөн бие засахаар гарсан байна. Гэтэл уян дээр нь дүүхэлзсэн цагаан морь хөлөө цавчлаад зогсч байж. Өвгөн гайхаад “Хар үүрээр хаанахын хэнбугай нь ийм сайхан яндан цагаан морь унаад ирдэг байна аа” гээд Рэнцэнгийн ортол цаадах нь “Би хоёр хонь авчраад нядалчихлаа. Чи арьсыг нь шувглаатах” гэсэн гэдэг. Түүний хүрэн мориноос уур савсаад өвгөний нүдэнд яг л цагаан морь болж харагдсан байгаа юм. Тавиад оны үед Увс аймагт “Сайн эрийн” Дэндэв гэдэг шилийн эр байж. Гучаад оны үед ид гялалзаж явах үедээ бужигнуулж явсан хүн юм билээ. Эцгийг нь “Салга” Ерөөлт гэдэг байсан ч Дэндэвийг нутгийн нь ардууд сайн эр болохоор нь “Сайн эрийн” Дэндэв гэж дууддаг байж. Тавиад оны үед Дэндэв гуай баригдаад аймгийн шүүхэд байцаагдах болсон байна. Нэгэнт сайн эр болохоор энд тэндээс хулгай хийсэн мал хуй нь гарч ирээд байж. Угийн зальтай сэргэлэн хүн болохоор тэдгээр мал хуйг өөрөөсөө бултуулж аргалаад байсан байна. Харин нэг атан тэмээ яалт ч үгүй түүн дээр уначихаад болж өгсөнгүй. Тэгэхээр нь “Сайн эрийн” Дэндэв зүүн аймагт нэрд гарсан нэг шилийн хулгайчийн нэрийг бариад буучихаж. Энэ хүний нэрийг нь л сонсч байсан болохоос биш нэг ч удаа уулзаж учирч явсангүй. “Тунгалаг тамир” кинон дээр Хонгор “Цахиур” Төмөрийг аварч магадгүй гээд түүнд жасын хөрөнгөнөөс алдагдсан малгайн бүчийг тохдог шүү дээ. Үүн шиг л аврал эрсэн юм байх. Дэндэвийг

аймгийн шүүхийн “Шүлхий” Бадарч гэдэг хүн байцааж байсан гэдэг. Тавиад оны үед харилцаа холбоо овоо хөгжчихсөн байсан болохоор Дэндэвийн яриад байдаг нөгөө зүүн аймгийн шилийн хулгайчийг хуулийнхан тодруулаад, бүр Дэндэвтэй нүүрэлдүүлэхээр аваад ирсэн байгаа юм. Энэ хоёрыг нүүрэлдүүлэх үед янз бүрийн юм хоорондоо тохиролцож магадгүй гээд хажууд нь “Шүлхий” Бадарч болон өөр бусад хүмүүс байлцсан байна. “Сайн эрийн” Дэндэв нөгөө хүний өөдөөс харж суунгуутаа “Хаврын өдөр гэдэг урт юм даа. Нар шарлаж ханын дөрвөн нүд орлоо” гээд амаа нэг их том ангайгаад эвшээж хэлсэн байна. Цаад хүн нь үүнийг юу гэж ойлгосон бэ гэхээр нар шарлаж гэдгийг шар зүсмийн ямар нэгэн мал байна, том эвшээсэн болохоор урт хөлийн амьтан тэмээ байна, ханын нүд гэдгийг ханан бөхтэй тэмээ байна, дөрвөн нүд орлоо гэдгийг мөнхүү тэмээ нь дөрвөн настай юм байна гэж сэтгэсэн байгаа юм. “Шүлхий” Бадарч зүүн аймгийн шилийн эрээс “За та энэ хүнд юм өгсөн үү?” гэж асуухад тэрхүү гүжир хар хүн “Би энэ хүнд мал өгч байсан юм байна. Дөрвөн настай шар ат өгч байсан” гэж хэлж. Ингээд Дэндэв аврагдаж байсан гэдэг. “Шүлхий” Бадарч Дэндэвээс “Сайн эрийн” гэх үг алдуулж хэрэгт нь нэмэр хачир болгохоор “Чамайг Сайн эрийн Дэндэв гэдэг байх аа?” гэж асуухад мань эр “Үгүй ээ, би Сайн эрийн Дэндэв биш, “Салга” Ерөөлтийн Дэндэв байна. Шүүхээр сүрдүүлдэг “Шүлхий” Бадарч гэдэг чинь чи байх аа” гэж хэлдэг, үүнээс болж мань хоёр ач тач хэрэлддэг байсан гэдэг.

## Шилийн эрстэй холбоотой уул усны домог

Монгол орны нэг сая таван зуун мянган хавтгай дөрвөлжин км газар нутаг дээр сайн эр, сайхан хүүхний домог түүх, элдэв адал явдлаар нэршчихсэн уул овоо, хад цохио, тал хөндий нэлээд байдаг. Энэ нь сайн эр, сайхан хүүхнийг эртнээс янагш хүндлэн дээдэлж, шүтэн биширч ирсэн монголчуудын түүхэн уламжлалтай холбоотой. Жишээ нь сайхан хүүхний домог түүхээр нэршсэн “Тамирын гол”, “Хүүхний хөтөл”, “Ээж хайрхан”, “Сэрхийн нуруу”, “Гүнжийн сүм”, “Бортоо нуур”, “Бошлой хад” гээд олон арван уул ус, тал хөндий бий. Үүн лүгээ сайн эрсийн домог түүхээр нэршсэн “Шилийн богд”, “Бөхөн шарын нуруу”, “Дааган толгой”, “Сартагтайн суваг”, “Хутагтын хад”, “Молорын агуй”, “Шижирийн даваа”, “Шижигтийн хавцал”, “Махваалайн хонгил” гээд өөрийн гэсэн домог түүхтэй уул ус, тал хөндий олон буй. Ингээд сайн эрстэй холбоотой зарим нэг уул усны домог түүхээс өгүүлсү.

### Дааган толгой

Эрт цагт холын хошууны нэгэн сайн эр зүүн аймгаас хурдан удмын азарга адуу хулгайлаад Тэсийн голыг уруудан хөөсөөр одоогийн Увс аймгийн Зүүговь сумын нутагт байх “Тохой газар”-аас салж баруун зүг зугтаж явтал хурдын удмын адуунаас нь ихэр даагатай эрмэг хоогч гүү холын замд муудаж цааш явж чадахгүй болжээ. Тиймээс сайн эр эрмэг хоогч гүүг хоёр дааганы хамт орхиод цааш хөдөлсөн байна. Гэтэл нэг даага нь тэр дороо нүд аньж, нөгөө нь цаашаа таван мод газар яваад нэгэн толгод дээр сульдан унажээ. Тэр цагаас хойш нугийн ардууд эхний даага унасан толгодыг “Дааган толгой”, хоёр дахь даага унасан толгодыг “Дээд дааган толгой” гэж нэрлэх болжээ. Харин хоёр дааганы эх хоогч гүү үр төлөө орхин явж чадалгүй тэр хавьдаа эргэлдэж байгаад усгүй хатаж үхсэн бөгөөд гүүний сэг зэм үлдсэн нэгэн бяцхан уулыг “Хоогч гүү” гэж нэрлэсэн байна. Энэхүү гурван уул Хан Хөхий уулын зүүнтээ, Тэсийн голын баруунтаа өргөн удам тал дунд оршино. Эдгээрээс арваад км газарт хар модоор хучигдсан нэгэн сүрлэг уул байдаг бөгөөд үүнийг нутгийнхан сайн эрийн хулгайлсан хоогч гүүтэй хурдан удмын адууны азарга нь гэж домоглон ярьсаар иржээ.

### Тонгорогийн даваа

Эрт цагт хангайгаас говийг зорин ноёд баядын адууг хөөж ядууст тараадаг шилийн сайн эрс “Тонгорогийн даваа”-г зүрх алдан туулдаг байжээ. Зөвхөн оройн хэсэг нь арваад км үргэлжилдэг энэхүү даваа нь усны эх, уулын оргилыг бараадаж явдаг шилийн эрчүүдэд заримдаа аврал болдог байж. Өврийн сайхан хангайгаас Хүйсийн говийг зорин гурван азарга адуу тууж гарсан нэгэн сайн эр араас нь хөөсөн нэхүүлүүдийг төөрүүлж орхихдоо тонгорогоо судагт гэсэн дүр эсгэн амь мултарч, зам буруулсанаас энэхүү эгц халил, огцом тонгоруу замтай давааг тус нутгийн ардууд “Тонгорогийн даваа” гэж нэрлэх болжээ. Энэхүү даваа нь Өвөрхангай, Баянхонгор аймгийн нутгийг холбон орших бөгөөд эрт цагт Сайн ноён хан аймгийн шилийн эрчүүд “Тонгорогийн даваа”-н дээр жилдээ нэг удаа гарч хийморио сэргээдэг байсан байна. Дарьгангын шилийн эрчүүд “Шилийн богд” уулан дээр гарч хийморио сэргээдэг байсан гэдэг. Үүн лүгээ “Тонгорогийн даваа” нь Сайн ноён ханы эрчүүдийн хувьд “Шилийн богд” уулыг орлож байсан хэрэг.

### Суваргын нуруу

Баянхонгор аймгийн Шинэжинст сумын харьяат “Бөх” Ванган хэмээх шилийн эр 1920-иод оны үед Хятадын гамин цэргийн харгислалын эсрэг тэмцэж нутаг хошуундаа ихээхэн нэрд гарчээ. Тэрбээр нэг үе гамин цэргүүдийн эрлэг болж байсан гэдэг. Нэг удаа Ванган Шинэжинст сумын нутагт байх “Угалзын нуруу”-нд буудалласан гамин цэргийн хуаран руу нөхдийнхөө хамт шөнөөр дөхөж очмогцоо “Бид цөөхүүлээ, гамин цэрэг олуулаа. Тиймээс юуны өмнө даргыг нь устгаж удирдлагагүй болгоё” гээд нөхдөө орхин ганцаараа гэтэж майхнаас майхан дамжин нуугдаж явсаар Хятадын цэргийн ерөнхийлөн захирагчийн майханд орж түүнийг хөнөөгөөд ирж байсан гэдэг. Тиймээс ерөнхийлөн захирагчгүй болсон гамин цэргүүд яах учраа олохгүй нутаг буцахаар шийджээ. Тэднийг Хонгор нутгийн “Цагаан хаалга”-ны эхэнд очоод байхад нь сайн эр Ванган нөхдийнхөө хамт дайран орсон аж. Харамсалтай нь энэхүү тулалдаанд Ванган гамин цэргийн суманд оногдож нас барсан байна. Нутгийн ардууд эр зоригтой ганц сайн эр “Бөх” Ванганаа Угалзын нуруунд нутаглуулж суварга босгосон бөгөөд тэр цагаас хойш уг нурууг “Суваргын нуруу” гэх болсон байна. Зарим түүх домогт “Бөх” Ванганыг Османы дээрэмчидтэй тулалдаж яваад амь эрсэдсэн гэж өгүүлсэн байх ажээ.

### **Шижирийн даваа**

Шижирбаатар хэмээх зоригт эр одоогоос гурван зуугаад жилийн тэртээ баатарлаг үйлсээрээ ард түмний дунд домог болон үлджээ. Одоогийн Төв аймгийн Лүн сумын нутагт төрж өссөн тэрбээр Манжийн дарангуйллын эсрэг тэмцэж асан зоригт эрчүүдийн нэг байж. Шижирбаатарыг Их хүрээний ойролцоо амьдарч байхад нь ихэс ноёд эрэлхэг зоригийг нь таалан болгоож, хожим түүний дайн тулаанд хэрэглэж явсан хөө хуяг, зэр зэвсэгийг эх нутаг, уул усаа халдашгүй дархан байлгахын билэг тэмдэг болгосон байдаг. Жишээ нь Богдхан уулын “Цэцээ гүн”-д төрийн тахилга ёслол үйлдэх үедээ Шижирбаатарын зэр зэвсэгийг есөн хөлт цагаан тугныхаа дор хүндэтгэлтэйгээр байрлуулдаг байжээ. Манжийн эсрэг цогтой тэмцэж явсан энэхүү сайн эр зэр зэвсэг агсан тулалдахаас гадна эрт цагийн шилийн эрсийн жаягийг дагаж хятад худалдаачдыг Их хүрээний ойролцоох нэгэн даваан дээр отоож байгаад эд юмсыг нь дээрэмдэж ардуудад тарааж өгдөг байж. Тиймээс Улаанбаатар хотын баруун хойно байдаг тэрхүү давааг “Шижирийн даваа” хэмээн өнөөг хүртэл нэрлэж заншсан түүхтэй.

### **Шижигтийн хавцал**

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт орших Шижигтийн хавцалыг хол ойрын аянчин гийчид ихэд сониучирхдаг ажээ. Өндөр уулыг хаяалсан нарийхан хавцалаар цутган буух их ус, хөөс хаялан хурдлах усны чимээ зорьж ирсэн хүнийг ариусгах шидтэй гэнэм. Дээхэн үед байгаль цаг агаар сайхан байх цагт энэхүү усны чимээ үнэнхүү сүрлэг сонсогддог байсан бөгөөд зэрэгцэж зогссон хоёр хүн хоолой шахан хашгирч байж дуу дуугаа авалцдаг байж. Зөвхөн байгалийн дуу чимээ л ноёлдог асан Шижигтийн хавцал дээхэн үед монгол цэргүүдийг өстөн дайснаас аварч байсан түүхтэй бөгөөд буун дуу үл сонсогдох их усны чимээнээс сүрдсэн манж цэргүүд Шижигтийн хавцал руу айгаад ойртдоггүй байсан аж. Эрт цагт Шижигт хэмээх сайн эр энэхүү хавцалд орогнодог байснаас ийн нэрлэгдэх болсон хэмээн зарим эх сурвалжид өгүүлсэн байдаг. Шижигтийн хавцалын сар нь хүртэл усны хэлээр дуулдаг хэмээн домогт өгүүлсэн байх бөгөөд эрт цагт харийн ноёны гэргий болохоос татгалзсан нэгэн гоо бүсгүй энэхүү хавцалд ирж амь хоргодож, эцэст нь усанд амиа өргөж,

улмаар бүсгүйн нулимс ус болон урсч, сэтгэлийн зөрчил нь дуу чимээ болж үлдсэн гэх домог бас бий. Богд хаант Монгол улсын үед Увс нутгийн “Олгой” Загд хэмээх шилийн эр Шижигтийн хавцалд олон жил бүгэж арван тавны цагдаа нараас өөрийгөө хамгаалж байсан гэдэг. Ер нь арван тавны цагдаа болон ногоон малгайтануудаас өөрийгөө хамгаалахын тулд хэн хүний хүрч баршгүй хадан хавцал, агуй хонгилд орогнож байсан сайн эрс, лам хуварга цөөнгүй. Жишээ нь Ээж хайрханы “Ламын агуй”-д эртнээс янагш хүмүүс орогносоор ирсэн бөгөөд тус нутгийнхан “Ламын агуйд ээж уулын ижий лам амьдарч байсан” хэмээн домоглон ярьдаг байна. Түүхийн ухааны доктор Д.Очирбат удаан хугацааны турш сурвалжилсаны эцэст Ховог Сайрын торгууд гаралтай Равдан хэмээх сайн эр 1923 оноос эхлээд уг агуйд нэлээд хэдэн жил орогнож байсныг тогтоожээ. Равдан нь Маажинсан ууланд орогнож байсан Номун хан Дамбийжаагийн хамсааны хүн байсан бөгөөд түүнийг хорлогдсоны дараа Равдан “Ламын агуй”-д ирж нутгийн иргэн Түдэвийн Цэгмэд гэгчтэй ханилан сууж байгаад 1928 онд энэ л агуйдаа нас барсан гэдэг.

### **Махваалайн хонгил**

Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошуунд хамгийн их нэрд гарсан шилийн эр бол “Өндөр” Махваалай гэгч ажээ. Тус хошууны Бага уныт хэмээх газарт хэд хэдэн том агуй хонгил байдаг бөгөөд үүнийг нутгийн иргэд “Махваалайн хонгил” гэж нэрлэсээр иржээ. Учир нь шилийн сайн эр Махваалай баруун аймгаас тууж ирсэн адуу, үхрээ нядлаад махыг нь Бага унытын агуй хонгилуудад борцолж хатаагаад зуны цагт ядуу тарчиг айл амьтаныг тэтгэдэг байж. Махваалай чухам ямар хүн байсан тухай тус нутгийн “Данхар” Цэрэнпил, Даш-Онолт, Оростогоо нарын хөгшчүүл “Шилийн сайн эр Махваалай их өндөр нуруутай, адууны шүд шиг том цагаан шүдээ гаргаад сайхан исгэрдэг, хүнтэй барилдаад тонгороход бүдүүн хар гэзэг нь газар пид пид хийн цохилж байдаг, сөөнгөдүү дуутай, том хүрэн эр байлаа. Хошуу ноён Махваалайд их сайн байдаг байсан. Ер нь Илдэн бэйлийн хошууны ноёд, баяд өөрсдийнхөө адуу малыг шилийн сайн эрчүүдэд алдахгүй гэдэг үүднээс тэдэнд их сайн ханддаг байлаа” гэж хуучилдаг байж.

### **Хатан бээлийн даваа**

Отгонтэнгэр уулнаа Хатан бээлийн даваа гэж бий. Эл даваа хоёр морьтой хүн цуваад өгсөхөд өмнөх морины хомоол арын хүний толгой дээр унадаг тийм огцом эгц юмсанж. Түүгээр давдаг байсан хүн бол Засагт ханы шилийн сайн эр “Оргоо” Чойндон гэгч ажээ. Гэхдээ энэ хүнийг тавиад оны гэмт хэрэгтэн “Ононгийн лагерийг зовоосон” гэгддэг Хэнтий нутгийн “Оргоо” Чойндон гэгчтэй эндүүрч үл болно. Засагт ханы “Оргоо” Чойндон нэг удаа хошууныхаа өрийн дансыг хулгайлж Улиастайн амбанд хүргэгдэн цаазаар авах ял тулгагдаад байхдаа шоронгоос оргоод ууланд бүгчихэж. Энэ үед Тэрхийн голын “Хөөрхөн ягаан” хэмээх 19 настай Сэрээсан хэмээх гоо бүсгүйг ойролцоох хошууны ноён Дэнзэн гэгч Богдын лүндэн буулгуулан богтолж аваачаад бага хатнаа болгочихжээ. Үүнийг “Оргоо” Чойндон дуулж сонсоод Дэнзэн ноёныд шөнөөр давхин очиж улаан халзтай өргөөнийх нь үүдийг гэр дээр нь сөхөж тавин ган хэтээ цахиж гал асаагаад ажвал Дэнзэн ноён бага хатнаа өвөртлөөд унтаж байсан байна. Чойндон тэр даруйдаа бурханыхаа өмнөх алтан цоохор ширээн дээр залсан улаан хүрэн отго жинстэй ноён малгайг нь авч өмсөөд Дэнзэн ноёны булган хөнжлийг хуу татан сэрээж “За ноёнтон гуай та маргаааш наад бага хатнаа хоёр сайн морины хамт хойд

ууланд аваачиж өгөөд хэргэм зэргийн малгайгаа аваарай. Өөр хүн дагуулалгүй очно шүү. Би халхын сайн эр “Оргоо” Чойндон байна. Намайг бариулахаар хүн явуулбал ноён зэргээ алдахаас гадна таны талаар дүүрэн бэлчиж байдаг мал сүрэг чинь бусдын хоол болно шүү” гэж хэлээд мордоод давхичихаж. Маргааш нь бага үдийн алдад отго жинсгүй Дэнзэн ноён бага хатнаа дагуулан хоёр сайн морь хөтлөөд уул руу өгсөж явааг “Оргоо” Чойндон хараад өмнөөс нь угтан очиж хатан болоод морьдыг нь авч ноён малгайг нь буцааж өгөөд замаа буруулсан гэдэг. Тэрбээр гоо үзэсгэлэнт бүсгүй Сэрээсанг дагуулан алсын замд явахдаа,

“Оргож гараад Товцогт нуугдлаа

Очирваань уулын шилээр давлаа

Одод түгсэн шөнө давхисаар

Онцгой чамдаа хүрч ирлээ

Дэнзэн ноёны барьцыг

Дэнсэлж тавиулахаар бодлоо

Дэргэд суугаа чи минь

Дэгдэж хөөрөөд ирлээ” гэж дуулсан гэдэг. Тэгээд хоёр хос хэр баргийн хүн давж чадахааргүй “Хатан бээсийн даваа”-г давж гарсан бөгөөд уг давааг эмэгтэй хүн анх удаа давсан тул “Хатан бээсийн даваа” гэж нэрлэх болжээ. Эдүгээ харин “Хатан бээлийн даваа” гэж дуудах болсон байна. “Оргоо” Чойндон үзэсгэлэнт бүсгүй Сэрээсанг ийнхүү өөрийн болгосноор Алтайн нурууны нэгэн ханан цохионы агуйг засч янзлан тэндээ амьдрах болж, улмаар хол ойроос адуу хөөхөө болиод анчин болж хувирсан гэдэг. Үзэсгэлэнт амраг Сэрээсан нь түүний агнасан ангийн арьс үсээр дээл хувцас оёж, үүнийг нь Чойндон хошуу нутгийнханд наймаалж, хоёр хос насан намчитлаа өнөр өтгөн, сайн сайхан амьдарсан гэдэг билээ. Энэ тухай эрдэмтэн О.Сүхбаатар “Монголын газар усны нэрийн домог” номондоо онцлон дурдсан байдаг юм.

### **Бөхөн шарын нуруу**

Эрт цагт одоогийн Архангай аймгийн нутагт нэгэн бяр чадалтай хүү ээжтэйгээ амьдардаг байж. Нэгэн намар Манжийн хаан их наадам хийх болж түрүүлсэн бөхөд маш их хэмжээний шан харамж амлажээ. Үүнийг бяр чадалтай хүү дуулж сонсоод Манжийн хааны наадамд очиж барилдаад үзүүрт үлдсэн байна. Гэтэл манж нар “Энэ наадамд манай бөх түрүүлэх ёстой. Чи одоохон бууж өг” гэж хүүгээс шаарджээ. Хариуд нь хүү “Би хол газраас зорьж ирсэн хүн. Бууж өгөхгүй” гэж адарсан байна. Тэгээд тэр Манжийн бөхтэй ач тач барилдаад дийлчихэж. Манжийнхан манай бөх унаагүй гэж булхайцаад дахиад барилдуулахад хүү дахиад л унагачихаж. Гурав дахь удаагаа барилдуулахад мөн л хаячихжээ. Тиймээс манж нар хааны зарлигийг зөрчсөн гээд хүүг барьж аваад мөглөнд хорьчихсон байна. Гэтэл аз болж сайн санаатай харгалзагч өвгөн “Чи цаашдаа хол явж мэдэх үнэхээр сайн бөх. Харин би бол үхлээ хүлээсэн хөгшин хүн. Иймд би чамайг суллаж явуулаад өөрөө яахыгаа үзье” гээд хүүг

харанхуй шөнөөр суллаад тавьчихжээ. Хүү нутагтаа ирж ээжтэйгээ уулзаад “Би эзэн хааны зарлигийг зөрчсөн тул энд байж болохгүй. Уул хангай бараадаж амьдаръя” гээд Архангай аймгийн Хайрхан сумын нутагт байх нэгэн их хөвчид орогнох болжээ. Гэтэл энэхүү хөвчид “Бөх” Шар хэмээх шилийн эр орогнож байсан бөгөөд хоёр сайхан бөх хоорондоо учраа ололцон хуурай ах дүү бололцсон байна. Энэ явдлаас хойш таван жилийн дараа “Бөх” Шар хуурай дүүдээ хандаж “За миний дүү сонс. Би чиний адил их зовлон үзсэн хүн. Одоо чи бид хоёр салах цаг боллоо. Чи намайг хойшид хаанаас ч эрээд олохгүй. Харин надтай энд уулзсан гэж хүмүүст ярьж яваарай” гэж захиад сураг чимээгүй алга болжээ. Тэр цагаас хойш бяраа чадалтай хүү тааралдсан хүн болгондоо “Бөх” Шар ахынхаа тухай ярих болж, үүний улмаас Архангай аймгийн Хайрхан сумын нутагт байх нэгэн их хөвчийг “Бөхөн шарын нуруу” гэж нэрлэх болсон байна.

### **Сартагтайн суваг**

Эрт цагт алс баруун хязгаар нутагт Сартагтай хэмээх аварга биетэй эр байжээ. Эх оронч, үндсэрхэг үзэлтэй Сартагтай хятадуудад ихэд дургүй нэгэн байж. Тал хээр нутагт нь уул нурууд ховорхон байсан тул Сартагтай Тувагийн нутагт байдаг Тагнын нурууны үргэлжлэл “Ахарын уул”-аас тасдаж аваад төрсөн нутгаа чиглүүлээд шидэхэд уул болж тогтсон гэх домогтой. Увс аймгийн хойд талын сумд болох Тэс, Зүүнговийн заагт орших Сартагтай уул буюу “Сар толгой”-н нэр ингэж үүссэн түүхтэй аж. Зарим хүн энэ толгойг “Тасархай чулуу” гэдэг юмсанж. Нутгийнханы дунд “Сартагтай санаагүйдээ үхнэ” гэсэн хэлц үг байдаг бөгөөд үүний учир нь гэвэл сайн эр Сартагтай муу санаагүйдээсээ болоод хятадуудад хорлогдсон юмсанж. Мөн Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутагт “Сартагтайн суваг” гэж байдаг бөгөөд энэ нь дээр өгүүлсэнээс арай өөр домогтой. Эрт цагт Алтай нутагт ганц цагаан морьтой Сартагтай хэмээх өвгөн амьдардаг байж. Энэ өвгөн нэгэн үзэсгэлэнт охинтой байсан бөгөөд түүнийгээ алс Бээжинд хадамд гаргажээ. Охин явахдаа “Унасан газар угаасан усыг маань миний суух газарт хүргэж өг” гэсэн бөгөөд Сартагтай охиныхоо инжинд “Хар ус” нуурын усыг Бээжин тийш урсгахаар суваг малтаж “Унасан газар угаасан усыг чинь хазаартай морь шиг халгиулаад, хамартай тэмээ шиг булгиулаад ирлээ” гэж охиндоо хэлтэл ус нь эргээд нутаг руугаа урсав гэнэ. Тиймээс Сартагтай “Буцаад урссан нь Бульжин толгой бол, эргээд урссан нь Эрэг тохой бол” гээд нэг нэг хүрз шороо хаясанаар шуудуу тагларч Бульжин, Эрэг гэсэн нэртэй хоёр толгод үүссэн гэх домог бас бий.

### **Бад толгой**

Орхон голын баруун талаар нутагтай Исгэл хэмээх онч мэргэн сайн эр байжээ. Харсан ан гөрөөндөө нумаа ганц эвшээхэд л сум нь байндаа тусна. Адуу мал хөөж, ав хоморгонд мордохоос гадна дайн тулаанд эрэмгий түүнийг нутгийнхан нь ихэд хүндэлдэг байж. Сайн эр Исгэл нас хэвийсэн хойноо алс зүүн зүгээс үзэсгэлэн төгөлдөр эхнэр авчээ. Ингээд олон оныг аз жаргалаар дүүрэн үдсэн ч тэдэнд нуган үр заяасангүй. Сайн эрийн явдлаа өвлүүлж үлдээх хүү төрөөгүйд Исгэл хааяахан уйд автана. Гэтэл түүнийг нэг удаа холын аянд явсан хойгуур үзэсгэлэнт эхнэрийг нь өмнө нь шохоорхдог байсан уугуул нутгийн нь сайн эр хулгайлаад зүүн зүгт зугтаажээ. Үүнийг мэдсэн Исгэл тэдний араас өдөр шөнийн турш нэхэн хөөсөөр барааг нь олж хармагцаа нумаа эвшээхэд сум нь эндүүрч тусаад хайртай эхнэрийг нь сүлбэчихэж. Тиймээс уурлаж бачимдсан Исгэл нумаа эвдэж, сумаа хугалж хаяад сэлмээрээ



дэргэдэх уулаа цавчтал орой нь тэрүүхэн тэндээ “Бад” гэсэн дуу гарган унаж гэнэ. Тэр газар нь Төв аймгийн Эрдэнэсант, Булган аймгийн Рашаант сумын зааг, алдарт Батхаан уулын баруун хойд биед байх бөгөөд энд “Бад” хэмээх жижигхэн толгод байдаг аж. Эдүгээ энд “Бад” хэмээх шагайн харвааны тойром үйл ажиллагаа явуулдаг бөгөөд жил бүр нутаг нутгийн харваачид цуглаж цэц мэргэнээ сорьдог юмсанж.

## Молорын агуй

Хэнтий аймгийн Галшир сумын нутагт “Сүмийн чулуу” нэртэй уул байдаг бөгөөд энэхүү уулын ханан хадны ёроол дахь баруун урагшаа харсан аманд хоёр хүн босоогоороо элбэг багтах зайтай агуй байдаг аж. Нутгийнхан уг агуйг эртнээс “Хулгайчийн агуй” гэж нэрлэсээр иржээ. Ийнхүү нэрлэх болсоны учир нь эрт дээр үед алс холоос адуу мал хөөдөг нэг сүрхий эр энд орогнодог байж. Тэрбээр хэд хоногоор явж ирээд агуйн хажуугийн сүрлэг хадан дунд морио хашиж орхиод, ойролцоох бяцхан тойрмоос ус авч хоол цайгаа хийдэг байж. Хожим түүний морио хашдаг байсан сонин тогтоцтой хадыг нутгийн ардууд “Морины хороо”, уургаа түшүүлэн тавьдаг байсан хадыг “Уурга”, эмээлээ тохдог байсан хадыг “Эмээлийн тавиур” гэж нэрлэх болжээ. Ер нь шилийн сайн эрчүүдийн орогнож байсан агуй хонгилууд тэдний нэрээр нэршиж үлдсэн нь цөөнгүй. Жишээ нь Хантайн нурууны “Зэрлэг” Цамбын орогнож байсан агуй Булган аймгийн Тэшиг суманд байдаг бөгөөд энэ тухай тус сумын анчин Жамсрангийн Чүлтэм “Биднийг бага байхад шилийн сайн эр “Зэрлэг” Цамбын тухай хөгшчүүл их ярьдаг байсан. Хангайн нурууны ар талын “Моёдой” уулын баруун суганд “Цамбын гозгор” нэртэй жижигхэн байц хад одоо хүртэл байж л байна. Дээр үед энд морь, хүн элбэг багтахуйц томоохон пүнз байсан гэдэг. Тэгтэл нугалаа завхралын үед шатааж устгасан байгаа юм. Дотоод яамныхан сүм хийдийг галдан шатаахын хажуугаар нутгийн ардын шүтээн болсон шилийн сайн эрсийн оромжийг хүртэл устгаж байсан нь мөн ч тоогүй яа” гэж халаглаж байсан удаатай. Мөн хорь, гучаад оны үед шилийн сайн эр явсан Тавдугаар хүүхэн хутагт Найдансүрэнгийн орогнож байсан Тахилтын овоог нутгийн ардууд “Хутагт хад” гэж нэрлэсэн байх бөгөөд нэг удаа Хүүхэн хутагт арван тавны цагдаа нараас зугтааж яваад Тахилтын овоо руу давхиад орчихож. Уг овоо нь хад цохио ихтэй, эгц өндөр уул тул арван тавны цагдаа нар мориноосоо буугаад явган мацацгаажээ. Эцэст нь тэд нум сумаар харватал Хүүхэн хутагт суунгуутаа хад болж хувирсан гэх домог бий. Түүнээс хойш нутгийн ард олон тэр хадыг Хутагт хад гэх болжээ. Харин хэн нэг нь “Хүүхэн хутагт бол нэрнээс нь үзсэн ч эмэгтэй хүн байсан байх, тиймээс Хутагт хаданд хүүхнүүд мөргөж байх ёстой” гэж мэдэмхийрсэнээс нэг үе Тахилтын овоог тахих үед охид бүсгүйчүүд тэр хаданд мөргөдөг болжээ. Хутагт хаднаас доош уулын хормойд Онон мөрний шугуйн захад жижигхэн нуур байх бөгөөд тэрхүү нууранд хааяа нэг морин толгой үзэгддэг, тэр нь Хүүхэн хутагтын унаж явсан морины толгой гэх бас нэгэн домог яриа байдаг билээ. Сэцэнхан аймгийн Боржигон Цэцэн вангийн хошуу, одоогийн Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг “Аргийн чулуу” хавиар нутаглаж байсан Харын Молор хэмээх шилийн сайн эрийг говийнхон андахгүй. Баянжаргалан сумаас зүүн тийш орших Аргийн чулууны ар этгээдэд Молорын амьдарч асан “Харын агуй” гэж байдаг ажээ. Энэхүү агуй нь ихээхэн нууцлаг бөгөөд хэр баргийн хүн олоод очиж чаддаггүй юм байх. “Молорын агуй” гэж нэрлэлгүй “Харын агуй” гэж нэрлэсэн нь цаанаа бас учиртай. Молорын эцэг Хар хэмээх сайхан эр мөн л шилийн сайн эр байсан бөгөөд дээр өгүүлсэн шилийн сайн эрсийн зарчимаар өөрийнхөө амьдарч асан агуйг хүүдээ өвлүүлсэн ажээ. Манжийн үед “Боржигон Цэцэн вангийн шилийн сайн эр “Хар” гэсэн нэр

ядуу ардуудын дунд ихэд тархсан бөгөөд тэрбээр голдуу ноёд баядын адуу хөөж, пүүсний данжаадуудыг тонон дээрэмдэж, үүнээс олсон олзоо ядуу ардуудад тараадаг байсан болохоор ингэж нэрд гарахад хүрчээ. Тэгээд хүү Молороо өөрийнхөө энэ замаар оруулаад “Миний хүү ядарсан ардуудаа л хайрлаж хамгаалж явдаг юм шүү” гэж захиж байсан гэдэг. Манжийн үед “Босоо” Монголжав тэргүүтэй дөрвөн сайн эр нутаг орондоо алдартай усан тэлмэн жороо бор гүүг хятадууд урагш нь гаргах гэж байгааг мэдмэгцээ араас нь сэмхэн дагаж явсаар Мэнэнгийн талд гүйцэж очжээ. Тэгээд уран арга хэрэглэж жороо бор гүүг тэднээс хулгайлаад Түшээт ханы нутгийг хөндлөн гулд туулсаар үл мэдэг даваан дээр гарч ирэхэд үзэсгэлэнт Туул голын хөндий нүд булааж, буурал өнгийн туяа татаад явчихсан гэдэг. Тиймээс тэрхүү жижигхэн толгодыг “Буурлын даваа” гэх болсон гэдэг. Түүнчлэн ном зохиолд гардаг “Хангай” Базар, “Хулгар” Нацаг, “Ганган” Төгс, “Улаан” Дамаа, “Цахиур” Төмөр, “Царцаа” Намжил, “Торой” Банди, “Тогос” Чүлтэм, “Хүрлэг” Дамбий нар нь цөм өөр өөрсдийн орогнох газар, агуй хонгилтой байсан гэдэг. Хятадын пүүс, жингийн цувааг удаа дараа дээрэмдэн эд барааг нь тонож нутгийн ардуудад түгээдэг байсан Дайчин Жонон вангийн хошууны сайн эр “Хүрлэг” Дамбий гэхэд л Архангайн Хөх нуурын хөвчид өөрийнхөө нэрээр нэршсэн гурав дөрвөн ч нууц агуйтай байсан гэлцдэг. Гэвч улаан хувьсгалчид 1932 онд лам нарын нуусан бурхан тахилыг хайж явахдаа түүний агуйг олж аваад юу ч үгүй тоночихсон гэдэг билээ. “Хүрлэг” Дамбийн агуйгаас хуй хуйгаар нь торго дурдан, авдар дүүрэн эрдэнийн чулуу, цул алтаар чимэглэсэн хурдан буу, Бухар хотын урчуудын эрдэм шингэсэн ган сайтай чинжаал хутга, бүрэн хэрэглэлтэй мөнгөн эмээл, хазаар гарч байсан гэдэг. Энэ мэтээр дээхэн үеийн шилийн сайн эрсийн нэрээр нэршсэн уул хад, хөвч тайга, агуй хонгилуудыг тоочоод баршгүй.

***Эрхэм уншигч та бүхэн тавь, жар, далаад онуудад өөрсдийнхөө нутаг оронд алдаршсан шилийн сайн эрсийн талаар бичүүлэхийг хүсвэл 95824175 дугаарын утсаар холбогдож болно.***

## ЗОХИОГЧИЙН ТУХАЙ ТОВЧХОН

Балсанцэрэнгийн Ойдов. Өвөрхангай аймгийн Хужирт сумын уугуул. Яруу найргийн “Парнаст хүрэх зам”, “Эрх танхай нүргэлээн”, шүлгийн түүвэр, “Халхын шоронгийн амьд түүх”, “Гучаад оны хэлмэгдүүлэлт”, “Ужид цэнгэлийн манан”, “Үндэстний үзэлтэнүүд ярьж байна”, “Үлэмж сэтгэлийн тусын тулд”, “Гяндангийн вант улсын эзэн хаан”, “Яруу найрагч Р.Чойномын нүүрний хэв”, “Дал, ная, ерээд оны Улаанбаатарын атаманууд” зэрэг арав гаруй ном туурвисан. “Ар халхын шилийн сайн эрчүүд” ном нь түүний 18 дахь ном болой.

# Table of Contents

## Гуравдугаар дэвтэр

### Өмнөтгөл

Дарьгангын сайн эр “Хангай” Базар

“Ирэг зум”-аар гаршсан Хоноцын Самдан

Бээжингийн шулаачдыг бэмбэгнүүлж явсан Орлойн хөх Доодой

Шилийн богдод тангараг өргөсөн 32 дахь сайн эр “Исгэрдэг” Дамба

Тахь зайран буюу “Сунагар” Цэсрэн

Тувагийн баячуудын шүдний өвчин болж явсан “Чотонгийн Арьяа

Жараад оны “Хэлхээн” Чойжилсүрэн

“Тайгын чоно” хочит Дүгэр бол шилийн сайн эр биш алуурчин

Жа лам Дамбийжаагийн ивээлд багтсан “Тэмээний хулгайч” Архадын Дархай

“Цагаан шүдэн” Баатар, “Атгадаг” Тамжид нар Үзэмчин, Барга хошууд руу довтолсон нь

Тогос шиг гоёж явсан “Тогос” Чүлтэм

Хуурамч зоостой хутгалдсан “Хөмсөг” Тавхай

Гамин цэргийн эрлэг болж явсан “Сайн хулгай” Цэрэндондог

Завхан аймгийн Сонгино сумын сайн эрчүүд

Халх дөрөв, шавь таван аймагт алдаршсан “Дөрөөт” Тэгшбүрэн

“Чавганц” Дампил тамгын газрын тахарын гайхлыг төрүүлсэн нь

Ногоон малгайтануудаас бултаж хээрээр гэр, хэцээр дэр хийсэн эрчүүд

Нэг: Цаазын тавцангаас мултарсан Соёрохын Мягмар

Хоёр: Хүүхэн хутагтын шавь “Ойлон” Санжаа

Гурав: Тагнуулын ҮҮрэг гҮйцэтгэж Явсан “Домогт” Балдан

Дөрөв: Амжиж оргоод адуу хөөх болсон Амарбилэгийн Чулуунсэд

“Босоо” Бадарчийг босохгүй болтол нь залхаасан “Чоно” Цээтуяа

Засагт ханы Дампил панз

Дунганы дээрэмчдийг явгалж орхисон халхын сайн эр Жунай Цогбадрах

“Бөх-хулгайч” гэж цоллуулж явсан “Хулгар” Нацаг

Энэрэнгүй сэтгэлтэй эрт цагийн хулгайч “Сээтэн” Жалбаа

Хэнтийн ян хөвчөөр гэр хийсэн “Бозлог” Даш

Засаг ноёнттойгоо хамтарч хятадуудыг тоносон “Яргай” Дугаржав

Хан хөхий уулын савдаг гэгдэж явсан Шагжийн Шарав

Сэтгүүлч, найрагчдын урлан дахь Засагт ханы хөх харчууд

Есөн зоосны мэргэнд ээрэгдсэн шилийн эр Наваантаяа

Ванчин гавжийн агуй Оросоогийн агуй болж хувирсан нь

“Хэрзгэр” Лувсандагва

“Ягаан” Гончиг

“Царай” Цамба

“Нохой” Дугар

Шаргиатын гарамын “Жууз” Молом

Дарьгангын сүүлчийн сайн эр “Төлгөн” Жамбалдорж

Хятадын эсрэг үзэлтэн “Хэлэмгий” Жамц

Дорноговийн домогт эрс “Тэлмэн” Зундуй, “Хилэн хормойт” Ашуу  
Баруун гурван аймагт домог болж явсан “Доль” Банзрагч  
Шилийн сайн эрсийн шийрийг хатааж явсан Шуумарын Банзрагчийн тухай тэмдэглэл  
40 жил хээрээр гэр хийсэн “Доль” Банзрагч  
“Доль” Банзрагчийг шоронгийн дээвэр дээрээс үсрэхэд хуягийн бууны сум гүйцээгүй  
Увсын дуулиант эр Харигийн Цийрэн  
Манжийн эсрэг тэмцэгч Амарсанаа, Чингүнжав нарын үеэс шилийн эрчүүд хөдөлгөөнд  
орж эхэлжээ  
Боржигон сэцэн вангийн сайн эр Гээнзий  
“Нугалдаг” Жамбий, түүний хүү “Гүзээ” Содном  
Хан Хэнтийн “Гайхал” Батчулуун  
Сайн эр, сайн морь хоёрын бахархаж биширмээр явдал суудал  
Шилийн эрстэй холбоотой уул усны домог